



МУРАКАМИ ХАРУКИ

НОРВЕГИЙН

Си

Харуки Мураками

Норвегийн ой

Зохиолчийн зурвас

Хэдийгээр би зохиол бүтээлүүдээ зурвас бичдэггүй ч энэ романы тухай хэд гурван зүйл дурдах шаардлагатай болов уу. Эхэндээ би таван жилийн өмнө тэрлэсэн "Гэрэлт цох" өгүүллэгээсээ санаа авч гэгээн хайрын тухай өгүүлэх хөнгөхөн роман зохиох санаа өвөртөлсөн юм. Гэсэн ч бичих явцад энэ зохиол маань "хөнгөн" гэхээргүй утга агуулгатай болжээ.

Зүйрлэвэл, Скотт Фицджеральдын "Ялдамхан шөнө" болоод "Агуу Гэтсби" нь зарим сэжүүрээрээ холбогдсон лугаа адил энэ зохиол тодорхой хэмжээгээр миний амьдралтай сүлэлджээ.

Хүмүүн бидний амьдрал гэгч нь сайнтай муутай, арван хуруу тэгш байдагчлан энэ романыг дэнсэлвээс нэг талаас сайн, нөгөөтэйгүүр тааруухан гэж хэлж болохоор юм. Гагцхүү зохиолын маань үзэл санаа миний бодьгал зан чанараас илүүтэй болоосой гэсэн чин сэтгэлдээ хөтлөгдсөн гэхэд хилсдэхгүй.

Энэхүү романаа би 1986 оны 12-р сарын 21-ний өдөр Грекийн Микене арал дээр эхэлж, 1987 оны 3-р сарын 27-ны өдөр Рим хотноо дуусгалаа. Эх орноосоо хол хөндий орчинд үзэг цаас нийлүүлсэн нь зохиолын үйл явдалд нөлөөлсөн эсэхийг мэдэхгүй ч зохиолч хүнд нам тайван орчин юу юунаас илүү чухал биз ээ.

Энэ романы эхлэл хэсгийг Грекд, өрнөлийг Сицилид, төгсгөлийг Рим хотноо тэрлэсэн бөгөөд энэ зуур би Битлз хамтлагийн "Sergeant Peppers" хуурцгийг зуу гаран удаа сонссон доо.

Эцэст нь дурдахад, эхэнүү хоманаа амьдралын жамаар холдон одсон анд нөхөддөө өргөн барья

1987 оны 6-р сар

Харуки Мураками

НЭГДҮГЭЭР
БҮЛЭГ

Боинг-747 онгоцонд сууж явсан тэр жил би гучин долоо хүрч байлаа. Онгоц нүүгэлтсэн борооны үүлсийг зүсэн Хамбургийн буудалд газардахаар доошилно.

Арван нэгэн сарын хүйтэн бороо газар чийглэж, тэртээ дор харагдах онгоцны буудлын ажилчид цув өмсжээ. Цохио хад шиг сүндэрлэх буудлын дээвэр дээр янз бүрийн далбаанууд намирч, БМВ-гийн сурталчилгааны самбарууд байх нь эгээтэй л фландрийн дүнсгэр зургийг санагдуулна. “Дахиад Германд ирлээ.”

Онгоц газардмагц “Тамхи татахыг хориглосон” сануулга унтарч, дээрээс намуухан хөгжим эгшиглэв. Найрал хөгжим Битлзийн Norwegian Wood-ийг гайхалтай тоглох аж. Энэ аялгууг сонсох бүр сэтгэл үймэрдэг боловч тэр өдөр урьд урьдаас илүүтэй гэгэлзэн хөвсөлзөж билээ.

Бодол санаа минь уураг тархийг өрөмдөж, өөрийн эрхгүй хоёр гараараа толгойгоо барин тонгойлоо. Удалгүй онгоцны үйлчлэгч герман бүсгүй дөхөж ирээд зүгээр эсэхийг минь англиар лавлаж асуув. Би толгой бага зэрэг эргэснээс бүх юм зүгээр хэмээлээ.

- Үнэхээр зүгээр үү?

- Зүгээр ээ. Баярлалаа.

Үйлчлэгч бүсгүй инээмсэглэсээр явж одов. Төдхөн Билли Жоэлийн дуу хөвөрлөө.

Толгойгоо өндийлгөн Хойд далайг бүрхсэн бараан үүлсийг ажингаа энэ насандаа алдаж гээсэн үй олон зүйлсийн тухай эргэн дурслаа. Нэгэнтээ урсаж өнгөрсөн цаг хугацаа, хорвоогоос хальсан, сураг алдарсан анд нөхөд, эргэж ирэхгүй хором мөчүүд.

Онгоц зогсож, хүмүүс суудлын даруулгаа тайлаад, тавиур дээрээс ачаа тээш, хувцас хунараа авна. Харин би өвсний үнэр ханхийж, салхи сэвэлзэн, шувууд жиргэсэн тэр хээр талд үлджээ. 1969 оны намар буюу хорьж болдоггүй хорин нас шүргэсэн тэр жилийн минь намар.

Үйлчлэгч бүсгүй дөхөж ирээд алжаасан эсэхийг минь асуунгаа хажууд суув. Би:

- Одоо зүгээр дээ. Хүнд хааяа ганцаардах үе байдаг даа (It's all right now, thank you. I only felt lonely, you know.) гэж хэлээд инээмсэглэв.

- Ойлгож байна аа. Би ч гэсэн үе үе ганцаарддаг юм. (Well, I feel same way same thing, once in a while. I know what you mean.)

Бүсгүй толгой дохин хөгжилтэй нь аргагүй инээмсэглээд:

- Сайхан аялаарай. Баяртай! (I hope you'll have a nice trip. Auf Wiedersehen!) гэсээр босч явлаа.

- Auf Wiedersehen!

Хэдийн арван найман жил өнгөрсөн ч тэр хээр талын дурсамж бүдгэрсэнгүй. Хэдэн өдөр зүсэрсэн бороонд шороо тоос нь дарагдсан уулсаар хөхөлбөр туяа татжээ. Өвсний түрүү арван сарын салхинд сэрчигнэж, тэртээ дээр цасан хунгар мэт урт үүлс суунаглана. Нүд алдам хязгааргүй хөх тэнгэр. Сэвэлзүүр салхи бүсгүйн үсийг намируулж ойн тийш одно.

Навчис шуугьж, хаа нэгтээ нохой хуцах нь нөгөө ертөнцөөс дуулдах бүдэг бадаг улих дуун мэт чихэнд хүрнэ. Ойр орчинд нилдээ анир чимээгүй ноёлох аж.

Бидхоёртой нэг ч хүн таарсангүй. Тэртээ талаас хоёр улааншувуу үргэж, төгөл рүү нисэн одов. Зам зуур Наоко нэгэн худгийнтухай ярьж өглөө.

Хүний ой ухаан гэдэг хачин юм шүү. Би тэр үесд сэтгэл хөвсөлзөн энэ бүхнийг анзаараагүй бөгөөд арван найман жилийн дараа нэг бүрчлэн санан дурсана чинээ бодож явсангүй. Үнэндээ тэр мөчид эргэн тойрноо анзаарах сөхөөгүй явжээ.

Оюун бодолд минь өөрийн бие болон зэрэгцэн алхах сайхан бүсгүй, цаашдаа хэрхэн тухай сэтгэхээс өөр зүйл байсангүй. Хаашаа ч харсан,

юү ч мэдэрсэн, хэн бугайг ч бодсон эцсийн эцэст бүхнийг өөртөө хамаатуулдаг нас байдаг даа.

Тэр үед би дурлалдаа шатаж явлаа. Дур хүсэл минь хаашаа ч юм бэ хөтөлж, хүрээлэн буй орчноо анзаарч харах сөхөө өгдөггүй байжээ.

Эдүгээ тэр нуга, өвсний үнэр, сэвэлзүүр салхи, уул нуруу, нохойн хуцах дуун л санаанд буудаг. гараа сунгах төдийд л хүрчихмээр тодхон буухыг нь яана!

Харамсалтай нь, бидний дүр төрх замхарчээ. Би ч, Наоко ч харагдахгүй юм. Бид хоёр хаачсан юм бол? Юуны учир ийн алга болов? Миний хувьд үнэт эрдэнэсээс өөрцгүй байсан тэр бүсгүй, миний бие, миний бяцхан ертөнц хааччих нь энэ вэ?

Тийм ээ. Би тэр бүсгүйн царай зүсийг шуудхан санаж чадахгүй нь. Хүний сүүдэр үл үзэгдэх тэр хээр тал л санаанд үлдэж.

Мэдээж, тухтайхан бодвол царай зүсийг нь санаж болох л юм. Жижигхэн, хүйтэн гар, зөөлөн, шулуун үс, чихнийх нь гэдэс, гэдэснийх нь дор байх жижигхэн мэнгэ, өвөл өмсдөг байсан тэмээний ноосон дэгжин хүрэм, юм асуухдаа өөдөөс ширтэх нүд, чивчирсэн дуу (хааяадаа үг яриа нь уулын орой дээр салхинд зогсоод үглэх мэт сонсогддог сон). Энэ бүхнийг эвлүүлж бодмогц аяндаа дүр төрх нь тодорно.

Үргэлж хажууд минь явдаг болохоор эхэндээ хажуу талаасаа тодордог юм.

Түүний инээмсэглэл, өөдөөс минь ширтэн ярих тэр агшин, толгойгоо ялимгүй гилжийлгэн ярих тэр мөч. Энэ үед тэр тунгалаг голын уснаа жирэлзэн өнгөрөх загас жараахайг олж харахыг хичээх мэт өөдөөс минь цоо ширтдэг байж билээ.

Гэхдээ энэ бүхнийг сэтгэлдээ буулгатал хэдэн хором өнгөрнө. Он жил өнгөрөх тусам энэ хугацаа уртсаад ч байх шиг. Гунигтай ч гэлээ, энэ бол бодит байдал.

Эхэндээ түүний дүр төрх таван эгшинд буудаг байсан бол аажмаар арав, хорь болж, сүүлдээ минут хэртэй бодож байж сэтгэлд минь тодорно. Энэ хугацаа үдэш болоход сүүдэр уртсах шиг улам бүр нэмэгдэнэ. Эцэстээ тэр чигтээ харанхуйд автах биз ээ.

Цагийн саалтаар дурсамж дурдатгал минь бид хоёрын зогссон тэр газраас холдсоор л байна. Тэртээ арван сарын хээр тал алдартай кино зураг шиг ахин дахин бууж, сэтгэлийн минь нэгээхэн хэсгийг цочроох мэт болно.

Босох болоогүй юу? Өндийгөөд ямар учраас энд ирснээ бод доо. Эдүгээ сэтгэл минь өвдөхөө больжээ. Энэ бүхнийг дурсах болгонд хөндий хоосон зүйл нүдэх мэт л ажрахаа больж дээ. Цаг хугацаа улиран өнгөрөхөд энэ дуу авиа бусдын адил сарниж алга болно.

Тэгэвч Хамбургийн онгоцны буудалд Люфтханзагийн онгоцонд суугаа энэхэн үест энэ цохилтууд “Одоо босооч, ойлгооч!” гэх шиг урьд байгаагүйгээр хүчтэй, удаан байх ажээ.

Ийм учраас л би энэ хэдэн мөрийг холбож сууна. Үймэрсэн бодол санаагаа цаасан дээр буулгахаас нааш учрыг нь олохгүй би гэж ийм л хүн дээ.

Тэртээд үлдсэн тэр өдөр Наоко юун тухай ярьж байлаа?

Тийм ээ. Бүсгүй хээр талд байсан нэг худгийн тухай ярьсан шүү дээ. Үнэндээ тэр худаг байсан эсэхийг би мэдэхгүй. Энэ бүхэн хар дарсан зүүд шиг тэр өдрүүдэд оюун бодолд нь ээрсэн зүйлсийн нэгэн адил хий хоосон төсөөлөл, билгэ тэмдэг байсан уу, хэн мэдэх вэ?

Гэсэн хэдий ч энэ худгийн тухай ярьснаас нь хойш би хээр талыг тэр худаггүйгээр төсөөлөхөө больсон юм. Чухамдаа би хоёр нүдээрээ хараагүй ч тэр худаг санаанд минь эргэн эргэн буух талд өдий болтол оршсоор байдаг.

Тэр худгийг би нэгд нэгэнгүй дүрсэлж чадна. Худаг хээр тал бяцхан төгөлтэй нийлэх тэрхэн хэсэгт байх агаад алд хэрийн харанхуй амсрыг

нь тойроод өтгөн өвс халхлан ургана. Ойр орчимдоо хожуул болоод чулуун хашилтгүй, газарт нэг нүх л онгойж харагдана.

Худгийн амсрыг тойруулж тавьсан чулуунууд борооны усанд идэгдэж цайгаад, зарим хэсгээрээ цуурч доош унан, завсар зайлхайгаар нь жижигхэн ногоон гүрвэл гүйнэ. Доош харвал нүдэнд торох нэгээхэн ч зүйл үгүй.

Худаг төсөөлөхийн аргагүй гүнзгий бөгөөд нягтруулж шахсан мэт тас харанхуй орчноор дүүрэн гэдгийг л би мэднэ. Наоко үгээ цэнэн байж:

-Худаг их гүнзгий, маш их гүнзгий гэж билээ.

Тэр заримдаа санаагаа яв цав ойлгуулахын тулд удаан ярьдаг байлаа.

-Маш гүнзгий шүү. Тэр худаг энд байдаг ч чухам хаахна байдгийг хэн ч мэдэхгүй. Ямар ч байсан энэ хавьд бий.

Бүсгүй ингэж хэлээд хүрэмнийхээ халаасанд гараа хийж, намайг ширтэн “Нээрээ шүү!” гэх шиг инээмсэглэв.

-Тийм бол энэ чинь их аюултай юм биш үү? Хаа нэгтээ гүнзгий худаг байгаа ч яг хаана байгааг нь хэн ч мэдэхгүй. Уначихвал яана?

-Уначихвал шунхийгээд л пидхийнэ.

-Тэр худагт хүн унадаг гэж үү?

-Хааяа унадаг л юм. Хоёр, гурван жилд нэг удаа... Хэн нэгэн ор сураггүй алга болж, хайгаад хайгаад олдохгүй болохоор нутгийнхан худагт уначихсан гэлцдэг юм.

-Тэгж үхэх хэцүү л байх даа.

-Аймшигтай. Шууд хүзүүгээ хугалбал амар. Харин хөлөө хугалчихвал ч хэцүү дээ. Орилж хашгираад нэмэр болохгүй. Хэн ч сонсохгүй. Хэн ч олохгүй. Хаа сайгүй аалз, унаж үхсэн хүмүүсийн араг яс, тас харанхуй. Тээр дээр өвлийн сар шиг дугуйрсан тэнгэр л харагдана. Ганцаараа аажмаар үхнэ дээ.

Ингэж хэлэнгээ тэр хүрмэн дээрээ наалдсан навчийг авч хаялаа.

Бодохоос ч аймаар юм. Тэр худгийг олоод хайс татчихаасай.

-Хэн ч олж чадахгүй юм чинь. Энд замаасаа хазайж болохгүй.

- Тэр ч мэдээжийн хэрэг.

Тэр зүүн гараа халааснаасаа гаргаж гараас минь барилаа.

- Айсны хэрэггүй. Чи энд шөнө дөлөөр явсан ч худагт унахгүй. Би ч гэсэн чамтай байгаа цагтаа унахгүй.

- Хэзээ ч унахгүй гэж үү?

- Хэзээ ч.

- Яаж мэдэж байгаа юм бэ?

- Зүгээрл мэдэжбайна гээд тэр гараас минь чанга атгасан сан.

Бид хэсэг зуур чимээгүй алхав.

- Би иймэрхүү зүйлийг мэддэг юмаа. Зүгээр л унахгүй гэдгээ мэдэрдэг. Жишээ нь, чамтай байхад би юунаас ч айдаггүй. Муу муухай зүйл намайг урхидаж чадахгүй.

- Ийм амархан юм бол үргэлж хамт байхад л болох юм байна.

- Чи үнэндээ ингэж бодож байна гэж үү?

- Тэгэлгүй яахав.

Бид хоёр зогсоод, Наоко мөрөн дээр минь хоёр гараа тавьж, нүд рүү минь ширтлээ. Хархан нүдэнд нь ус эргэлдэх шиг. Сайхан нүдээрээ хэсэг зуур намайг ширтээд өсгийгөө өргөн хацарт минь хацраа наав. Халуу төөнөж, сэтгэл гэгэлзээд, зүрх минь зогсохоо дөхлөө.

- Чамд баярлалаа.

- Зүгээр дээ.

- Хамт байя гэхийг чинь сонсоод ямар их догдолсныг минь мэддэг ч болоосой.

- Харамсалтай нь, бид хоёр хамт байж чадахгүй байх даа гэж тэр их л гунигтай өгүүлнэ.

- Яагаад?

- Яагаад гэвэл боломжгүй шүү дээ. Дэндүү хатуу сэтгэл гаргасан болно... Яагаад гэвэл...

Тэр дуугаа хураан хэсэг алхлав. Дотроо элдвийг бодож буйг нь ойлгох учир чимээгүйхэн зэрэгцээд явлаа.

- Учир нь бид хоёр хамт байж болохгүй.

- Яагаад болохгүй гэж?

- Хэн нэгэн нөгөөгөө үргэлж хамгаалж, хамт байх боломжгүй шүү дээ. Бид хоёр ханиллаа гэж бодъё. Чи ажил хийх нь мэдээж. Харин ажилдаа явсан хойгуур чинь хэн намайг хамгаалах вэ? Эс бөгөөс томилолтоор явбал хэн намайг гэх вэ? Үхэн үхтлээ чамайг дагах хэрэг үү? Ингэж болохгүй. Эцэстээ энэ болгоныг эр, эмийн харьдаа гэж хэлэхийн аргагүй болно. Тэгээд хэзээ нэгэн цагт чи надаас залхаж “Амьдралын минь утга учир юу юм бэ? Энэ эмэгтэйг асарч халамжлахад л бүхнээ зориулах гэж үү?” гэх болно. Би ингэмээргүй байна. Өөрийнхөө асуудлыг өөрөө шийдсэн болохгүй шүү дээ.

Би нуруугаар нь илээд:

- Насан туршдаа ийм байхгүй шүү дээ. Хэзээ нэгэн цагт эдгэрч л таарна. Тэр үед нь хоёулаа цаашдын амьдралаа бодъё. Наоко минь, тэр үед чи надад туслах юм бил үү, хэн мэдэх вэ? Амьдрал гэдэг чинь сайнтай муутай, аваа өгөөтэй л байдаг шүү дээ. Юм бүхнийг хүндрүүлж, сэтгэлээ чилээсний хэрэг юун. Сэтгэл тавгүйтээд ирэхээр

юм бүхэн хэцүү санагддаг. Сэтгэл амар байвал аяндаа л болж бүтдэг дээ.

- Чи яагаад ингэж ярих болов оо?

Хоолой нь сааралтаж, буруу юм хэлснээ ойлголоо.

Наоко газар ширтсэн хэвээр:

- Сэтгэл минь амар байвал аяндаа болж бүтнэ гэж бодоход тайтгардаг хэдий ч үнэндээ ийм үг сонслоо гээд зовлон минь нимгэрэхгүй. Ойлгож байна уу? Сэтгэл амрах төдийд л би түмэн хэсэг болно. Амьдрал минь анхнаасаа ийм байсан учраас Хэдийн дасчхаж. Нэг л жолоо алдвал буцаад барьж дийлэхгүй татагдаад явчихна. Бутарч унаад, хаа нэгтээ хийсээд явчихна. Чи ойлгохгүй байна уу? Үүнийг ойлгохгүй байж намайг хамгаална гэж хэлж чадна гэж үү?

Би ам ангайж зүрхэлсэнгүй.

-Сэтгэл минь чиний төсөөлснөөс илүүтэй үймрэх юм. Чи тэр өдөр яах гэж надтай дотноссон юм бэ? Орхиод явчихгүй яав даа.

Ер бусын нам гүмхэн нарсан төглөөр алхахад зуны сүүлээр үхсэн голио царцаа зам дээр хатаж хөглөрөөд, хөл дор гишгэгдэн шаржигнана. Хоёул ямар нэгэн зүйл хайх мэт толгой гудайлган явлаа. Наоко:

-Уучлаарай гэж хэлээд гараас минь зөөлөн атгаж, толгойгоо хэдэнтээ сэгсрээд:

- Чамайг гомдооё гэж бодоогүй юм шүү. Элдвийн юм бодсоны хэрэггүй. Намайг уучлаарай. Өөртөө бухимдах үе байх юм.

- Би чамайг нэвт шувт мэднэ гэж хэлэхгүй л дээ. Толгой муутай болохоор юм ойлгохдоо удаан. Энэ бүхнийг ойлгоход тодорхой хугацаа хэрэгтэй. Тэгсэн цагт би чамайг хэн хүнээс илүү сайн мэддэг болно.

Бид хоёр чимээ аниргүй орчинд уусан зогслоо. Би гутлынхаа хоншоороор мөчир өшиглөж, нарсан дундаас цэлийн харагдах тэнгэр

өөд ширтэв. Наоко гараа халааслаад, юу ч харалгүй бодолд автан зогсоно.

- Ватанабэ, чи надад хайртай юу?

- Хайртай шүү дээ.

- Тэгвэл хоёр хүслийг минь биелүүлээч.

- Хоёр биш гурав байдаг байх аа?

Бүсгүй толгой сэгсрэн мишээнэ.

- Хоёр байхад хангалттай. Надтай ирж уулзсанд үнэн сэтгэлээсээ талархаж буйг минь ойлговол эхний хүсэл минь биелнэ. Үнэхээр их баяртай байна. Авралын оч гийх шиг л болох юм. Чамд мэдэгдэхгүй байж болох ч үнэндээ их хөөрлөө.

- Би ирж байна аа. Харин хоёр дахь нь?

- Намайг дурсаж яваарай. Би гэж хүн байсныг, хажууд чинь зогсож байсныг битгий мартаарай.

- Мартахгүй ээ.

Ингэж хэлээд тэр урагш алхлахад моддын навчсан дундуур тусах намрын шаргал нарны туяа хүрмэн дээр нь бүжнэ.

Ойрмогхон нохой хуцах дуун гарч, тэр гүдгэр хэсгээр давж, бяцхан төглөөс гараад шалавлан уруудав. Би хоёр гурван алхмын цаанаас дагаж явлаа. Араас нь:

- Хүлээ л дээ. Нөгөө худаг гараад ирэх ч юм бил үү? гэвэл тэр инээмсэглэсээр намайг хөтлөв. Ингээд бид хоёр мөр зэрэгцэн алхлаа.

- Намайг хэзээ ч мартахгүй биз? хэмээн шивнэх шахам асуухад нь би:

- Насан туршдаа санаж явна. Наокогоо хэзээ ч мартахгүй! гэж билээ.

Гэсэн хэдий ч цаг хугацааны эрхээр энэ бүхэн холдон замхарч, олон зүйл ой тойноос минь арчигджээ. Дурсамжаа сэргээн бичих энэхэн үест нэгээхэн чухал зүйлээ ор тас мартчихвал яана даа? гэсэн бодол эргэлдэж сэтгэл эмзэглэнэ. Оюун бодлын минь нэгээхэн хэсэгт энэ бүхэн сэвсгэр тоос болон хуралдаж байвал би яалтай?

Эдүгээ би энэ бүхнийг санаж байна. Он цагийн эрхэнд сэтгэлээс минь мултрах дөхсөн дурсамжаа энгэртээ наасаар Хэдийн мөлжсөн ясыг ахин дахин мэрэх шиг энэ мөрүүдийг холбож сууна. Наокод өгсөн амлалтаа үүнээс өөрөөр биелүүлэх аргагүй болжээ.

Дурсамж дурдатгал минь тодхон байсан залуу зандан ахуйдаа түүний тухай бичихийг хэдэнтээ оролдсон боловч үг үсгээ холбож дийлээгүй юм. Эхний өгүүлбэрээ эвлүүлээд буулгачихвал аяндаа хөврөөд явах ч чухамдаа хичнээн хичээгээд энэ эхний өгүүлбэр нь санаанд буухгүй байлаа. Дурсамж минь хэтэрхий тод томруун байснаас яаж эхлэх учраа олохгүй байж. Хэт нарийвчилсан газрын зураг бодит байдалд хэрэг болдоггүйтэй адил юм уу даа.

Гэвч эдүгээ би чухам яаж өгүүлэхээ мэдэх болсоон. Эцсийн эцэст энэ бүхнээ нэгтгэхэд, ой тойноос минь алдагдах дөхсөн дурсамж, мартагдах нь холгүй мэдрэмжээ түүнтэй адил найдвар муутайхан цаасан дээр үзэг цаас холбон буулгах нь зөв бололтой.

Наокогийн тухай дурсамж бүдгэрэх тусам түүнийг ойлгох шиг болно. “Санаж яваарай!” гэсний учир начрыг эдүгээ л ухаарах шиг.

Тэр дурсамж минь баларч бүдгэрнэ гэдгийг мэдэж байсаан. Иймийн учраас л тэгж хүссэн биз ээ.

“Намайг битгий мартаарай. Байсан гэдгийг минь санаж яваарай.”

Тэр бүсгүй надад дурлаагүй учраас ингэж бодоход сэтгэлд уйтай.

Хоёрдугаар
Бүлэг

Эртээ мэт санагдах ч хориодхон жилийн өмнө юм. Тэр үед би оюутны байранд амьдарч байлаа. Арван найм хүрч, их сургуульд дөнгөж ороод байсан үе. Токиогийн талаар ямар ч ойлголтгүйн зэрэгцээ гэрээсээ анх удаа холдож буй надад эцэг эх минь санаа зовсондоо тэр байрыг олж өгсөн юм. Оюутны байранд хоол унд болоод ахуйн хэрэглээний аар саар зүйл бэлэн зэлэн болохоор хоёр хөгшин маань арван наймтай, юм үзээгүй банди яаж ийгээд амьдраад явчихна гэж үзэж л дээ.

Мэдээж зардал мөнгөний асуудал ч байлаа. Байр хөлсөлснөөс оюутны байранд суух нь хамаагүй хямд. Хөнжил хийгээд ширээний чийдэн байхад л болоод явчихна.

Болдог сон бол байр хөлсөлж, тухтайхан аж төрчих санаа байсан ч хувийн сургуулийн элсэлтийн хураамж, хичээлийн төлбөр, сар сарын ахуйн зардлаа бодоод эцэг эхдээ ам нээж зүрхэлсэнгүй. Эцсийн эцэст хаа ч амьдарсан ялгаа юу байх вэ.

Дотуур байр маань өндөрлөг газар байх агаад эндээс хотын орчин тойрон хачин сайхан харагдана. Оюутны хотхон нэлээд том, гадуураа бетонон өндөр хашаатай. Төв хаалганы үүдэнд наанадаж зуун тавин настай гэх өнчин шаталзай ургана. Дор нь зогсоод дээш харахад тэнгэр харагдахгүй.

Явган хүний зам энэ шаталзайг тойрч муруйгаад, шулуун болж цэцэрлэгийн дундуур үргэлжилнэ. Цэцэрлэгийн хоёр талаар гурван давхар төмөр бетон хоёр барилга сүндэрлэнэ. Олон цонхтой энэ хоёр барилга нэг харахад шорон болгож зассан орон сууц мэт, нөгөө харахад орон сууц болгон өөрчилсөн шорон шиг үзэгдэх ажээ.

Байшингуудыг хайш яайш, хар бараан гэхээргүй бөгөөд нээлттэй цонхоор радио сонсогдоно. Цонхондоо гандсан ч мэдэгдэхгүй цайвар өнгийн хөшигтэй.

Явган хүний замаар урагшлахад эндээс цаашхан хоёр давхар төв байр байна. Нэгдүгээр давхартаа хоолны газар, угаалгын газар, хоёрдугаар давхартаа концертын танхим, лекц, семинарын хэд хэдэн өрөө,

хэрэглээ нь тодорхойгүй тусгай хүлээн авалтын өрөөтэй. Төв байрны хажууд мөн л гурван давхар гуравдугаар байр байна.

Оюутны хотхоны ногоон талбайд энд тэндгүй зүлэг услах хоолойнууд гэрэл хугалан эргэлдэнэ. Төв байрны ард хөл бөмбөг, бэйсболын зориулалтаар ашигладаг талбай, теннисний зургаан талбайтай, ер нь л юм юм бүрдсэн газар.

Эндхийн нэг жигтэй зүйл гэвэл барууны үзэлтэй нэгнээр толгойлуулсан нэр нь үл мэдэгдэх сан оюутны хотхоныг хянаж байсан явдал юм. Надад энэ байгууллага их л хачирхалтай санагддаг байлаа.

Энэ байдал нь оюутны байрны дотоод журмаас нэвт шувт үнэртэнэ. Нэр нөлөө бүхий олон хүний хөрөнгөөр бүтсэн энэ сан хотхоныг “боловсролын үндэс суурийг бэхжүүлж, залуусыг улс орондоо хэрэгцээтэй хүн хүч болгон бэлтгэхийн” тулд “өөрийн хөрөнгөөр” цогцлоон байгуулжээ. Өнгөн дээрээ ийм ч үүний цаана чухам юу нуугдаж буй нь тодорхойгүй.

Хэн ч энэ тухай тодорхой ойлголтгүй байлаа. Зарим нэгэн үүнийг татвараас зайлсхийх, эс бол нэр төрөө өсгөх арга гэх атал нөгөө нэгэн дотуур байр барих нэрийдлээр нэгдүгээр зэрэглэлийн бүсэд газар луйвардаж авсан хэмээнэ.

Үүнээс гадна эл явдлыг илүү нарийн учиртай гэх хүн ч байлаа. Эдний хэлэх нь ээ, хотхоны залуусаар улс төр-эдийн засгийн хүрээнд бүлэглэл үүсгэх гэсэндээ ийм башир арга хэрэглэж буй ажээ.

Үнэн хэрэгтээ хотхонд энд амьдардаг тэргүүний залуусаас бүрдсэн тусгай эрхтэй нэгэн клуб үйл ажиллагаа явуулж, үүсгэн байгуулагчидтай сард хэд хэдэн удаа лекц семинар зохион байгуулах бөгөөд энэ клубт элссэн залуус ажилгүй суухын зовлон эдлэхгүй гэлцэнэ.

Энэ таамаглалууд хэр зэрэг бодитой эсэхийг мэдэхгүй ч “энд нэг л жигтэй дээ” гэсэн бодол өөрийн эрхгүй төрдөг байлаа.

Би энэ жигтэй газар 1968 оны хавраас 1970 оны хавар болтол хоёр жил амьдарсан ч яаж яваад энэ газар өдий удсанаа хэлж мэдэхгүй юм даа. Өдөр тутмын амьдралд баруун, зүүний үзэл, тэдгээрийн ариун үйлс, нүгэл хилэнц ерөөс чухал биш шүү дээ.

Хотхонд өглөө болгон далбаа мандуулах сүрлэг ёслол болж, мэдээжийн хэрэг төрийн дуулал эгшиглэнэ. Төрийн далбаа бадраах суурь гол цэцэрлэгийн төвд буюу аль ч байрны цонхоор харагдах газар байрлажээ.

Төрийн далбааг мандуулах ажлыг миний амьдардаг зүүн байрны комендант хариуцна. Манай комендант гэж жар орчим насны, өндөр нуруутай, мөнгөн сор татсан тун чиг ширүүн хар үстэй, борлосон хүзүүндээ уртаа гээчийн сорвитой, ширүүн харцтай нэгэн байлаа.

Комендантыг Наканогийн явган цэргийн сургууль дүүргэсэн гэлцэх агаад үнэн эсэхийг хэн ч мэдэхгүй. Түүнийг нэг оюутан дагалдах ч хэдэн тоотод суудаг, хэн гээч болохыг нь мөн л мэдэх хүнгүй. Би хоолны газар, угаалгын өрөөнд тэр залуутай таарч байсангүй. Оюутан эсэх нь ч тодорхойгүй. Гэхдээ оюутны дүрэмт хувцастай юм чинь оюутан л байх. “Накано”-той харьцуулбал туслах нь цайвар царайтай, намхан, махлаг залуу юм. Ингээд өглөө бүрийн зургаан цагт этгээд хоёр маань хотхонд төрийн далбаа мандуулна.

Оюутны байранд ороод эхэндээ би өглөө болгон зориуд зургаад босч энэхүү эх оронч ёслолыг ажигладаг байлаа.

Радиоогоор зургаан цаг болсныг зарлахтай уралдаад хоёул гол цэцэрлэгт үзэгдэнэ. Энэ үедээ “Дүрэмт хувцаст” оюутны дүрэмт хувцас, хар арьсан гутал, “Накано” хүрэм, цагаан пүүз өмссөн байна. “Дүрэмт хувцаст” хавтгай модон хайрцаг, “Накано” зөөврийн “Сони” хөгжим барина. Улмаар “Накано” хөгжмөө газар тавьж “Дүрэмт хувцаст” модон хайрцагнаасаа нямбайлан эвхсэн далбаагаа гаргаж “Накано”-д хүндэтгэлтэйгээр өгөхөд цаадах нь далбаагаа бэхлээд, “Дүрэмт хувцаст” хөгжмөө асаана даа.

“Кимигаё” (Япон улсын төрийн дуулал, орч)-гийн дуунаар далбаа өргөгдөж, “Сазарэ ишино о...” гэж эгшиглэхэд далбаа баганын тэхий

голд хүрч, “маадэ...” гэхэд дээд цэгтээ бадраад, манай хоёр далбаа өөд ширтэн номхон зогсоно. Сэвэлзүүр салхитай цэлмэг өдөр энэ бүхнийг харахад үнэхээр сүрдмээр.

Харин орой болж, далбааг буулгахад мөн л иймэрхүү ёслол үйлдэх ч энэ бүх үйл явц яг эсрэгээрээ давтагдана. Манай хоёр далбаагаа буулгаж, модон хайрцгандаа эвхэж хийнэ дээ.

Далбаагаа шөнө буулгадгийн учрыг би ойлгодоггүй байлаа. Төр улс шөнө дөлөөр ч оршин тогтносон хэвээр. Олон хүн шөнөөр ажилладаг. Төмөр замын засварынхан, таксины жолооч, ширээний үйлчлэгч, гал сөнөөгчид, албан газрын хамгаалагчид гээд л ... шөнийн ээлжийн ажилчид төр улсынхаа ач ивээлийг хүртэж чадахгүй гэхээр тун ч шударга бус санагддаг сан.

Гэхдээ энэ бүхэн тэр болгоныг чилээгээд байх чухал зүйл биш л дээ. Тунгааж шүүхгүй боловч хийх юмгүйдээ элдвийг эргэцүүлж бодохоос цаашгүй над шиг нэгэнд л иймэрхүү бодол төрөх биз ээ.

Оюутны байранд нэг, хоёрдугаар курсийнхэн өрөөндөө хоёулаа, гурав, дөрөвдүгээр курсийнхэн тус тусдаа нэг өрөөтэй. Хоёр хүний өрөө нь зургаан татамигаас ялимгүй урт зайтай, хаалган тушаанаа хөнгөн цагаан хүрээтэй цонхтой, нуруу нуруугаа нийлүүлж суугаад хичээлээ давтах сандал ширээтэй. Үүдний зүүн талд хоёр давхар ортой, эдэлгээ сайтай энгийн эд хогшилтой.

Сандал ширээнээс гадна хоёр шүүгээ, цайны жижиг ширээ, ханын тавиуртай. Өнгөтэй өөдтэй талаас нь харъя гээд ч энэ бүхнийг тохь тухтай гэхээргүй. Ихэнх өрөөний тавиур дээр транзисторын хүлээн авагч, үсний сэнс, ус буцалгагч, будаа агшаагч, найруулдаг кофе, дүрдэг цай, ёотон, бэлэн гоймон чанадаг тогоо зэрэг ойр зуурын сав суулга өрөөтэй.

Шохойдсон ханан дээр “Хэйбон Панч” сэтгүүлд гарсан сайхан бүсгүйчүүдийн зураг, хаа нэгтээгээс олж авсан порно киноны зурагт хуудсууд наалттай. Нэг оюутан гахай нийллэгийн зураг наасан байсан нь урьд хожид үзэгдэж харагдаагүй явдал байлаа. Оюутнууд ханандаа ихэвчлэн нүцгэн хүүхэн, залуу дуучид, жүжигчдийн зурагт хуудас

наана. Номын тавиур дээр сурах бичиг, толь бичиг болоод уран зохиолын ном өрөөтэй.

Эрчүүл амьдардаг газар болсон хойно эмх цэгцгүй, ундуй сундуй байх нь олонтаа. Хогийн савны ёроолд жүржийн хөгцөрсөн хальс, арваад санжийн зузаан үнстэй лааз хэвтэх агаад дутуу унтраасан тамхи уугивал шар айраг, эс бөгөөс кофе асгаж унтраах тул эхүүн үнэр ханхийнэ.

Өнгөр сууж толбо тогтсон сав суулга, гоймонгийн уут, шар айрагны шил, эсэн бусын таглаа хаа сайгүй хөглөрнө. Хогоо шүүрдэх сэтгэлтэй нэгэн байсангүй дээ.

Салхи гарвал шалан дээрх тоос босч, өрөө болгоноос эвгүй үнэр сэнхийнэ. Өрөө болгон тоос шороо, хөлс чийг холилдсон өөр өөр үнэртэй.

Хиртэй хувцсаа хэн хүнгүй орон доогуураа чихнэ. Хөнжлөө наранд хатаадаг нь байхгүй болохоор хөлсний эхүүн үнэр тэр хавиар нэг тархана. Одоо бодох нь ээ, хөл толгой нь мэдэгдэхгүй ийм байдалд халдварт өвчин гараагүй нь яамай.

Энэ бүхэнтэй харьцуулбал манай өрөө шарил хадгалах газар шиг гял цал хийсэн газар. Шалан дээр тоос татаж, цонхны шил загалтана гэж үгүй. Хөнжлөө долоо хоног болгон наранд хатааж, харандаануудаа үзэг балны саванд хийж, хөшгөө наанадаж сардаа нэг угаана. Хамт амьдардаг залуу маань жигтэйхэн цэвэрч нэгэн байсанд л хамаг учир оршино.

Ямар сайндаа би “Манай хүн хөшгөө хүртэл угаадаг” гэхэд итгэх хүн олдсонгүй. Хөшиг бол цонхны нэг салшгүй хэсэг гэж бодохоос биш угаах хэрэгтэй гэдгийг мэдэх хүн байсангүй.

Бүгд л түүнийг “Цаадах чинь гажиг шүү” гэх агаад бүр “Нацист, Довтлогч” хэмээн хочилно.

Манай өрөөнд сайхан бүсгүйчүүдийн зурагт хуудас ч байсангүй. Харин Амстердамын сувгийн зураг өлгөөтэй. Би нэг эротик зурагт

хуудас наавал Довтлогч “Ватанабэ, б-бийим юманд дургүй л дээ” гээд хуулж аваад, Амстердамын зургийг наачихаж билээ.

Би ч тэр садар зургийг өлгөө гэж зүтгэсэнгүй. Өрөөгөөр маань орж гарсан хүмүүс энэ зургийг хараад “Энэ чинь одоо юу вэ?” гээд дуу алдана.

“Довтлогч энэ зургаа хараад гар хангалга хийдэг!” гээд тоглоом шоглоомоор хэлсэнд бүгд итгэчихэв. Би ч сүүлдээ мань эрийг энэ зурагнаасаа таашаал авдаг гэж бодох боллоо.

Бүгд л намайг Довтлогчтой хамт нэг өрөөнд орсонд өрөвдөх боловч би түүнд тэгтлээ дургүйлхсэнгүй. Цэмцгэр суувал миний хэрэгт хошуу дүрэхгүй тул чих амар.

Мань хүн өрөөгөө цэвэрлэж, хөнжлийг минь наранд дэлгэж хатаагаад, хогоо хаяна. Завгүй үедээ гурван өдөр шүршүүрт орохгүй өнжвөл мань эр хамраа мушийлгаад усанд ор гэхээс гадна, үсээ засуулах, хамрынхаа үсийг авах талаар ч сануулаад авна даа.

Ганц төвөгтэй зантай нь манай хүн булан тохойгоос хорхой шавж олоод харчихвал хор цацаж, би гэж хүн хажуугийн “ундуй сундуй оромжинд” хорогдох хэрэг гарна.

Довтлогч улсын их сургуульд газар зүй судалдаг байлаа. Нүүр хагарсан даруйдаа:

- Би нөгөө га-га-газрын зураг судалдаг юмаа гэж билээ.

- Газрын зурганд дуртай юм уу?

- Тийм ээ. Их сургуулиа төгсөөд Улсын геодез зураг зүйн газарт орж зу-зу-зураг зохионо доо.

Хүн гээч амьтан юу эсийг мөрөөдөж тэмүүлдэг юм бэ дээ? Токиод ирээд гайхширсан анхны зүйл нь чухамдаа Довтлогчийн энэ хүсэл тэмүүлэл. Газрын зураг зурах сонирхолтой, хүсэл эрмэлзэлтэй хүн

олон байх шаардлагагүй ч ийм хүн огт үгүй гэмээнэ асуудал үүсэх нь мэдээж.

Гэхдээ л газрын зураг гэх болгондоо ээрч муурах хүнийг энэ салбарт хүч үзнэ гэхээр нэг л төсөөлөмгүй. Тэр хааяа түгдчих боловч газрын зураг гэх тоолондоо баараггүй ээрнэ.

- Харин ч-чи юу үздэг вэ?

- Драм.

- Драм гэхээр жүжиглэнэ гэсэн үг үү?

- Үгүй ээ. Зохиол бүтээл уншиж судална гэсэн үг. Расин, Ионеску, Шекспир гээд л...

- Шекспирээс бусдыг нь мэдэхгүй юм байна даа.

Би ч бусдынх нь тухай барагтай бол сонсоогүй, лекцийн конспектэн дээр бичсэн байсныг нь хэлсэн хэрэг.

- Чи жүжигт дуртай юмаа даа?

- Нэг их сонирхолтой биш ээ.

Хариулт маань түүнийг гайхшруулж орхив. Тэр гайхаж сандарвал улам их ээрнэ. Энэ үед би гэм хийсэн хүүхэд шиг сэтгэл эмзэглэсэн юм.

- Надад угсаатан зүй, дорно дахины түүх судлал гээд хаашаа ч орсон хамаагүй байсан юмаа. Тэгээд л драм судлалын ангид орчихсон.

Ингэж хэлсэн ч мань хүн учрыг нь олсонгүй.

-Ойлгохгүй юм. Би гэхэд га-га-газрын зурагт сонирхолтой. Тэгээд л энэ ангид орсон. Бүр Токиод ирж их сургуульд орсон. Су-сургалтын төлбөрийг маань шилжүүлдэг. Харин чи мэргэжилдээ сонирхолгүй...

Түүний бодол зөв учраас би үг хэлж төвдсөнгүй. Бид хоёр чүдэнзний модоор шодоод тэр дээд талын, би доод талын орон дээр унтахаар

боллоо.

Тэр цагаан даавуун цамц, хар өмд, хар хөх ноосон цамц өмсөж, үсээ богинохон засуулна. Өндөр нуруутай, өргөн шанаатай. Сургуульдаа дүрэмт хувцас, тас хар

өнгийн гутал цүнхтэй явна. Хэн ч харсан “барууны үзэлтэй амьтан” болохоор Довтлогч гэсэн хочтой болсон юм. Үнэн хэрэгтээ тэр улс төр сонирхдоггүй, хувцас сонгохоос залхуу нь хүрдэг учраас нэг хувцаснаасаа салдаггүй байлаа.

Довтлогч эргийн өөрчлөлт, хөмөр замын шинэ туннель гаргахаас өөр зүйл огт сонирхохгүй. Энэ тухайгаа ам хамхилгүй түгдрэхдээ түгдэрч намайг зугтгал, эс бөгөөс унтгал ам хамхилгүй ярина даа.

Мань хүн өглөө болгон зургаан цагт “Кимигаё”-гийн дуунаар босно. Бусдад харуулахаас цаашгүй энэ ёслол бас сайн талтай. Ингээд манай хүн босч хувцсаа өмсөөд, угаалгын өрөөнд орж, гучин хоёр шүдээ нэг бүрчлэн угаах мэт таг чиг алга болно.

Өрөөндөө ирээд алчуураа сэгсэрч, пааран дээр дэлгээд шүдний сойз, савангаа байр байранд нь тавьж, радио асаагаад дасгал хийнэ.

Би шөнө дөл болтол ном уншиж, өглөө найм хүртэл ухаангүй унтдаг болохоор түүнийг яаж ч түжигнээд, радиогоо асаасан ч ажирдаггүй. Гэхдээ үсрэлтийн дасгал хийхэд нь яалт ч үгүй сэрчихнэ. Тэгэхээс ч аргагүй. Учир нь манай хүн жигтэйхэн өндөр үсрэхэд ор доргино.

Хүнтэй хамт амьдрахад тэвчээр хэрэгтэй юм хойно эхний гурван өдөр би дуугүй л өнгөрлөө. Гэсэн ч дөрөв дэх өдрийн өглөө тэсвэр алдав.

- Чи наад дасгалаа дээвэр дээр хийвэл дээргүй юү? Үсрээд эхлэхээр чинь сэрчих юмаа гэхэд мань эр нүдээ дүрлийлгэн:

- Зургаа хагас болж байна шүү дээ гэв.

- Мэдэж байна аа. Гэхдээ зургаа хагаст би унтаж байдаг юм. Угаасаа сурчихаж.

- Дээвэр дээр гарвал гурван давхрынхан дургүйцнэ шүү дээ. Харин манай доор агуулах байдаг тул хэн ч юу ч хэлэхгүй.

- Тэгвэл гадаа зүлгэн дээр хий л дээ.

- Гадаа хийх боломжгүй ээ. Ра-радио маань транзисторынх биш болохоор залгуургүй бол ажиллахгүй. Хөгжимгүй бол дасгал яаж хийх вэ дээ?

Үнэндээ түүний радио гэж дэвэн галавын юм байлаа. Харин миний транзистор фм-ийн долгионоос өөр юм барихгүй. Би ёстой бүтэхгүй нь дээ гэсэн юм бодоод:

- Тэгвэл дасгалаа хийхдээ үсрэхээ л больчих. Чимээтэй гэдэг нь гэвэл мань эр амаа ангайлгаад:

- Ү-үсрэх ээ?

- Тийм ээ үсрэх. Өөдөө үсрэхийг чинь хэлээд байна гээд толгой өвдөж байсан ч хэлснээ тодруулахад илүүдэхгүй хэмээн сэтгэж, арга буюу босоод НК-гийн дасгалын дууг аялан, хэд хэд үсэрч үзүүлэв.

- Ингэсэн биз дээ?

- Тэ-тэгсэн л дээ. Ер а-анзаарсангүй.

Орон дээрээ суугаад:

-Энэ хэсгээ л больчих. Бусдаар бол наад дасгалаа хий дээ. Үсрэхээ болиод тайван унтуулаад орхи гэсэнд өөдөөс:

-Нэг хэсгийг нь хасчихаж болохгүй л дээ. Нэг хөдөлгөөнийг нь хасчихвал е-ерөөсөө хийж чадахгүй. Арван жил өнжилгүй хийсэн болохоор асаагаад л өөрийн мэдэлгүй бүгдийг нь хийчихдэг хэмээн шийдэмгий хэллээ.

Надад хэлэх үг олдсонгүй. Ийм хүнд юу ч гэмээр юм бэ дээ? Байхгүй хойгуур нь радиог нь цонхоор шидчихэж болох ч өөрийн гэсэн эд хогшлоо өр зүрхнээсээ илүү нандигнах Довтлогч галзуурч мэднэ!

Ингэж бодоод учраа олохгүй сууж байтал өөдөөс минь инээмсэглээд:

-Ва-ватанабэ, уг нь өглөө босоод хамт дасгал хийвэл аятай сан гэж аргадаад, өглөөний ундандаа явлаа.

Наокод Довтлогчийн талаар, өглөөний дасгалынх нь тухай ярихад тас тас хийтэл хөхөрч билээ. Инээдэм болгож ярья гэж бодоогүй ч би өөрийн эрхгүй дагаад инээв. Тэр үед би Наоког инээхийг харалгүй удсан байлаа.

Бид хоёр Ёцүягийн буудал дээр метроноос бууж, Ичигая чиглэн алхсан тэр өдөр таван сарын дундуур тохиосон Ням гараг байв.

Өглөө үе үе шаагиж орсон бороо үд гэхэд зогсчээ. Доошилж тогтсон бараан үүлс урд зүгээс сэвэлзэх салхины аясаар туугдана. Сакүрагийн навчис салхинд дэрвэлзэж, нарны гэрэлд гялтганана.

Нар зуны эхэн сар шиг ээж, зөрж өнгөрөх хүмүүс хувцсаа нимгэлж, мөрөндөө тохоод, эсхүл гартаа барьжээ. Үдийн халуун наранд хэн хүнгүй жаргалтай. Шороон овоолгын цаахна талын теннисний талбайд нэгэн залуу футболкоо тайлаад богино өмдтэйгээ явах ажээ.

Сандал дээр суусан хоёр гэлэнмаа л өвлийн хувцастайгаа байх нь тэр хоёрт нарны илч хүрэхгүй байгаа мэт санагдана. Гэлээ ч тэд сэтгэл тэнэгэр ярилцаж сууна.

Арван таван минут алхахад нуруу хөлөрч, би зузаан даавуун цамцаа тайлж футболкатайгаа үлдлээ. Наоко биеийн тамирын бүдэг саарал цамцныхаа ханцуйг тохойгоо гартал шамлав. гараараа бишгүй угаасан мэт гандсан цамц нь аятайхан өнгөтэй юм.

Нэлээн дээр түүнийг энэ цамцтай нь харсан байж болох ч би тэр болгоныг сайн санасангүй. Хэсэгхэн дурсамж сэдэрсэн гэх үү дээ. Тэр үед би Наоког нүд салгалгүй ажиж, сэтгэлдээ тээж явсангүй.

- Оюутны байранд ямар байна даа? Хүмүүстэй хамт амьдрах хөгжилтэй байна уу?

- Дөнгөж сар болсон болохоор сайн мэдэхгүй л байна. Гэхдээ дажгүй шүү. Тэсвэр алдахаар юм алга л байна.

Наоко ундны усны оргилуурын дэргэд зогсон уснаас нэг балгаад, өмднийхөө халааснаас цагаан алчуур гаргаж ирээд амаа арчлаа. Дараа нь гутлынхаа үдээсийг чангалав.

- Би тэнд амьдарч чадах болов уу?

- Дотуур байранд уу?

- Тийм ээ.

- Юу ч гэмээр юм бэ дээ. Хувь хүний зан чанараас шалтгаалах байх. Төвөгтэй зүйл бий нь ч бий. Этгээд дүрэм журам, хурууныхаа чилээг гаргах гэсэн амьтад, зургаа гучид дасгал хийдэг нөхөр гээд элдвийн л юм байна. Хаа сайгүй ийм гэж бодвол энэ бүхнийг анзаарахгүй. Орох оронгүй хэн ч амьдарчихна.

- Тэр ч тийм байх шүү.

Наоко ингэж хэлээд толгой дохиж, хэсэг зуур бодолхийлэн ямар нэг содон зүйл олж харсан мэт харцаараа төөнөлөө.

Гайхмаар тунгалаг нүдтэй юм. Энэ мөчийг хүртэл нүдийг нь ийм тунгалаг чинээ санасангүй. Сайтар бодвол нүд рүү нь эгцлэн харах боломж надад тохиож байсангүй. Бидхоёр анх удаа ийм удаан ярилцаж билээ.

- Оюутны байранд суумаар байна уу?

- Үгүй дээ. Зүгээр л олон хүнтэй амьдрах хэр бол гэж бодоод... нөгөө юу л даа... гэж хэлэнгээ Наоко үгээ олж ядан уруулаа хазалж дорвитой юм олсонгүй болтой санаа алдан:

- Мэдэхгүй юм даа. Явья гэсээр газар ширтэн харцаа бурууллаа.

Бид хоёрын яриа тасалдаж, тэр зүүн тийшявж, би араас нь алхав.

Би Наокотой жил тойрон уулзаагүй байсан бөгөөд тэр нэлээд турж, булцгар хацар нь хонхойгоод хүзүү нь нарийссан ч яс арьс болж өвдсөн мэт харагдсангүй. Турсан ч сайхан харагдаж байлаа. Булан тохойд нуугдаж байгаад бие хаа нь нарийссан шиг санагдаж билээ.

Тиймдээ ч урьдынхаасаа илүү үзэсгэлэнтэй болсон шиг. Энэ тухай хэлэх гэсэн ч эвлүүлж дийлэлгүй дуугүй өнгөрсөн юм.

Тэртээ өдөр Наоко бид хоёр төв шугамын метронд улаан халз мөргөлдөж билээ. Тэр кино үзэхээр, харин би Кандагийн номын дэлгүүр орохоор явж байсан юм. Тийм болохоор бид хоёрт товлосон зорилго байсангүй. Наоко бууя гэхэд нь дагаад буувал Ецүягийн буудал байж таарав.

Бид хоёрт аминчлан ярилцахаар юм үнэндээ байсангүй. Наоко чухам яагаад бууя гэснийг би ойлгоогүй бөгөөд яриа маань анхнаасаа л эвлээгүй юм.

Тэр метроноос буугаад үг дуугүй алхсанд би арга буюу дагалаа. Хоёул хүсвэл ойртож болох ч дөлсөөр алд хэрийн зайтай явав.

Би Наокогийн нуруу, шулуун хар үсийг нь ажин араас нь алхлаа. Наоко том бор хавчаараар үсээ хавчсан байх агаад эргэж харах тоолонд жижигхэн цагаан чих нь нүдэнд торно.

Тэр хааяахан эргэж хараад хэд гурван үг хэлэхэд би гэж амьтан заримд нь хариулж, заримд нь юү хэлэхээ мэдсэнгүй. Хэлсэн үгсийнх нь хэсэг бусгийг ер дуулсангүй. Үг яриа нь чихэнд минь хүрсэн эсэх нь түүнд хамаагүй ч юм шиг. Эргэж харж хэдэн үг хэлээд цааш алхана. Би тэнгэр сайхан байхад зугаалж л байя хэмээн бодож билээ.

Зугаалахад арай хурдан алхаж байсан ч тэр Иидабашигаас баруун тийш эргэж, Охорибата руу гараад, удалгүй Жинбочогийн уулзвар өнгөрч, Очяномизүгийн гүвээгээр даван Хонгод ирэв. Эндээсээ төмөр зам дагаж явсаар Комагомэ хүрлээ. Бид хоёрыг энд ирэхэд нар Хэдийн хэвийжээ. Хаврын дулаахан үдэш биднийг илбэн авав.

Наоко гэнэт ухаан орсон мэт:

- Бид хоёр хаана ирчихэв ээ? гэх нь тэр.
- Комагомэд. Хоёулаа тойрч яваад энд ирлээ.
- Яагаад энд ирчихдэг байна аа?
- Чи л ирсэн шүү дээ. Би дагаад л явсан.

Бид хоёр төмөр замын буудлын хажуугийн цайны газар орж, хөнгөхөн хооллоод, би ам ангасандаа нэг шар айраг уув. Хоолоо захиалаад идэж дуустлаа ам нээсэнгүй. Би алхсандаа ядарч, харин тэр ширээн дээр тохойгоо тавиад бодолд автана.

Зурагтын мэдээгээр ням гарагт цэнгээний газрууд дүүрэн хүнтэй хэмээнэ. Ёцүягаас Комагомэ хүрснээ санаад:

- Чи ч чанга хөлтэй юмаа.
- Гайхсан уу?
- Тийм ээ.
- Дунд сургуульд байхдаа арав, арван таван километр гүйж байсан юмаа. Багаасаа аавтайгаа Ням гараг болгон ууланд авирдаг байлаа. Чи мэднэ дээ, гэрээсээ гараад л уул хадтай болохоор хөл чангарсан байх аа.
- Чамайг хараад тэгж хэлэхээргүй шүү.
- Хүн бүр л намайг сул дорой амьтан гэж боддог юм. Анхны харцаар дүгнэж болохгүй шүү дээ.

Наоко ингэж хэлээд үл ялиг инээлээ.

- Харин би ядарсан шүү.
- Чамайг өдөржингөө чангаасан бол уучлаарай.

- Чамтай ярилцсан нь сайн боллоо. Бид хоёр өмнө нь хоёулхнаа ярилцаж байгаагүй шүү дээ.

Би ийн хэлсэн ч бодоод бодоод юу ярьснаа санаж чадсангүй.

Тэр ширээн дээрх үнсний савыг оролдонгоо:

- Хэрвээ чи дургүйцэхгүй бол, чамд төвөгтэй биш бол хоёулаа дараа нэг уулзах уу? Ийм юм ярих эрхгүй гэдгээ мэдэж байна л даа хэмээв.

- Ярих эрхгүй гэж юү гэсэн үг вэ?

Наоко гайхширсныг минь хараад минчийтлээ улайв.

- Юү ч гэмээр юм бэ дээ. Сайн мэдэхгүй байна.

Тэр ханцуйгаа тохой хүртэл шамлаад буулгалаа. Чийдэнгийн гэрэлд шууных нь шар үс алтран гялтганах ажээ.

- Ярих эрхгүй гэж хэлэх гээгүй юмаа. Арай өөрөөр хэлэх гэсэн юм.

Наоко ширээн дээр тохойгоо тулан хэлэх үгээ олж харах гэсэн шиг хананд өлгөсөн хуанлиг гөлөрнө. Үгээ олоогүй бололтой санаа алдан нүдээ аньж, хавчаараа оролдов.

- Санаа зоволтгүй ээ. Юу гэж хэлэх гэснийг чинь би ойлгож байна аа. Би ч чиний оронд байсан бол үгээ олохгүй биз.

- Дорвитойхон тайлбарлаж чадахгүй юм. Сүүлийн үед дандаа л ингэх юм. Нэгийг хэлэх гээд нөгөөг яриад. Эсвэл бүр эсрэгээр нь хэлээд л. Үг яриагаа засах гэхээр учраа олохоо байчихна. Тэгээд анх ярьснаа мартчихна. Бие маань хуваагдаад, нэгнээсээ зугтаад ч байгаа юм шиг. Өөрөө өөртэйгээ багана тойрч хөөцөлдөөд ч байх шиг. Нөгөө хэсэг маань хэлэх гэсэн үгийг минь булаагаад зугтаахад элдэж гүйгээд гүйцэхгүй юм.

Наоко намайг эгцлэн ширтэнэ.

- Ойлгож байна уу?

- Санаагаа яв цав илэрхийлж чадахгүйдээ хүн бүр цухалддаг шүү дээ.

Наоко энэ үгийг минь сонсоод гонсойх шиг боллоо.

- Тийм биш ээ гээд дуугаа хураав.

- Зүгээр ээ. Хоёулаа уулзъя. Би тэртээ тэргүй Ням гарагт хийх юмгүй. Явган явах ч тустай.

Бид хоёр Яманотэгийн метронд сууж, Шинжюкүгийн буудал хүрмэгц Наоко төв шугамын метронд шилжин суулаа. Тэр Кокүбүнжигийн түрээсийн жижигхэн байранд амьдардаг байлаа. Салж явахаасаа өмнөхөн:

- Би урьдынхаасаа өөр ярьдаг болж уу? гэсэнд:

- Жаахан өөрчлөгджээ. Гэхдээ үнэнийг хэлэхэд урьд нь бид хоёр ойр ойрхон уулзаж байсан ч сүйдтэй ярьж байгаагүй болохоор сайн мэдэхгүй юм даа.

- Тийм дээ. Хагас сайнд чам руу ярьж болох уу?

- Бололгүй яахав. Ярихыг чинь хүлээж байя.

Энэ бүсгүйг би ахлах сургуулийн хоёрдугаар ангийн хавраа анх харсан юм. Надтай ялгаагүй ахлах сургуулийн хоёрдугаар ангид сурдаг байлаа. Сургууль нь их цэмцгэр. Сурагчид нь хичээлээ сайн давтсан нэгнээ “болхи бүдүүлэг” гэсэн шиг л харна.

Наоко цорын ганц дотны найз минь болох Кизүкигийн найз охин байлаа. Тэр хоёр мэдээ орохын л салж чаддаггүй найзууд байсан бөгөөд таван алхмын зайтай амьдарцгаана.

Хар багаасаа нөхөрлөсөн болоод ч тэр үү, бусдад нээлттэй, нуугдаж булагнахгүй. Нэг нэгнийхээрээ орж гарч, гэрийнхэнтэй нь хамт хооллон, маажин тоглох нь элбэг.

Тээр жил Наоко хэд хэдэн удаа найз охиноо дагуулан дөрвүүлээ уулзсан юм даг. Бид амьтны хүрээлэн, усан сан орж, кино үзсэн сэн.

Наокогийн ангийнхан царайлаг боловч ихэмсэг зантай. Харин надад дэггүй аашилдаг ч чөлөөтэй ярьж болох ангийн охид маань илүү таалагдана.

Наокогийн ангийн хөөрхөн охид юу боддогийг би ухааж ойлгосонгүй. Тэд ч миний учрыг олоогүй биз ээ.

Ийм ч учраас Кизүки надтай хосын болзоонд явахаа больж, бид гурав хаа нэгтээ зугаалж, элдвийг хүүрнэн суудаг болсон юм.

Хачирхалтай ч, бид гуравт ингэх нь таатай байлаа.

Өөр нэгэн нэмэгдээд ирвэл гурвуул тавгүйрхэнэ.

Бид гурвын уулзалт миний хувьд зочин, Кизүки хөтлөгч, харин Наоко түүний туслах болсон телевизийн шоуг эрхгүй сануулна. Кизүки ямагт биднийг манлайлдаг байлаа.

Кизүки бусдыг шоглох нь олонтаа, биеэ тоосон гэж санагдахаар ч үнэн хэрэггээ сайхан сэтгэлтэй, шударга хөвгүүн. Гурвуулаа байхад тэр Наоко бид хоёртой ялгалгүй харилцаж, бид хоёрыг уйдаахгүй гэсэндээ хөгжөөнтэй яриа дэлгэнэ. Хэн нэгэн дуугаа хураавал тэр дор нь яриа өднө. Хажуунаас нь харахад ингэх нь төвөгтэй санагдавч Кизукигийн хувьд үүнээс амар юм байсангүй.

Кизүки торгон мэдрэмжтэй, уран цэцэн үгтэй. Сонирхол муутайхан яриа хөөрөөнөөс ч донж маягийг нь олох ховорхон чадвартай нэгэн байж дээ. Тиймээс ч түүний хажууд би өөрийгөө ихээхэн сонирхол татахуйц нэгэн болгон төсөөлж, баялаг амьдарсан мэт санагдана.

Гэсэн хэдий ч Кизүкиг нийтэч гэж хэлэхээргүй бөгөөд сургууль дээр тэр надаас өөр нэгэнтэй дотно харилцаж байсангүй. Толгой сийрэг, хэл ам сайтай хөвгүүн чухам яагаад олны дунд оролгүй, Наоко бид гурвын бэсрэгхэн

ертөнцөд бүхнээ төвлөрүүлж, хангалуун явааг би ухаардаггүй байлаа. Яагаад надтай нөхөрлөснийг мөн л ойлгосонгүй.

Би гэдэг хүн ганцаараа ном уншиж, хөгжим сонсох дуртай жирийн л нэгэн. Кизүкигийн анхаарлыг татахуйц гоц гойд юм надад ер үгүй.

Гэлээ ч бид хоёр тэр даруй нэг нэгнээ ойлгож, сайн найзууд болж билээ. Аав нь нэлээд үнэтэй үйлчилдгээрээ алдартай шүдний сайн эмч. Кизүки надтай танилцсан даруйдаа:

Ням гарагт хосын болзоонд явах уу? Найз охин маань охидын сургуульд сурдаг юм. Хөөрхөн охин дагуулаад ирнэ гэлээ.

Явъя.

Чухам энэ өдөр би Наоког анх харсан.

Бид хэд хэдэн удаа уулзсан бөгөөд Кизүкиг холдмогц Наоко бид хоёрын хэл яриа эвлэж өгөхгүй, юун тухай ярихаа мэддэггүй байлаа.

Үнэндээ Наоко бид хоёрт ярьчихаар юм байсангүй. Ус балгасан мэт дуугаа хурааж, юм уугаад, хуруу гараа оролдон Кизүкиг хүлээнэ. Кизүкиг ирмэгц яриа хөвөрнө дөө.

Наоко над шиг дуу цөөтэй, ярихаасаа илүүтэй сонсоно. Иймээс хоёулхнаа үлдэхэд таарч тохирохгүй гэхээс илүү ярих юмгүйдээ эвгүйрхэнэ.

Кизүкигийн ажил явдлаас хойш хоёр долоо хоногийн дараа би Наокотой уулзсан бөгөөд кафед суун хэрэг явдлаа ярьж дуусаад хэлэх үгээ олж ядсан сан. Элдвийн юм ярих гэж хичээсэн ч нэг л эвлэсэнгүй.

Наоко надад гоморхсон мэт ярих сонирхолгүй байлаа. Надад нэг л уурлаад байх шиг санагдсан ч, учрыг нь олсонгүй. Ингээд хаврын тэр нэгэн өдөр төв шугамын метронд Наокотой нүүр тулж билээ.

Кизүки сүүлийн удаа түүнтэй бус надтай уулзсанд Наоко гомдсон байж ч мэднэ. Ингэж хэлэхэд эвгүй ч гэлээ, сэтгэлийг нь ойлгох юм. Санаагаар болдог сон бол өөрийнхөө оронд Наоког уулзуулж болох л байж. Гэвч энэ бүхэн Хэдийн улиран өнгөрч дээ.

Сэтгэлийн минь хамгийн гүн дайдад үлдсэн таван сарын тэр сайхан өдөр Кизүки үдээс хойшийн хичээлээ тасалж биллиард тоглоё гэсэн юм. Үдээс хойш сонирхолгүй хичээлтэй болохоор би энэ санааг нь өлгөн авч хоёул сургуулиас гарлаа. Уруу замаар аажуухан алхсаар боомт хүрч, хажууханд нь байх биллиардын газар ороод, дөрвөн ч удаа биллиард тоглож билээ.

Эхний удаа би хөнгөхөн хожсон ч дараа нь гурав дараалаад хожигдов. Ингээд тохирсноороо би тооцоо хийлээ. Хачирхалтай нь, тэр өдөр Кизүки нэг ч удаа тоглоом шоглоом хийсэнгүй. Тоглож дуусаад амсхийнгээ тамхи сорлоо.

- Чи өнөөдөр их нухацтай байна шүү гэхэд Кизүки сэтгэл тэнэгэр инээмсэглээд:

- Өнөөдөр хожигдмооргүй санагдаад гэж билээ.

Тэр шөнө Кизүки гараждаа амьсгал хураасан N360-ынхаа янданд шланг углаад нөгөө үзүүрийг нь машиныхаа кабинд оруулж, цонхоо скочдоод мотороо асаасан байлаа. Амь тасартлаа хэр удсаныг бүү мэд.

Эцэг эх нь өвчтэй хамаатнаа эргэж ирээд машинаа тавихаар гаражийнхаа хаалгыг нээхэд тэр Хэдийн амьсгал хураасан байжээ. Машины радио дуугарч, шил арчигчинд нь шатахуун түгээх станцын тасалбар байсан гэдэг.

Анд минь гэрээслэл, сэжүүр гэхээр юм үлдээсэнгүй. Хамгийн сүүлд надтай уулзсан учраас цагдаагийнхан намайг дуудаж байцаасан юм. Мөрдөн байцаагчид “Ямар ч сэжиг төрөөгүй”, “Урьдынх шигээ байсан” гэхээс өөр хэлэх үг олдсонгүй.

Мөрдөн байцаагч Кизүки бид хоёрын тухай сайнаар бодоогүй нь лавтай. Хичээлээ таслан биллиард тоглодог хөвгүүн амиа хорлосонд тэр нэг их гайхсангүй.

Удалгүй сонинд товчхон мэдээ гарснаар энэ хэрэг хаагдаж, улаан өнгийн N360-ыг устгалд оруулаад, ангийн ширээн дээр нь нэг хэсэг цагаан цэцэг тавиаастай байлаа.

Кизүкиг нас барснаас хойш сургуулиа төгстөл арван сарын турш би яах учраа олсонгүй. Нэг охинд дурлаж, өвөр түрийдээ орсон ч хагас жил бололгүй холдлоо. Тэр надад гомдож туньсангүй.

Чадал хүрэх Токиогийн хувийн сургуульд элсэлтийн шалгалт өгч орлоо. Үүндээ сэтгэл хөөрч хөвсөлзсөнгүй. Нөгөө охин маань намайг Токио руу явуулахыг хүсээгүй ч би шинэ газарт шинэ амьдралд хөл тавихыг хүсэмжлэн, Кобэгоос явахын түүс болж байлаа. Түүнийг:

-Унтаж хэвтчихээд хаяж байгаа юм уу? хэмээн уйлахад нь би:

-Үгүй дээ гэхээс өөр үг хэлж чадсангүй.

Ердөө л тэр газраас холдмоор байлаа. Явах гэсэн хүслийг минь тэр охин ойлгоогүй учраас бид хоёр хөндийрсөн юм. Би Токио орох шинкансэнд бие галбирыг нь дурсан, сайн охиныг гомдоосондоо өөрийгөө зүхэж суулаа. Гэсэн ч өнгөрснийг эргүүлэх аргагүй болохоор түүнийг мартахаар шийдлээ.

Токиод ирж дотуур байранд амьдарч эхэлсэн надад аливаа зүйлд эмзэглэлгүй, сэтгэлээ татаж явах цор ганц зорилго бий.

Ногоон хилэнгээр бүрсэн биллиардын ширээ, час улаан N360, ширээн дээрх цагаан цэцэгс, чандарлах газрын өндөр яндангаас хаялах утаа, мөрдөн байцаагчийн ширээн дээрх зузаан хавтас... би энэ бүхнийг мартахаар сэтгэл шулуудсан юм.

Эхэндээ мартсан шиг санагдсан ч аажимдаа сэтгэлд минь хар үүл нүүгэлтэх шиг болж билээ. Цаг хугацаа улирахын хэрээр энэ үүл хэлбэржиж, **үхэл гэдэг нь энэ амьдралын нэгээхэн хэсэг** хэмээн тодрох шиг болно.

Үгээр илэрхийлэх амархан ч тэр үед энэ бүхэн сэтгэл зүрхийг минь сүлбэж байлаа. Тэр биллиардын ширээн дээрх дөрвөн ширхэг алаг бөмбөгөнд ч үхэл оршиж байжээ. Үнэндээ бид амьсгалын тоогоор үхэл рүүгээ ойртдог.

Тэрхэн мөчийг хүртэл би “Хүн гэдэг мөнх биш хойно нэгэн цагт үхэлтэй нүүр тулах нь мэдээж. Гэсэн ч Эрлэгийн элч хаалга тогших тэр өдрийг хүртэл бид амар амгалан амьдарна” хэмээн үхэл гээчийг амьдралаас хол тасархай зүйл мэтээр төсөөлдөг байж.

Амьдрал, үхэл хоёрыг зоосны хоёр тал шиг хүлээн авах нь миний хувьд жам ёсных байсан юм. Одоохондоо би зоосны нэг талд байгаа бөгөөд нөгөө талд нь гарах болоогүй хэмээн боддог байлаа.

Гэсэн ч Кизүкиг алдсан тэр шөнөөс хойш үхэл, амьдралын тухай урьдын адил энгүүнээр сэтгэж чадахгүй болсон. Гашуун ч гэлээ би үхэл гээч нь амьдралын нөгөө тал бус, миний оршихуйд ч мөн нуугдаж буйг ухаарч билээ. Арван долоотой байх ахуйн таван сарын тэр нэгэн өдөр Кизүки дээр ирсэн Эрлэгийн элч үнэн хэрэгтээ намайг ч атгандаа оруулжээ.

Эрийн цээнд хүрч, арван найман настай болсон тэр хавар энэ бодрол сэтгэл зүрхийг минь эзэмдэн авчээ.

Бодол санаагаа үлдэн хөөхийг хичээж байсан ч үнэн мөнөөс зугтааж буйгаа мэдэрч байлаа.

Үхэл гэдэг яах аргагүй бодитой зүйл. Тэр үед би энэ бодолдоо хичнээн ч их энэлэн шаналж явав. Эдүгээ эргэж дурсахад, тэр үесд амьдрал минь бүхэлдээ үхэл гээчийг тойрон эргэлдэж байсныг нуух юун.

Гуравдугаар
Бүлэг

Наоко бямба гарагт над руу залгаж ням гарагт уулзахаар болзлоо.
Энгийн л нэг болзоо.

Бид хоёр урьдын адил зугаалж, кофе уунгаа хоолонд орж, орой болуут гэр гэртээ харив.

Наоко урьдын адил хааяа нэг үг унагааж, би ч илүү дутуу юм ярьсангүй. Бид хоёр сургууль соёл, оюутны амьдралын талаар хэд гурван үг солилоо. Өнгөрснөө сөхөлгүй гудамжаар алхаж явлаа. Хязгаар нь үгүй Токиогийн өргөн гудамжаар алхахад таатай.

Удалгүй бид хоёр долоо хоног бүр уулзаж зугаалах болов. Наоко урд гараад алхална.

Тэр хэд хэдэн үсний хавчаартай бөгөөд баруун чих нь байнга нүдэнд тусна. Би түүнийг ихэвчлэн араас нь харж байсан болоод тэр үү, энэ дүр төрх сэтгэлд минь шингэн үлджээ. Наоко ичингүйрэхдээ хавчаараа оролдож, алчуураараа амаа арчина. Юм ярихаасаа өмнө амаа арчдаг зантай байсан даа. Би Наоког ажиглан, аажимдаа түүнд сэтгэл алдарч билээ.

Тэр Мүсашиногийн захад байрлах эмэгтэйчүүдийн их сургуульд сурдаг байлаа. Нэр хүнд сайтай энэ сургууль англи хэл маш сайн заадгаараа алдартай. Гэрийнх нь ойролцоо тунгалаг уст горхи урсаж, бид хоёр байсгээд л тийш очно.

Хааяахан Наоко намайг гэртээ урьж, хоол хийж өгдөг ч хоёулхнаа байгаагаа огт анзаарахгүй. Өрөө нь цэмцгэр бөгөөд цонхны хажуугийн буланд хатаахаар дэлгэсэн эмэгтэй хүний оймсыг анзаарахгүй бол бүсгүй хүн суудгийг таахын аргагүй.

Наоко найз нөхөд цөөтэй, нам жимхэн амьдарна. Сургуульд байхын содон хувцаслаж, найз нөхдөөрөө хүрээлүүлсэн, сэргэлэн цовоо охин өдөр хоногийг ингэж өнгөрөөнө гэдэгт би итгэж өгөхгүй байсан юм.

Тэр над шиг төрсөн гэрээ орхин, олны газарт шинэ амьдралаа эхлэхийг хүссэн нь илэрхий.

-Манай сургуулиас энд нэг ч хүүхэд ороогүй болохоор би элссэн юм. Хүн болгон л нэр хүндтэй сургуульд орохыг хүсдэг дээ?

Өдөр хоног улиран өнгөрч, Наоко бид хоёр бие биедэээнэгшин даслаа.

Зуны амралтын дараа шинэ улирал эхлэхэд Наоко урд алхахаа болиод мөр зэрэгцэн явах болов. Намайг найзаа болгож хажууд минь алхах болсонд би битүүхэндээ хөөрч билээ.

Бид хоёр Токиогийн гудамжаар харсан зүгтээ алхалж, уул нуруу, гол горхи, төмөр зам гаран зугаална. Зорьсон газаргүй ч гэлээ явган явах сайхан байлаа. Бороо шивэрвэл шүхрээ дэлгээд явна даа.

Намар болж оюутны хотхонд энд тэндгүй хайлаасны навч хөглөрнө. Хаа сайгүй намрын сэрүү уналаа. Би хуучин муу гутлаа хаяж, шведийн шинэ гутал авав.

Бид хоёр тэр үед чухам юу ярьдаг байсныг санахгүй ч урьдын адил өнгөрснөө сөхөж, Кизүкигийн тухай дурсдаггүй байлаа. Аанай л дуу шуугүй өөд өөдөөсөө харан цайлж сууна.

Би Наокод Довтлогчийн тухай ярилаа. Зургаан сард Довтлогч нэг удаа ангийнхаа охинтой болзож, тэр оройдоо их л гутруу орж ирсэн юм. Мань хүн намайг хал үзэж, хашир суусан хүн гэж бодсон бололтой “В-ватанабэ, б-болзоонд очоод юу яривал дээр вэ?” хэмээн асуув. Тэр үед би юу хэлж амыг нь тагласнаа одоо ч санадаггүй.

Долоон сард Довтлогч харьсан хойгуур хэн нэгэн Амстердамын зурагт хуудасны оронд Сан Францискогийн “Алтан гүүр”-ний зургийг өлгөлөө. Төдхөнөө өөр нэгэн цаст уулын зурагт хуудас наачихав. Энэ болгонд Довтлогч үймрэнэ гэж жигтэйхэн.

- Хэ-хэн энэ зургийг наачихав аа?

- Зүгээр л байна шүү дээ. Гоё зураг байна. Хэн ч наасан ямар хамаатай юм бэ?

- Тийм л дээ. Гэхдээ л эвгүй юм.

Довтлогчийн тухай энэ мэтийн паян ярихад Наоко тас тас хөхөрнө. Наоко ховорхон инээмсэглэх учраас би хүссэн хүсээгүй байн байн Довтлогчийн тухай ярих боллоо.

Жирийн айлын гутгаар хүү болох Довтлогч үнэндээ гүдэсхэн, шулуухан нэгэн. Газрын зураг зурах бяцхаан мөрөөдөлтэй энэ залуугаар хэн бугай ч тохуу хийх ёсгүй.

Гэсэн хэдий ч оюутны байраар “Довтлогчийн паян” шил шилээ даран тарж, Наоког инээмсэглэхэд сэтгэл сэргэнэ. Би өөрийн мэдэлгүй цуурхай амлан хөршийнхөө паянг тараадаг болсон доо.

Наоко нэг удаа намайг найз охинтой эсэхийг асуухад би хоёр тийш болсон найз охиноо ярьж, хамт байхад аятайхан байсан ч таарч тохироогүй холдсон гэлээ. Сэтгэлийн минь нандин утсыг хөндөх хүн тэр бүр байдаггүй хэмээгээд хэн нэгэнд ухаан алдтал дурлаж яваагүйгээ ч хэлж амжлаа.

- Чи дурлаж үзээгүй гэж үү?

- Үзээгүй л байна.

Үүнээс хойш Наоко энэ тухай дахиж ам нээсэнгүй.

Намар шувтарч, зэвэргэн салхи үлээх нь ихсэхэд Наоко намайг түшиж явах боллоо. Урт хүрэмнийх нь цаанаас халуун амьсгал нь мэдрэгдэнэ. Наоко чичирч даарсандаа халаасанд минь гараа шургуулж, гараас минь атгадаг байж билээ. Гэсэн ч дотносох хүсэлдээ намайг түшсэн гэвэл эндүүрсэн хэрэг.

Би ихэнхдээ гараа халааслаад алхана. Зөөлөн ултай гутлаараа унасан навчсан дээр гишгэлэхэд шүр шар хийхээс өөр чимээ гарахгүй.

Угтаа түүнд би биш, өөр нэгний халуун дулаан хайр энхрийлэл хэрэгтэй байсанд өөрийн эрхгүй Наоког өрөвдөж сэтгэл гонсойно.

Өвөл ойртоход Наокогийн нүд хичнээн тунгалаг болохыг би илүү мэдэрч эхлэв. Нүд рүү нь ширтэхэд амьдрал нь мухардсан шиг хачин мэдрэмж төрнө. Ямар нэгэн зүйл хайх мэт над руу ширтэхэд хүйт даах шиг болж, байж суух газраа олж яддаг сан.

Тэрбээр өөрийгөө ч ойлгохгүй, сэтгэлээ нээж дийлэхгүй байх шиг санагддаг байлаа. Тийм ч учраас дуугаа хурааж, хавчаараа оролдон, амаа арчиж, учраа олохгүй төөнөтөл ширтдэг биз дээ.

Наоког энгэртээ наахыг хүсч байсан ч сэтгэлийг нь эмзэглүүлэхээс эмээж зориг хүрсэнгүй. Иймээс ч хоёул Токиогийн гудамжнуудыг хөндлөн гулд хэмжиж, хий хоосон орчин тойрноос хэдэн үг олж холбохыг хичээдэг байлаа.

Наоког ярьсны дараа ням гарагийн өглөө эртлэн гарах бүрийд байрны маань нөхдүүд намайг нууц амрагтай болсон хэмээн доог тохуу болгоно. Ингэх нь ч аргагүй юм даа. Би бусдад долоон булчирхайгаа тоочих хүсэлгүй байсан учраас олны хэл амыг тоолгүй өнгөрөөв.

Орой ирэхэд хэрэгт дурласан хэн нэгэн ямар байрлалаар, яаж амрагласан, найз охин маань ямар өнгийн дотуур хувцастай байсныг асуух бөгөөд би тэр бүр булзааруулж дөнгөнө.

Хорвоогийн бор өдрүүд ээлжлэн өнгөрч, төрийн далбаа дээшилж доошилсоор би гэдэг хүн арван есөн нас хүрлээ. Ням гараг болгонд энэ хорвоог орхин одсон андынхаа найз охинтой уулзана. Өдгөө хийгээд цаашдаа юу хийх нь огтхон ч тодорхойгүй байлаа.

Их сургуульд бид Клодель, Расин, Эйзенштейнийг үзэж байсан ч сэтгэлд үлдсэн зүйл нэгээхэн ч үгүй.

Надад оюутан ахуйн найз гэхээр хүн байсангүй. Дотуур байрны хөршүүдтэйгээ хэд гурван үг солихоос цаашгүй. Ихэвчлэн ном уншиж суудаг намайг байрныхан маань зохиолч болно хэмээн сэтгэсэн ч надад үзэг цаас нийлүүлэх хүсэл төрж байсангүй. Хэн болох тухайгаа огт боддоггүй явж дээ.

Наоко намайг ойлгох болов уу гэсэндээ бодол санаагаа хуваалцъя гэж хэд хэд үзсэн ч хэл ам эвлэсэнгүй. Наокогийн хэлэх үгээ олж яддаг өвчин халдсан биш байгаа даа гэсэн бодол төрнө.

Бямба гарагийн орой би Наоког утасдахыг хүлээн лоббид суудаг байлаа. Оройдоо залуус хаа нэгтээ зугаацахаар явж, танхимд нам гүм байх ажээ. Энэ үед би гэрэл ажиглан, сэтгэл зүрхээ мэдрэхийг хичээнэ.

Өөрөөсөө чухам юүг эрэн хайж байна даа хэмээн түмэнтээ асуусан ч хариулж дийлсэнгүй. Анивалзах гэрлийн өөдөөс гараа сунгахад мэдрэгдэх юмгүй.

Олон цагаар ном шагайдаг байсан ч олон ном уншсангүй. Таалагдсан номоо ахин дахин унших нь олонтаа. Тэр жилүүдэд би Труман Капотэ, Жон Апдайк, Скотт Фицжеральд, Раймонд Шэндли нарын зохиолд хорхойсдог байсан даа. Гэсэн ч ангийнхан болоод байрныхан маань эдгээрийг сонссоноос цаашгүй байлаа. Тэд ихэвчлэн Такахаши Казүми, Кэнзабүро Оэ, Мишима Юкио болон францын орчин үеийн зохиолчдын уран бүтээлийг сонирхоно.

Ийм ч учраас тэдэнтэй хэл амаа ололцохгүй, арга буюу ганцаараа ном шагайж сууна. Сэтгэл гижигдсэн номоо хэд хэд уншаад, нүдээ анин тэр цаг үед уусна. Номон завсар гараа хавчуулаад суух энэхэн үесдээ би гэдэг хүн жаргалд умбадаг байлаа.

Арван найман настайдаа би Жон Апдайкийн Хүн гөрөөс-д ухаангүй дурлаж, хэд хэд уншаад улмаар сонирхол буурч, Скотт Фицжеральдын Аугаа Гэтсби-д хорхойсох болов. Таарсан хуудсаа унших бүр улам амтшиж, энэ бүтээлийг биширч явлаа. 1968 онд эл зохиолыг уншина гэдэг эсэргүү болохгүй юмаа гэмээнэ яавч сайшаагдах зүйл биш. Эдүгээ ч энэ бол миний хамгийн дуртай зохиол.

Шохоорхсон зохиолынхоо аугаа гайхамшгийг хүнтэй хуваалцахыг хүсэвч, тоож анзаарах хүн олдсонгүй.

Тухайн үед эргэн тойрны минь ганц хүн энэ зохиолыг уншсан байсан нь Токиогийн их сургуулийн хуулийн ангийн гуравдугаар курсийн оюутан Нагасава. Бид хоёр энэ номоор холбогдож нөхөрлөсөн сөн. Нэг

байранд сууж байсан болохоор зүс таних ч нэг удаа намайг хоолны газарт сууж байтал мань хүн уншиж байгаа номыг маань сониучирхан асуусан юм. Би Аугаа Гэтсби-г уншиж байна гэхэд сонирхолтой эсэхийг нь лавлав. Гуравдахь удаагаа уншиж байгаа ч улам бүр татагдаж буйгаа хэлбэл Нагасава:

-Аугаа Гэтсби-г гурав уншсан хүнтэй найзлахад болохгүй гэх газаргүй хэмээн хэлсэн дээ. Бид хоёр ийнхүү арван сарын нэгэн өдөр андын холбоо тогтоосон юм.

Нагасаваг таньж мэдэхийн хэрээр би гайхширдаг байлаа. Энэ яваа насандаа нэлээдгүй хүнтэй учирч явсан ч хувь заяа намайг түүн шиг гайхалтай хүмүүнтэй зөрөлдүүлж байсангүй. Тэрбээр номын хорхойтон байсан бөгөөд миний хувьд хаана нь ч хүрэхгүй. Нагасава энэ хорвоогоос халиад гучин жил өнгөрөөгүй зохиолчдын номыг барьж авдаггүй байлаа. Тэрбээр ийм зохиолуудад итгэдэггүй байсан юм.

Орчин цагийн уран зохиолд итгэдэггүй дээ биш л дээ. Амьдрал богинохон. Цагийн аясыг давж гараагүй ном зохиол уншиж цаг алдмааргүй байна гэдэг сэн.

- Чи ямар зохиолчдод дуртай вэ?

- Бальзак, Данте, Жозеф Конрад, Диккенс гэж нэг амьсгаагаар хариулав.

- Орчин үеийн хүн алга шив.

- Тийм болохоор л дуртай. Бусдын уншдаг номыг уншвал тэдэн шиг л сэтгэдэг болно. Хоцрогдсон, бодох санах юмгүй хүмүүс л тэгдэг юм. Эрүүл саруул хүн бол өөр шүү, Ватанабэ. Манай байранд бид хоёроос өөр эрүүл ухаантай хүн байхгүй. Бүгдээрээ хог шаар гэсэнд эгдүү хүрч:

- Чи яаж мэдэж байгаа юм бэ? гэвэл мань хүн:

- Духан дээр нь биччихсэн байхад харваас ойлгомжтой. Бодох ч шаардлагагүй. Тэгээд ч бид хоёр л Аугаа Гэтсби-г уншсан даа?

Би Скотт Фицджеральдын нас барсан он сарыг тооцоод:

- Скотт Фицджеральд чинь хорин найман жилийн өмнө нас барсан шүү дээ гэвэл Нагасава:

- Хоёр жил бол юу ч биш. Түүн шиг сайн зохиолчийг уншихад гэмгүй хэмээв.

Байрныхан Нагасаваг толгой сайтай гэхээс сонгодог уран зохиол уншдагийг тэр бүр мэдэхгүй бөгөөд мэдлээ ч тоох хүнгүй.

Нагасава толгой өвдөлгүй Токиогийн их сургуульд элсэж, сайн сурдаг байлаа. Тэрбээр төрийн албаны шалгалт өгч, Гадаад хэргийн яаманд дипломатч болохоор эрмэлзэнэ.

Аав нь Нагояд том эмнэлэгтэй, Токиогийн их сургуулийн анагаахын факультетыг төгссөн ах нь эцгийнхээ ажлыг өвлөх болжээ. Нагасавагийнх чинээлэг болохоор мөнгөөр дутахын зовлонгүй. Нүдэнд дулаахан залуу. Хэн хүний хүндлэл хүлээсэн. Тэр байтугай комендант түүнд их зан гаргахгүй. Хүн бүр л түүний гуйсан болгоныг биелүүлэхийг хичээнэ. Тэгэхээс ч аргагүй.

Бусдыг өөртөө татаж, дагуулах төрөлхийн авьяастай. Бусдаас илүүрхэж, нөхцөл байдлыг шуурхай дүгнэж, зөв зүйтэй тийш нь чиглүүлээд, араасаа дагуулдаг.

Тэрбээр сахиусан тэнгэр мэт шидийн эрч хүчтэй байсан нь хүн болгонд өөрийн эрхгүй “Энэ залуу үнэхээр онцгой” гэсэн бодол төрүүлнэ.

Иймээс ч Нагасава хүн анзаарамгүй над шиг амьтантай нөхөрлөсөнд хэн хүнгүй гайхширсан юм. Үүнээс болоод тэр үү танихгүй залуус намайг хүндэлж харьцах болов. Бид хоёрын андын холбооны утга учир маш энгийн гэдгийг тэд гадарласангүй.

Би Нагасаваг хүндэлж зусардсангүй, сурлага сайтай, эрч хүчтэй, өв тэгш царай зүстэйд нь атаархаж шунасангүй. Зөвхөн хувь хүнийх нь этгээд зан чанарт татагдаж байсан учраас сонирхлыг нь татсан биз ээ. Энэ байдал минь түүнд этгээд сонин санагдсан байх талтай.

Нагасава өөр хоорондоо эрс тэс гэмээр зан чанартай нэгэн байлаа. Энэрэнгүй занд нь хааяахан сэтгэл хөдөлнө. Ярилцахад аятайхан ч хорон үг хавчуулах нь олонтаа. Оюунлаг хэрнээ бэртэгчин. Бусдыг уриалан дагуулах ч сэтгэл зүрхэндээ бүгшсэн хар намгаасаа мултарч чаддаггүй.

Түүний энэ эсрэг тэсрэг зан чанарыг би анхнаас нь олж харсан ч бусдын анзаараагүйд гайхширна. Тэр залуу өөрийн гэсэн тамын тогоондоо амьдардаг байж дээ.

Угтаа би түүний чин шударгуу зан чанарт татагдсан юм. Нагасава худал хэлдэггүй, нэр сүрийг нь гутаасан ч алдаагаа хүлээн зөвшөөрдөг хүлцэнгүй нэгэн. Надтай ямагт эелдэг харьцаж, тусалж дэмжих нь олонтаа. Одоо бодоход, түүнгүйгээр оюутны байранд хэцүүхэн байх байсан даа.

Харин Кизүкигээс ялгаатай нь би түүнд сэтгэлээ дэлгэсэнгүй. Архинд хөлчүүрхэн нэг бүсгүйтэй балмад харилцахыг нь хараад сэтгэлээ нээх хүн биш хэмээн бодох болж билээ.

Тэр үед байранд Нагасавагийн тухай домог мэт хэдэн цуу яриа тархсан байлаа. Эдгээрийн нэг нь түүнийг хоёр гурван нялхан хорхой залгисан, нөгөө нь маш том бэлэг эрхтэнтэй гэх агаад зуугаад бүсгүйтэй орооцолдож явсан гэх.

Тэр үнэн хэрэгтээ нялхан хорхой залгисан байжээ.

- Гурван хорхой залгисан юм.

- Яагаад залгисан юм бэ?

- Хүнд нөхцөлд орсон. Намайг энд ирэхэд курсийн ялгаа байлаа. Есөн сард юмуу даа. Би ахлах курсийнхэнтэй учраа олохоор шинэ

оюутнуудыг төлөөлөөд очсон юм. Кэндогийн саваа барьсан “Барууныхны” залуустай яаж хүч үзэх вэ дээ. “Хэлснийг чинь хийе. Тэгээд хал балгүйхэн хоёр тийш больё” гэсэн чинь нөгөөдүүл “Нялхан хорхой залгичих” гэдэг юм байна. Би ч зөвшөөрөөд новшнуудын олж ирсэн томоо гээчийн гурван хорхойг нь залгисан юм.

- Ямар байсан бэ?

- Ямар олиг байхав. Залгиж үзээгүй хүн мэдэхгүй л дээ. Хүйтэн юм хоолой давж ходоод руу ороход ч эвгүй. Дараа нь аманд гашуу амтагдаад, хүсэх юм биш ээ. Бодохоор л зарсхийдэг юм. Бөөлжихгүй гэж их хичээсэн дээ. гаргачихвал дахиад л залгих болохоор тэвчсэн.

- Тэгээд яасан?

- Өрөөндөө орж давстай ус уусан. Өөр яахав.

- Ёстой нэг...

- Үүнээс хойш дээд курсийнхэн хүртэл өөдөөс минь үг хэлэхээ больсон юм. Надаас өөр тийм хорхой залгих хүн байхгүй шүү.

- Тийм дээ.

Төд удалгүй бид хоёр хамт шүршүүрт орж, үнэн хэрэгтээ л том эрхтэнтэйг нь мэдэж авлаа. Харин зуугаад бүсгүйн тухайд цуу ярианаас цаашгүй, далаад л бүсгүйтэй энгэр зөрүүлсэн гэж билээ. Би нэг л бүсгүйтэй дотно байсан гэвэл мань хүн:

- Дараа хамт гарна аа. Үүн шиг амархан юм гэж хаана байна аа? ХЭМЭЭВ.

Тэр үед би Нагасавад итгээгүй ч бодит байдал дээр энэ нь үнэндээ амархан байж таарсан юм. Энгэр зөрүүлэх ийм амархан гэдэгт итгэж өгсөнгүй. Бид хоёр Шибүя, эс бөгөөс Шинжюкүд товлосон газартаа орж хоёулаа суух бүсгүйчүүдийг эргүүлнэ. Азаар энэ хорвоо хоёулаа яваа бүсгүйчүүдээр дүүрэн байх юм. Ингээд хамт ууцгааж, зочид буудал орж, эр эмийн ажил хийхээс өөр замгүй болно доо.

Нагасава хэл амаа билүүдэхгүй ч бүсгүйчүүд түүнийг ам нээнгүүт ярианд нь мансуурч, толгой алдан, согттолоо уугаад өвөрт нь орно.

Үүний сацуу нүдэнд дулаахан, анхаарал халамжтай, мэдрэмжтэй залуугийн хажууд эмэгтэйчүүд таашаал авах нь мэдээж. Хачирхалтай нь, түүний хажууд байхдаа би ч царайлаг болсон шиг санагдахыг яана. Нагасавагийн яриаг өлгөн авахад бүсгүйчүүд намайг аанай л жигтэйхэн шохоорхож инээлдэнэ. Тэр бусдад илбийн юм шиг л нөлөөлдөг байсанд би гайхдаг байлаа.

Харин Кизүки түүний хажууд амны салиа нь арилаагүй жаахан хүүхэд шиг байж дээ. Нагасаватай байсан ч би Кизүкиг үгүйлсээр. Кизүки уужуу сэтгэлтэй нэгэн байсныг ахин дахин мэдрэх шиг болж байлаа. Анд минь Наоко бид хоёрт байдаг чадлаа үзүүлэхийг хичээдэг байж дээ.

Үүнтэй харьцуулахад Нагасава хүн болгонтой тоглох мэт өөртөө татаж, өөдөөс нь харах бүсгүйтэй чин сэтгэлээсээ бус тоглоом шоглоомоор энгэр зөрүүлдэг шиг санагдана.

Би зүс танихаас цаашгүй бүсгүйчүүдтэй нэг хөнжилд орох сонирхолгүй байсан ч дур хүслээ дарахын тулд хэд хэд зугаацав. Бүсгүй хүний бие хааг мэдэрч, тэврэлдэж суух сайхан шүү дээ.

Маргааш өглөө нь хоёр тийш болоход сэтгэл тавгүйрхдэг байлаа. Өглөө сэрэхэд өвөрт минь танихгүй бүсгүй унтах бөгөөд архины эхүүн үнэр сэнхийж, эрээн мяраан хямдхан зочид буудлын өрөөнд шартах гээчийн үйлийн үрийг үзнэ дээ. Удалгүй нөгөө бүсгүй сэрж дотуур хувцсаа хайн “Жирэмслэх үе маань юмсан. Өчигдөр бид хоёр нөгөө юу хийж унтсан биз дээ?” гээд энэ тэрүүгээр гүйж, шалаар хөглөрөх дотуур хувцсаа цуглуулна. Ингээд толгой өвдөж, будаг шингэхгүйгээ гайхан, уруулаа будаж, хиймэл сормуусаа наана.

Энэ бүхэнд миний дургүй хүрнэ гэж жигтэйхэн. Хамт хонохыг хүсдэггүй ч арван хоёр цагаас өмнө буюу оюутны байрны хаалга барихаас өмнө охидын толгойг эргүүлж амжихгүй нь ойлгомжтой. Тийм ч учраас тэр шөнөдөө чөлөө авч, аргагүйн эрхэнд өглөө болтол

буудалд орогнож, өөрийгөө жигшсээр байрандаа орно. Нарны гэрэлд нүд гялбан, ам ангаж, толгой салчих шиг болно доо.

Энэ маягаар Нагасаватай гурав, дөрвөн удаа явлаа. Нагасавагаас далан бүсгүйтэй энгэр зөрүүлсэн ч дахиад ингэхээсээ жигшдэггүй юм уу? гэхэд:

- Жигшиж байна гэдэг чинь эрүүл саруул ухаантай байна гэсэн үг. Баярлууштай хэрэг шүү. Дөнгөж танилцсан хүнтэйгээ унтахад ядарч сульдаад өөрийгөө жигшихээс өөр юм нэмэгдэхгүй. Би ч дургүй хүрдэг л юм хэмээв.

- Тэгээд юунд нь болж охин эргүүлдэг юм бэ?

- Мэдэхгүй юм. Достоевскийн мөрийтэй тоглоомын тухай бичсэнийг уншсан уу? Эргэн тойрон ийм юм байхад өөрийгөө татаж авч дийлдэггүй гэх үү дээ.

- Нээрээ ч тийм юм уу?

- Орой болж охид хаа сайгүй хийх юмаа олж ядаад, нэг л юм хайж ууж суухад нь би гэдэг хүн нөгөө юмыг нь өгч чадах болохоор ор хөнжлийн ажил ус уухаас ер ялгаагүй. Бүсгүйчүүд өөрсдөө өвөрт орохыг хүсдэг шүү дээ. Амандаа орсон шар тосыг хэлээрээ түлхэж болдоггүй гэдэг шиг ийм юмыг тойроод өнгөрч болохгүй. Чадал чансаагаа гайхуулах боломж гарч байхад зөрөөд өнгөрнө гэж үү?

- Би ингэж яваагүй болохоор сайн мэдэхгүй юм даа.

- Энэ талаараа чи ч азтай шүү!

Ар гэр нь чинээлэг хэрнээ дотуур байранд суудгийн учир нь хүүхэмсэг зантайд нь байж.

Эцэг нь хүүгээ Токиод ганцаараа амьдарвал бүсгүйчүүдтэй орооцолдож хөл алдана гэсэндээ түүнийг дөрвөн жил оюутны байранд зориуд суулгажээ.

Харин мань хүн дотуур байрны дүрэм журмыг хайхралгүй зоргоороо амьдардаг байлаа. Тэр хүссэн үедээ гадуур хонох чөлөө авч, “ан хийж”, найз охиныдоо хонохоор явна. Ерөөс гадуур хонох чөлөө авах хэцүү боловч Нагасавад энэ журам үйлчлэхгүй. Түүний буянаар би гэж хүн төвөггүйхэн чөлөө авна.

Нагасава найз охин Хацүмитэйгээ их сургуульд орсон цагаасаа үерхэж, бид хэд хэдэн удаа уулзсан юм. Хацүми их аятайхан бүсгүй байж таарлаа.

Нүдэнд тусмаар царайлаг гэж хэлэхээргүй, жирийн охин байсанд мань Нагасава яаж тоосон юм бол гэж бодсон сон. Гэсэн ч хэд гурван үг солиод сэтгэл татагдана. Уужуу сэтгэлтэй, ухаан саруул, хошин шогийн мэдрэмжтэй, хүн ойлгодог дэгжин бүсгүй.

Хацүми надад их таалагдаж, ийм найз охинтой бол өөр нэгэнтэй цаг нөгцөөхгүй хэмээн бодож билээ. Тэр ч надад талтайн зэрэгцээ клубийнхээ найз охинтой танилцуулахыг оролдоно. Гэсэн ч би урьдын алдаагаа давтахгүйг хичээж, ялих шалихгүй шалтаг зааж бултана. Хацүми чинээлэг айлын охид явдаг их сургуульд сурдаг байсан учраас тиймэрхүү охидтой яриа нийлэхгүй нь ойлгомжтой.

Тэрээр Нагасаваг өөр бүсгүйчүүдтэй зугаацдагийг мэдэх боловч энэ тухай нэг ч үг унагахгүй. Нагасаваг чин сэтгэлээсээ хайрлаж, юу ч шаардахгүй. Нагасавагийн “Надад ахадсан бүсгүй дээ” гэсэнтэй би санал нэгтэй байсан юм.

Тэр өвлөөс би пянзны дэлгүүрт цагаар ажиллах боллоо. Цалин багатай ч хөнгөхөн ажилтай, долоо хоногт гурван удаа шөнийн ээлжинд гарна. Далимаар нь хямдхан пянз авчих боломжтой.

Зул сарын баяраар би Наокод түүний дуртай Хэнри Манцинигийн Dear Heartдуутай пянз авч өглөө. Пянзаа цаасанд боож улаан туузаар ороов. Харин Наоко надад нэхсэн бээлийгээ бэлэглэсэн юм. Эрхий хуруугаараа жаахан бариу ч дулаахан бээлий. Наоког улаа бутран:

- Би сайн нэхэж чаддаггүй юмаа гэхэд би:

- Зүгээр ээ. Таарч байна гээд өмсөж үзүүлэв.

- Наадахаа өмсөөд гараа халааслахаа болино биз?

Тэр өвөл Наоко Кобэ руу харьсангүй. Би ч оны сүүлээр ажлаа хийгээд Токиод үлдлээ. Кобэ явсан ч тэнд уулзаж учраад байх сонин содон хүн байхгүй.

Оюутны байрны хоолны газар Цагаан сараар үүдээ барьж би Наокогийн хооллох болов. Бид хоёр мочи шарж, мочитой ногоотой шөл хийж уулаа.

1969 оны нэг, хоёр дугаар сар үйл явдлаар дүүрэн өнгөрсөн юмдаг.

Нэгдүгээр сарын сүүлээр Довтлогч дөч хүртэл халуурч хэвтэрт орсноос болж Наоко бид хоёрын болзоо өнгөрлөө. Би ихээхэн чармайсны эцэст Брамсын 4-р симфонийн концертын хоёр тасалбар олоод Наоког урьсан юм. Наоко энэ симфонид дуртай болохоор тэр өдрийг тэсэн ядан хүлээж байлаа.

Гэсэн ч Довтлогчийн бие муудаж, орон дээрээ хөрвөөгөөд, байж суухын аргагүй харагдахаар нь орхиод явж чадсангүй. Довтлогчийг надаас өөр халамжлах хүн үнэндээ байсангүй. Би мөс худалдаж аваад, хэдэн давхар гялгар уутанд хийж, толгойд нь жин тавиад, хүйтэн алчуураар хөлсийг нь арчиж, цаг тутам халууныг нь хэмжиж, цамцыг нь сольж суулаа.

Халуун нь өдөржингөө буусангүй. Хачирхалтай нь, мань эр маргааш өглөө нь сэмбэлзтэл босоод дасгалаа хийв. Халууныг нь хэмжвэл 36,2 байсанд нүдэндээ итгэсэнгүй. Довтлогч надаас болж халуурсан янзтай:

- Сонин юм. Өдий хүртэл ингэж их халуурч байсангүй гэсэнд би нөгөө хоёр тасалбараа харуулаад:

- Жигтэйхэн их халуурсан шүү дээ! хэмээлээ.

- Худалдаж авсан биш урилгын тасалбар юм чинь зүгээр дээ гэхэд нь радиог нь аваад шидчихмээр санагдсан ч хөнжилдөө буцаад шургав.

Хоёрдугаар сард хэд хэдэн удаа цас хаяллаа.

Сарын сүүлээр би манай давхрын ахлах курсийн нэг оюутантай маргалдаж, зодоон хийсэнд өнөөх нь толгойгоороо хана мөргөөд сүйдтэй гэмтээгүй ч комендантад дуудагдлаа. Нагасава нөхцөл байдлыг намжаасан ч комендантаас банга хүртэж, дотуур байрны аж амьдрал минь бага зэрэг хүндрэв.

Нэгдүгээр курсээ дүүргэж хавар боллоо. Би хэд хэдэн хичээлдээ унаж, үлдсэн хичээлийнхээ ихэнхэд нь “С”, “D”, ганц хоёрхон “В” авч гавьтай амжилт гаргасангүй. Харин Наоко нэгдүгээр курсээ амжилттай төгслөө. Алтан наран ургаж, алаг дэлхий эргэсээр дахин нэг жил тойров.

Дөрөвдүгээр сарын дундуур Наокогийн хорин насны төрсөн өдөр тохиосон юм. Би арван нэгэн сард төрсөн учраас Наоко надаас долоон сараар эгч гэсэн үг.

Наоког хорьтой гэж бодохоор хачин жигтэй ч юм шиг. Арван найм, естэй байх нь түүнд илүү зохих шиг санагдана.

Хүн ер нь арван найм, есөн насандаа эргэлдээд байдаг бол сайхан шүү. Арван найм, арван ес, эргээд арван найм гээд л. Гэсэн ч тэр хорь хүрлээ. Намар болоход би гэдэг хүн мөн энэ босгоор алхана. Нөгөө ертөнц рүү одсон Кизүки л арван долоотой үлдэж дээ.

Наокогийн төрсөн өдрөөр бороо зүсэрч байлаа. Тэр өдөр би хичээл тарсны дараа бялуу авч, метронд суугаад тэднийх рүү явсан юм. Би түүнд хорин насны төрсөн өдрөө тэмдэглэх хэрэгтэй гэж билээ. Миний бодлоор хорьж болохгүй хорин насаа ганцаараа угтана гэдэг байж боломгүй зүйл.

Ингээд метронд чихэлдсээр Наокогийн ирвэл бялуу маань Римийн Колизей шиг налчийжээ. Гэсэн ч бэлдсэн хорин лаагаа зоож чүдэнзээр асаагаад, хөшгөө хааж, гэрлээ унтраахад баярын уур амьсгал орлоо. Наоко дарс задалж, бид хоёр дарс уун, бялуугаа амталж, оройн хоолоо идлээ.

- Ингээд хорь хүрдэг юм байжээ. Хорьтой гэж бодохоор нэг л санаанд багтахгүй юм. Ямар ч бэлтгэлгүй байгаад хүнд хөөгдсөөр хорь хүрчихсэн ч юм шиг.

- Харин надад бүтэн долоон сар бэлдэх цаг байна.

- Чи ч азтай! Арван естэй!

Хоолоо идэнгээ би Довтлогчийн авсан шинэ цамцны тухай ярьлаа. Тэр ахлах сургуульд өмсөж байсан хар хөх өнгийн нэг л цамцтай. Мань эр энгэртээ бугын зурагтай улаан алаг цамц авсан бөгөөд цамц нь дэгжин боловч харсан болгон өөрийн эрхгүй инээж шоолно. Хүмүүс чухам яагаад инээгээд байгааг Довтлогч ойлгохгүй байлаа. Цайны газарт сууж байтал Довтлогч дөхөж ирээд:

- Ватанабэ, б-би зүгээр байна уу? Нүүрэн дээр юм наалдчихаж уу? гэхэд нь би инээдээ барьж ядан:

- Зүгээр байна аа. Гоё цамц байна шүү гэлээ.

- Баярлалаа.

Наоко Довтлогчийн тухай сонсох дуртай л даа.

- Нэг уулзах юм сан.

- Болохгүй ээ. Чи шоолно.

- Шоолохгүй ээ.

-Хамт амьдардаг би хүртэл инээдээ барьж дийлэхгүй байхад чи тэсэхгүй ээ.

Бид хоёр хоолоо идчихээд, аяга тавгаа хурааж, дарсаа шимэн шалан дээр суулаа. Нэг хундага уух зуур Наоко хоёрыг ууж, өөртөө нэмээд хийчихэв.

Тэр өдөр Наоко хүүхэд ахуй, сургууль соёл, гэр бүлийнхээ талаар ам хамхилгүй ярьж билээ. Чимхлүүр зураг зурах мэт нарийн ширийн

зүйлүүдийг өгүүлнэ. Би түүний ой сайтайг нь гайхсан юм. Г эвч чагнах тусам өнгө аяс нь этгээд, нэг л жигтэй гажууд гэмээр санагдлаа.

Ярьсан явдлууд нь нэг нэгнээсээ хөврөн гарна. Үүх түүх нь эмх цэгцтэй, өөр хоорондоо нарийн сэжүүрээр холбогдож тасралтгүй, төгсгөлгүй үргэлжилнэ.

Эхэндээ би аан уун гэж байсан ч удалгүй дуугаа хурааж, пянзаа сольж тавих болов. Зургаан пянз байсанд би нэг нэгээр нь солино. Эхлээд Битлзийн Түрүүч Пепперийн гоонь хүмүүсийн клуб-ийг тавьж, Билли Эвансын Деббид зориулсан вальс-ыг хамгийн сүүлд тоглуулна.

Цонхны цаана бороо шаагиж, цаг хугацаа зогссон мэт болов. Наоко ярьсаар л.

Кизүкитэй холбоотой болоод миний мэдэхгүй зарим нэг зүйлийг зориуд алгасаад ч байх шиг. Гэсэн хэдий ч холбоо хамааралгүй жижиг сажиг зүйлийн тухай тасралтгүй өгүүлнэ. Анх удаа ингэж ярихыг нь сонсоод үг хавчуулсангүй.

Арван нэг болмогц би тавгүйрхэж эхэллээ. Наоко дөрвөн цаг гаруй ам хамхилгүй ярьжээ. Метроноос хоцрох вий гэсэндээ эгзгийг нь тааруулаад “Явдаг юм уу. Метроноос хоцрох нь” гэж хавчуулаад цагаа харсан ч Наоко хормын төдий дуугаа хураагаад, аанай л анзаарсан шинжгүй дүнгэнэтэл ярьсаар.

Би ч дүүрсэн хэрэг гэж бодоод хоёр дахь шил дарснаасаа балгаж эхлэв. Яриаг нь тасалсны хэрэггүй гэж бодож билээ. Метро, дотуур байрны журам яавал ч яаг гэж бодлоо.

Эсэн бусын бодолд автан нэг сэхээ авбал Наоко чимээгүй болжээ. Ярьж байснаа дуусгаагүй ч хэлэх үгээ олохгүй дуугаа хураачихав.

Надаас болоод яриа нь тасалдлаа. Хэлсэн зүйл минь арайхийж чихэнд нь хүрээд, нэлээд удсаны эцэст ойлгогдон, хэл амыг нь хөдөлгөж байсан хөшүүрэг эвдэрчих шиг нам жим боллоо.

Наоко тэжээлээс нь салгасан машин шиг амаа үл ялиг ангайлгаад, бүрэлзсэн нүдээрээ намайг ширтэнэ.

-Яриаг чинь тасалсан бол уучлаарай. Оройтчихлоо...

Бөнжигнөсөн дусал нулимс хацраар нь доошилж, пянзны хавтсан дээр под хийн унав. Наоко гараараа шал тулаад тонгойсон чигтээ эхэр татан уйллаа. Би анх удаа хүн ийн цөхрөнгөө баран уйлахыг харж билээ. Мөрөнд нь хүрвэл чичрэх юм.

Өөрийн мэдэлгүй түүнийг энгэртээ нааж тэвэрлээ.

Наоког үл ялиг чичирч, чимээгүйхэн мэгшихэд цамцны минь энгэр гашуу оргиулан мэлтэрсэн нулимс, халуун амьсгалд нь норсон юм. гар хуруу нь ямар нэг зүйл эрэх мэт нуруугаар минь тэмтчинэ.

Би зүүн гараараа зөөлөн шулуухан үсийг нь илбэж тайвшрахыг нь хүлээсэн ч Наоко уйлсаар.

Энэ шөнө бид хоёр дотносож билээ. Түүнээс хойш хэдий хорин жил өнгөрсөн ч би өдий болтол зөв, буруугаа ялгаж салгаж чаддаггүй. Энэ яваа насандаа би энэ асуултанд хариулж дөнгөхгүй л болов уу.

Тэр үед өөр арга байсангүй. Би Наокогийн эмтэрсэн сэтгэлийг аргадаж тайтгаруулахыг хүссэн юм.

Гэрлээ унтраагаад хувцсыг нь тайлж тэвэрч авлаа. Бороо шивэрсэн дулаахан шөнө бид хоёр нүцгэн хэвтсэн ч даарсангүй. Харанхуйд үг дуугаралгүй биесээ энхрийлэв.

Уруул дээр нь үнсэж, хөхийг нь барьж хоёр биенээ таалахад Наоко намайг тэврээд, халуу оргин урин дуудах шиг.

Эр эрхтэн минь дотор нь шунган ороход өвдсөн нь илэрхий. Анх удаа эсэхийг нь асуувал Наоко толгой дохилоо. Би Кизүки тэр хоёрыг нэг хөнжилд орсон гэж боддог байсан учраас үнэхээр гайхсан сан. Би дотор нь ороод хөдөлсөнгүй нэлээн удлаа. Наоког тавирмагц удаан гэгч нь хөдөлсөөр тавихад намайг чанга тэврээд ялимгүй дуу алдав.

Эмэгтэй хүн дур тавихдаа тэгж гунигтай дуу алдахыг би сонсож явсангүй.

Түүнээс Кизүкитэй яагаад дотносоогүйг нь асуусандаа өдгөө ч харамсах юм. Тэр үед Наоко гараа татаж аваад буруу харан чимээгүйхэн уйлсан сан. Би ханын шүүгээнээс хөнжил гаргаж, Наоког хучаад дөрвөн сарын зүсрэх бороог ширтэн тамхиа сорлоо.

Үүр хаяарахад тэнгэр цэлмэв. Наоко буруу хараад унтжээ. Үнэндээ сэрүүн байсан биз ээ. Би хэд хэдэн удаа үг солих гэсэн ч Наоко дуугарч хөдөлсөнгүй. Түүний нүцгэн мөрийг хэсэгтээ хараад тэвчээр алдан босов.

Шалан дээр пянзны хавтас, дарсны шил, хундага, үнсний сав, ширээн дээр өчигдрийн бялууны үлдэгдэл байна. Би шалан дээрх юмаа эмхлүүлээд, хоёр аяга ус уулаа.

Бичгийн ширээн дээр толь бичиг, франц хэлний үйл үгийн хувирлын хүснэгт харагдана. Хананд ямар ч тэмдэглэл бичээгүй зураггүй хуанли байх ажээ.

Би шалан дээр тараасан хувцсаа авч өмсөхөд цамцны энгэр чийгтэй хэвээрээ. Цамцанд минь Наокогийн үнэр шингэжээ. Ширээн дээрээс нь тэмдэглэлийн цаас авч “Сэтгэл чинь уужирвал хэд хоногоос тухтай ярилцъя. Ойрмогхон залгаарай. Төрсөн өдрийн мэнд хүргэе!” хэмээн бичээд араас нь хараад чимээгүйхэн гарлаа.

Долоо хоног өнгөрсөн ч Наоко ярьсангүй. Гэр лүү нь залгавал хариу өгсөнгүйд ням гарагийн өглөө гэрт нь очихоор Кокүбүнжи рүү явлаа. Гэсэн ч Наоко гэртээ байсангүй. Хаалган дээрх овог нэр нь ч алга болжээ. Цонхнууд нь гаднаасаа түгжээтэй. Байрны жижүүрээс асуувал гурав хоногийн өмнө “Хашаа ч юм бэ” нүүсэн гэв.

Би байрандаа ирж, Наокогийн Кобэ дахь гэрийн хаягаар уртаа захиа бичлээ. Наоко хаа ч байсан энэ захиаг авч л таарна.

Захиандаа би зүрх сэтгэлээ ойлгож ухаарахыг чин сэтгэлээсээ хүсч байгаа боловч тодорхой хугацаа хэрэгтэй бөгөөд энэ хугацаа

өнгөрөхөд хаа байхаа мэдэхгүй байна. Тиймээс ч түүнд ам гарч, ямар нэгэн зүйл тулган шаардаж, гоё сайхан үг хэлэх учиргүй гэлээ. Нэгдүгээрт, бид хоёр хоёр биенээ бараг мэдэхгүй боловч Наоко надад боломж олговол учир зүйгээ олж болох юм. Ямартаа ч дахин уулзаж, тухтайхан ярилцах хүсэлтэй байна. Кизүкиг явснаас хойш би Наокотой адил сэтгэлээ уудлах хүнгүй болжээ. Тиймээс ч бид өөрийн мэдэлгүй нэг нэгэндээ тэмүүлж, бэдэн явсаар хоёр биенээ олсон биз ээ. Амьдрал минь өөрөөр эргэж болох байсан ч өөр зам байсангүй. Надад өөр сонголт байсан гэж үү? Үүнээс өмнө хэн нэгэнтэй Наокотой шиг халуун дотно харьцаж явсангүй. Ямар ч хариу бичлээ, би тэсэн ядан хүлээж сууна хэмээн тэрлэсэн юм.

Гэлээ ч Наокогоос хариу ирсэнгүй.

Сэтгэл зүрхний минь нэгээхэн хэсэг хоосон орон зай үлдээн өмрөн унах шиг болж билээ. Бие хөнгөрөөд орчин тойрны дуу чимээ хий хоосонд замхрах шиг болно.

Хичээлээ таслахаа больж, урд эгнээний захад ганцаараа суугаад нэгэн хэвийн уйтгартай лекц сонсон, хичээлдээ шамдах боллоо. Би ангийнхныгаа огт анзаардаггүй байлаа. Хэнтэй ч ярилгүй ганцаараа хооллож, тамхинаас гарахаар шийдсэн дээ.

Тавдугаар сарын сүүлээр оюутнууд “их сургуулиа нураана” гэх мэтийн уриа лоозон барьж хөдөлгөөн өрнүүлээд, хичээл хаяв. Би “Нураавал нураана л биз. Хамаа алга. Хөлөөрөө дэвслээд нураагаад аль” гэсэн шүү бодол тээсээр сургуулийн дарлалаас ангижирвал яаж ийгээд болоод явчихна хэмээн эргэцүүлнэ. Бас ч үгүй нураахад нь тусламж хэрэгтэй бол гар бие оролцож болох л юм хэмээн сэтгэнэ.

Ингээд их сургууль маань үүдээ барьж, би тээврийн компанид цагийн ажил хийх болов. Ачааны машины жолоочтой хамт явж, ачаа тээш буулгана. Хар ажил болохоор эхэндээ өглөө босоход булчин шөрмөс жигтэй янгинана. Гэсэн ч цалин сайтайн зэрэгцээ сэтгэл зүрхээ чагнаж уйтгарлах завгүй нь сайхан.

Би долоо хоногийн таван өдөр тээврийн компанид, гурван шөнө нь пянзны дэлгүүрт ажилладаг байлаа. Шөнийн ээлжгүй өдрөө виски

балгангаа ном уншина. Довтлогч архи дарс уудаггүй болохоор үнэр танарыг нь тэвчихгүй. Виски уухад үнэрт нь байж суухын арга алга гээд өөр газар очиж уу гэв.

- Дуртай бол чи өөрөө явахгүй юү!

- Гэ-гэхдээ дотуур байранд ууж болохгүй журамтай шүү дээ.

- Чи өөрөө яв аа!

Дургүй хүрсэндээ дээвэр дээр гарч, вискигээ ууж дуусгалаа.

Зургаан сард би Наокод дахин нэг захиа бичиж, Кобэгийн хаягаар нь явууллаа. Түрүүчийн захиатай бараг ялгаагүй захиа. Төгсгөлд нь хариу хүлээж суух ямар хэцүү болоод гомдоосон үгүйгээ мэдмээр байгаагаа бичлээ.

Захиагаа шуудангийн хайрцганд шургуулах тэр мөчид сэтгэл зүрхний минь хоосон орон зай улмаа нэмэгдэж байгааг мэдэрсэн юм.

Зургаан сард Нагасаваг даган бүсгүйчүүдтэй зугаацахаар хоёр удаа хот орж билээ. Нэг бүсгүйтэй зочид буудалд орж оролдож эхлэхэд жигтэйхэн эсэргүүцэхэд нь залхсандаа ном уншиж эхэлбэл өөрөө өдөж эхэлсэн дээ. Харин нөгөө нэг нь өвөрт орсныхоо дараа аа бээгүй шалгаав.

Хэдэн охинтой унтсан, ямар сургуульд сурдаг, ямар хөгжим сонсдог, Дазаи Осамүгийн номнуудыг уншсан эсэх, гадаад руу аялах бол хаашаа явах вэ, миний хөх бусад бүсгүйчүүдийнхтэй харьцуулбал арай том байгаа биз гээд л асууж гарсан.

Би хайнгадуухан хариулж байгаад унтчихлаа. Өглөө сэрвэл нөгөө бүсгүй надтай өглөөний цай уумаар байна гэдэг юм байна. Бид хоёр кафе орж, амт муутайхан шарсан талх, өндөг идэж, кофе уулаа.

Бүсгүй аавын ажил, хичээл сурлага, төрсөн өдөр, мэлхий идэж үзсэн эсэхийг минь лавласаар л байлаа. Толгой өвдөж ундалж дуусмагцаа

нөгөө бүсгүйд цагийн ажилдаа явах хэрэгтэй гэсэн ч сэтгэл нь ханаагүй бололтой:

- Дахиад уулзах уу? гэв.

- Дэлхий бөөрөнхий болохоор тааралдах байлгүй гэхээс өөр юм хэлсэнгүй.

Ганцаараа үлдээд “Би ер нь юү хийгээд явна?” гэсэн бодолдоо шаналж, зугаа цэнгэл хөөх цаг нь мөн үү хэмээн бодлоо. Гэвч арга мухардаж, бие хаа минь бүсгүй хүнийг хүснэ. Энэ хоёр бүсгүйг тэврэхдээ би Наоког мартаж чадсангүй.

Харанхуйд цайрах Наокогийн нүцгэн бие, тэр шөнийн зүсрээ бороо сэтгэлд буух тоолонд дур хүсэл бадамлан асна. Дээвэр дээр гарч виски уунгаа хаачихаа мэдэхгүй толгой гудайлгана.

Долдугаар сарын эхээр Наокоогоос богинохон хариу ирлээ.

“Хариу бичилгүй удсанд уучлаарай. Намайг ойлгоно биз ээ. Хэдэн мөр холбох тэнхээтэй болтлоо их удлаа. Захиа бичиж чаддаггүй болохоор энэ захиагаа арван ч удаа хууллаа.

Одоо гол юмаа бичье. Би яах учраа олохгүй сургуулиасаа жилийн чөлөө авсан. Гэсэн ч их сургуульдаа эргэж орохгүй биз дээ. Эргэж очихгүй гэх шалтаг олох гэсэндээ л чөлөө авсан юм.

Чи гайхаж болох ч би аль эртнээс энэ тухай бодож байлаа. Чамд хэд хэдэн удаа хэлье гэсэн ч ам нээж зүрхэлсэнгүй.

Сэтгэл хоосорсон гэж бодсоны хэрэггүй. Хүн гэдэг заяа төөргөө дагадаг юм байна. Чамайг эмзэглүүлсэн бол намайг уучлаарай.

Надаас болж гэмшиж гутарсны хэрэггүй. Бүх юм надаас л болсон. Би тэр явдлыг бүтэн жилийн турш хойшлуулж, чамайг бишгүй зовоосон. Одоо бүх юм дууссан бололтой.

Кокүбүнжигээс нүүсний дараа би Кобэд гэртээ ирж, нэг хэсэг эмнэлэгт эмчлүүлээ. Эмчийн хэлэх нь, Киотогийн ууланд надад

тохирсон сувилал байдаг гэнэ. Тийм болохоор хэсэгтээ тэнд эмчлүүлэх байх. Эмнэлэг гэхээсээ илүү сувиллын газар.

Одоо захиа бичихэд хэцүү байгаа учраас дараагийн захиандаа тодорхой бичье. Юун түрүүнд тусгаарлагдмал, нам гүмхэн газарт сэтгэл санаагаа тайвшруулах хэрэгтэй байна.

Бүтэн жил хажууд минь байсанд чамд талархаад баршгүй. Үүнд л итгэж үзээрэй. Чи намайг огтхон ч гомдоогоогүй. Би л өөрийгөө шархлуулсан.

Одоохондоо чамтай уулзахад бэлэн биш байна. Уулзахыг хүсээгүйдээ ингэж хэлээгүй юм шүү. Сэтгэл уужирвал тэр даруйдаа захиа бичнэ ээ. Тэр үед чиний. хэлсэнчлэн хэн хэнээ илүү сайн мэдэх боломж гарах биз ээ. Баяртай.”

Би энэ захиаг хэдэнтээ уншсан бөгөөд тэр болгонд Наокогийн нүд санаанд орж, уйтай бодол хөвөрнө.

Сэтгэл шимшрүүлсэн энэ бодролоо би яаж ч хичээгээд үлдэн хөөж дийлсэнгүй. Агаар салхи лугаа барьцгүй, хэлбэр дүрсгүй дүр зургууд нүдний өмнө жирэлзэх боловч хэлэх үгс нь дуулдахгүй.

Бямба гарагийн орой би урьдын адил лоббид суудаг боллоо. Ингэхдээ зурагтаар бейсболын тэмцээн үзэж байгаа царайлна. Зурагт, буйдан хоорондын орон зайг алгандаа багтахаар жижигхэн болтол нь оюун бодолдоо хуваана.

Ингээд арван цагт зурагтаа унтрааж, өрөөндөө ороод унтахаар хэвтэнэ дээ.

Долоон сарын сүүлээр Довтлогч надад шилэнд хийсэн гэрэлт цох бэлэглэж билээ.

Найруулдаг кофений саванд бага зэрэг ус, хэдэн навч хийгээд таглааг нь хэд хэд цоолжээ. Харуй бүрий болоогүй байсанд гэрэлт цох жирийн нэг цох хорхой шиг харагдсан ч Довтлогч үүнийг жинхэнэ гэрэлт цох хэмээв.

Довтлогч гэрэлт цохыг сайн мэднэ гэсэнд би эргэлзсэнгүй. Унтамхай байрын гэрэлт дох шилний ханаар өгсөх болгондоо хальтирч унана.

- Наадхыг чинь цэцэрлэгээс олоод.

- Эндээс үү?

Довтлогч “Э-энэ хавийн зочид буудлууд хүн татах гээд зундаа гэрэлт цох гаргадаг шүү дээ. Тэгээд л нисээд ирээ биз” гэж хэлээд хар цүнхэндээ хувцас, конспект хоёроо чихлээ. Зуны амралт эхлээд хэдэн долоо хоног өнгөрч, мань мэтийн хэдэн хүн л байранд үлдсэн байлаа. Кобэ явах хүсэлгүй байсан учраас би ажлаа хийж, харин Довтлогч дадлагатай байсан юм. Дадлагаа дуусгаад Довтлогч Яманаши дахь гэртээ харина.

- Охид гэрэлт цохонд дуртай байдаг юм. Бэлэглэвэл баярлана даа.

- Баярлалаа.

Орой болоход эл хуль болсон дотуур байр хаягдсан цайз шиг санагдана. Төрийн далбаа бууж, хоолны газрын гэрэл асчээ. Ихэнх оюутан нутаг буцсан учраас хоолны газрын зарим чийдэнг асаахаа больсон юм. Баруун талынх нь унтраастай, зүүн талынх нь асаалттай. Оройн хоолонд өгсөн цөцгийтэй жигнэсэн махны үнэр сэнхийнэ.

Би гэрэлт цохоо авч дээвэр дээр гарлаа. Дээвэр дээр хэн нэгний хатаах гэж өлгөөд мартсан салхинд дэрвэлзэх цамцнаас өөр юмгүй.

Булангийн төмөр шатаар өгсөж, ус нөөцлөх дугуй саван дээр гараад, хашлага түшин суулаа. Цилиндр хэлбэртэй усны сав өдөржин наранд халж, төөнөх ажээ. Дугариг цагаан сар өөдөөс мэлтийнэ.

Баруунтаа Шинжюкү, зүүнтээ Икэбүкүрогийн гэрэл анивалзана. Машины урд гэрлүүд гудамж сүлжин эцэс төгсгөлгүй хөвөрнө. Гудамжнууд түмэн янзын дуу чимээнээс бүрдсэн нүргээнд автжээ.

Шилний ёроолд гэрэлт цох бүдэгхэн гэрэлтэнэ. Гэрэл нь дэндүү бүүдгэр юм. Тэртээ олон жилийн өмнө хүүхэд ахуйдаа харж байсан

гэрэлт цохнууд үүнээс хавьгүй тод гэрэлтэж байсан даа. Би гэрэлт цох шатаж буй мэт гэрэл цацруулдаг гэхээс өөрийг мэддэггүй байлаа.

Энэ гэрэлт цох үхэж байгаа ч юм бил үү? гэсэн бодол төрөв. Шилээ хэд хэд хөнгөн сэгсэрвэл цох ойж буусан ч гэрэл нь тодорсонгүй.

Сүүлийн удаа гэрэлт цох харснаа санах гэж хичээлээ. Санаж байгаа ч чухам хэзээ, хаана гэдэг нь бүдэг бадаг болжээ.

Харанхуйд хажууханд ус хоржигноно. Холгүйхэн урсах горхин дээр хуучин усан тээрэм байх агаад горхины ус замаг ногоонд баригджээ.

гар чийдэнгээ унтраавал хөл доорх газраа ч олж харахын аргагүй түнэр харанхуй. Харин усан тээрмийн цаахна хэдэн зуун гэрэлт цох нисэх ажээ. Цацруулсан гэрэл нь усанд ойж галын дөл мэт үзэгдэнэ.

Нүдээ аниад дурсамжаа сэргээлээ. Сэвэлзүүр салхи үлээж, бие зарсхийлгэн гэрэл татуулсаар одно. Нүдээ нээвэл улам харанхуй болжээ.

Гэрэлт цохоо шилнээс нь гаргаад усны савнаас гурван санж орчим илүү гарсан ирмэг дээр тавилаа. Гэрэлт цох гуйвждайвсаар эрэг шураг тойрч, хуурч хөндийрсөн будган дээгүүр ийш тийш явав. Баруун тийш мөлхөж, ирмэгт нь хүрээд зүүн тийш эргэнэ. Эрэг өөд авирч хэсэгтээ л үхсэн мэт эвхрэн суув. Амьсгал хураасан шиг ер хөдөлсөнгүй.

Би хашлага налж хөдөлгөөнгүй суугаад гэрэлт цохыг удаан гэгч нь ажиглалаа. Зөөлөн салхи биднийг илбэж, хайлаасны навчис шүр шар хийнэ.

Их удаан хүлээж билээ.

Нэлээд удсаны эцэст гэрэлт цох гэнэт далавчаа дэлгэн түнэр харанхуй рүү дэр хийн нисэв. Алдсан цаг хугацаагаа эргүүлэх гэсэн мэт усан савны хажуухантаа нум зурж, гэрлээ уусахыг ажих мэт түрхэн зуур зог тусаад, төд удалгүй зүүн тийш одлоо.

Гэрэлт цох нисч одсоны дараа цацруулсан гэрэл нь санаанаас гарсангүй. Энэ бүдэгхэн гэрэл хэн нэгний сүнс мэт нүдний минь өмнүүр жирэлзэн өнгөрнө.

Харанхуйд гараа хэдэнтээ сунгасан ч баригдах юмгүй бөгөөд тэр бяцхан гэрэл өмнө минь алд хэрийн дайтай сүүмэлзэх авай.

Дөрөвдүгээр
БҮЛЭГ

Зуны амралтын үеэр их сургуулийнхан цэргийн хүчээр түрэмгийлэн босогчдын барьсан хаалт хашилтыг нурааж, дотор нь хоргодож байсан оюутнуудыг баривчиллаа. Тухайн үед их сургууль болгонд ийм явдал болов.

Ингэх нь жам ёсны хэрэг байсан бөгөөд их сургуулиудыг нураах нь битгий хэл ямар ч өөрчлөлт орсонгүй. Асар их хөрөнгөөр босгосон сургуулиудыг хэсэг оюутны үймээнээр сүйдэлнэ гэж юу байхав.

Угтаа үймээн дэгдээсэн оюутнууд сургуулийн зохион байгуулалтыг өөрчлөх санаатай байснаас эвдлэн сүйдлэе гэж хөдлөөгүй юм. Харин миний хувьд сургуулийн удирдлага хэний гарт байх нь огтхон ч сонирхол татсангүй. Иймээс ч оюутнуудын бослого дарагдсанд сэтгэлээр унасангүй.

Есөн сард нуранги байх болов уу? хэмээн горьдсоор хичээлдээ очсон боловч сургуулийн барилга бүрэн бүтэн байв. Номын сангийн номнууд байр байрандаа, багш нарын өрөө, сургалтын албаны байранд ч хүний гар хүрсэн шинжгүй байхыг хараад оюутнууд чухамдаа юу хийж цаг нөгцөөв? гэсэн бодол эргэлдэнэ.

Оюутнуудын бослого дарагдаж, үймээн дэгдээгчид цэргүүдийн хяналтан дор хичээлдээ хээв нэг сууж, лекцээ тэмдэглэж, ирцээ бүртгүүлнэ. Бослого гаргах шийдвэр цуцлагдаагүйн зэрэгцээ бослогоо зогсоох шийдвэр гараагүй учраас энэ байдал их л жигтэй санагдав.

Их сургуулийнхан цэргийн хүчээр хаалт хашилтыг нураасан ч үнэндээ бослого үргэлжилсээр байсан юм. Хэнэггүй царайлан хичээлдээ явах энэ нөхөд бослого гаргахаар шийдмэгцээ бусдыг уриалан дуудаж, тээнэгэлзсэн нэгнээ газар дор ортол нь шүүмжилж байсан нь саяхан. Би тэднээс бослогоо хаяад хичээлдээ суух учрыг нь лавлавал хэлэх үгээ олж ядна. Үнэндээ тэдэнд хэлэх үг байсангүй. Ирц нь дутаж, оноо нь буурна гэхээс айцгаасан нь илт. Сургуулиа нураана хэмээн байдаг чадлаараа орилж байсныг нь бодохоор инээд хүрэх шиг. Иймэрхүү хулчгар хүмүүс салхины аясаар намирч байдаг даа.

Кизүки минь, энэ хорвоо ямар хуурамч юм бэ? Энэ хүмүүс дүнгийн төлөө суралцаж, тулга тойрсон өчүүхэн нийгмээ бүтээнэ.

Би энэ өчүүхэн орчинд бачимдан цухалдаж, лекцэнд суухдаа утга учиргүй ч гэлээ ирцээ бүртгүүлмээргүй санагдав. Ингэлээ гээд юм өөрчлөгдөхгүй л дээ.

Аажимдаа би бусдаас тусгаарлагдаж, ирц бүртгэхэд намайг дуудах тоолонд хариу өгөхгүй учраас хэн хэндээ эвгүй болно. Би хэнтэй ч үг солихоо болиод, тэд ч надтай дуугарахаа больсон юм.

Есдүгээр сарын хоёр дахь долоо хоногт их сургуулийн боловсрол гээчийг хүнд уй гунигаа даван туулан тэсвэр хатуужил суулгахаас өөр ямар ч утга учиргүй хэмээн дүгнэлээ. Сургуулиа хаялаа гэхэд хийх юмгүй хойно гэлдрэхээс өөр замгүй. Иймээс ч өдөр бүр хичээлдээ сууж, тэмдэглэл хөтлөн, зав зайгаараа номын санд сууж, ном уншингаа хичээлээ давтана.

Галав юүлэх шиг нэг үйл явдал болсон нь есөн сар Хэдийн гарсан ч Довтлогч аанай л эргэж ирээгүй явдал байв. Довтлогч хичээлээ тасална гэдэг урьд өмнө үзэгдэж харагдаагүй хэрэг.

Оо сойз, аяга таваг, хорхой шавжны хор зэрэг эд хогшил нь байсан байрандаа тоосонд дарагджээ.

Довтлогчтой жил хагас амьдарсан болохоор гял цал байдалд нь дасчихаж. Иймээс ч эзгүйд нь өрөөгөө цэвэрлэхээс өөр арга үлдсэнгүй.

Шалаа өдөр өнжилгүй шүүрдэж, гурав хоноод цонхоо арчиж, долоо хоногтоо нэг хөнжлөө хатаана. Довтлогч ирээд “Ватанабэ минь, ёстой болж дээ. Цэвэрхэн гэж жигтэйхэн” хэмээн уулга алдах байх гэсэн бодол битүүхэндээ тээсээр.

Гэсэн ч тэр ирсэнгүй. Нэг өдөр хичээлээсээ ирвэл эд хогшил нь алга болжээ. Тэр байтугай хаалган дээр наасан овог нэр нь байсангүй. Комендантаас Довтлогчийг сураглавал “Байрнаас гарчихсаан. Түрдээ ганцаараа сууж бай” гэхээс өөр юм хэлсэнгүй. Цаад учрыг нь лавлавал хариулсангүй.

Комендант албан тушаалдаа дуртай, ажил хэргээ бусдад тайлагнадаггүй, үүнээсээ ч таашаал авдаг бололтой байрын бүдүүлэгдүү эр байлаа.

Хэсэг хугацааны дараа цаст уулын зурагт хуудасны оронд Жим Моррисон, Майлз Дэйвисийн зураг нааж, өөрийн орон зайг бий болгов.

Цагийн ажил хийж олсон мөнгөөрөө авсаархан стерео тоглуулагч авч, оройдоо жаал жуул юм уунгаа хөгжим сонсоно. Хааяадаа Довтлогчийг үгүйлэх ч ганцаараа амьдрах таатай юмаа.

Даваа гарагийн арван цагаас “Драмын түүх II”-ийн лекцээр Эврипидийн тухай орж, хичээл арван нэг хагаст тарав. Лекц тараад сургуулиас арваад минут явах зайтай жижигхэн зоогийн газар орж шарсан өндөг, зууш авч идлээ.

Шуугиант гудмаас зайтайхан энэ зоогийн газар оюутны хоолны газраас бага зэрэг үнэтэй ч толгой амармаар нам гүмхэн агаад амттай хоолтой. Энд дуу цөөтэй гэр бүлийн хоёр болоод цагаар ажилладаг нэг бүсгүй ажиллана. Цонхны хажуугийн ширээнд суугаад хооллож байтал дөрвөн оюутан орж ирлээ. Цэмцгэр хувцасласан хоёр залуу, хоёр бүсгүй үүдний хажуугийн ширээнд суугаад хоолны цэсийг удаан гэгч нь үзэж, захиалгаа өглөө.

Энэ үед нэг бүсгүй нь намайг нууцхан ажиглаж буйг анзаарав. Тэр бүсгүй богинохон тайрмал үстэй, зузаан нарны шил зүүж, цагаан даавуун огтор даашинз өмсчээ. Би бүсгүйг танихгүй болохоор сэтгэл төвдөлгүй хоолоо идэж суув. Бүсгүй гэнэт босоод дөхөж ирлээ. Тэгээд ширээ түшин:

- Чи Ватанабэ биз дээ? гэлээ.

Бүсгүйг ойроос хараад ч хэн болохыг нь таньсангүй. Нүдэнд тусахаар царай зүстэй ийм бүсгүйг хэр баргийн эр хүн мартажгүй дээ. Тэгээд ч их сургуульд цөөн хэдэн хүн намайг танина.

- Түр сууж болох уу? Хүн хүлээж байна уу?

Би балмагдсан ч толгой дохилоо.

- Үгүй дээ. Суугаач.

Бүсгүй сандал чахруулан татаж суугаад шилнийхээ дээгүүр эхлээд над руу дараа нь тавагтай хоол руу харав.

- Амттай харагдаж байна шүү.

- Амттай шүү. Мөөгтэй шарсан өндөг, вандуйтай зууш.

- Дараа авч иднэ ээ. Би өөр юм захиалчихсан.

- Юу захиалсан юм бэ?

- Бяслагтай гоймон.

- Бас л амттай. Бид хоёр урьд нь уулзаж байсан бил үү? Ер санахгүй юм.

- Эврипид.

- Электра! “Бурхан хүртэл золгүй амьтдын дуу хоолойг сонсохгүй юм даа!” гэх лекцийн хичээл саяхан тарсан шүү дээ.

Бүсгүйг дахин харвал тэр шилээ авч, “Драмын түүх”-ийн лекцэн дээр таарсан нэгдүгээр курсийн оюутан болохыг нь танилаа. Үсний засалтаа өөрчилсөн учраас танихгүй байжээ.

- Зуны амралтаас өмнө чи ийм урт үстэй байсан биз дээ? хэмээгээд арваад санжийн доогуур заахад тэрээр дөрөв таван санжийн богинохон үсээ илэнгээ:

- Тийм ээ. Зун хими хийлгэсэн чинь хачин муухай болчихсон. Үхчихье гэж бодсон шүү. Живж үхсэн хүний толгойд замаг орооцолдчихсон юм шиг харагдаад. Гэхдээ үхсэнээс дээр биз гэж бодоод бүр хусаад хапзан болчихсон. Унжиж санжихгүй амар ч юм уу? гээд инээмсэглэв. Шарсан өндгөө үмхэнгээ:

- Дажгүй болжээ. Арагшаа хар даа гэхэд бүсгүй хажуу тийш хараад тав зургаан секунд хөдөлсөнгүй.

- Чамд зохижээ. Толгойны хэлбэр сайтай, хөөрхөн чихтэй юм.

- Би ч тэгж бодсон. Халзлаад харсан чинь дажгүй санагдаад. Гэхдээ эрчүүд ер урмын үг унагахгүй, бага ангийн сурагч шиг, эсхүл хорих ангиас зугтсан хүн шиг гэх юм. Та хэд яахаараа урт үстэй охидод дуртай байдаг байна аа? Фашистууд шиг. Дургүй хүрмээр гэдэг нь. Урт үстэй л бол эрхэмсэг, нинжин сэтгэлтэй, эмэгтэйлэг гэх юм. Урт үстэй, санаа муутай охид түм бумаараа байхад гэхэд нь:

- Надад бол наад үс чинь илүү таалагдаж байна аа! хэмээн сэтгэл шулуухан хэлэв.

Үнэндээ урт үстэй байхдаа бүсгүй жирийн л нэг хөөрхөн охин байлаа. Харин одоо тэрбээр урин хавартай золгож буй эрч хүч нь амтагдсан нялх бяцхан амьтан шиг болжээ.

Инээмсэглэж, бухимдаж, уурлаж гайхшрух нүд нь ерөөс энэ биеэсээ тусдаа нэгэн биет гэлтэй. Ойрын хугацаанд ийм цоглог бүсгүй хараагүй тул хэсэгтээ л амьсгаа даран ажлаа.

- Үнэн үү?

Би зууш идэнгээ толгой дохивол бүсгүй шилээ зүүгээд над руу харлаа.

- Худлаа хэлээгүй биз?

-Үгүй дээ. **Шулуун шударга байя гэж чадлаараа л хичээдэг юм.**

- За, за. Тийм байж.

-Үсээ богиносгосон чинь ямар ч хамгаалалтгүй, олны өмнө нүцгэлчихсэн юм шиг санагдаад болж өгдөггүй. Тэгээд л зүүсэн юм.

- Аан. Зөв зөв.

Бүсгүй намайг өндгөө идэж дуустал сониучирхан ажив. Найзууд руу нь заагаад:

- Тийшээ очихгүй юу? гэвэл:

-Хоол авчрахаар очно оо. **Чамд саад болоогүй биз дээ?**

- Хаанаас даа. Тэгээд ч идээд дуусчихлаа.

Явах шинжгүй суухаар нь би кофе захиалав. Эзэгтэй аяга тавгаа хурааж, элсэн чихэр, сүү авчирч тавьлаа.

-Өнөөдөр лекцэн дээр ирц бүртгэхэд яагаад дуугараагүй юм бэ? Чи чинь Ватанабэ Торү мөн биз дээ?

- Мөөн.

-Тэгээд яагаад хариу хэлдэггүй юм бэ?

- Хариулмааргүй байдаг юмаа.

Бүсгүй шилээ авч ширээн дээр тавиад жигтэй амьтан үзэж байгаа мэт нүдээ бүлтийлгээд:

- Хариулмааргүй гэнэ ээ? Чи Хэмфри Богарт шиг хэнэггүй, танхай ярих юмаа.

- Хаанаас даа. Би жирийн л нэг хүн шүү дээ.

Эзэгтэйг кофе авчрахад би сүү, чихэр хийлгүй уув.

- Сүү, чихэр ч хийдэггүй биз дээ?

- Чихэрлэг юманд дургүй. Намайг нэг л ойлгохгүй байна аа даа?

- Хаана ингэж борлоо вэ?

- Хоёр долоо хоног энэ тэрүүгээр явган аялаад. Ачаа бараагаа үүрч явсаар борлоо байлгүй дээ.

- Хаа хүрсэн юм бэ?

- Каназава, Нотогийн хойг, Ниигата орсон.

- Ганцаараа юу?

- Ганцаараа. Хааяадаа хүн амьтантай таарсан л даа.

- Замдаа бүсгүйчүүлтэй учир ургуулсан уу? Очсон газраа хүнтэй танилцаагүй юу?

- Учир ургуулах аа? Чи намайг нэг л буруу зөрүү бодоод байх шиг. Ганцаараа үүргэвчээ үүрээд, сахал үсэндээ баригдаж яваа хүн хаана, яаж учир ургуулах вэ дээ!

- Тэгээд ганцаараа л яваад байдаг хэрэг үү?

- Тийм ээ.

Бүсгүй эрүүгээ тулаад:

- Ганцаардалд дуртай юмаа даа? Лекцэнд, хоолонд, аялалд явахдаа ч ганцаараа.

- Ганцаардалд дуртай хүн гэж байдаггүй биз дээ. Сэтгэл санаа нийлэхгүй хүмүүстэй нөхөрлөхийг хүсдэггүй юмаа. Урам хугарахаас цаашгүй шүү дээ.

Бүсгүй шилээ оролдон:

- “Ганцаардалд дуртай хүн гэж байдаггүй. Урам хугарахаас цаашгүй...”
Дурсамж тэрлэхдээ ингэж бичмээр юм байна даа гэлээ.

- Хичээе дээ.

- Чи ногоон өнгөнд дуртай юм уу?

- Яаж байна?

- Ногоон цамц өмссөн болохоор чинь л...

- Дуртай гэхэд ч хаашаа юм бэ? Хувцасны өнгө тийм чухал гэж үү?

Бүсгүй аанай л хэлснийг минь давтаж:

- Дуртай гэхэд ч хаашаа юм бэ? Хувцасны өнгө тийм чухал гэж үү?
Надад чам шиг хүн таалагддаг шүү. Хана туургаа жигдхэн шавардаж байгаа юм шиг. Ийм үг дуулсан уу?

- Үгүй ээ.

- Намайг Мидори (японоор ногоон гэсэн үг, орч) гэдэг. Гэхдээ ногоон өнгө надад ер зохидоггүй. Сонин байгаа биз? Арай дэндүү. Эгчийг маань Момоко (японоор “момо” гэдэг нь тоор гэсэн үг, орч) гэдэг. Инээдтэй ч юм шиг.

-Тэгээд эгчид чинь улбар ягаан өнгө зохидог уу?

- Төрмөл өнгө нь гэлтэй хачин сайхан зохино. Хорвоо гэж хачин юм даа.

Удалгүй тэдний хоолыг авчрахад индиан маягийн шоотой цамцтай залуу “Мидори, хоолоо ид” гэсээр дуудав. Мидори дууллаа гэсэн шиг гараа даллаад:

- Ватанабэ, чи “Драмын түүх”-ээ тэмдэглэж байгаа юу? хэмээн асуулаа.

- Тэмдэглэлгүй яахав.

-Дэвтрээ түр өгөөч. Би хоёр удаа тасалчихсан. Чамаас өөр таних хүнгүй.

Би дэвтрээ гаргаж ирээд илүү дутуу юм бичсэн эсэхээ шалгаад Мидорид өглөө.

- Баярлалаа. Чи нөгөөдөр сургууль дээр ирнэ биз дээ?

- Ирнэ ээ.

- Тэгвэл арван хоёр цагт энд хүрээд ирээч. Дэвтрийг чинь өгөнгөө хоолоор дайल्या. Хүнтэй юм идвэл гүйлгэчихгүй биз дээ?

- Хаанаас даа. Дэвтрээ өглөө гээд хоолонд орохоор их хэрэг хийсэн биш.

- Зүгээр дээ. Би хүн баярлуулах дуртай. Мартахгүй биз? Тэмдэглээд авах юм уу?

- Мартахгүй дээ. Нөгөөдөр арван хоёр цагт энд уулзъя.

Ширээнийх нь залуус “Мидори, хурдал л даа. Хөрчихлөө шүү дээ!” гэхэд бүсгүй тоосонгүй.

- Чи угаасаа л ингэж ярьдаг байсан уу?

- Магадгүй л юм. Хэл яриагаа анзаарч байсангүй.

Урьд нь хэн нэгэн намайг этгээд ярьдаг гэж хэлж байсангүй.

Бүсгүй хэсэг зуур бодолхийлж сууснаа инээмсэглээд, ширээ рүүгээ явлаа. Тэндээс гарахдаа хажуугаар нь өнгөрвөл Мидори гараа даллана. Нөгөө гурав нь намайг хальт харснаас цаашгүй.

Лхагва гарагийн арван хоёр цаг болсон ч зоогийн газарт Мидори үзэгдсэнгүй. Мидориг хүлээнгээ шар айраг уух гэсэн боловч хүн олширч хоолоо захиаллаа.

Арван хоёр гучин тавд хооллож дууссан ч Мидори ирээгүй л байлаа.

Тооцоогоо хийж, шар айрагнаыхаа үнэрийг дарангаа зоогийн газрын өөдөөс харсан жижигхэн сүмийн чулуун хашлага дээр нэг цаг хүртэл Мидориг хүлээж суув. Мидори ирсэнгүй. Номын сан руу зүглэж, хоёр цагаас герман хэлний хичээлдээ суулаа.

Хичээл тарсны дараа сургалтын албаар орж “Драмын түүх”-ийн бүлгээс нэрээр нь хайвал Мидори гэсэн нэртэй нэг хүн байсан нь

Кобаяши Мидори. Үүний дараа биоюутнуудын картан дундаас 1969 онд элссэн Кобаяши Мидориг олж, гэрийнх нь хаяг, утсыг тэмдэглэж авав. Тэрээр Тошима дүүрэгт орших хувийн байшинд амьдардаг ажээ. Утасны автоматаас түүн рүү залгахад харилцуурын цаанаас нэгэн эр:

- Кобаяшигийн номын дэлгүүр! гэх нь сонсогдов. Номын дэлгүүр гэхийг нь сонсоод балмагдсан ч:

- Уучлаарай, Мидори байна уу? гэвэл:

- Одоохондоо алга.

- Хичээлдээ яваа юу?

- Эмнэлэг рүү явах шиг болсон. Та хэн бэ?

Би “Баярлалаа” гээд нэрээ хэлэлгүй утсаа салгалаа. Эмнэлэг явсан гэнэ ээ? Гэмтэж бэртсэн юм болов уу? Эсхүл өвдөө юм болов уу? Тэр эрэгтэй “Эмнэлэг рүү явсан” гэх хэлэхдээ “Дэлгүүр явсан” гэсэн шиг огт санаа зовсон шинжгүй байсан даа. Эмнэлэг түүний ахуй амьдралын нэгээхэн хэсэг гэлтэй өнгө аяс цухалзав.

Энэ тухай эргэцүүлж бодсоор байрандаа ирж, Нагасавагаас авсан Жозеф Конрадын Lord Jim-ийг уншиж дуусгаад, номыг нь өгөх далимаар өрөөнд нь очлоо. Нагасава хоолонд орох гэж байсанд зам нийлж, хамтдаа хооллов.

- Яамны шалгалт чинь дажгүй юу?

Найман сард авсан Гадаад хэргийн яамны хоёр дахьшатны шалгалтыг Нагасава ер тоосон шинжгүй сууна.

- Дажгүй ээ. Дундаж дүн авахад л тэнцэнэ. Ямарч газрын ярилцлага нэг тиймэрхүү байдаг. Охинэргүүлэхээс ер ялгаагүй!

- Амархан байжээ дээ? Дүн нь хэзээ гарах вэ?

- Арван сарын эхээр. Тэнцвэл сайхан дайлна аа.

- Гадаад яамны хоёр дахь шатны шалгалт гэж ямар юм байнааа? Чам шиг хүмүүс л орж байна уу?

- Юу гэж. Ихэнх нь мулгуу амьтад байна лээ. Тэнэг биш бол солиотой. Албан тушаалын төлөө үхэн хатан тэмцдэг хүмүүсийн зууны ерэн тав нь хог хаягдлууд байдаг. Үнэн шүү! Олигтойхон юм унших ч чадваргүй амьтад.

- Тэгвэл чи Гадаад яаманд орж яах нь вэ?

- Гадаадад ажиллах гээд элдвийн шалтгаан байна аа. Гадаадад ажиллаж үзмээр байна. Гэхдээ гол нь чадлаа сорих гэсэн юм. Төрийн албанд хэр өндөрт мацаж гарахаа сорьж үзье. Ойлгож байна уу?

- Тогломоор санагдсан юмаа даа?

- Тэгж хэлж болох л юм. Эрх мэдэл, мөнгө төгрөгөнд шунасандаа ч биш. Хувиа бодсон, дураараа зантай ч тиймэрхүү зүйлд шунадаггүй. Шунал тачаалгүй хүн гэх үү дээ. Сониуч зан л байна. Уудам боловч хахир хатуу энэ хорвоод хаахна яваагаа мэдэж, чадал чансаагаа сорьж үзмээр санагдах юм.

- Чамд ер нь хүсэл тэмүүлэл гээч юм байна уу?

- Амьдралд хүсэл тэмүүлэл хэрэггүй ээ. Амьдралын тодорхой хэм хэмжээ байхад л хангалттай.

- Гэхдээ л үй олон хүн энэ хэм хэмжээ гээчийг мэдэхгүй өдөр хоногоо өнгөрөөдөг шүү дээ.

- Амьдралын минь хэв маяг чамд таалагддаггүй гэж үү?

- Больж үз. Таалагдах, таалагдахгүй нь хамаагүй. Чи бод доо. Би Токиогийн их сургуульд орж чадахгүй. Хүссэн үедээ дуртай бүсгүйтэйгээ унтаж хэвтэхээр яриа хөрөөтэй хүн биш шүү дээ. Энэ хорвоо дээр намайг хүндэлдэг хүн гэж үгүй. Найз охин ч байхгүй. Хоёрдугаар зэргийн хувийн сургуулийн хүмүүнлэгийн ангиа төгсөөд

яах юм бүү мэд. Ийм байхад чиний амьдрал таалагдахгүй байна гэж хэлж зүрхлэхгүй шүү дээ.

- Тэгвэл надад атаархдаг хэрэг үү?

- Үгүй дээ. Би энэ байдалдаа дасчихсан. Үнэндээ Токиогийн их сургууль, Гадаад яам надад хамаа ч алга. Хацуми шиг найз охинтойд чинь л атаархах юм.

Нагасава хэсэгтээ л дуугаа хурааж, хоолоо идэж дуусаад:

- Ватанабэ, сургуулиа төгсөөд арав, хорин жилийн дараа бид хоёр хаа нэгтээ эргэж уулзах байх даа. Тэгээд тэр үед ямар нэг сэжмээр холбогдож таараа гэхэд би өөрийн эрхгүй инээд алдан:

Диккенсийн зохиол шиг л ярих юм гэж билээ.

- Нээрээ тийм байна шүү. Гэхдээ би ч зөнтэй дөг өө. Ингээд бид хоёр хажуугийн кафед орж, ес хүртэл ууж суулаа.

- Чи ер нь ямар зарчмаар амьдардаг хүн бэ?

- Инээд чинь хүрнэ.

- Юу гэж шоолох вэ?

- Ер нь эр хүн шиг л эр хүн явах юмсан гэж боддог юм. Би инээд алдаагүй ч сандлаасаа унах дөхлөө.

- Тэгэхээр жинхэнэ эр хүн байх зарчимтай юм бий?

- Тийм ээ.

- Тэгээд ямар хүнийг жинхэнэ эр хүн гэх вэ? Тодорхойлолт гэж юм бий дээ.

- Жинхэнэ эр хүн зоргоороо авирлалгүй, хийх ёстой зүйлээ хийдэг юм даа.

- Миний мэдэх хүмүүсээс чи тэс ондоо.

- Харин чи бол миний мэдэх хүмүүсээс хамгийн цэгц шулуун гэж хэлж болохоор цорын ганц хүн.

Тэр өдөр Нагасава намайг дайлж билээ.

Дараа долоо хоногийн даваа гарагийн “Драмын түүх”-ийн лекцэнд Мидори мөн л ирсэнгүй. Ангиа тойруулж харсан ч тэр байсангүй. Урьдын адил нүүрэн талын ширээнд сууж, багш орж иртэл Наокод захиа бичив. Захиандаа зуны аялал, явсан зам, бууж мордсон хот суурингууд, уулзаж учирсан улс амьтны талаар дурдлаа.

“Шөнө болгон чамайг бодох юм. Чи надад хичнээн их хэрэгтэй болохыг одоо л ухаарах шиг боллоо. Өөрийгөө боловсруулахыг хичээсэндээ их сургуулийн утга учиргүй хичээлд уйгагүй сууж байна. Чамайг явснаас хойш сэтгэл минь эзгүйрчээ. Уулзаж тайван ярилцах юмсан. Боломжтой сон бол чамайг эргэж, хэдхэн цаг ч атугай ярьж суух сан. Болох болов уу? Урьдынх шигээ мөр зэрэгцэн алхах сан. Хэцүү ч гэлээ хэдэн мөр бичээрэй.”

Дөрвөн хуудас захиагаа цэвэрхэн нугалж, дугтуйнд хийгээд, Наокогийн төрсөн гэрийн хаягийг бичлээ.

Удалгүй лекцийн багш болох намхан бухимдуу эр орж ирээд, ирц бүртгэж, духаа арчив.

Багш хөл муутай учир таяг тулах агаад “Драмын түүх”-ийн лекц нь сэтгэл татахгүй ч мэдүүштэй зүйл ихтэй.

“Нохой гаслам халуун байх юм” гэсээр лекцээ эхэлж, Эврипидийн тухай яриад, түүний бурхад болоод Эсхилл, Софоклын бурхдын ялгааг тайлбарлана.

Арван таван хормын дараа хаалга онгойж, Мидори орж ирлээ. Биеийн тамирын хар хөх өнгийн хүрэм, даавуун өмд өмсөөд нөгөө нарны шилээ зүүжээ.

Мидори багшаас уучлал эрэн инээмсэглээд, хажууд минь суулаа. Цүнхнээсээ дэвтрийг минь гаргаж өгсөнд “Намайг уучлаарай. Лхагва гарагт очиж чадсангүй. Гомдоогүй биз?” гэсэн зурвас хавчуулжээ.

Лекц дундаа орж, багш самбар дээр Эртний Герегийн театрын тайз зурж байх үест хамгаалалтын малгай духдуулсан хоёр оюутан орж ирлээ. Хошин шогийн үзүүлбэрт гардаг шиг нэг нь өндөр цагаан, нөгөө нь намхан бөгөөд дугуй бор царайтай, огт зохиогүй жирвээ сахалтай ажээ.

Өндөр залуу нь ухуулгын хуудас барьжээ. Намхан залуу нь багшид ойртоод “Лекцийн үлдсэн цагийг хэлэлцүүлэгт ашиглахыг зөвшөөрнө үү? Эртний Герегийн эмгэнэлт жүжгээс илүү чухал асуудал даян дэлхийд тулгамдаад байна” хэмээв.

Энэ хүслээ багшид бараг л тулган шаардсан гэж болно. Багш “Энэ мөчид чухамдаа Герегийн театрын урлагаас амин чухал зүйл байхгүй гэдэгт бүрнээ итгэлтэй. Гэвч иймэрхүү хүмүүст юу ч хэлээд нэмэргүй хойно дураараа болцгоо” гээд ширээний захаас зууран индрээс бууж, хөлөө чирэн, таягаа тулсаар гарч одов.

Өндөр нь хуудсаа тараах үед намхан нь индэр дээр гарч үг хэллээ. Хуудсан дээр үзэл бодлоо товч бөгөөд тодорхой илэрхийлэх энгийн хэв маягаар бичсэн “Оноогоор жагсаах ректорын зарчмыг халах хэрэгтэй!”, “Оюутнуудын шинэ бослогод бүх хүчээ дайчлан орьё!”, “Үйлдвэрлэл, шинжлэх ухааныг хөхүүлэн дэмжих Япон орныг орвонгоор нь эргүүлбэр!” гэх зэргийн хэдэн өгүүлбэр дурайна.

Үзэл санаа нь хачин сайхан хэдий ч ханцуй шамлан тэмцэлд нэгдэх хүсэл төрүүлэмгүй, итгэл үнэмшил муутай юмаа. Намхан залуу хэлсэн үгээ хаа нэгтгээгээс хуулбарласан ч юм шиг. Уриа лоозон нь өөрчлөгдсөн ч улиг болсон өнөө л бослого. Тэдний гол дайсан нь төр засаг бус, харин эрэмдэг зэрэмдэг оюун санаа нь гэлтэй.

Мидори “Хоёулаа гаръя” гэсэнд би толгой дохин дагаж гарвал намхан залуу араас нэг юм хэлж байна. Мидори түүнд “Баяртай” гээд гараа даллан гарлаа.

- Бид хоёр хувьсгалын эсэргүүнүүд боллоо доо. Хувьсгал ялбал хоёуланг маань утасны нэг шонд дүүжлэх биз гэхэд нь би:

- Дүүжлүүлэхээсээ өмнө хоолонд орох хэрэгтэй юм байна даа гэж хэлээд инээд алдсан сан.

- Яг үнэн. Хоёулаа холхон ч гэсэн нэг газар очъё. Завтай биз дээ?

- Хоёр цагаас хичээлтэй болохоор амжина аа. Эднээс мултарсан хойно явъя.

Ингээд бид хоёр автобусаар Ёцүя орж, Мидори намайг эндхийн нэг мухрын цайны газарт авчирлаа.

Ширээнд суумагц улаан чийтэй хайрцганд хийсэн хоол, шөл авчирч тавив. Автобусаар зорьж ирэхэд аятайхан газар юм.

- Амттай байна шүү.

- Бас хямдхан. Би сургуульд байхын л энд ирдэг байсан юм. Сургууль маань ойрхон байдаг ч чанга дэглэмтэй болохоор энд нууцаар ирнэ дээ. Багш мэдвэл улираана шүү дээ.

Нүдний шилгүй Мидори нэг л нойрмог харагдана. Зүүн гартаа зүүсэн нарийхан мөнгөн бугуйвчаа байн байн оролдож, чигчий хуруугаараа нүдээ ухна.

- Нойр чинь хүрээ юу?

- Харин тийм ээ. Нойр дутуу. Өчигдөр ажил ихтэй, завгүй байлаа. Гэхдээ санаа зоволтгүй ээ. Эртээд очиж чадаагүй. Намайг уучлаарай. Хар өглөөгүүр чухал ажил гараад яаж ч чадсангүй. Зоогийн газар луу ярих гэсэн ч нэрийг нь санадаггүй. Гэрийн чинь утсыг мэдэхгүй болохоор яаж ч чадсангүй. Намайг удаан хүлээсэн үү?

- Гайгүй ээ. Завтай байдаг болохоор зүгээр.

- Тийм их завтай гэж үү?

- Болдог сон бол энэ их цагийг чамтай хуваалцаж унтуулмаар л байна шүү.

Мидори шанаагаа тулан инээмсэглэнэ.

- Чи иххаламжтай юм.

- Халамжтайдаа биш ээ. Хийх юмгүйдээ л тэр. Тэр өдөр танайх руу ярьсан чинь нэг хүн чамайг эмнэлэг явсан гэсэн. Чи зүгээр үү?

- Манай утасны дугаарыг чи хаанаас мэдсэн юм бэ?

- Сургалтын албанаас авсан. Хэн бугайн ч утасшөрмөсийг олоод авчих боломжтой.

Мидори хэд хэд толгой дохиод бугуйвчаа оролдоно.

- Аан. Би мэдээгүй л дээ. Танай утсыг бас авч болох юм байна, тийм үү? Эмнэлгийн тухай дараа больё. Одоо тэр тухай ярьмааргүй байна. Ойлгоно биз дээ?

- Зүгээр ээ. Чиний хэрэгт хошуу дүрчихлээ.

- Үгүй ээ. Ойрдоо нэлээд ядраад...

- Харьж унтаач.

- Унтмааргүй байна аа. Жаахан алхах уу?

Мидори намайг Ёцуягийн хажууханд байх охидынахлах сургуульдаа дагуулж очив.

Энэ хавиар өнгөрөнгөө би Наоког, түүнтэй зугаалжявснаа нэхэн дурслаа. Тэр мөчөөс л энэ бүхэн эхэлсэндээ. Хэрэв зээ би тэр 5 сарын нэгэн ням гарагт метрондНаокотой тааралдаагүй бол амьдрал өөрөөр эргэх байлаа. Гэсэн ч тэр өдөр учирдаггүй юмаа гэхэд хожмоо нэг нартай өдөр нүүр тулах нь мэдээж. Ингээд бодох нь ээ, Наоко бид хоёр заяа төөргөөрөө уулзаж учирсан биз ээ.

Мидори бид хоёр цэцэрлэгийн модон сандал дээр суугаад сургуулийнх нь байшинг ажиглалаа. Ханаар нь мөлхөө өвс ургаж, дээвэр дээр нь хэдэн тагтаа суух юм. Эрт үеийн сүртэй барилга юмаа. Хашаанд нь ургах том

царсны хажуухнаас цагаан утаа эгц дээшээ суунаглаж, нарны хурц туяанд сарнина. Мидориг:

- Ватанабэ, чи энэ юуны утаа болохыг мэдэх үү? гэж асуухад:

- Мэдэх юм алга гэвэл өөдөөс:

- Эмэгтэй хүний ариун цэврийн хэрэглэл шатаасан утаа гэдэг юм байна. Би ч:

- Хм... гэхээс өөр хэлэх үг олсонгүй.

Мидори инээсээр:

Янз бүрийн ариун цэврийн хэрэгсэл... охидын сургууль болохоор хогийн саванд хаясан хэрэглэлүүдийг нь жижүүр түүж аваад зууханд шатаадаг юм. Тэгээд л энэ утаа гарна даа гэв.

- Гунигтай л юм.

- Би ч гэсэн энэ утааг ангийнхаа цонхоор харж суухдаа гунигладаг байлаа. Манай сургуульд бараг мянгаад хүүхэд сурдаг байсан юм. Есөн зуугаадынх нь сарын тэмдэг ирчихсэн. Өдөр болгон таван хүний нэгнийх нь сарын тэмдэг ирдэг гэж бодвол зуун наяд охин болно доо. Бүгдээрээ л өдөр болгон ариун цэврийн хэрэглэлээ хаяна. Тийм ээ?

- Тийм байх аа. Би ч тоондоо маруухан даа.

- Зуун наян хүний хэрэглэлийг цуглуулж аваад шатаавал ч овоо юм болно доо. Шатааж байгаа хүн юу боддог бол?

- Төсөөлж чадахгүй л юм.

Үнэндээ энэ талаар өөр яаж ч бодолтой билээ? Бид хоёр хэсэгтээ л тэр утааг харж суулаа. Мидори толгой сэгсэрнэ.

- Үнэндээ би энэ сургуульд орьё гэж бодоогүй. Энгийн хүүхдүүдийн жирийн сургуульд явж, зоргоороо явмаар байсан ч аав, ээжийнхээ бардам зангаас болж энд орсон.

Сурлага сайтай хүүхдийг багш нар “Толгой сайтай юм чинь ийм сургуульд хөнгөхөөн орчихно” гэдэг дээ. Тэгээд л энд зургаан жил сурсан. Хурдхан төгсөх юмсан гэхээс өөр юм бодож явсангүй. Сургуульдаа дургүй хүрдэг ч хичээлээ тасалж, хоцорч байгаагүй болохоор баярын бичиг авсан. Яагаад сургуульдаа дургүй байсан гээч?

- Яагаад?

- Энэ газарт би анхнаасаа л дургүй байсан юм. Тийм болохоор нэг ч удаа хичээлээ таслаагүй. Аль нь дийлэхээ үзье гэж бодоод. Нэг л дийлдчихвэл тэр чигтээ уруудаад явчихна. Гучин ес хүртлээ халуурсан ч сургуульдаа гэлдэрнэ дээ. Багш “Хөөе, Кобаяши, бие чинь муу байна уу даа?” гэсэн ч би шүдээ зуугаад л зүгээр гэж худал хэлнэ. Төгсөхдөө хоцролт, таслалтгүй гээд баярын бичиг, франц хэлний толь бичиг бэлгэнд авсан. Дургүй хүрээд өгсөн бэлгийг нь ашиглахгүй гэсэндээ их сургуульд зориуд герман хэл сонгосон. Өөрийнхөөрөө амьдарч үзмээр байна шүү дээ.

-Тэгээд яагаад сургуульдаа дургүй байсан юм бэ?

- Чи сургуульдаа дуртай байсан уу?

- Дуртай, дургүй гэж хэлэх ч хаашаа юм бэ. Жирийн сургуульд сурч байсан болохоор ингэж бодож явсангүй.

- Энэ сургуульд чинээлэг айлын сурлага сайтай охид сурдаг юм. Төлбөр ихтэй. Байнга л хандив цуглуулна. Киото руу аяллаар явахдаа бүхэл бүтэн зочид буудалд бууна гээч. Тэгээд л цайны ёслолын үеэр лакдсан модон ширээнд суугаад хоол иднэ. Жилд нэг удаа Токиогийн хамгийн үнэтэй зочид буудалд боловсон зан сурна. Хэцүү дээ! Манай бүлгийн зуун жаран хүүхдээс манайх л Тошимад байлаа. Нэг удаа

хүүхдүүдийн гэрийн хаягийг сонирхоод харсан чинь Чиёдагийн 3-р гудамж, Минатогийн Мотоазабү, Оотагийн Дэнъэнчөфү, Сэтагаягийн Сеижо гээд л дандаа баячуудын хорооллынхон. Чибад амьдардаг нэг охинтой л би найзалдаг байсан даа. Сайн охин шүү. “Жаахан хол ч гэсэн манайд очъё” гэхээр нь зүгээр ээ гээд очоод цэцэрлэгийг нь л үзэх гэж арван таван минут болсон доо. Хашаанд нь эгээтэй л жижиг оврын машин шиг хоёр том нохой үхрийн мах зулгааж байгаа юм чинь. Чибад амьдардаг, бенцээр сургуульдаа явдаг тэр охин үүнээсээ их л санаа зовдог байж билээ. Тэднийх яг л кинон дээр гардаг шиг бүрх малгай духдуулж, цагаан бээлий өмссөн жолоочтой. Гэсэн ч тэр ичдэг байсан. Хүн ийм юмнаас ичнэ гэж байх уу?

Би толгой дохилоо.

-Манай Тошимагийн Кита-Оцүка шиг газар амьдардаг хүүхэд нэг ч байгаагүй. Тэр тусмаа аав нь “Номын дэлгүүрийн эрхлэгч” хийдэг хүүхэд байхгүй. Ангийнхан маань хүссэн үедээ дуртай номоо уншдаг гээд л надад атаархахыг нь яана. Ёстой тэнэг! Тэд “Кинокүния” шиг жигтэйхэн том дэлгүүртэй л гэж төсөөлөхөөс биш жижигхэн юм санаанд нь орохгүй. Үнэндээ манай Кобаяшигийн дэлгүүр гэж өрөвдөлтэй юм байдаг. Эсэн бусын сэтгүүл зардаг. Хамгийн их гүйлгээтэй нь энгэр зөрүүлэх элдвийн арга барилтай, зурган хавсралтгай эмэгтэйчүүдийн сэтгүүлүүд. Тэр хавийн эмэгтэйчүүд тийм сэтгүүл авч хариад, гал тогооныхоо өрөөний ширээнд суугаад, зураг хөргийг нь үзээд л судалж гарна даа. Тэгээд нөхрүүдээ ирэнгүүт нь туршина. Нөхөрт гарсан эмэгтэй өөр юү ч хийх билээ? Комиксуудаас гадна Magazine, Sunday, Jump, долоо хоног тутмын сэтгүүлүүд сайн зарагдана. Тэгээд уран зохиолын хэдхэн ном л борлуулалт сайтай. Далд ертөнц, адал явдал, хайр дурлалын романуудаас өөр зохиол бараг зарагдахгүй дээ. Дээрээс нь Даам тоглох ёсон, Бонсаи, Хуримын ёслолын дэг жаяг, Сексийн талаар мэдэх шаардлагатай баримтууд, Тамхинаас хэрхэн гарах вэ гэх мэтийн жижиг сажиг ном гүйх нь их дээ. Манайх бас бичгийн хэрэгсэл зарна. Кассынхаа хажууд хэдэн үзэг бал, дэвтэр зэргээ өрдөг юм. Дайн ба Энх, Кэнзабуро Оэгийн Тачаангүй хүн, Хөх тариан талбайн дундуур байхгүй ээ. Кобаяшигийн дэлгүүр гэж нэг иймэрхүү л юм байдаг юм. Гайхуулаад байх юмгүй.

- Төсөөлж л байна.

- Манайх иймэрхүү л дэлгүүртэй. Тэр хавьдаа ном сэтгүүл хүргэнэ. Байнгын үйлчлүүлэгчид олонтой болохоор бид дөрөв тов хийтэл амьдарчихна даа. Өр зээл байхгүй. Хоёр охиноо их сургуульд сургачих бүрэн боломжтой. Илүү гарах юмгүй болохоор энэ сургуульд оруулах хэрэггүй л байсан юм. Зовлонгийн нэмэр шүү дээ. Ингэж бодохоор бачимдахыг минь яана. Хандив цуглуулах тоолонд аав, ээж маань үглэнэ. Ангиараа нэг газар орох бол мөнгө хүрэхгүй үнэтэй газар орчих вий гээд л сэтгэл зовно. Хэцүү л байлаа. Харин танайх чинээлэг үү?

- Манайх уу? Аав маань жирийн нэг компанийн албан хаагч. Дундаж айл ч гэлээ ганц хүүгээ Токиод сургах гэж хэрэндээ хичээсэн дээ. Бага зэрэг мөнгө явуулдаг болохоор би цагийн ажил хийдэг. Жирийн л айл. Багахан газартай, Тоёота Королла-тай.

- Чи хаана ажилладаг юм бэ?

- Долоо хоногт гурван өдөртөө Шинжюкүгийн пянзны дэлгүүрт оройн ээлжинд ажилладаг. Биед амар. Лангуугаа хараад л сууна даа.

- Тийм үү? Чамайг хараад мөнгө олох гэж зүдэрдэггүй гэж бодож байлаа.

- Тийм дээ. Үнэндээ л зүдэрч үзээгүй. Зүдэрч олох хэмжээний мөнгөгүй. Ийм амьдралтай хүн олон доо.

Мидори хоёр гарын алгаа өвдгөн дээрээ дээш харуулан тавиад:

- Манай сургуульд чинээлэг айлын хүүхдүүд явдаг байсан болохоор хэцүү байсан юмаа гэв.

- Одоо тэгвэл орчлон хорвоотой танилцах цаг нь ирж дээ.

- Чинээлэг байхын давуу тал нь юу гээч?

- Мэдэхгүй юм.

- Мөнгөгүй гэдгээ шулуухан хэлж болдог нь л сайхан. Жишээ нь, би ангийнхаа охинтой нэг газар оръё гэхэд тэр мөнгөгүй гээд шуудхан хэлчихнэ. Харин би тэгж хэлж чадахгүй. Тэгээд хэлчихвэл үнэндээ л халаас хоосноо хэлсэн болж бусдын доог тохуу болно шүү дээ. Царай зүс сайтай нэгэн “Будаг шингэхгүй байна. Гадагшаа гарахгүй” гэхэд хүн анзаарахгүй бол царай муутай нэгэн ингэж хэлбэл хүмүүс шоолохтой л адилхан. Өнгөрсөн жил хүртэл зургаан жил ингэж амьдарлаа.

- Яваандаа мартаж байлгүй.

- Хурдан мартаж юмсан. Их сургуульд ороод жирийн хүмүүстэй харилцаад сэтгэл хөнгөрсөн.

Мидори ялимгүй инээмсэглээд үсээ иллээ.

- Чи цагийн ажил хийдэг үү?

- Хийдэг шүү. Газрын зурагны тайлбар бичдэг. Газрын зурагтай дагалдаж ирдэг жижигхэн ном байдаг даа. Тэр хотын үүх түүх, хүн ам, дурсгалт газар, нутгийн домог яриа, аяллын маршрут, ан амьтны тухай бичдэг. Хибиягийн номын санд нэг өнжөөд л бүхэл бүтэн ном зохиочих боломжтой. Амархан. Жаахан сэргэлэн байхад ажил мундахгүй.

- Сэргэлэн гэхээр яана гэж?

- Сонирхол татахуйц, бусдын бичээгүй юм оруулах хэрэгтэй. Тэгвэл захиалагчид “Энэ ч аятайхан бичдэг юм байна” гэнэ. Зарим нь бишрэх нь халаг! Чухал биш ч гэсэн жижигхэн юм шигтгэчих хэрэгтэй. Жишээ нь, “Энэ боомтыг барихын тулд эрэг орчмын нэг тосгоныг шилжүүлсэн бөгөөд хавар ирэх бүрдээ нүүдлийн шувууд үүнийг дурсах мэт эргэлдэн ганганалддаг” гэвэл хүмүүс их дуртай. Уянгын халилтай байгаа биз дээ? Тайлбар бичдэг залуус үүнийг мэддэггүй юм. Тийм болохоор иймэрхүү юм бичээд дажгүй мөнгө олдог.

- Энэ болгоноо хаанаас олж мэдэх вэ?

- Эрээд байвал олдоно оо. Олдохгүй бол аятайхан зохиочихно.

- Тийм дээ! хэмээн уулга алдахад Мидори:

- Peace! гэсээр тосч авлаа.

Мидори оюутны байрны тухай сонирхоход би төрийн далбааны ёслол төгөлдөр үйл ажиллагаа, Довтлогчийн өглөөний дасгалын тухай ярив. Довтлогчийн тухай ярихад Мидори элгээ хөштөл инээнэ. Мань хүн хүн бүрийг инээлгэх онцгой чадвартай ажээ. Мидори дотуур байранд орж үзмээр байна гэсэнд би:

- Сонирхоод байх юмгүй. Хөглөрсөн өрөөндөө архи ууж, гар хангалга хийдэг хэдэн зуун эрээс өөр юм байхгүй гэлээ.

- Чи ч бас тэгдэг үү?

- Эрчүүд бүгдээрээ л тэгдэг. Охидын сарын тэмдэг ирдэг шиг лхэвийн үзэгдэл. Хэн хүнгүй ялгаагүй.

- Секс хийдэг найз охинтой ч гэлээ тэгдэг гэж үү?

- Түүндээ биш ээ. Жишээ нь, манай хажуу өрөөний Кейод сурдаг залуу гар хангалга хийгээд болзоонд явдаг. Сэтгэл нь амардаг гэнэ билээ.

- Охидын сургуульд явдаг байсан болохоор би ойлгохгүй юм байна.

- Тэр ч тэгнэ. Эмэгтэйчүүдийн сэтгүүлд энэ тухай ямар бичих биш.

Мидори тас тас хөхрөөд:

- Тийм дээ. Ватанабэ, энэ бүтэн сайнд чи завтай юу? гэлээ.

- Бүтэн сайнд зургаан цаг хүртэл завтай байдаг юмаа. Зургаад ажилтай.

- Тэгвэл манай Кобаяшигийн номын дэлгүүрт хүрээд ирээч. Дэлгүүр онгойхгүй ч би гэртээ утас сахина. Хамт хооллоё. Би хоол хийчихнэ.

- Дуртайя очно оо.

Мидори дэвтрээсээ нэг хуудас урж аваад, гэр хүртэлх замаа тодорхой зурж, байшингаа улаан балаар “Х” үсэг тавьж тэмдэглэв.

- Гаднаа Кобаяшигийн номын дэлгүүр гэсэн томоо хаягтай. Арван хоёрын алдад хүрээд ирээрэй. Би хоол хийчихье.

Би цаасыг нь авч халааслаад, төдхөнөө хоёр цагаас орох герман хэлний хичээлдээ суухаар, Мидори хаашаа ч юм бэ явахаар Ёцүягийн буудлаас метронд суулаа.

Ням гарагийн өглөө би есөн цагт босч, сахлаа хусаад хувцас хунараа угааж, дээвэр дээр дэлгэв. Тогтуун сайхан намрын өдөр байлаа. Ойр хавийн хүүхдүүд зүлгэн дээр нисэх улаан царцаануудыг хөөж, тор барин гүйлдэнэ. Салхигүй болохоор төрийн далбаа унжжээ.

Цамцаа чамбай гэгч нь индүүдэж өмсөөд трамвайн буудал руу алхлаа. Оюутны хотхон эл хуль байх агаад ихэнх дэлгүүрүүд үүдээ барьжээ.

Нам гүмхэн орчинд ялаа дүнгэнэх нь дуулдах шиг. Модон өсгийтэй гутал угласан эмэгтэй асфальтан замаар тог тогхийлгэн хөндлөн гарч, депогийн хажууханд дөрөв таван хүүхэд эгнүүлж тавьсан хоосон лааз өөд чулуу шидэлнэ.

Цэцгийн лангуунаас хэдэн хонин нүдэн цэцэг авч, трамвайд орвол гурван эмгэнээс өөр хүн байсангүй. Намайг суухад тэр гурав над руу эргэж, нэг нь гартаа барьсан цэцгийг минь хараад үл ялиг мишээлээ. Хариу инээмсэглээд эрээлжлэн өнгөрөх байшингуудыг ажиглан захын суудалд суув. Трамвай хуучин байшингуудыг шүргэх шахам хурдална.

Нэгэн байшингийн тагтан дээр улаан лоолийн суулгацтай хэд хэдэн сав байх агаад хажууханд нь томоо хар муур наранд биеэ ээнэ. Хөөсөн бөмбөлөг үлээх жаалхүү нүдний үзүүрт өртлөө. Хаа нэгтээгээс Ишида Аюмигийн дуу эгшиглэж, карриний үнэр ханхийнэ.

Төрсөн нутгийг минь санагдуулах гудамжаар трамвай шунгинан өнгөрнө. Нэгэн буудлаас хэдэн зорчигч суухад гурван эмгэн ам булаалдан ярилцсаар.

Би Оцүкагийн буудал дээр бууж, Мидоригийн зурсан зургаар баримжаалан алхлаа. Усны дусал шиг адилхан гудамжны лангуунууд нүд эрээлжлүүлэх ч эзэд нь хөлжиж дэвжсэн шинжгүй. Дэлгүүрийн хуучин барилгуудад гэрэл нэвтэрдэггүй мэт. Зарим хаяг нь барагтай бол баларчээ.

Энэ дүүрэг дайны бөмбөгдөлтөд өртөөгүй бололтой, хуучны барилгуудтай юм. Ихэнх байшингуудыг өргөтгөсөн боловч, энэ нь өнгө алдсан хуучин барилгаасаа долоон дор болжээ. Уугуул оршин суугчид нь машин тэрэг, агаарын бохирдол, чимээ шуугиан, түрээс ихтэйн улмаас хотын зах руу дайжиж, хямдхан байр, компанийн орон сууцанд амьдрагсад болоод нүүхэд хүчир дэлгүүрүүд болоод хэдэн үеэрээ суурьшсан хүмүүс л үлдсэн бололтой. Хаа сайгүй савсах машины угаараас үүдэн байшин барилгууд нь бүүдийн сааралтжээ.

Арваад хормын дараа би шатахуун түгээх станцаас нэлээн хэдэн дэлгүүртэй гудам руу баруун эргэж, тэр дундаас Кобаяшигийнномын дэлгүүр гэх хаягийг олж харлаа.

Том гэхээргүй ч Мидоригийн ярьсан шиг жижигхэн дэлгүүр биш юмаа. Хаа сайгүй таарах номын дэлгүүрүүдээс ялгарах юмгүй. Багадаа хүүхдийн сэтгүүлийн шинэ дугаар гарахыг тэсэн ядан хүлээж, иймэрхүү дэлгүүрээс авдаг байлаа. Кобаяшигийн дэлгүүрийн үүдэнд зогсонгоо балчир насаа дурсан санагалзав. Хаа ч явсан нэг иймэрхүү дэлгүүр байдаг даа.

Хаалганы төмөр хаалтан дээр “Пүрэв гараг бүр Shuukan Bunshun (долоо хоног тутмын Уран зохиолын хавар сэтгүүл, орч) сэтгүүлийн шинэ дугаар ирнэ” хэмээн бичжээ. Арван хоёр цагт арван таван минут дутуу байсан тул цэцгээ барьсаар тэр хавиар сэлгүүцсэн ч хийх юмаа олж ядаад, хонхыг нь дарлаа. Хаалганаас нь хоёр алхам холдоод арваад секунд хүлээсэн ч чимээ гарсангүй. Дахиад дарах гэтэл хоёр давхрын цонх онгойж, Мидори цухуйгаад гараа даллан:

- Хаалтаа сөхөөд ороод ир хэмээн хашгирав.

- Би арай эрт ирчихэв үү дээ?

- Зүгээр ээ. Дээшээ гараад ир. Би гарч чадахгүй нь.

Ингэж хэлээд Мидори цонхоо хаачихав.

Төмөр хаалтыг нь тар няр хийлгэн метрийн дайтай өргөөд дотогш шургаж ороод буцааж хаалаа. Дотор харанхуй гэж жигтэйхэн. Буцаахаар боосон сэтгүүлд бүдэрч унахаа шахаж тэмтэчсээр шат руу дөхөөд гутлаа тайлж дээш гарлаа.

Эднийх харанхуй юм. Дээш гарвал зочны давчуухан өрөө байх ажээ. Арваад жилийн өмнө үзсэн польшийн нэг кинонд иймэрхүү байр гарч билээ. Жижигхэн өрөөнд цонхны цаанаас бүдэг гэрэл тусна. Зүүн талдаа агуулахтай. Зочны өрөөний баруун талын огцом шатаар болгоомжтой өгсөж, хоёр давхарт гарвал хамаагүй гэрэлтэй. Сэтгэл онгойх шиг боллоо.

- Наашаа хүрээд ир! гэх Мидоригийн дуу гарна. Шатны баруун талд гал тогоо байх агаад ширээ сандал, тавилга шүүгээ, угаалтуур зэргийг нь шинээр сольсон болтой гялалзаж гялтганана. Мидори хоол хийж байлаа. Тогоотой шөл пор пор хийн буцалж, шарсан загасны үнэр ханхийнэ. Мидори эргэж хараад:

- Хөргөгчинд шар айраг бий. Уугаад наанаа сууж бай! гэв.

Хөргөгчнөөс нь хэдэн сар хадгалсан гэмээр шүд хага ташим хүйтэн шар айраг авч суугаад уулаа. Ширээн дээр үнсний жижиг цагаан сав, сонин сэтгүүл, цуунаас гадна цаас харандаа байх ажээ. Цаасан дээр хэдэн утасны дугаар, авсан юмны үнээ жирийтэл бичжээ.

- Арван минутын дараа боллоо. Суугаад хүлээж бай. Чадна биз дээ?

- Чадалгүй дээ.

- Тэгвэл хоол идэхдээ бэлдээд сууж бай. Ахиухан иднэ шүү!

Шар айраг шимэнгээ нуруугаа харуулан зогсох Мидориг ажлаа. Мидори хэзээний эзэгтэй хүн шиг хөдөлж, дөрвөн ч хоол зэрэг хийх

юм. Тогоотой хоолноосоо амсангаа ногоо хэрчиж, хөргөгчнөөс юм аваад, хэрэглэсэн аяга тавгаа угаана.

Хонх цохиж, бөмбөр нүдэн, ясан хөгжим ээлж дараалан тоглох энэтхэг хөгжимчин өөрийн эрхгүй санаанд буув. Мидори юу хийхээ андахгүй. Би энэ бүхнийг амьсгаа даран ажиглав.

- Би туслах уу?

- Хэрэггүй ээ. Ганцаараа хийгээд сурчихсан юм.

Мидори цэнхэр өнгийн бариу жийнс, Apple Record гэсэн бичигтэй алимны зурагтай хөх футболка өмсчээ. Нарийхан гуятай болохоор араасаа банди шиг харагдана.

Угаалтуурын дээд талын цонхоор тусах нарны гэрэл Мидориг хүрээлэх шиг болно.

- Ийм сүртэй хүлээн авалт хийх хэрэг байсан юм уу?

- Ямар юмных нь хүлээн авалт байхав? Өчигдөр завгүй, олигтой юм авч амжаагүй болохоор хөргөгчинд байгаагаа л хольж сууна. Нарийн ширийн хоол байхгүй. Манайхан угаасаа хүн дайлах жигтэйхэн дуртай. Зочломтгой зангаараа нэрд гараагүй ч гэлээ бүгдээрээ л ийм. Хүн ирвэл ажлаа хаяад л анхаарал тавина. Сайн уу, муу юу бүү мэд. Аав бараг уудаггүй ч манайд архи дарс байх нь элбэг. Зочдоо дайлах гэж авдаг юм. Тийм болохоор хүссэнээрээ шар айраг уугаарай.

- Баярлалаа.

Авчирсан цэцгээ гутлаа тайлсан газраа орхисноо гэнэт санаад буцаж буулаа. Газар хэвтэх арван цэцэгтэй баглаагаа барьсаар гарч ирээд Мидорид өгвөл шүүгээнээсээ шилэн сав гаргаж ирээд хийчихэв.

- Би ч цэцгэнд дуртай. Ахлах сургуульд байхдаа урлагийн үзлэгээр Долоон хонин нүдэн гэдэг дуу дуулж байлаа. Мэдэх үү?

- Мэдэлгүй дээ.

- Фолк хамтлагт гитар тоглодог байлаа.

Мидори дуу аялангаа хоолоо таваглана.

Хоол унд нь санаснаас минь хавьгүй амттай болжээ. Цуугаар амталсан амар загас, өндөгний ороомог, давсалсан балмад загас, жигнэсэн чэс ногоо, тунгалаг шөл, цуунд дарсан удвал цэцгийн үндэстэй шөл, мөөгтэй зутан хийж, кансаи маягаар давс хужрыг нь сулавтар тааруулан амталжээ.

- Сайхан амттай юм.

- Ватанабэ, чи намайг хоол сайн хийдэг гэж бодоогүй дээ?

- Үнэндээ...

- Чи Кансаигаас ирсэн болохоор давс хужрыг нь ингэж тааруулсан хоолонд дуртай биз дээ?

- Тэгээд надад зориулж кансаи маягаар амталжээ дээ?

- Хаанаас даа. Зориуд тэгнэ гэж юу байхав. Манайх дандаа ингэж амталдаг юм.

- Аав, ээж чинь Кансаигаас гаралтай юу?

- Үгүй ээ. Аав эндхийнх. Харин ээж маань Фүкүшимагийнх. Кансаид төрсөн хүн ганц ч байхгүй. Манайхан бүгдээрээ Токио, хойд Кантоогоос гаралтай.

- Тэгээд яаж Кансай маягаар хоол хийж сурсан юм бэ? Хэн зааж өгөөв?

- Энэ их урт түүх ээ. Ээж маань гэрийн ажилд дургүй, ер хоол хийж чаддаггүй байсан юм. Дэлгүүртэй болохоор ажилд дарагдаад ихэнхдээ энд тэнд хоолонд орж, эсвэл бэлэн хоол авдаг байлаа. Би багаасаа л гадуур хооллох дургүй байсан юм. Ээж нэг удаадаа гурван өдөр идэх карри хийчих нь энүүхэнд. Тэгээд дунд сургуулийн гуравдугаар ангид байхдаа хоол сайн хийж сурахаар сэтгэл шулуудсан даа.

Шинжюүгийн Кинокүния орж хоолны тухай таалагдсан номоо авч,

бичсэн бүгдийг нь хийж сурсан. Гампанз, хутгаа яаж сонгох, хутгаа ирлэх, загас цэвэрлэх, хэрчих гээд л бүгдийг нь сурсан. Тэр номын зохиолч нь Кансаин хүн байсан болохоор ингэж хийж сурсан юм.

- Ном уншаад л хоол хийж сурсан гэж үү?

- Дараа нь мөнгө цуглуулж жинхэнэ хүлээн авалтанд очдог болсон л доо. Тэндээс ч их юм сурсан. Би логик сэтгэлгээ шаардахгүй юмыг амархаан сурчихдаг юм.

- Хүнээр заалгаагүй байж ийм сайхан хоол хийж сурдаг сүрхий юм.

- Суръя гэж их хичээсэн. Гэрийнхэн маань хоол хийх дургүй, хоол ч хийдэггүй л дээ. Сайн хутга, сав суулгаар яах нь вэ? Тэртээ тэргүй байхад шинийн хэрэг байна уу? гээд мөнгө өгдөггүй хүмүүс. Хоолны талаар ямар ч ойлголтгүй. Мохоо хутгаар яаж загас цэвэрлэх вэ гэвэл тэр загасаа цэвэрлэж яах нь вэ? гэнэ. Мөнгөө цуглуулж хутга, сав суулга, шигшүүр зэргээ өөрөө авсан. Арван тав зургаатай охин халаасны мөнгөө цуглуулж сав суулга, хутга билүү авдаг гэж чи төсөөлөхгүй л дээ. Найзууд маань жигтэйхэн их мөнгөтэй ч гоё даашинз, гутал авахаас өөр юм толгойд нь орохгүй. Шударга биш байгаа биз?

Би удвал цэцгийн үндэстэй шөлнөөс оочингоо толгой дохилоо.

- Ахлах сургуулийн нэгдүгээр ангидаа өндөг шарагч авах гэж их зүдэрсэн. Өндөгний ороомог хийхэд хэрэглэдэг урт нарийн зэс хайруулын таваг. Хөхөвч авах гэсэн мөнгөөрөө авчихаад гурван сар нэг хөхөвчнөөсөө салаагүй. Орой угааж тавиад л яаж ийж байгаад хатаагаад маргааш нь өмсөөд явна. Заримдаа чийгтэй болохоор ёстой хэцүү. Өндөгний ороомог хийх гэсэндээ ингэж байна гэж бодохоор л гол харладаг сан. Чи төсөөлөхгүй л дээ.

Би инээдээ барьж дийлсэнгүй.

- Төсөөлж л байна.

- Ингэж ярих нь нүгэл ч гэлээ, ээжийг өнгөрснөөс хойш амар болсон гэх үү дээ. Дуртай юмаа авч, олон ч сав суулгатай болсон доо. Аав үрсэн мөнгийг минь хянах биш.

- Ээж чинь хэзээ өөд болсон юм бэ?

- Тархины хорт хавдраар хоёр жилийн өмнө. Жил хагас эмнэлэгт хэвтэж, их ч ядарсан. Сүүлдээ орон гаран болж, эмэндээ уусч, ухаан оролгүй байсаар амьсгал хураасан юм. Хамгийн аймшигтай үхэл. Ээж маань ч, бид ч их шаналсан. Хорин мянган иений үнэтэй тариа тариулж, асарч сувилах хэрэгтэй болохоор мөнгөний бараа харахгүй. Ээжийгээ сахисаар хичээлээсээ хөндийрч, их сургуульд орохоо хойшлуулж билээ. Аймшигтай шүү...

Мидори үгээ гүйцээлгүй дуугаа хурааж, савхаа тавиад санаа алдлаа.

- Ийм гунигтай юм яриад яахав.

- Чи нойтон хөхөвчний тухай ярьж байсан.

- Энэ ороомгийг л хийх гэсэндээ тэр.

Ингэж хэлэхдээ түүний сэтгэл хөдөлсөн нь илт.

Би тавагтай хоолоо идэж дуусгаад цадлаа. Мидори “Хоол хийхээр сэтгэл цадчихдаг юмаа” гээд сүйдтэй идсэнгүй.

Мидори аяга тавгаа хурааж, ширээгээ арчаад хайрцаг Марльборо гаргаж ирээд нэгийг татлаа. Цэцэгтэй шилээ хэсэгтээ л харж зогсов.

- Цэцэгний саванд хийх хэрэггүй юм байна. Эрэг дээрээс түүж авчраад шилэнд хийчихсэн шиг л харагдаж байна.

- Оцүкагийн буудлын хажуугийн голын эргээс түүлээ гэвэл Мидори жуумалзана.

- Чи тэгж байгаад их сонин хүн шүү. Тоглоом шоглоомыг чинь ер ойлгохгүй нь.

Мидори шанаагаа тулсан чигтээ тамхиа дутуу татаад, үнсний саванд унтраагаад нүдээ нухлав.

- Бүсгүй хүн чинь тамхиа арай боловсон унтраах учиртай. Хамаг хүчээрээ дарж яах нь вэ? Муухай харагдана. Захаас нь хөнгөхөөн дарахад л болно. Утаагаа хамраараа битгий гарга. Эрэгтэй хүнтэй хамт хооллож байхдаа жирийн охин гурван сар нэг хөхөвчтэй явснаа ярихгүй л болов уу?

- Би гэж ийм л хүн. Тамхиа аятайхан унтрааж чаддаггүй юмаа. Гоё харагдах гэж татдаг гэх үү дээ. Өөр хэлэх юм бий юу?

- Бүсгүйчүүд Марльборотатдаггүй юм.

- Ямар ч тамхи татсан ялгаа юу байна? Адилхан л гашуун шүү дээ?

Тэр Марльборо-гийн хатуу хайрцгийг оролдоод:

- Өнгөрсөн сараас саваагүйтсэндээ л татаж эхэлсэн юм гэлээ.

- Яагаад саваагүйтэв? гэвэл Мидори алгаа хавсран хэсэг дуугүй суугаад:

- Зүгээр л... Чи татдаг уу? хэмээн асуулаа.

- Зургаан сараас гарсаан.

- Яагаад?

- Залхуутай санагдаад. Шөнө тамхигүй болчихвол босоод явах хэцүү. Тэгээд л гарсан. Ямар нэгэн юманд хүлэгдэх дургүй.

- Чамайг хараад ийм няхуур гэж хэлэхээргүй шүү.

- Магадгүй л юм. Ийм зантай болохоор хүмүүс надаас дөлдөг биз. Хар багын л ийм зантай.

- Хүн болгонд таалагдах албагүй гэж бодсондоо л хүн ингэдэг биз. Тэгээд л зарим хүн чамд дургүй байдаг байх. Харин би чамтай ярих

дуртай. “Ямар нэгэн юманд хүлэгдэх дургүй” гээд л этгээд ч юм шиг яриа хөөрөө чинь таалагддаг гэх үү дээ.

Угаасан аяга тавгийг нь арчиж тавингаа:

- Танайхан өнөөдөр хаачаа вэ? гэсэнд Мидори:

- Ээж маань оршуулгын газарт. Хоёр жилийн өмнө нас барсан гэлээ.

- Чи хэлсэн шүү дээ.

- Эгч сүйт залуутайгаа машинаар нь зугаалахаар гарсан. Тэр нь машины үйлдвэрт ажилладаг болохоор машин тэрэгт нугасгүй. Харин би машин сонирхдоггүй.

Тэр хэсэгтээ үг хэлэлгүй сав суулгаа угаана.

- Аав маань...

- Хаачсан гэж?

- Аав зургаан сарын өмнө Уругвай яваад ирээгүй.

Би гайхсандаа:

- Уругвай гэнэ ээ? Яах гэж? хэмээн уулга алдав.

- Аав Уругвай руу цагаачлах хүсэлтэй байсан юм. Цэрэгт хамт байсан найз нь тэнд фермтэй болохоор хөлөө олчихно гэж бодсон байх л даа. Нэг өдөр пал хийтэл хэлээд л онгоцонд суусан. Хэл ус мэдэхгүй, Токиогоос холдож үзээгүй хүн тэнд яаж болох вэ гэж хичнээн хэлээд нэмэр болоогүй. Аав ээжийг нас барснаас хойш сонин болчихсон. Ээжид хэтэрхий их хайртай байсан юм. Тэгээд л ухаанаа алдсан биз.

Би ам нээсэн ч хэлэх үг олсонгүй.

- Ээжийг нас барсны дараа аав эгч бид хоёрт юу гэсэн гээч. “Ээжийг чинь алдсанд орвол та хоёрыг алдсан нь дээр!” Эгч бид хоёрт үнэндээ хэлэх үг олдоогүй. Ингэж хэлж болох уу? Хайртай хүнээ алдах хэцүү

гэдгийг ойлгож байгаа ч төрсөн охиддоо ийм үг унагааж болно гэж үү?
Арай дэндүү биз?

-Дэндүү л юм!

- Бид хоёр гомдоно шүү дээ. Манайхан ер нь хачин хүмүүс шүү.

- Тийм юм шиг байна аа.

- Гэхдээ л хүн хүнээ хайрлана гэдэг сайхан шүү. Эхнэрээ охидоосоо илүү хайрлана гэдэг...

- Нэг талаар сайхан л юм.

- Тэгээд л эгч бид хоёрыг хаяад Уругвай явчихсан.

Би үг дуугаралгүй сав суулгаа арчиж дуусмагц Мидори тавиур дээр өрлөө.

- Ааваас чинь сураг ажиггүй юу?

- Гуравдугаар сард нэг ил захидал ирсэн. Их л халуун, жимс ногоо нь амт муутай гэхээс өөр юм бичээгүй байна билээ. Тэгээд бас илжигний зурагтай ил захидал явуулсан байгаа юм. Нөгөө найз, танилаа олсон ч юм уу, үгүй ч юм уу бүү мэд. Сүүлд нь хөл дээрээ босчихвол эгч бид хоёрыг авна гэсэн байсан. Дараа нь захиа бичсэн ч хариу ирээгүй.

- Аав чинь Уругвайд ирээч гэвэл чи очих уу?

- Би бол очиж үзнэ ээ. Сонирхолтой шүү дээ. Харин эгч маань яасан ч явахгүй гэсэн. Манай эгч бохир заваан орчинд дургүй.

- Уругвайд тийм бохир юм уу?

- Мэдэхгүй ээ. Эгч л тэгж боддог. Замаараа дүүрэн илжигний ялгадастай, ариун цэврийн өрөө нь усгүй, хаа сайгүй гүрвэл, хилэнцэт хорхойтой гэдэг. Киноноос үзсэн байх. Эгч шавж хорхойнд угаасаа дургүй. Гял цал болсон машинаар Шёнанаар зугаалах дуртай.

- Тийм үү?

- Уругвай тийм муухай биш биз дээ? Очиж үзмээр л байна.

- Дэлгүүрт чинь хэн ажилладаг вэ?

- Эгч. Жаахан дурамжхан л ажиллаж байгаа. Хажууханд байдаг манай хамаатны ах ойр зуур тусалдаг. Завтай үедээ би ч тусална. Номын дэлгүүрт сүйдтэй их ажилгүй болохоор болоод л байна. Аягүйдвэл дэлгүүрээ зарна даа.

- Чи аавдаа хайртай биз дээ?

Мидори толгой сэгсэрлээ.

- Нэг их хайртай гэх нь ч хаашаа юм бэ.

- Тэгвэл Уругвай явж яах нь вэ?

- Аавдаа итгэдэг болоод л.

- Итгэдэг ээ?

- Аавдаа тийм ч хайртай биш гэлээ итгэдэг. Эхнэрэ алдаад цочирдсон. Гэр орон, үр хүүхэд, ажил төрлөө хөсөр хаяад явсан ч аавдаа итгэсэн хэвээрээ.

Би уртаар санаа алдаад:

- Сайн ойлгохгүй л юм гэлээ.

Мидори инээгээд нурууг минь хөнгөхөн алгадаад авав.

- Санаа зоволтгүй дээ.

Тэр ням гарагт хачин үйл явдлууд шил дараалан боллоо. Эхлээд тэдний ойрмогхон гал гарч, бид хоёр нэг хэсэгтээ л багшран баагих хар утааг гурван давхрын тагтнаас харж зогсов. Дараа нь бид хоёр санаандгүй

үнсэлцлээ. Санаандгүй гэж хэлэхээргүй ч хоёул үнэндээ тэгнэ чинээ бодсонгүй.

Хооллож дуусаад, их сургуулийнхаа талаар ярилцан кофе ууж суутал галын машины дуу хадав. Дуу нь ойртсоор хэд хэдэн машин ирсэн юм. Хүмүүс цонхон доогуур гүйлдэж, зарим нэг нь хашгиралдана.

Мидори зам руу харсан цонхоор цухуйгаад “Одоохон” гэчихээд чимээ гарган дээшээ гарчихав.

Би “Ингэхэд Уругвай чинь хаана байдаг билээ?” гэсэн маягаар эргэцүүлж бодон кофе ууж суулаа. Бразиль, Венесуэлийг мэдээд байна. Хажууханд нь Колумби байгаа. Харин Уругвай яг хаахна билээ?

Энэ үед Мидори “Хурдан хүрээд ир!” гэх нь дуулдаж, бид хоёр огцом шатаар өгсөж, өргөн тагтан дээр гарлаа. Тэдний байшин ойр орчмын байшин барилгуудаас өндөр тул тэр хавь алган дээр тавьсан шиг илхэн.

Гурав дөрвөн байшингийн цаахнаас утаа баагиж, угаар үнэртэнэ.

Мидори хашлага налан:

- Сакамотогийнд гал гарчээ. Тэднийх барилгын багаж хэрэгслийн дэлгүүртэй байсан ч ажиллуулахаа больсон гэлээ.

Хажуугийн гурван давхар барилга хааж байсан ч галын гурав, дөрвөн машин ирж гал унтрааж байлаа. Зай муутай давчуухан нарийн гудамд хоёр машин л орсон харагдана. Зам дээр хэрэгт дуртай хүмүүс шуугилдана.

- Хэрэгтэй юмаа аваад гарсан нь дээр. Салхины чиг өөрчлөгдвөл яаж ч мэднэ. Шатахуун станцын хажууд осолтой. Юмаа цуглуул, би туслая.

- Хэрэгтэй гэхээр юм байхгүй ээ.

- Хадгаламжийн дэвтэр, тамга тэмдэг, бичиг баримт гээд л байгаа биз дээ? Хэрэг бишдвэл мөнгөгүй хэцүүднэ.

- Зүгээр дээ. Би зугтахгүй.

- Гэр чинь шатахаас айхгүй байна гэж үү? гэхэд Мидори:

- Үхсэн ч хамаа алга! гэж билээ.

Би нүд рүү нь харсан ч үнэн хэлсэн эсэхийг нь ялгаж салгаж чадсангүй. Бид хоёр нэг нэгнээ ширтсээр энэ бүхэн үнэндээ огт хамаагүй мэт санагдлаа.

- Тэгвэл би ч явахгүй!

Мидори нүдээ гялалзуулан:

- Хамт үхнэ гэж үү?

- Хаанаас даа. Гал авалцвал би явчихна шүү. Чи хүсээд байвал эндээ үлд.

- Хувиа хичээсэн гэдэг нь.

- Чи намайг өдрийн хоолоор дайллаа гээд хамт үхэж болохгүй биз дээ? Оройн хоол байсан бол ч яая гэхэв.

- Хм, энд зогсоод харъя. Дуу дуулья, тэгэх үү? Осолтой болвол гарч болох л юм.

- Дуу дуулах аа?

Ингэж хэлээд Мидори хоёр олбог, дөрвөн лааз шар айраг, гитар авч ирээд, дээш олгойдох хар утааг ажиглан суух зуур дуу дуулдаг юм байна.

Хажууханд нь байшин шатаж байхад тагтан дээрээ шар айраг уун дуу дуулахад хүмүүс элдвээр хэлэх вий гэвэл Мидори:

-Зүгээр ээ. Хөршүүдтэйгээ сүжрээд байдаггүй юм гэсээр хэдэн жилийн өмнө нэлээд түгсэн фолк стилийн дуу аялав.

Мидориг сайхан дуулдаг гэхээргүй ч дуулах дуртайболлолтой. Lemon Tree, Pop, 500 miles, Цэцэгч хаачив, Майкл минь, сэлүүрдээрэй хэмээх дуунуудыг ээлждараалан дуулна.

Эхэндээ надтай хамт дуулах гэсэн ч би гэдэг хүн солгой хоолойтойг мэдээд ганцаараа дуулав. Би дуу сонсонгоо шар айраг шимж, гудамжны үймээнийг ажиглан суулаа.

Хар бараан утаа нэг хэсэг бургилж, хэсэгтээ намжина. Хүмүүс хашгиралдана. Удалгүй сонины газрын нисдэг тэрэг шунгинан нисч ирээд хэд хэдэн зураг дараад алга болов. Бид хоёрыг дарчихаагүй байгаасай хэмээн залбирлаа.

Цагдаа хэрэгт дурласан хүмүүсийг цагаан хоолойгоор холдохыг шаардана. Жаалхүү уйлсаар ээжийгээ хайна. Хаа нэгтээ шил хагарах чимээ гарна.

Төдхөн салхи өөрчлөгдөж, үнс хаялж эхэллээ. Мидори шар айраг балгангаа дуулсаар сууна. Мэддэг дуунуудаа дуулж дуусаад өөрийнхөө зохиосон жигтэй дууг аялав.

“Тогоогүй боловч чамдаа нухаш хийж өгөх сөн

Утасгүй боловч чамдаа ороолт нэхэж өгөх сөн

Үзэг балгүй боловч чамдаа шүлэг бичиж өгөх сөн”

- Юу ч үгүй гэдэг дуу.

Энэ дууны үг ая гэж авах юмгүй.

Энэ мөчид “Шатахуун түгээх станц шатвал эднийх ч дэлбэрнэ дээ” гэхээс өөр юм бодсонгүй.

Мидори гитараа хойш тавиад, биеэ наранд ээх муур шиг намайг налав.

- Энэ дууг би зохиосон юмаа. Таалагдав уу? гэсэнд санаа зовсондоо:

- Чамтай адилхан этгээд содон л юм гэхээс өөр юм хэлсэнгүй.

- Баярлалаа. Гол санаа нь Юу ч байхгүй

- Тийм байна аа.

- Ээжийг нас барсны дараа...

- Яасан гэж?

- Би ер гуниглаагүй шүү.

- Тийм үү?

- Аавыг явсны дараа ч гуниглаагүй.

- Тийм гэж үү?

- Тийм ээ. Сонин байна уу? Хувиа хичээсэн амьтан юм уу даа.

- Шалтгаантай болоод л тэгээ биз.

- Тийм ээ. Манайх гэдэг айл хэрэндээ л ээдрээтэй амьдралтай. Амьдралын эрхээр аав, ээжээсээ хагацахад хүрвэл их л гуниглана гэж бодож байсан ч эсрэгээр нь болсон доо. Ганцаардаж гансраагүй. Сэтгэл эмтлэх дурсамж гээд байх юм үлдээгүй. Ээжийгээ л хаа нэг зүүдлэх юм. Харанхуйгаас “Яваад өгсөнд минь баярлаж сууна уу?” гээд л над руу хардаг. Гуниглаж гансраагүй ч гэлээ баярлаад байх юмгүй. Багадаа муур маань үхэхэд шөнөжингөө уйлсан ч ээжийгээ таалал төгсөхөд нулимс дуслуулаагүй.

Улалзах гал үзэгдэхгүй ч жигтэйхэн их утаа хаялна. Юунаас ингэж их утаа савсдаг байна? гэсэн бодол эргэлдэнэ.

- Гэхдээ би зөрүүд зантайдаа ийм болчихсон юм биш. Хувиа хичээдэг ч аав, ээж маань намайг арай илүү хайрласан бол ийм болохгүй байлаа. Илүү их хайрлуулсан бол гуниглах байсан юм.

- Чамд хайргүй байсан гэх гээд байна аа даа?

- Хоёрын хооронд, гурвын дунд гэх үү дээ. Хайраар цангаж, одоо болно гэтлээ хайрлуулмаар санагддаг байлаа. Ганц удаа боловч сэтгэлээ дүүртэл хайрлуулахыг хүссэн ч түүнээ мэдэрч чадаагүй. Нэг юм гуйхад цааш түлхэнэ, мөнгөө дэмий үрлээ гэнэ. Тэгэхээр нь жилийн дөрвөн улиралд намайг хайрлаж халамжлах хүн олж аваад түүнийгээ ч хайранд умбуулна гэж бодсон доо. Тэр үед би тав, зургаадугаар ангид байсан болов уу.

- Тэгээд олсон уу? гэхэд Мидори холыг ажин хэсэгтээ бодолхийлээд:

- Удаан хүлээсэн болохоор олоход хэцүү юм. Төгс төгөлдөр юм л хайгаад байх шиг байна.

- Төгс төгөлдөр хайр дурлал хайсан гэж үү?

- Үгүй дээ. Би их юм хүсдэг ч хэр хэмжээгээ мэднэ ээ. Гэхдээ л миний төлөө бүхнээ зориулах хүнтэй учрах сан. Жишээ нь, “Гүзээлзгэнэтэй бялуу идмээр байна” гэхэд ум хумгүй гүйж очоод аваад ирдэг. “Одоо идэх хүсэлгүй болчихлоо” гээд цонхоор шидчихэд ойлгох хүн л хэрэгтэй.

Би гайхаж:

- Энэ чинь хайр дурлалтай огт хамаагүй гэвэл:

- Хамаатай байлгүй яахав. Эмэгтэй хүн хааяахан ч гэлээ ийм зүйлээр дутдаг юм.

- Гүзээлзгэнэтэй бялуу цонхоор шидэхийг хүсдэг гэж үү?

- “Мидори минь, жимстэй бялуунд дургүйг чинь би гадарлах учиртай байж. Намайг уучлаарай. Би гэж мулгуу, хэнэггүй амьтан юм. Дуртай юмыг чинь аваад өгье. Шоколадтай, эсхүл бяслагтай бялуу авах уу?” гэж хэлэх тэнхээтэй л эр хүнийг хайдаг юм.

- Тэгж хэллээ гээд байдал өөрчлөгдөх үү?

- Намайг хайрлахын хэрээр түүнийгээ хайрлах болно.

- Ийм юм гэж байхгүй шүү дээ.

- Гэхдээ л би хайр гэдгийг ингэж төсөөлдөг. Хүмүүс ойлгохгүй байх. Зарим хүмүүсийн хувьд аар саархан юмнаас болоод л нөгөөдөө дурлачихдаг. Тэр аар саархан юм нь үгүй бол дурлахгүй ч байж мэднэ.

- Анх удаа л эмэгтэй хүн ингэж ярихыг дууллаа.

- Ихэнх эмэгтэйчүүд ингэж боддог.

Мидори хумсаа оролдоод шулганасаар.

- Би бодсоноо л хэлж байна. Бусдаас ялгарах гэсэндээ ингэж боддогтоо ч биш. Үнэндээби бусдаас онцгойрохыг огт хүсдэггүй. Үнэнээ хэлэхээр хүмүүс тоглоод, жүжиглээд байна гэдэг юм. Тийм ч учраас энэ бүхнээс залхсан гэх үү дээ.

- Тэгээд гал гарвал шатаж үхье гэж боджээ дээ?

- Үгүй ээ. Сониуч араншин минь хөдлөөд л тэгсэн юм.

- Галд шатах сонин байна гэж үү?

- Хаанаас. Чамайг яах нь вэ гэж бодсон юм. Гэхдээ би үхлээс айдаггүй ээ. Угаартаж үхэх амархан биз дээ? Би айхгүй байна аа. Ээж, хамаатнуудын минь үхэлтэй харьцуулахад энэ бол юу ч биш. Манайхан бараг бүгдээрээ, удмаараа хүнд өвчин тусч, тарчилсаар амьсгал хураадаг. Сүүлдээ амьсгаатай, үгүй нь мэдэгдэхгүй. Ийм хүн ухаантай үедээ өвдөж гуниглахаас өөр юм мэдрэхгүй.

Мидори ахиад нэг тамхи асааж, яриагаа үргэлжлүүлэв.

-Хүн аажмаар үхэх л хамгийн аймшигтай. Үхлийн сүүдэр амьдралын гэрэл гэгээг сөөм сөөмөөр мэрсээр нэг л мэдэх нь ээ тас харанхуй болж, эргэн тойрныхон маань намайг амьд гэхээсээ илүү Хэдийн амьсгал хураачихсан гэнэ шүү дээ. Тэгэхгүй л юмсан.

Гучаад хормын дараа гал унтарлаа. Гал газар авсангүй, хүн амьтан ч гэмтээгүй бололтой. Хүмүүс тарж, дохиогоо асаасан цагдаагийн

машин л үлдлээ. Хаанаас гарч ирсэн нь мэдэгдэхгүй хоёр хэрээ шон дээр суугаад эргэн тойрныг ажиглана.

Гал унтармагц Мидори тамираа барсан гэлтэй тэртээ холыг ширтээд дуугаа хураачихав.

- Ядраа юу даа?

Үгүй ээ. Бие тавираад. Ойрд юм бодолгүй энэ мэт суусангүй.

Хоёр биенээ халз ширтэн суух тэр мөчид би Мвдоригийн мөрөөр тэвэрч, уруул дээр нь үнслээ. Мидори мөрөө хавчсан ч төдхөн биеэ суллаад нүдээ анилаа. Хэсэгхэн зуурын энэ үнсэлт хожмын хувь тавиланг шивнэх шиг болж билээ.

Намрын шаргал нарны туяанд чичирхийлэх сормуусных нь сүүдэр Мидоригийн нүүрэн дээр тусна. Халуун дулаан боловч тэрхэн үедээ утга учиргүй үнсэлт.

Бид хоёр үдийн нарнаар дээвэр дээр шар айраг шимж, улалзан асах галын утааг ажиглан суугаагүй сэн бол үнсэлцэхгүй байсан биз ээ. Мидори ч үүнийг мэдэрсэн.

Наранд гялалзах барилгын дээвэр, багшран баагих утаа, тэмээлзгэнүүдийг ажингаа нэг нэгэндээ уусч, энэхэн мөчийг алдахгүй гэсэндээ л чингээ биз. Энэ үнсэлт ийм л учиртай байж.

Мидори ам нээж, найз залуутайгаа хэлж чадсангүй гэж билээ. Би энэ тухай бүдэг бадаг таамаглаж байлаа.

- Чи найз охинтой юу?

- Бий.

- Тэгээд яагаад бүтэн сайнд завтай байдаг юм бэ?

- Хэлэхэд хэцүү л дээ.

Энэ мөчид үзэсгэлэн төгс намар оройн нарны туяа бүдгэрэх шиг боллоо.

Би таван цагт ажилдаа явахаар тэднийхээс гарч, Мидориг хамт хоолонд орё гэвэл тэр утас манах хэрэгтэй хэмээн үлдлээ.

- Өдөржин гэртээ утас чагнаж суух хэцүү л дээ. Ганцаараа байхад хамаг бие ялзрах шиг болдог юм. Ганцаараа өнжвөл ялзраад газарт шингэх шиг болохыг яана. Тэгээд өмссөн зүүснээс өөр юм үлдэхгүй.

- Хоол хийж өгнө гэвэл дараагийн удаа дуудлага хүлээхэд чинь хамт байж болох л юм гэхэд Мидори:

- Тэгнэ ээ. Амттан болгож гал тавихаа ч мартажгүй ээ гэсээр үлдлээ.

Маргааш нь Мидори “Драмын түүх”-ийн лекцэнд ирсэнгүй. Хичээл тармагц оюутны гуанз орж, амт муутайхан хоол идээд нарлаж суулаа. Хажууханд хоёр. бүсгүй шивэр авир ярилцана. Нэг нь теннисний цохиураа нялх хүүхэд лугаа нандигнан тэвэрч, нөгөө нь хэдэн ном, Леонард Бернштейний цомог барьжээ.

Дажгүй царайлаг бүсгүйчүүд юм. Клубт хэн нэгэн баргил хоолойгоор гамм уншиж байлаа. Оюутнууд энд тэндгүй дөрөв таваараа цуглаж, инээлдэж шуугилдана.

Хэдэн хөвүүн машины зогсоол дээр скейтбордоор гулгах агаад ширэн цүнх сугавчилсан багш хажуугаар нь хялав хийн өнгөрнө.

Хамгаалалтын малгайтай охид зүлгэн дээр суугаад Ази тивд шургалж буй Америкийн империализмын тухай ханын сонин зурах ажээ. Их сургуулийн үдийн завсарлага нэг иймэрхүү өнгөрнө.

Хэдийн ижил дасал болсон энэ байдлыг ажиглангаа хүн бүр дор бүрнээ жаргалтай харагдав. Үнэн эсэхийг нь мэдэхгүй ч есөн сарын сүүлийн энэ өдөр хүн болгон жаргалтай байлаа. Үүнээс болоод ч тэр үү, илүүтэй ганцаардав. Амьдралын энэ дүр зурганд надад оногдсон байр суурь үгүй мэт санагдана.

“Өдий болтол би гэж хүн чухамдаа хаа оршиж байв?” гэх бодол хургаж, Кизүкигийн хамт биллиард тоглосон тэр нэгэн өдөр санаанд буулаа. Тэр шөнө Кизүки амьсгал хурааж, хойно нь би гэдэг хүн энэ орчлонгоос тусгаарлагдах шиг болсон сон.

Кизүки миний хувьд хэн байсан юм бэ? гэж тунгаагаад хариулж дөнгөсөнгүй.

Тэр өдрөөс хойш сэтгэлийн минь нэгээхэн хэсэг болсон Adore Sence гэх мэдрэмжүүд ор мөр алдагдсан гэлтэй. Энэ бүхнээ ойлгох боловч юунд хүргэхийг нь төсөөлшгүй.

Энэ мэтээр цаг нөгцөөж эргэцүүлэхдээ зөрж өнгөрөх хүмүүсийг ажлаа. Мидоритой таарч магад гэж харуулдсан ч талаар болж, төдхөнөө номын санд ороод, герман хэлний хичээлээ давтав.

Ингээд бямба гараг болж Нагасава “Хот орж зугаацъя. Гадуур хонох зөвшөөрөл авчихна” гэсээр орж ирлээ. Толгойгоо гашилтал элдвийн юм бодсон тул би зөвшөөрсөн юм. Хэнтэй ч хамаагүй унтмаар санагдсан даа.

Оройдоо шүршүүрт орж, сахлаа хусаад, майкан дээрээ даавуун цамц өмсөн, Нагасаватай хооллож, хамтдаа Шинжюкү орох автобусанд суулаа.

Нагасава бид хоёр Шинжюкүгийн хүн ихтэй гудамжинд бууж, ордог баарандаа суугаад охидыг ажиглав. Энэ бааранд олон бүсгүй ордог боловч тэр өдөр манай ширээнд хэн ч дөхөж ирсэнгүй. Нагасава бид хоёр согтчихгүй гэсэндээ содтой вискигээ бага багаар шимэн ууж, хоёр цаг суув. Удалгүй хоёр бүсгүй орж ирээд, тэйкний ард суугаад Гимлет, Маргарита захиаллаа. Нагасава хэл амаа билүүдэн яриа өдсөн ч бүсгүйчүүд найз залуусаа хүлээж байжээ. Гэсэн ч бид хоёртой хууч хөөрөн, найзууд нь ирэнгүүт орхиод явлаа.

Нагасава өөр бааранд орьё гэсээр хүн ихтэй, дуу шуутай булангийн нэг жижигхэн газарт оров.

Хоёул голын ширээнд суусан гурван бүсгүйтэй хамт сууж бурж эхлээд тавуулаа хөөрхөн халлаа. Ингээд цугтаа өөр газарт орж юм ууя гэсэнд нөгөө гурав дотуур байрны үүд барихаас өмнө харина гэсээр яваад өгдөг юм байна.

Гурван бүсгүй их сургуулийн дотуур байранд амьдардаг ажээ. Тэр өдөр ажил хэрэг үнэндээ бүтсэнгүй. Бид хоёр өөр газар орсон ч бүсгүйчүүд хаданд гарчихсан юм шиг бүтэлтэй юм болсонгүй.

Арван нэг хагас болоход Нагасава:

- Чамайг шал дэмий чирсэнд ёстой уучлаарай гэх нь тэр.

- Зүгээр дээ. Чамд ч ийм үе байдаг гэж бодохоор дотор онгойх шиг боллоо.

- Жилдээ ганц нэг удаа ингэдэг юмаа.

Би үнэндээ секс хийх ямар ч хүсэлгүй боллоо.

Бямба гарагийн үдэш гурван цаг гаруй хуял тачаалдаа автан архинд мансуурч, Шинжюкүгийн гудамжаар тэнүүчилсэндээ гутрах шиг болов.

- Ватанабэ, одоо хаачих вэ?

- Шөнийн кино үздэг юм бил үү. Ойрд кино үзээгүй.

- Тэгвэл би Хацүмигийн очлоо. Болно биз дээ?

- Бололгүй яхав.

- Хүсвэл нэг шөнө өнгөрөөчих охинтой танилцуулъя. Ямар вэ?

- Больё доо. Өнөөдөр кино үзмээр байна.

- За за. Тэгвэл дараагийн удаа сайхан наргина аа гэсээр Нагасава алга боллоо.

Түргэн хоолны газарт чизбургер идэж, кофегоор даруулаад толгой сэргэмэгц кинотеатр орж Төгсөлт хэмээх кино үзлээ.

Сонирхолгүй ч гэлээ хийх юмгүйдээ хоёр удаа үзэв. Ингээд үүрийн дөрвөн цагт эл хуль болсон Шинжюкүгийн гудамжаар алхаллаа.

Ядарсандаа шөнийн кафе орж, кофе уунгаа метро явтал ном уншиж суухад хэсэг хугацааны дараа метро хүлээх хүмүүс ар араасаа цувлаа.

Зөөгч залуу миний суусан ширээнд өөр хүмүүсийг суулгаж болох эсэхийг асуусанд тэртээ тэргүй ном уншиж суусан тул татгалзсангүй.

Хажууд минь царайлаг гэмээргүй ч нүдэнд дулаахан, нас чацуухан хоёр бүсгүй суулаа.

Кабүки-чөгоор үүрийн тав хүртэл зугаацдаг гэж хэлэмгүй даруухан хувцасласан байхыг нь харвал сүүлийн галт тэрэгнээс хоцорсон нь илт.

Цэвэрхэн хувцастай, сахал самбаагүй, Томас Манны Шидэт уул-ыг унших над шиг залуугийн хажууд суусандаа энэ хоёр баярлана.

Арай биерхүү нь саарал цамц, цагаан жийнстэй, хиймэл арьсан томоо цүнхтэй бөгөөд томоо гээчийн дун шиг ээмэгтэй юм. Нөгөө нь биеэр жижиг, нүдний шилтэй, шоотой цамцан дээр задгай энгэртэй цамц өмссөн байх агаад оюу шигтгээтэй бөгж зүүжээ. Бүсгүй байн байн шилээ авч нүдээ нухална.

Бүсгүйчүүд safe au lait захиалж, бялуу идэнгээ шивэр авир хийнэ. Биерхүү бүсгүй хэдэнтээ толгой дохисон ч нөгөөх нь толгой сэгсэрнэ. Marvin Gaye, эсхүл Bee Gees-ийн хөгжим хангинаж, тэдний яриа дуулдсангүй боловч биерхүү нь нөгөө бүсгүйгээ тайтгаруулж буй аятай.

Би ном уншиж байгаа царайлан бүсгүйчүүд рүү нууцхан харц шидэлж суулаа.

Удалгүй шавилхан бүсгүй нь цүнхээ аваад ариун цэврийн өрөө орсон хойгуур нөгөө нэг нь “Уучлаарай” гэсээр дөхөж суув. Номоо ширээн

дээр тавиад өөдөөс нь харвал:

- Ойр хавьд юм уучихмаар газар байдаг юм болов уу? Та мэдэхгүй биз?

- Өглөөний тав өнгөрч байхад уу?

- Тийм ээ.

- Тав хорь болж байна шүү дээ. Уусан нэг нь амрахаар харьж яваа байлгүй дээ гэвэл бүсгүй баахан ичингүйрсэн байртай:

- Тийм л дээ. Гэхдээ найзын маань сэтгэл тавгүйтээд юм уух хэрэгтэй байна.

- Хариад уухаас өөр аргагүй дээ.

- Би долоо гучид Нагано руу явах гэж байдаг.

- Тэгвэл автоматаас нэг юм аваад гудамжинд уухаас өөр яхав.

Бүсгүй жийрхээд байгаа бололтой хамт явъя гэлээ. Шинжюкүгийн гудамжинд энэ байтугай юм үзсэн ч өглөөний тав хорьд огт танихгүй бүсгүй юм ууя гэсэнтэй таарч явсангүй.

Татгалзахад эвгүй, тэгээд ч завтай тул ойролцоох автоматаас хэдэн шил сакэ, ойр зуурын даруулга авч, гурвуул галт тэрэгний буудлын баруун гарцны тэртээхэн сууцгаав.

Бүсгүйчүүд энэ жил коллежоо дүүргэж, нэг аяллын компанид ажилд ороод найзалж нөхөрлөжээ.

Биеэр жижиг бүсгүй нь найз залуутай, түүнтэйгээ жил гаран үерхсэн аж. Ингээд саяхан шиг нөгөө залуугаа өөр бүсгүйтэй учир ургуулсныг нь мэдээд ихэд шаналжээ.

Биерхүү бүсгүйн ах энэ өдөр хуримаа хийх учраас өчигдөр явах байсан ч энэ шөнийг Шинжюкүд найзгайгаа өнгөрөөж, өглөөний галт тэргэнд суухаар тогтсон гэнэ билээ. Би жижигхэн бүсгүйгээс:

- Өөр хүүхэнтэй гэдгийг нь яаж мэдсэн юм бэ? гэвэл бүсгүй өвс зулгаангаа:

- Өрөөнд нь орсон чинь нөгөө бүсгүйтэйгээ хэвтэж **байсан** гэлээ.

- Хэзээ тэр вэ?

- Уржигдар орой.

- Хм, хаалгаа түгжээгүй байжээ дээ?

- Тийм ээ.

- Яагаад?

- Би яаж мэдэх вэ?

Энэ үед сайхан сэтгэлтэй байрын биерхүү бүсгүй:

- Үнэндээ цочролд орсон доо. Муухай биз? Сэтгэлээр унах нь мэдээж хэмээв.

- Юу ч гэмээр юм бэ. Тэгэхдээ л ярилцах хэрэгтэй. Чи гол нь цаадахаа уучилж чадах уу?

Бүсгүй:

- Хүн намайг ойлгохгүй л дээ гэсээр өвс зулгаана.

Баруунтаа хэдэн хэрээ үзэгдэж, Одакю их дэлгүүрийн дээгүүр нисч одов. Үүр хаяарчээ. Ойр зуурын юм ярьсаар биерхүү бүсгүйн явах цаг дөхөж, гурвуул үлдсэн сакэгаа метроны зогсоол дээр байх гуйлгачинд өгөөд, нөгөө бүсгүйг гаргаж өглөө.

Галт тэрэг бараа сураггүй болмогц шавилхан бүсгүйн хамт зочид буудал орлоо. Өвөр түрийдээ орохоор хэлэлцэж тохироогүй ч ингэх нь мэдээжийн юм шиг санагдаж билээ.

Би хувцсаа тайлж, усанд орж хэвтээд шар айраг уув. Нөгөө бүсгүй араас минь орж ирээд хажууд хэвтлээ. Нэлээд уусан ч халсангүй. Бүсгүй булбарай цагаан арьстай, шулуухан хөлтэй юм. “Сайхан хөлтэй юмаа” гэсэнд бүсгүй хүйтэн хөндий дуугаар “Баярлалаа” гэв. Гэвч тэр бүсгүй орон дотроо тэс өөр авирласан.

Илж таалахад бүхий л биеэрээ хариу өгч, дотор нь ороход нуруунд минь хумсаа шигтгэж, тавирахдаа хэн нэгний нэрийг арван зургаан удаа дуудлаа. Түүнд таашаал амсуулья гэсэндээ би биеэ барьж, тэр болгоныг нь тоолсон хэрэг.

Унтаад сэрвэл арван хоёр гуч болжээ. Өнөө бүсгүй зурвас үлдээлгүй яваад өгчээ. Хар үүрээр нэлээд ууснаас болоод толгой дүүрнэ.

Ингээд шүршүүрт орж нойроо сэргээгээд, хөргөгчнөөс шүүс авч, нүцгэн чигээрээ сандал дээр суугаад уулаа. Өчигдрийн уйл явдлыг санахыг хичээсэн ч бүдэг бадаг юм санаад оров. Ширээн дээрх шар айрагны хундага, угаалгын өрөөн дэх хэрэглэсэн шүдний сойз нүдэнд тусна.

Шинжюкүд үдийн хоолонд орж, Мидориг утсаа сахиж сууж юуны магад хэмээн залгасан ч хариу өгсөнгүй. Хориод минутын дараа дахин залгасан ч мөн л хариугүй.

Автобусанд сууж, байрандаа ирэхэд үүдэнд байх шуудангийн хайрцганд Наокогоос ирсэн захиа байж билээ.

Тавдугаар

БҮЛЭГ

“Захиа бичсэнд баярлалаа.”

Миний захиаг гэрийнхэн нь Наокогийн байгаа газарт илгээжээ. Захиаг минь аваад Наоко магнай тэнийтлээ баярлаж, хариу тэрлэсэн нь энэ байж.

Би цонхоо нээж, цамцаа тайлаад орон дээр суулаа. Тагтаануудын гур гур хийх дуун сонсогдож, зөөлөн салхи хөшиг дэрвүүлнэ.

Сэтгэл догдлон Наокогийн бичсэн долоон хуудас захидлыг барьж авав. Хэдхэн мөр уншсан ч бодит орчноосоо тасрах шиг боллоо. Нүдээ аниад үймэрсэн сэтгэлээ тайвшруулж, нэлээд суусны эцэст гүнзгий амьсгаа авч захиаг нь уншлаа.

“Энд ирээд дөрвөн сар болохдоо чамайг бишгүй л бодлоо. Бодох тусам чамд шударга бус, хатуу хандсанаа ойлгож байна даа. Сэтгэл санаагаа дэлгэх хэрэгтэй байжээ.

Зөв, бурууг нь мэдэхгүй юм даа. Үеийнхэн маань шударга мэтийн үгсийг барагтай бол хэрэглэдэггүй шүү дээ. Энгийн бүсгүйчүүд аливаа зүйл шударга эсэхэд сэтгэл зовних нь юу л бол.

Бүсгүйчүүд буруу явдал гэж юу болохыг мэдэх ч шударга үнэний талаар эргэцүүлэх нь ховор. Ихэвчлэн гоо сайхан, аз жаргалтай болох тухайгаа л төсөөлөн боддог. Эрчүүд л шударга хэмээх энэ үгийг илүү хэрэглэдэг биз ээ. Гэхдээ энэ нөхцөл байдалд шударга гэхээс өөр үг тохирохгүй санагдана.

Миний хувьд гоо сайхан, аз жаргалтай болох талаар эргэцүүлэх нь уйтгартай бөгөөд адармаатай. Тиймээс ч *энэ тухай бодох дургүй. Харин шударга ёс, үнэнч сэтгэл гэх ойлголтууд сэтгэлд минь илүү ойр.*

Гэсэн ч би чамд шударга бус хандаж, гомдоож, нэлээдгүй зовоосон. Ингэснээрээ өөрийгөө ч тамладаг байж. Тайлбар тавих гэсэндээ ингэж хэлээгүй юм шүү. Чамайг ч гомдоогоод, өөрийнхөө сэтгэлийг ч шархлуулжээ. Намайг битгий л үзэн ядаарай.

Би чиний бодсоноос тэс ондоо, төгс төгөлдөр хүн огт биш юм. Ийм учраас намайг битгий үзэн ядаарай гэж ахин дахин гуйя. Чамд үзэн ядах сэтгэл төрүүлсэн баймааж нь би тэсч гарахгүй л болов уу. Чам шиг бодит байдлаас нуугдаж хаагдаж чадахгүй санжээ.

Сайн мэдэхгүй ч, хааяадаа чи чухам ийм хүн шиг санагдах юм. Ийм болохоор битүүхэндээ чамд атаархаж, тэр хил хязгаарыг давсан биз ээ.

Нөхцөл байдлыг хэтэрхий их задлан шинжилж байж болох л юм.

Энд задлан шинжлэх аргаар эмчилгээ хийдэггүй ч хэдэн сар болоход аливаа асуудлыг өөрийн эрхгүй “Энэ нөхцөл байдал үүнээс болж үүссэн. Энэ нь тийм гэсэн үг” гэх мэтээр эргэцүүлдэг болчих юм. Гэхдээ ингэснээр хорвоо ертөнцийн учир зүйг олж ойлгодог эсэхийг сайн мэдэхгүй юм даа.

Ямартаа ч, сэтгэл санаа тайвширч, эргэн тойрныхон ч энэ байдлыг минь анзаарах болжээ.

Үүнээс гадна ойрын үед сэтгэл амар захиа бичиж суусангүй. Долоон сард илгээсэн захиагаа хүчлэн байж бичсэн юм шүү дээ. (Үнэндээ юу бичсэнээ сайн санахгүй юм. Хэтэрхий хахир хатуу юм бичээгүй байгаасай билээ.) Харин одоо дотор уужраад хариу илгээж байгаа минь энэ.

Надад энэ цэвэр агаар, тусгаарлагдсан нам гүм орчин, зохистой дэглэм, өдөр бүрийн дасгал хэрэгтэй байсан даг аа.

Захиа занаагаар харилцах хүнтэй байна гэдэг сайхан. Сэтгэл санаагаа хэн нэгэнтэй хуваалцахаар үзэг барин суух үнэхээр их аз завшаан.

Санаа бодлоо цаасан дээр буулгахад дутагдалтай ч хэн нэгэнд сэтгэлээ нээх хүсэлтэй болсондоо сэтгэл тэнүүн явна. Иймээс ч чамд хариу илгээхээр шийдлээ.

Одоо долоо хагас болж байна. Би оройн хоолоо идээд, усанд орчихлоо. Эргэн тойрон нам гүм, гадаа ёлтойх ч гэрэлгүй харанхуй болжээ. Энд

одод харагддаг ч өнөөдөр бүрхэг. Эндхийнхэн одцын ордыг сайн мэднэ. Охины орд, Нумын орд гэхчлэн зааж өгдөг тул орой үдэш хийх юмгүй хүн тэнгэрт түгэх түг түмэн оддыг нэг бүрчлэн мэддэг болох биз ээ.

Үүний сацуу хүн болгон цэцэг шувуу, хорхой шавжны талаар сайн мэднэ. Тэдэнтэй ярилцахад маш олон зүйл мэдэж авах бөгөөд энд ч атугай юм олж мэдсэндээ баярладаг шүү.

Энд далаад хүн, хориод ажилтантай. Зай ихтэй болохоор заримдаа “эл хуль” санагдана.

Хаашаа л харна нүд алдам ээрэм тал, ой мод үргэлжилнэ. Тайван, сайхан орчинтой учраас өөрийн эрхгүй жинхэнэ амьдрал гээч нь энэ юм болов уу? гэсэн бодол эргэлдэнэ. Гэсэн ч тийм биш юм.

Би теннис, сагсан бөмбөг тоглодог. Ажилтан, өвчтөнүүдээс бүрдсэн сагсан бөмбөгийн багтай (өвчтөн гэдэг үгэнд би дургүй) боловч тоглож байхад хэн хэн нь ялгаагүй болчихно.

Хачин жигтэй гэмээр ч тоглож байхдаа эргэн тойрноо ажихад энэ хүмүүс нэг л өөр харагдана. Эмч маань бид чухам ийм хүмүүстэй дасан зохицож сурах хэрэгтэй гэдэг. Бодит байдлаа хүлээж авч чадахгүйдээ л биднийг энд ирсэн гэх юм.

Хүнбүр өөр өөрийн алхаа гишгээтэй шиг аливаа зүйлийг өөр өөрөөр мэдэрч хүлээн авдаг бөгөөд энэ зан чанарыг нь өөрчлөхөд тун чиг ярвигтай. Хүчээр өөрчилбөл бусад мэдрэмжиндээ нөлөөлдөг гэнэ билээ.

Энгийн тайлбар ч гэлээ бидний сэтгэл зүйг чухам ингэж тайлбарладаг. Гэсэн ч би эмчийн санааг ойлгох шиг болсон.

Угтаа бид бодит ертөнцийг ухаарч сэхээрч чадаагүйн улмаас уйтгар гунигаа хөөж дийлэлгүй энд иржээ.

Энд байх нь бусдыг болоод өөрийгөө зовоохгүй сайн талтай. Бүгд л сэтгэлийн хатгүйгээ мэдэх учраас дотор уужирдаг гэх үү дээ. Энд

гадаад ертөнцөөс огт өөр. Үнэндээ бодит байдалд үүнээ хамсарлахгүй ч олон хүн сэтгэлийн зовиуртай.

Гэхдээ энд сэтгэлдээ гуниг тээсэн хүмүүс нэг дор дугласан учир дор бүрнээ нам гүмхэн.

Спортоор хичээллэхээс гадна ногоо тарина. Улаан лооль, хааш, өргөст хэмх, тарвас, гүзээлзгэнэ, сонгино, байцай, цагаан лууван гээд ихэнх жимсногоогоо тарьдаг хүлэмжтэй.

Энд амьдардаг хүмүүс ногоо тарих дуртай шүү. Энэ тухай ном уншиж, мэргэжилтэн урьж авчрахын сацуу өдөржингөө эрдэс бордоо, үржил шимтэй хөрсний тухай ярьж суух нь энүүхэнд.

Би ногоо тарих дуртай болсон. Жимс ногоо өдрөөс өдөрт томорч ургахыг харахад сэтгэл сэргэх юм. Чи тарвас тарьж үзсэн үү? Аажим аажмаар томрох нь эгээтэй л бяцхан амьтнаас өөрцгүй.

Өдөр болгон шинэхэн жимс ногоо идэх тул аандаа мах идэх хүсэлгүй болчих юм. Эндхийн жимс ногоо их амттай.

Заримдаа ууланд гарч зэрлэг ургамал, мөөг түүнэ. Буруузөвийг нь ялгаж салгах олон мэргэжилтэнтэй (бодоод байх нь ээ, энд мэргэжилтэн олонтой). Би энд ирээд зөв хооллох болсноор гурван хил нэмж, хэвийн жинтэй боллоо.

Завтай үедээ ном уншиж, хөгжим сонсоод, юм нэхдэг. Энд зурагт радиогүй боловч сайхан номын сантай, Малерийн симфониос авахуулаад Битлзийн дуунуудтай маш олон пянзтай. Өрөөндөө байнга хөгжим сонсдог шүү.

Гэхдээ энд нэг ирсэн хүн явмааргүй санагдаж, бодит ертөнцөөс айж эхэлдэг юм байна. Энд байхад сэтгэл уужирч тайвширдаг. Гэсэн хэдий ч хүмүүс биднийг ойлгож хүлээн авна гэдэгт эргэлзсээр л.

Эмч маань намайг гадны хүмүүстэй уулзаж эхлэх хэрэгтэй гэсэн шүү. Гадны гэхээр эргэлтээр ирэх хүмүүс. Намайг хүн эргэж ирнэ гэж бодохоор чамаас өөр нэгэн санаанд буухгүй нь.

Үнэндээ надад аав, ээжтэйгээ уулзаад байх хүсэл алга. Миний төлөө сэтгэл нь зовнидог учраас уулзахад таагүй.

Үүнээс гадна чадах үгүйгээ мэдэхгүй ч гэсэн чамд зарим нэгэн зүйлийг тайлбарлах шаардлагатай гэж бодлоо.

Гэхдээ заавал ир гэж тулгаагүй юм шүү. Би хэнд ч садаа болохыг хүсэхгүй. Надад сайн санаж явдгийг чинь мэдсэндээ баяртай сууна. Тиймээс ч энэ бүхнээ ний нуугүй бичлээ.

Одоо надад чам шиг хандах хүн маш их хэрэгтэй. Эвгүй юм хэлж гомдоож байсан бол уучлаарай.

Дээр бичсэнчлэн би гэдэг хүн чиний бодсон шиг төгс төгөлдөр хүн биш юмаа.

Хааяадаа бид хоёр энгийн нөхцөлд учирч, нэг нэгэндээ татагдсан бол амьдрал хэрхэн эргэх байсан тухай бодох юм. (намайг бодвол чи ямагт энгийн хүн байсан шүү дээ) Кизүки байгаагүй сэн бол яах байсан бол? Гэхдээ энэ бүхэн хий хоосон мөрөөдлөөс цаашгүй.

Сэтгэлээ нэеэ гэсэндээ, сэрэл мэдрэхүйгээ чамд мэдрүүлье гэсэндээ энэ бүхнийг бичлээ.

Энд жирийн эмнэлгийг бодвол эргэлт чөлөөтэй. Ирэхээсээ нэг өдрийн өмнө утсаар хэлбэл уулзах боломжтой. Хамт хооллож, хоноод явсан ч болно. Тиймээс боломжтой үедээ ирээрэй. Чамтай уулзах сан. Энэ газрын байршлыг зураад явууллаа. Захиа минь урт болсныг ойлгоно биз ээ.”

Би Наокогийн захиаг ахин дахин уншлаа. Ингээд автоматаас кола авч орж ирээд, дахиж уншаад дугтуйнд нь буцааж хийв.

Ягаан дугтуйн дээр хаягийг минь эмэгтэй хүнийх гэхэд жижигхэн үсгээр бичжээ. Ширээний ард суугаад дугтуйг хэсэг ажвал буцах хаяг нь Амирё гэжээ.

Сонин л нэртэй газар юм. “Ami” гэх франц үгнээс гаралтай байж таарна даа.

Би тэр захиаг шүүгээндээ хийж, өрөөнөөсөө гарлаа. Суугаад байвал ахин дахин уншаад л байна.

Ингээд Наокотой урьд зугаалж байсан шигээ Токиогийн гудамжаар алхалж, бичсэн үг өгүүлбэр болгоныг нь бодож тунгаав. Бүрий болмогц байрандаа ирж, хот хоорондын холбоогоор Наокогийн байх Амирё рүү залгалаа.

Хэрэг зоригийг минь лавласан хүлээн авахын ажилтанд маргааш үдийн хойно Наокотой уулзах хүсэлтэйгээ хэлэхэд овог нэрийг минь асуугаад, гучин минутын дараа дахин залга гэв.

Оройн хоолны дараа дахин залгахад эмэгтэй “Уулзаж болно оо. Та заавал ирээрэй” гэлээ.

Би эмэгтэйд талархаад харилцуураа тавьж, өрөөндөө ороод солих хувцас, ариун цэврийн хэрэгслээ цүнхэлж бэлдээд, нойроо хүргэх гэж брэнди уунгаа Шидэт уул-аа уншсаар хоёр цагийн алдад унтав.

Зургаадугаар

БҮЛЭГ

Даваа гарагийн өглөө би долоод эртлэн босч, гар нүүрээ угаагаад, сахлаа хусч хоолонд ч оролгүй комендантаас хоёр хоног ууланд авирна хэмээн чөлөө авахаар гарлаа. Хэд хэдэн удаа аяллаар явж байсан болоод тэр үү комендант “Яв, яв” гэхээс өөр юм хэлсэнгүй.

Хүн чихэлдсэн метрогоор Токиогийн буудал хүрч, Киото явах эхний Хикари шинкансэнд суув. Өглөөний ундандаа сендвич идэж, кофегоор даруулаад цаг хэртэй унтжээ.

Ингээд арван нэгэн цагт Киотогийн буудал дээр ирлээ. Наокогийн бичсэнээр гуравдугаар гудамж хүрэх автобусанд сууж, хот хоорондын автобусны зогсоол хүрээд, Амирегийн сувилал хүрэх арван зургаадугаар чиглэлийн автобус хэзээ, хаанаас явахыг лавлав. Автобус арван нэг гучин тавд цаад захын зогсоолоос хөдөлж, цагийн дараа зорьсон газраа хүрэх ажээ.

Тасалбар авч, хажууханд байх номын дэлгүүрээс газрын зураг аваад хүлээлгийн танхимд суунгаа Амирегийн сувиллыг хайлаа. Сувилал уулсын дунд байрлах юм. Энэ чиглэлийн автобус уул нуруу даван явсаар цааш явах боломжгүй газарт тулаад эргэнэ. Миний буух газар эцсийн зогсоолоос наахна юмсанж.

Наокогийн бичсэнчлэн автобуснаас буугаад хориод минут явж Амирейд хүрнэ. Холын уулсын бэлд намуухан байх нь аргагүй ээ.

Хорь гаруйхан хүнтэй автобус Киотогоос гарч, Камо голын хөвөөгөөр умар зүгт хурдална. Хотоос холдохын хэрээр байшин барилга цөөрч, тариан талбай, ашиглаагүй

цулгуй газар нүдэнд тусна. Хар вааран дээвэр, хүлэмжүүд наранд гялтганан гялалзана.

Автобус уулын тахиралдсан замаар урагшилж, жолооч эр хүрдээ зогсоо чөлөөгүй мушгина. Дотор эвгүйрч, өглөө уусан кофе амтагдах шиг.

Удалгүй зам цагаан болж, тайван амьсгаа авах зуур хушин ойн дундуур үргэлжлэв. Хүний гар хүрээгүй сүрэг хуш моддын сүүдэр хавь орчныг нилдээ бүрхэнэ. Сэвэлзүүр салхи үлээж, чийг үнэртэнэ. Уулын горхи даган, хушин ойн дундуур нэлээд удаан явсаар, хорвоо дэлхий нилдээ хушин ойгоор хүрээлэгдээ юу гэж санах үест дөрвөн талаараа уул нуруудаар хүрээлэгдсэн хөндийд хүрлээ. Тариалангийн талбай ногоорч, зах нь тэртээд үзэгдэнэ. Замын хажуугаар тунгалаг уст гол урсах аж.

Тэртээ хол цагаан утаа суунаглаж, хаа нэгтээ хэцэн дээр хатаасан хувцас хунар харагдаж, нохой хуцна. Айлууд саравчиндаа түлээ өрж, зарим айлын дээвэр дээр муур хэвтэх юм. Олон байшинтай ч хүний бараа сураггүй. Автобус хушин ойгоос гарч суурингаар өнгөрөөд аанай л ойд орно. Хэд хэдэн тосгоноор өнгөрөхөд хэдэн хүн буусан ч нэг ч хүн суусангүй.

Дөчөөд минутын дараа автобус даваанд тулж, жолооч эндээ 4-5 хором зогсох тул түр бууж болно гэлээ. Хүнээ шингэлсээр надтай нийлээд дөрвөн хүн үлджээ. Хүмүүс автобуснаас бууж, тамхи татаж, биеийнхээ чилээг гарган тэртээ дор цэлийх Киотог ажина.

Жолооч эр замын хажуу руу морь харав. Дээсээр томсон том цагаан хайрцаг барьсан, харлаж борлосон тавь эргэм насны эр “Ууланд авирах нь уу?” гэсэнд би “Тийм ээ” гэлээ.

Хэдэн минутын дараа эсрэг чиглэлийн автобус үзэгдэж, манай автобустай зэрэгцмэгц жолооч нь буугаад, манай жолоочтой хэдэн үг солиод, зорчигчдоо суулгаж өөр өөрийн замаар хөдөллөө. Цааш хөдөлбөл зам хоёр автобус зөрөхийн аргагүй болтлоо нарийсчээ. Ийм учраас ч нөгөө автобусаа энд хүлээдэг бололтой. Замд хэд хэдэн машин таарсан бөгөөд тэр бүр машинууд ухарч зам тавьж өгнө.

Суурингууд цөөвтөр айлтай болоод байшин барилга цөөрч, хагалсан талбайн хэмжээ улам бүр багасаад, уулс сүндэрлэнэ. Гэсэн ч хааяагүй олон нохойтой, автобус ойртоход өрсөх мэт боргоно.

Би айл хунар, тариан талбайгүй, гагц буудлын тэмдэгтэй эл хуль зам дээр бууж, уулын бэл хүрсэн замаар үүргэвчээ мөрлөн алхав. Замын

зүүн хажуугаар нарийн горхи урсаж, баруун талд уулс дүүхэлзэнэ. Арван таван минут яваад баруун талдаа “Амирёгийн сувилал”. Гадны хүн орохыг хориглоно” гэсэн бичигтэй салаа замын уулзварт хүрэв. Нэг машин арай чүү багтах нарийхан замтай юм. Машины дугуйн мөр тодорно. Ойн тэртээгээс ямар нэгэн том шувуу далавчаа сар сар дэвэн нисэх чимээ дуулдав. Тэртээ холд буун дуу бололтой тасхийлээ. Тэртээ холоос сонстсон сулхан дуун.

Ойн захад дээгүүрээ төмөр утасгүй, хэн хүссэн нь даваад гарчих боломжтой, хар өнгийн том төмөр хаалга нь онгорхой, миний хэрийн өндөртэй цагаан чулуун хашаа байх юм.

Манаачийн дөрвөлжид мөн л хүнгүй. Үүдний хажууд мөнөөх “Амирёгийн сувилал”. Гадны хүн орохыг хориглоно” гэх самбар. Манаач саяхан гарсан бололтой. Ширээн дээр гурван ширхэг тамхины иштэй үнсний сав, аягатай цай, транзисторын хүлээн авагч байх агаад ханын цаг чаг чаг хийн цохилно.

Манаачийг хэсэг хүлээсэн ч аанай л бараа сураггүй. Би нэг товчлууруу дээр хэдэнтээ дарлаа. Үүдний хажуугийн гучаад машины зогсоол дээр нэг микро автобус, 4WD Ланд Крузер жийп, хар хөх өнгийн Вольвогоос өөр юмгүй.

Хоёр гурван минутын дараа шар дугуй унасан хүрэн хувцастай манаач нь болтой хүн ирж яваа харагдав. Жар орчим насны янхигар өвгөн ер санаа зовсон шинжгүй “Уучлаарай” гэсээр дугуйгаа налуулж тавилаа. Дугуйных нь шаврын хаалт дээр цагаан будгаар “32” гэж тэмдэглэжээ.

Овог нэрээ хэлбэл манаач өвгөн утас цохиод, миний нэрийг хэд хэд хэлээд төд удалгүй “За, мэдлээ” гэсээр харилцуураа тавив. Манаач өвгөн:

-Та төв байранд очоод Ишида багштай уулзаарай. Энэ замаар яваад салаа замын уулзвараас зүүн талаасаа хоёр дахь замаар нь явна. Тэнд нэг хуучин байшин бий. Тэндээс баруун эргээд цаашаа явахад төмөр бетон төв байр харагдана. Тэмдэглэгээтэй болохоор амархан олно гэлээ.

Өвгөний хэлснээр явахад салаа замын уулзварын зүүхэнтээ үүдэндээ чулуун гэрэлтүүлэг, арчилж тордсон сайхан мододтой, нэгэн цагт хэн нэгний зуслангийн сууц байсан шинжийн хуучин барилга үзэгдэв.

Тэндээс баруун эргэж явбал сувиллын төв байр байх ажээ. Хонхор газар барьсан болоод ч тэр үү, цэвэр цэмцгэр, энгийн даруу орчинтой гурван давхар энэ барилга овор багатай юм.

Шатаар өгсөж хоёр давхрын шилэн хаалгаар орвол ширээний ард улаан даашинзтай бүсгүй сууж байлаа. Би нэрээ хэлж, Ишида багшийг сураглав.

Бүсгүй эелдгээр инээмсэглээд “Та тэнд суугаад хүлээж байхгүй юу?” гэсээр лоббид байх хүрэн буйдан руу дохиод харилцуураа авав.

Би үүргэвчээ буулгаж, буйдан дээр тухлангаа эргэн тойрноо ажлаа. Цэвэр цэмцгэр, тохь тухтай лоббид гоёлын ургамалтай хэд хэдэн том сав, абстракт зурагнууд өлгөөстэй. Гял цал хийсэн модон шалан дээр юмс ойж харагдана.

Бүсгүй “Багш одоохон ирнэ” гэхээс өөр юм хэлсэнгүй.

Би толгой дохилоо. Ялаа нисэх нь сонстмоор нам гүм байх ажээ. Хүн амьтан дуг хийдэг үдийн амралтын цагаар анир чимээгүй байх нь аргагүй.

Төдхөн ширүүн байрын богинохон үстэй, дунд хэрийн насны эмэгтэй хөнгөхөн алхаж ирээд хажууд минь хөлөө ачаад суув. Эмэгтэй гар барихдаа миний гарыг эргүүлж тойруулан ажиглана. Эмэгтэйг:

- Сүүлийн хэдэн жил хөгжим тоглоогүй юмаа даа гэж ам нээвэл би хачирхсандаа:

- Тийм ээ гэлээ.

- Хөгжим тоглодоггүй хүний гар шиг байна.

Нүүр нь багагүй үрчлээтсэн ч овор багатай, нүдэнд дулаахан эмэгтэй. Үрчлээ нь сайхан зохисон ч юм шиг.

Эмэгтэй гучин хэдтэй шиг санагдсан бөгөөд сэтгэл татам гэхэд хилсдэхгүй. Анх хараад л надад таалагдлаа.

Үсээ хайш яайш зассан ч өөрт нь сайхан зохижээ. Цагаан футболка, хөх цамц, цайвар даавуун өргөн өмд өмсөөд теннисний шаахай углажээ.

Туранхай, жижигхэн хөхтэй, нэг тал руугаа ялимгүй жуумалзах жимбийсэн уруултай. Амьдралаас үл ялиг залхсан шинжтэй, ааш сайтай, чадварлаг мужаан мэт харагдана.

Эмэгтэй жуумалзсаар хэсэг зуур намайг толгой түрүүгүй ажиглах нь эгээтэй л халааснаасаа хулдаасан метр гаргаж ирээд хэмжих нь үү гэлтэй.

- Хөгжим тоглодог уу?

- Тоглодоггүй ээ.

- Харамсалтай л юм. Тоглодог бол аштай юу.

- Тийм гэж үү?

Эмэгтэй хөгжмийн тухай ярьсаар байсанд би бага зэрэг балмагдлаа. Төдхөнөө энгэрийн халааснаасаа хайрцаг Seven star гаргаж ирээд нэгийг зууж асаагаад, таатай нь аргагүй сорлоо.

- Чамайг Ватанабэ гэдэг байх аа. Наокотой уулзахаас өмнө жаал жуул юм ярилцъя гэж бодоод. Энд бусад газраас арай ондоо. Бага сага ойлголттой болохгүй бол будлиж магад. Чи манай сувиллын тухай бараг мэдэхгүй биз дээ?

- Тийм ээ, бараг мэдэхгүй.

- Тэгвэл эхнээс нь тайлбарлаж өгье гээд гэнэт юм санасан аятай хуруугаа дуугаргаад:

- Чи юм идсэн үү? Өлсөөгүй биз? гэлээ.

- Өлсөж л байна.

- Тэгвэл хоолны газар орж юм идэнгээ ярилцъя. Үдийн цай өнгөрсөн ч хоол үлдсэн байх аа.

Эмэгтэй урд гарч хурдан алхсаар шатаар буугаад, нэг давхарт байх хоолны газарт намайг дагуулан орлоо. Хоёр зуугаад хүнтэй хоолны газрын талыг нь ашигладаг бололтой. Үлдсэн ширээ сандлаа цэгцлэн хураажээ. Амралтын улирал дууссан хойно ирсэн аятай л санагдав.

Бид хоёр нухсан төмстэй гоймонтой шөл, ногооны салат, талх идэж, жүржийн шүүс уулаа. Наокогийн бичсэнчлэн ногоо цагаа нь үнэхээр амттай.

- Чи ч хоолонд сайн юм. Минийхийг ид ид.

- Сайхан амттай юм. Би өглөөнөөс хойш олигтой юм идээгүй гэхэд эмэгтэй:

- Тэгвэл миний хоолыг ч бас идчих. Би цадчихлаа.

- Та идэхгүй бол тэгье.

- Миний ходоод жижигхэн болохоор их идэж чаддаггүй юм. Гэхдээ тамхи татахыг үзүүлнэ ээ. Намайг Рэйко гэдэг гээд тамхиа асаав.

Би түүний ам хүрээгүй төмсний шөлийг уун, талх идэх зуур намайг сониучирхан ажиглана.

- Та Наокогийн эмч үү?

- Би юу? Хэн тэгж байна?

- Ишида багштай уулзаарай гэхээр нь л... (японоор эмч, багш нарыг ихэнхдээ багш гэж авгайлдаг, орч)

- Би энд хөгжим заадаг. Тэгээд л багш гэсэн байх. Үнэндээ би энд эмчлүүлдэг юм. Ирээд долоон жил болсон болохоор хөгжим зааж,

бичиг хэрэгт нь тусалдаг. Сүүлийн үед өвчтөн гэхээсээ ажилтан нь болсон ухаантай. Наоко миний тухай яриагүй юу?

Би толгой сэгсэрлээ.

- Сонин л юм. Наоко бид хоёр нэг өрөөнд суудаг. Янз бүрийн юм яриад хамт байхад сонирхолтой шүү. Чиний тухай их ярьдаг.

- Миний тухай юу ярьдаг гэж? гэвэл эмэгтэй огт анзаарсангүй.

- Эхлээд сувиллынхаа талаар ярих хэрэгтэй байх. Эндхийг жирийн эмнэлэг биш гэдгийг юун түрүүнд ойлгох учиртай. Өөрөөр хэлбэл эмчилгээ биш, сувилгаа хийдэг гэсэн үг. Хэдэн эмч байдаг ч өдөрт нэг цаг хэртэй бидэнтэй харилцаж, халуун хэмжихээс хэтэрдэггүй. Эмнэлгээс ялгаатай нь энд эрчимтэй эмчилгээ хийдэггүй. Тийм болохоор төмөр торгүй, хаалга үүд нь ч үргэлж нээлттэй. Хүмүүс өөрсдөө энд ирж, хүссэн цагтаа явж болно. Ерөнхийдөө сувилахад тохиромжтой хүмүүс ирдэг. Гэхдээ тэр болгоныг энд байлгаад байдаггүй. Тусгай эмчилгээ шаардлагатай хүмүүсийг тохирсон эмнэлэгт нь хэвтүүлдэг. Ойлгож байна уу?

- Ойлгож л байна. Тэгээд энд ямар сувилгаа хийдэг вэ? Рэйко жүржийн шүүснээс уугаад:

- Эндхийн аж амьдрал өөрөө сувилгаа болдог. Цэвэр агаартай нам гүм орчинд зүй зохистой дэглэм барьж, спортоор хичээллэж илааршуулдаг гэх үү дээ. Эндээ талбайтай тул хүнсний хэрэгцээгээ барагтай бол хангачихна. Зурагт, радиогүй. Нөгөө яриад байдаг коммун юм уу даа. Гэхдээ ялгаатай нь энд сувилуулах үнэтэй.

- Тийм их үнэтэй гэж үү?

- Хаданд гарсан үнэтэй гэхээргүй ч хямд төсөр гэхээргүй шүү. Чи хар л даа. Зай талбай томтой, цөөн өвчтөнтэй, олон ажилтантай болохоор мэдээж шүү дээ. Би энд ирээд удсан болохоор бараг ажилтан нь болчихсон. Тийм болохоор эмчилгээний төлбөр бараг төлдөггүй юм. Чи кофе уух уу?

“Тэгье” гэвэл эмэгтэй тамхиа унтраагаад, лангуун дээр тавьсан кофе чанагчаас хоёр аяга кофе хийгээд авч ирлээ. Рэйко кофендоо чихэр хийгээд, халбагаараа хутгаж байгаад уув.

- Гэхдээ сувилал маань ашгийн байгууллага биш болохоор учиргүй их төлбөр авдаггүй. Хорин жилийн өмнө энд эдлэн газартай байсан хүн газраа хандивласан юм. Нэг хуучин байшин байхыг чи хараа биз?

- Харсаан.

- Урьд нь тэр байшингаас өөр байшин байгаагүй. Өвчтөнүүдээ тэнд цуглуулаад эмчилгээ хийдэг байсан. Учир юу гэхээр эдлэн газрын эзний хүү нь сэтгэл мэдрэлийн өвчтэй байсан гэдэг. Тэгээд эмч нь бусад хүмүүстэй харилцуулж эмчлүүлбэл дээр гэж л дээ. Тэр эмч тусгаарлагдсан орчинд биеийн хөдөлмөр эрхэлж, хэн хэндээ туслан аж төрснөөр сэтгэл мэдрэлийн зарим өвчин эдгэдэг гэж үздэг байж. Анх тэгж л эхэлсэн. Тэгээд яваандаа зөвшөөрөл авч, эдлэн газраа тэлээд, таван жилийн өмнө энэ төв байраа барьсан.

- Эмчилгээ нь үр дүнтэй л байж дээ.

- Тийм шүү. Энд ирээд эдгэрдэггүй хүмүүс байдаг ч олон хүн эдгээд явсан. Эндхийн хамгийн сайн тал нь бүгд нэг нэгэндээ тусалдаг явдал. Эмч, өвчтөн хоёрын ялгаа ихтэй бусад газрыг бодвол энд хүн гэдэг амьтан төгс төгөлдөр биш гэдгийг ойлгодог болохоор бүгд нэг нэгнээ дэмждэг. Харамсалтай нь, бусад газар ийм биш. Эмч бол эмч, өвчтөн бол өвчтөн. Өвчтөн эмчээс тусламж хүсч, эмч тусалдаг. Бид нэг нэгнийхээ хувьд өөрийгөө олж харах толь нь болж эмчтэйгээ найзалж нөхөрлөдөг юм. Эмч биднийг ажиглаж, шаардлагатай үед тусална. Гэхдээ бид ч түүнд туслах үе бий. Би нэг эмчид төгөлдөр хуур, өөр нэг өвчтөн, сувилагчдад франц хэл заах жишээтэй. Бидэн шиг иймэрхүү өвчтэй улсын дунд авьяастай хүн бишгүй. Тиймээс ч энд эмч, өвчтөн гэж ялгалгүй нэг ижил түвшинд харилцдаг. Өвчтөн, ажилтан, чи ч ялгаагүй. Энд байхдаа чи бидний найз нөхөр болж бидэнд тусална. Бид ч бас чамд тусална. Наоко та хоёр бие биедээ туслах болно.

- Би яаж туслах вэ?

- Юун түрүүнд туслах хүсэлтэй байх хэрэгтэй. Чамд ч гэсэн бусдын тус дэм хэрэгтэй. Хоёрдугаарт, юманд шударга хандах нь чухал. Юмыг аятайхан аргалаад өнгөрөөе, эвгүй гэж бодоод худал хэлж болохгүй. Ингээд л боллоо.

- Хичээе ээ. Харин Та яагаад энд бүхэл бүтэн долоон жил болоо вэ? Таныг хэвийн биш гэж хэлэхээргүй л юм байна.

- Өдөр бол зүгээр. Шөнө болохоор хэцүү дээ. Шүлсээ үсчүүлээд л шалаар хөрвөөнө.

- Тийм гэж үү?

- Тоглосон юм. Юу гэж тэгэх вэ? Би эдгэрсэн. Өөр нэгэнд туслая гэж бодсондоо л үлдсэн юм. Хөгжим зааж, ногоо тариад л. Би энд байх дуртай. Эндхийнхэнтэй Хэдийн найзууд болсон. Бодит ертөнцөд эндээс сайхан гэж үү? Би одоо гучин наймтай. Мөдхөн дөч хүрлээ. Наоко шиг залуу бол ч өөр хэрэг. Тэнд намайг гэх найз нөхөд, гэр бүл гэж үгүй. Ажил төрөл ч олдохгүй. Энд долоон жил болсон болохоор амьдралаас тасарчээ. Хааяа номын санд сонин уншдаг л юм. Гэхдээ энэ зуур эндээс ер холдож үзсэнгүй. гарлаа гэхэд юү хийхээ мэдэхгүй шүү дээ.

- Шинэ орчинтой болж магад. Оролдоод үзэх хэрэгтэй дээ.

- Болно л доо. Гэхдээ Ватанабэ, энд байх өөр шалтгаан бас байна аа. Би дараа хэлье гэсэнд би толгой дохилоо.

- Наокогийн бие дээрдсэн үү?

- Дээрдсэн шиг санагддаг шүү. Эхэндээ санаа зовмоор хэцүү байсан ч одоо тайвшраад, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болсон. Хамаагүй дээрдсэн. Гэхдээ Наоко арай эрт эмчлүүлэх хэрэгтэй байсан юм. Найз залуу Кизүки нь нас барснаас хойш өвчин нь илэрсэн юм билээ. Өөрөө ч, гэрийнхэн нь ч тоогоогүй дэг ээ. Тэгээд бас ар гэрийнхээ нөхцөл байдлаас болоод...

- Юу болсон гэж?

- Чи мэдээгүй юм уу?

Би толгой сэжлээ.

- Энэ тухай Наоко өөрөө хэлсэн нь дээр биз. Чамд их л юм ярих санаатай даг аа.

Рэйко кофегоо хутгаж балгаад:

- Үүнээс гадна Наоко та хоёр хоёулхнаа үлдэж болохгүй. Эргэлтээр ирсэн хүн өвчтөнтэй хоёулхнаа үлдэж болдоггүй журамтай. Би та хоёртой байна. Тийм болохоор тэвчихээс аргагүй. Зүгээр биз? гэсэнд инээмсэглэсээр:

- Зүгээр ээ гэлээ.

- Надаас гэрэвшилгүй чөлөөтэй ярилцаарай. Би тэртээ тэргүй Наоко та хоёрын тухай бараг нэгд нэгэнгүй мэднэ.

- Бүгдийг нь үү?

- Бараг л. Учир нь бид хэсэг бүлгээрээ ярилцдаг. Тийм болохоор бүгдийг нь мэднэ. Тэгээд ч Наоко бид хоёр ний нуугүй ярилцдаг. Нууц гэхээр юм үлдээгүй биз дээ.

Би кофе уунгаа Рэйког ширтлээ.

- Үнэндээ Токиод байхдаа Наокод тэгж хандсан нь зөвдөв үү, буруудав уу, бүү мэд. Энэ тухай бодоод бодоод учир зүйгээ олохгүй юм.

- Тэрийг би ч, Наоко ч мэдэхгүй. Та хоёр сэтгэлээ онгойтол ярилцах хэрэгтэй. Юмыг засч залруулж болдог доо. Нэг нэгнээ ойлговол зөв, буруугаа олоход амархан.

Би толгой дохилоо.

- Наокотой гурвуулаа бие биедээ тус дэм болно оо. Хэн хэндээ туслах чин хүсэлтэй байхад үр дүн гарч л таарна. Чи хэр удах вэ?

- Нөгөөдөр орой Токио руу буцах ёстой. Цагийн ажилтай. Пүрэв гарагт герман хэлний шалгалттай.

- Тэгвэл манай өрөөнд хоно. Илүү дутуу зардалгүй, оройтно гэлгүй чөлөөтэй ярих боломжтой.

- Танай өрөөнд үү?

- Тийм ээ. Наоко бид хоёрын өрөөнд. Тусгаарлах хаалттай. Тэгээд ч буйдантай болохоор санаа зоволтгүй.

- Эмэгтэйчүүдийн өрөөнд хонож болох уу?

- Чи бид хоёрыг шөнө хүчиндэхгүй биз дээ?

- Яалаа гэж.

- Тэгээд юунд нь санаа зовдог юм бэ? Манайд хоноод л чөлөөтэй ярилц. Тэр нь дээр. Тэгж байж л нэг нэгнээ ойлгоно. Гитар тоглохыг минь ч сонсоно биз. Би ч сайн тоглодог шүү.

- Та хоёрт төвөгтэй биш үү? гэвэл Рэйко гуравдахь тамхиа асаагаад:

- Наоко бид хоёр хэдийн яриад тохирчихсон. Тийм болохоор бид хоёрыг урьж байна гээд л бодчих. Болж байна уу? гэлээ.

- Бололгүй яахав дээ.

- Чи их сонин ярих юм. Хөх тариан талбайн дундуур зохиолын баатрыг дуурайдаг юм уу даа?

Намайг “Яалаа гэж?” хэмээн инээхэд Рэйко тамхиа зуусан чигтээ тас тас хөхрөв.

- Чи илэн далангүй хүн юм. Энд долоон жил болохдоо элдвийн хүнтэй таарлаа. Сэтгэлээ нээж чадах хүнийг хараад л мэднэ. Чи хүсвэл илэн далангүй байж чадах л юм байна.

- Сэтгэлээ нээлээ гээд яах ч юм билээ? гэхэд Рэйко алгаа хавсарч:

- Аз жаргалтай болно гэж билээ.

Тамхиных нь үнс ширээн дээр унасан ч Рэйко тоосонгүй.

Бид хоёр төв байрнаас гарч жижиг толгод даван усан сан, теннис, сагсан бөмбөгийн талбайн хажуугаар өнгөрөв. Теннисний талбайд дунд хэрийн насны туранхайвтар эр, махлаг залуу хоёр тоглоно. Хоёул муугүй тоглох бодолд автсан мэт бөмбөгөө дамжуулах нь огт өөр тоглоом наадаж буй мэт. Хэн хэнийх нь хөлс цутгажээ.

Залуу нь Рэйког хараад тоглохоо болин, дөхөж ирээд хэдэн үг солилоо. Талбайн хажууханд нэг эр өвс тэгшилдэг машин ажиллуулна.

Цааш явмагц төгөлд европ маягийн хориод жижиг байшин байлаа. Ихэнх байшингийн үүдэнд манаачийнх шиг шар дугуй түшүүлээстэй. Энд сувиллын ажилчид амьдардаг ажээ.

- Хоол хүнснийхээ ихэнх түүхий эдийг хот орохгүйгээр эндээс нийлүүлдэг. Шувууны аж ахуй, номын сан, хөгжмийн цуглуулга, спортын хэрэгсэл, жижиг дэлгүүртэй. Долоо хоногт нэг удаа үсчин ирнэ. Ням гарагт кино гаргадаг. Хэрэгтэй юмаа хот ордог ажилтанд захичихна. Хувцас хунараа сэтгүүлээс захиалаад авчихдаг юм.

- Хот орж болдоггүй юмаа даа?

- Тийм ээ. Шүд өвдөх зэрэгт хот орно л доо. Хүссэн үедээ эндээс явж болох ч тэгсэн тохиолдолд буцаж ирж болохгүй. Тэр чигтээ л явна гэсэн үг. Хот руу ирж очоод байвал бүгд л тийшээ зүглэнэ шүү дээ.

Төглөөс гарахад хэвгий газарт хоёр давхар модон байшингууд байлаа. Тэр байшингууд надад нэг л хачин жигтэй санагдав. Чухам учрыг нь тайлж чадахгүй ч анх нүдэнд тусахад л этгээд сонин санагдаж билээ. бодит бус байдлыг эвтэйхэн илэрхийлсэн уран зураг үзсэнээс өөрцгүй шахам. Мункийн зургаар Уолт Диснейн хүүхэлдэйн кино хийвэл нэг иймэрхүү болох талтай. Байшингууд нь бүгд тэгш дөрвөлжин, өнгө ижил. Том хаалгатай, олон цонхтой, өөр хоорондоо мурилзаж тахиралдсан зам харгуйгаар холбогджээ. Үүдэндээ арчилж тордсон

цэцгийн мандалтай. Хүн амьтан үзэгдэхгүй бөгөөд бүх хөшиг нь хаалттай байх аж.

- Энэ бол эмэгтэйчүүдийн С хэсэг. Дотроо дөрвөн өрөөтэй арван байшинтай. Нэг өрөөнд хоёр хүн суудаг гэхээр нийт наян хүн амьдрах боломжтой ч одоохондоо гучин хоёр хүн бий.

- Нам гүм юмаа.

- Одоо энд хэн ч байхгүй. Бүгд цагийн хуваарийн дагуу спортоор хичээллэх, орчин тойрноо тохижуулах, сэтгэл зүйн засалд орох, ургамлын үндэс түүх гээд хийх ёстой ажлаа хийж яваа. Би бол өөр л дөө. Хүн болгон хийх ажлынхаа хуваарийг гаргадаг юм. Наоко ханын цаас нааж байгаа бил үү, шохойдож байгаа бил үү? Өдөр болгон таван цаг хүртэл таван янзын юм хийдэг.

Рэйко С-7 гэсэн бичигтэй байранд орж, мухрын шатаар өгсөөд, баруун талын хаалгыг онгойлгов. Хаалга нь цоожгүй юм. Өрөө нь илүү дутуу юмгүй ч тохилог бөгөөд дотроо зочны хэсэг, унтлагын өрөө, гал тогоо, угаалгын өрөөтэй. Би Рэйкогийн хэлснийг санаж, сэтгэл тайвширч биеэ барихаа болилоо.

Зочны хэсэгт буйдан, түшлэгтэй сандал, ширээ байна. Гал тогооны өрөөнд мөн л нэг ширээ байх бөгөөд энэ хоёр ширээн дээр томоо гээчийн үнсний сав тавьжээ. Унтлагын өрөөндөө хоёр ор, бичгийн хоёр ширээ, хувцасны шүүгээтэй. Орны толгойн сэтгүүлийн ширээн дээр ширээний чийдэн, дэлгээстэй ном байх юм. Гал тогоондоо жижигхэн плитка, хөргөгчтэй. Ойр зуурын хоол хийгээд идчих боломжтой.

-Ванн байхгүй, зөвхөн шүршүүртэй. Гэхдээ аятайхан байгаа биз дээ? Усанд хэвтье гэвэл нийтийн халуун ус орно.

- Ёстой догь юмаа. Оюутны байрнаас хувь илүү юм гээч.

- Өвөлдөө ч хэцүү дээ.

Рэйко мөрөн дээр минь алгадаж буйданд суулгаад өөрөө ч хажууд суув.

- Эндхийн өвөл нь их урт. Хүйтэн ч гэж жигтэйхэн. Хаашаа л харна цас. Өдөржингөө цас цэвэрлэнэ дээ.

Голдоо ортол даарна. Байраа халаагаад хөгжим сонсонгоо ярьж хөөрнө, юм нэхнэ. Өрөө маань талбай томтой нь цаанаа учиртай. Зай муутай бол энэ хүмүүс чинь хийх юмаа олж ядаад бачимдана шүү дээ. Чи өвөл ирвэл мэднэ ээ.

Рэйко урт өвлийн тухай бодолд автсан бололтой санаа алдана.

- Буйдангаа дэлгээд унтчих. Бид хоёр өрөөндөө унтана. Болно биз дээ?

- Бололгүй яахав.

- Тэгвэл тохиролцлоо. Бид хоёр таван цагт ирэх байх.

- Тэр болтол эндээ хүлээж бай.

- Тэгье ээ. Герман хэлээ давтаж сууя.

Рэйког гармагц би буйдан дээр хэвтээд нүдээ анилаа. Энэхэн мөчид Кизүки бид хоёр мотоцикл хөлөглөн тэртээ хол явснаа нэхэн дурсав.

Яг л ийм намрын налгар өдөр байсан сан. Хэдэн жилийн өмнөх намар юм бэ дээ? Тийм ээ. Тэр өдрөөс хойш хэдийн дөрвөн жилийг элээжээ. Кизүкигийн арьсан хүрэмний үнэр, 125 кубын улаан өнгөтэй Ямаха мотоциклыг саналаа. Бид хоёр эргийн дагуу нэлээд хол явж, тамирдсан хоёр амьтан оройдоо эргэж эрсэн юм.

Сэтгэлд торох гоц гойд юм болоогүй тэр өдрийг би мартдаггүй.

Намрын сэвэлзүүр салхи чихний хажуугаар шунгинаж, Кизүкигийн хүрэмнээс тас зууран тэнгэр өөд ширтэхэд мөдхөн дүүлэн нисэх мэт болсон сон.

Буйдан дээр хэвтэнгээ энэ бүхнийг тодхон санав. Яагаад гэдгийг нь мэдэхгүй ч энэ өрөөнд хэвтэх зуур тэр бүр дурсаж яваагүй өнгөрсөн үеийн нандин учралууд нүдний минь өмнүүр шил шилээ даран жирэлзэх шиг боллоо. Баяр хөөр, уйтгар гуниг сүлэлдэн холилдсон тэр л мөчүүд.

Би хэр удаан хэвтсэн юм бүү мэд. Гэнэт нөмрөн ирсэн (хадан завсраар оргилох булаг мэт урсах) дурсамж дурдатгалдаа автсаар чимээгүйхэн орж ирсэн Наоког анзаарсангүй.

Нүдээ нээвэл Наоко өөдөөс минь ширтэн зогсож байлаа. Наоког хажууд минь суухад хий юм үзэв үү? хэмээн эхэндээ эргэлзсэн ч Наоко мөн ажээ.

- Унтчихаа юу?

- Үгүй ээ. Элдвийн юм бодоод л. Чи сайн уу? гэсээр би бослоо.

Наоко урьдынх шигээ инээмсэглэсээр.

- Сайн. Зав гарахаар нь ороод гаръя гээд. Буцаад явахгүй бол болохгүй. Миний үс хачин болж уу?

- Дажгүй л байна.

Үсээ бага ангийн сурагч охин шиг тайруулаад урьдын адил нэг талдаа хавчаар зүүсэн нь дундад зууны модон бар зурган дээр дүрслэгдсэн охинтой их төстэй болоод Наокод тун чиг зохижээ.

- Үсчинд очихоос залхуураад Рэйкоогоор тайруулсан юм. Зохиж уу?

- Сайхан зохижээ.

- Ээж харин муухай байна гэсэн.

Наоко эрвээхэйтэй хавчаараа авч, үсээ задлаад, гараараа хэдэнтээ илж ахин хавчив.

- Гурвуулаа уулзахаас өмнө чамайг хармаар санагдаад. Юм хэлэх гэсэндээ биш л дээ. Өөрийгөө дасгах гээд л. Хүний хажууд барьц алдаж магадгүй.

- Одоо дасч байна уу?

- Дасч л байна гэх Наоко хавчаараа оролдон:

- Одоо явахгүй бол горьгүй нь гэсэнд толгой дохилоо.

- Ватанабэ, ирсэнд чинь үнэхээр баяртай байна. Энд хэцүү байвал шуудхан хэлээрэй. Зарим хүмүүс энд байж чаддаггүй. Тийм болохоор гомдоод байх юмгүй. Эндхийн хүмүүс илэн далангүй байдаг юм.

- Ойлголоо.

Наоко дэргэд минь суугаад налахад тэвэрч авбал мөрийг минь дэрлэж, хүзүүнд минь нүүрээ наав. Биеийн халууныг хэмжих гэсэн мэт хэсэгтээ хөдөлсөнгүй. Түүнийгээ тэвэрч суухад цээж огших шиг боллоо.

Төдөлгүй Наоко чимээгүйхэн босч хаалга хаагаад гарав. Гансарсан сэтгэл минь дэвтэж, өөрийн мэдэлгүй унтчихжээ. Гал тогоонд Наокогийн аяга таваг, угаалгын өрөөнд шүдний сойз, унтлагын өрөөнд унтдаг ор нь буй энэ орчинд алжаалаа тайлан дугхийв. Эргэлдэн нисэх эрвээхэй зүүдэлж сэрээд цагаа харвал Хэдийн дөрөв гучин тав болжээ. Нар хэвийж, нам гүмхэн байх агаад тэртээ дээр үүлс хөвнө. Үүргэвчнээсээ алчуур гаргаж чийхарсан хөлсөө арчаад, цамцаа солилоо. Гал тогоонд орж ус уугаад цонхоор шагайлаа.

Хажуугийн байрны цонхон тушаа ан амьтан, жигүүртэн шувуудын нэлээн хэдэн цаасан хайчилбар өлгөжээ.

Эргэн тойрон чимээ аниргүй. Хэсэгтээ сайтар тордсон орд харшид орь ганцаар байх шиг хачин мэдрэмж төрнө.

Ингээд тав өнгөрөхөд хүмүүс нэг хоёроороо цувлаа. Гал тогооны цонхоор харвал гурван эмэгтэй явж өнгөрөв. Өргөн хүрээтэй малгайтай тул царай зүс, хэдий хэр настайг нь мэдсэнгүй. Дууг нь сонсвол дунд эргэм насны эмэгтэйчүүд бололтой. Тэднийг булан тойрмогц дөрвөн эмэгтэй үзэгдлээ.

Ой мод, уул нуруудаар жаргах нарны улаан туяа тусна.

Наоко, Рэико хоёр тав гучид ирлээ. Наокотой хавьд уулзалдаагүй найз нөхөд шиг мэнд мэдэлцэхэд тэр ихэд гэрэвшинэ. Рэико дэлгэсэн номыг

минь сониучирхан харах юм. Би өнөө л Шидэт уул-аа уншиж суулаа.

- Энэ хол ном чирч ирэх хэрэг байсан юм уу даа? хэмээн Рэикогийн хэлдэг үнэн л дээ.

Гурвуул Рэикогийн чанасан кофег ууж суунгаа Наокод Довтлогч ор сураггүй болсныг дуулгав. Сүүлчийн удаа уулзахдаа гэрэлт цох бэлэглэсэн тухай ч хэлэхээ мартсангүй.

- Харамсалтай л юм. Уг нь түүний тухай сонин сонсвол сайхан байлаа.

Рэико Довтлогчийн тухай мэдэхийг хүссэнд би хөршийнхөө тухай нэгд нэгэнгүй хуучиллаа. Элгээ хөштөл инээх юм. Довтлогчийн тухай ярихад энэ хорвоо баяр цэнгэлээр бялхах шиг санагддаг сан.

Зургаа болоход бид гурав өнөөх хоолны газарт орж үдийн хоолоо идлээ. Наоко бид хоёр шар буурцаг, загасны шөл, ногооны зууш, агшаасан будаа захиалж, Рэико гоймонтой зууш, кофеноос өөр юм авсангүй. Зуушаа идээд Рэико бага иддэгээ тайлбарлах аястай:

- Нас явахаар их юм идэж чадахгүй болчих юм гэлээ.

Хэд хэдэн хүн орж гарсныг эс тооцвол цайны газарт хориод хүн л хооллоно. Хөгшин залуу хүмүүс байхаас биш цайны газрын байр байдал оюутны гуанзнаас ялгамгүй. Бүгд л дүнгэр дүнгэр хөөрөлдөнө.

Тас тас хийсэн инээд, уулга алдах, хэн нэгнийг дуудах дуун гарахгүй бөгөөд хүмүүс гурваас тавуул хэсэг бүлэг болон суугаад дунгэнэтэл ярилцана. Нэг нь ярихад бусад нь анхааралтай сонсож, толгой дохицгоон, дуусмагц нь төд удалгүй өөр нэгэн ам нээнэ.

Яриа нь ойлгомжгүй бөгөөд сонин содон. Наоко эдэн шиг ярьдаг гэхэд итгэмгүй. Энэ бүхэн ой тойноос минь давж, би ганцаардах шиг боллоо.

Арын ширээнд суух өрвийсэн хэдэн үстэй, цагаан хувцастай эмч байрын эрэгтэй нүдний шилтэй бухимдуу залуу, хэрэм шиг царайтай дунд хэрийн насны эмэгтэй хоёрт жингүйдлийн нөхцөлд ходоодны шүүс хэрхэн ялгардаг тухай нэгд нэгэнгүй тайлбарлана.

Залуу, эмэгтэй хоёр аан, уун гэхээс өөр юм хэлэхгүй юм. Яриаг нь чих тавин сонвол өрвийсөн үстэй нөхөр эмч биш дэг ээ.

Энд гадны хүн ирэх нь жирийн үзэгдэл аятай. Цагаан хувцастай эр нэгэнтээ эргэж хараад “Хэр удах вэ?” гэхээс өөрөөр хэн ч намайг анзаарч тоосонгүй.

- Хоёр хоноод Лхагва гарагт буцна.

- Намартаа энд сайхан. Гэхдээ өвөл ирээрэй. Байгаль дэлхий цасанд хучигдсаныг харахад сэтгэл сэргэнэ шүү гэхэд Рэйко:

- Цас ороход Наоко явчих байлгүй гэлээ.

- Гэхдээ л эндхийн өвөл сайхан шүү гэх энэ эр яав ч эмч биш ээ.

Би Рэйкоогоос:

- Хүмүүс юун тухай хөөрөлддөг юм бэ? гэвэл тэр гайхсан шинжтэй:

- Юу юун тухай гэж? Энгийн л зүйл ярина шүү дээ. Өдөр хийсэн ажил, уншсан ном, тэнгэр хангай гээд л ойр зуурын аахар шаахар юмаа ярина. Хэн нэгэн гэнэт үсэрч босч ирээд “Өнөөдөр хойт туйлын цагаан баавгай од зооглосон болохоор маргааш бороо орно” гэж хашгирна гэж бодоогүй биз дээ?

- Хаанаас даа. Дүнгэнэтэл юм ярихаар нь гайхсандаа л асуулаа.

- Энд нам жимхэн болохоор хүмүүс өөрийн эрхгүй дуугаа намсгаж ярьдаг юм.

Наоко ингэж хэлээд идсэн загасныхаа ясыг тавагныхаа захад ялгаж тавиад амаа арчлаа.

- Тэгээд ч энд чанга ярих шаардлагагүй. Нэгнээ ятгаж сэнхрүүлж, анхаарал татах явдалгүй.

- Тийм байх.

- Нам гүм орчинд хооллох зуур чимээ шуугиан үгүйлэгдэх шиг. Хүмүүсийн дуу шуу, инээд хөөр, уулга, элдэв юмсын талаар хэтрүүлж ярихыг сонсмоор. Би хаа нэг хорвоо ертөнцийн дуу чимээнээс залхдаг ч чимээ аниргүй орчинд нэг л тухгүй.

Зүйрлэвэл, эндхийн уур амьсгал онцгой тоног төхөөрөмжийн эд ангийг танилцуулах үзэсгэлэн худалдаатай төстэй. Хүсэл сонирхол нэгтэй хэсэг бүлэг хүмүүс бусдад ойлгогдохгүй мэдээлэл солилцох мэт.

Хооллож дуусаад өрөөндөө ирсний дараа Наоко, Рэйко хоёр С хэсгийн нийтийн угаалгын газар луу явж, намайг хүсвэл шүршүүрт ороорой гэлээ. Би ч зөвшөөрлөө.

Тэр хоёрыг явсан хойгуур би хувцсаа тайлж, шүршүүрт ороод, үсээ угаав. Үсээ сэнсээр хатаангаа тавиур дээрээс Билли Эвансын пянзыг авч тавилаа. Хэсэгтээ сонсвол Наокогийн төрсөн өдрөөр хэд хэд эргүүлж тавьсан тэр пянз мөн шүү. Наоко тэр орой цурхиран уйлж, би гэдэг хүн тайтгаруулахыг оролдсон сон.

Хагас жил хүрэхтэй үгүйтэйн өмнөхөн боловч тэр нэгэн өдөр сэтгэлд минь эргэлдсээр эртээ мэт санагдах болжээ. Цаг хугацааны мэдрэмж алдагдаж, тэр үдэш сэтгэлд минь хадагдан үлдэж дээ.

Сар ихэд гэрэлтэх учир гэрлээ унтрааж, Билли Эвансын төгөлдөр хуурын аязанд умбан буйдан дээр тухлав. Сарны гэрэлд юмсын сүүдэр уртасч ханан дээр тусах нь эгээтэй л шингэлсэн бэх дусаасан мэт үзэгдэнэ. Үүргэвчнээсээ брэндитэй дашмагаа гаргаад балгахад хоолой даван ходоод руу халуу дүүгүүлэн урсана. Энэ илч бүх биеэр минь тарлаа.

Ахиж нэг балгаад дашмагаа далд хийлээ. Сарны гэрэл хөгжмийн аясаар бүжих мэт болно.

Хорин минутын дараа Наоко, Рэйко хоёр буцаад ирлээ.

- Гэрэлгүй байхаар нь юмаа хамж аваад Токио явчихав уу? гэж бодлоо шүү.

- Яалаа гэж дээ. Тэргэл сарны гэрэлд хэвтээгүй уджээ. Тэгээд л гэрлээ унтраасан юм.

- Сарны гэрэл ч сайхан шүү. Рэйко, сүүлд тог тасрахад барьж байсан лаа хаа байгаа билээ?

- Гал тогооны шургуулганд бий байх.

Наоко гал тогооноос том цагаан лаа авчирсныг би асаагаад үнсний саванд тосноос нь дусааж тогтоов. Рэйко лаанаас тамхиа асаалаа.

Ертөнцийн нэгээхэн мухарт энэ сүүмэлзсэн лааны гэрэлд гурвуулхнаа суух шиг эргэн тойронд чимээ аниргүй.

Лааны анивалзах гэрлийн чичирхийлсэн сүүдэр хананд тусна. Наоко бид хоёр буйдан дээр, Рэйко түшлэгтэй сандал дээр өөдөөс хараад суув.

- Дарс уух уу? гэсэнд гайхсандаа:

- Энд архи ууж болдог юм уу? гэвэл Рэйко ичсэн аятай чихээ маажгаад:

- Болохгүй л дээ. Гэхдээ бага зэрэг дарс, шар айраг уухад тоодоггүй юм. Би сайн таньдаг хүмүүстээ захиад авчихдаг юм гэсэнд Наоко:

- Бид хоёр энүүхэндээ булагначихна аа гэв.

- Догь юм гээч.

Рэйко хөргөгчнөөс цагаан дарс гаргаж онгойлгоод, гурван хундага барьсаар ирлээ. Гэрийн дарс гэмээр сайхан амттай дарс.

Пянз тоглож дуусмагц Рэйко орон доороосоо гитар гаргаж энхрийлж хайрлах мэт хөглөөд Бахын аязыг аядуухан тоглов. Хаа нэг хөг алдах ч сэтгэлээсээ тоглоно. Гитар дараад Рэйкогийн сэтгэл уужирдаг нь илт.

- Энд ирээд гитар тоглодог болсон. Өрөөнд минь төгөлдөр хуур байхгүй байгаа биз дээ? Өөрөө сурсан, тэгээд ч гар хуруу маань гитар дарахад тохиромжгүй учир жаахан эв дүй муутай. Гэхдээ л тоглох

дуртай. Авсаархан, энгийн, тоглоход амар сайхан хөгжим. Яг л жижигхэн дулаахан өрөө шиг.

Дарс шимэнгээ Бахын аялгууг сонсож, сэтгэл уужирч толгой сэргэх шиг боллоо.

Наоко Битлзийн дуунуудаас тоглооч гэхэд Рэйко:

- Санал хүсэлтийн цаг эхэллээ. Наоко ирсэн өдрөөсөө л Битлзийн дууг тоглуулах болсон. Дуунуудад нь нугасгүй дуртай гэсээр Мишель-ийг сурмаг тоглов. Дарс балгаж, тамхиа сороод:

- Сайхан дуу шүү. Би дуртай. Хөдөө талд бороо шиврэх шиг аялгуутай.

Үүний дараа Рэйко Nowhere man, Juliaхоёрыг үе үе нүдээ аньж, найган тоглоод, дарс шимэн ахиж нэг тамхи асаавал Наоко:

- Норвегийн ой-г дараач гэлээ.

Рэйко гал тогооноос мөнгө цуглуулдаг сав авчирсанд Наоко зуун иенийн зоос хийв. “Юу болоод байна?” гэж асуувал өөдөөс минь:

- Норвегийн ой хамгийн дуртай аялгуу минь болохоор тоглох болгонд нь зуун иен хийдэг юм гэхэд Рэйко:

- Би энэ мөнгөөр тамхиа авна гэсээр гитараа барьлаа. Рэйко хуруугаа амрааж байгаад Норвегийн ой-г дарав. Аялгуу бүрээ сэтгэлээсээ тоглох ч сэтгэлийн хөдөлгөөндөө автана гэж үгүй.

Би мөн адил халааснаасаа зуун иенийн зоос гаргаж хийсэнд Рэйко:

- Баярлалаа гэсээр инээмсэглэв.

Яагаад гэдгийг нь мэдэхгүй ч энэ аялгууг сонсоход хааяахан өөрийн эрхгүй ойд төөрсөн шиг сэтгэлд гуниг хурдаг. Хүйтэн, харанхуйн дунд ганцаар үлдсэнээс өөрцгүй. Тийм болохоор Рэйко намайг гуйхаас нааш тоглож өгдөггүй.

Рэико:

- Касабланка шиг л сонсогдож байна гэсээр инээмсэглэнэ.

Үүний дараа Рэико босанова стилийн хэд хэдэн аялгуу дарлаа. Тэр зуур би Наоког ширтсээр.

Захиандаа бичсэнчлэн спортоор хичээллэж, биеийн хүчний ажил хийж борлоод өнгө оржээ. Охин байхын тунгалаг нүд, жимбийсэн уруулыг нь эс тооцвол нас бие гүйцсэн эмэгтэй хүний шинжтэй болсон байлаа. Хааяадаа ширүүхэн байх харц нь зөөлөрчээ. Гоо төрх нь намайг догдлуулж билээ. Эмэгтэй хүн зургаахан сарын дотор ингэж өөрчлөгдөнө гэдэг гайхалтай. Урьдынхаасаа илүүтэй өөртөө татна. Гэсэн ч алдсан зүйлийг нь бодмогц харуусал төрнө.

Хүүхэд ахуйн гэнэн томоогүй, бардам дүр төрх нь ор мөргүй арилсан гэлтэй.

Амьдрал ахуйг минь асуусанд оюутнуудын бослогын тухай ярьж, анх удаа Нагасаваг дурслаа. Нагасавагийн этгээд жигтэй зан чанар, ижилгүй нэгэн үзэл бодол, нэг талыг хэт баримтлах ёс суртахууныг хоёр гуравхан үгээр илэрхийлэхийн аргагүй ч Наоко ойлгох шиг.

Оюутны байранд андын холбоо тогтоосон цорын ганц хүн маань ийм этгээд нэгэн бөгөөд харин ганзага нийлж охин эргүүлдэг тухайгаа ам нээсэнгүй.

Рэико дарс шимэнгээ өмнө нь тоглосон Бахын аязаа сургуулилна.

- Сонин хүн юм даа.

- Харин тийм ээ.

- Чамд таалагддаг уу?

- Сайн мэдэхгүй л юм. Таалагддаг гэмээргүй. Хүний өмнө шарваганаж шарвалзаад байдаг хүн биш л дээ. Илэн далангүй, чигч шударга, хатуужилтай залуу.

- Тийм олон бүсгүйтэй орооцолдсон хүн хатуужилтай байж дөнгөх үү?
Хэдэн охинтой унтсан гэлээ?

- Бараг наяд. Тооноос чанар гэдэг шиг улам бүр тоохоо больдог хүн.
Хүсээд байгаа зүйл нь тэр бололтой.

- Үүнээ тэгээд хатуужил гэдэг юм биз дээ?

- Тийм л болтой.

Наоко хэсэг бодолхийлээд:

- Надаас илүү толгойндоо юмтай нөхөр байна даа хэмээв.

- Тэр ч тийм шүү. Толгой сайтайн ачаар элдвийн зан аашаа өөр хооронд нь авцалдуулаад системжүүлчихсэн. Энд ирвэл хоёр гурав хоноод л энийг ч мэдлээ, тэрийг ч ойлголоо гэх вий. Гэхдээ л нийгэм даяараа түүн шиг улсыг хүндэлдэг.

- Би ч толгой муутай даг аа. Энд ирээд өдий болоход энэ газар, өөрийгөө сайн ухаж ойлгоогүй л явна.

- Чи толгой муутай биш ээ. Энгийн л хүн. Хааяадаа би ч өөрийнхөө учрыг олдоггүй. Хүмүүс ийм л байдаг.

Наоко өвдгөө тэвэрч суугаад:

- Чиний тухай илүү ихийг мэдмээр байх юм гэв.

- Би бусдаас ялгаагүй жирийн л нэгэн. Гэр орон, сургууль соёл, царай зүс, хичээл сурлага, бодол санаагаараа олны дундаас онцгойроод байх юмгүй.

- Чиний дуртай Скотт Фицджеральдын зохиолд өөрийгөө жирийн гэдэг хүнд итгэж болохгүй гэдэг байх аа. Чамаас авч уншиж байсан даа.

- Тийм л дээ. Гэхдээ би дүр эсгээгүй юм шүү. Үнэндээ өөрийгөө энгийн гэж боддог. Надад жир бус зан авир бий юу?

- Мэдээж. Сэтгэлд минь хүрсэн, онцгой санагдсан болохоор л дотноссон. Тэрнээс архинд хөлчүүрч харсан хүнийхээ өвөрт орчихно гэж бодоогүй биз?

- Хаанаас даа.

Наоко хэсэгтээ дуугаа хурааж гараа ажиглана. Би юу хэлэхээ мэдэхгүй дарсаа уулаа.

- Чи хэдэн бүсгүйтэй дотносож байсан бэ?

- Найм ес байх аа.

Рэйко “Хорь хүрээгүй байж яасан замбараагүй юм бэ?” гэсээр гитараа хойш тавив. Наоко өөдөөс минь дүрэлзтэл ширтэнэ.

Би Рэйкод анхны найз охинтойгоо хэрхэн дотносч, хоёр тийш болсон, яаж ч хичээгээд түүнд дурлаагүй, аажимдаа Нагасаваг дагаж хэд хэдэн бүсгүйтэй нэг хөнжилд орсноо нэгд нэгэнгүй ярьлаа.

- Чи надтай уулзаж учирч байсан ч сэтгэлдээ Кизүкиг тээсээр байсанд эмзэглэж явлаа. Бодох бүр бачимдаж, тааралдсан бүсгүйчүүдтэй нэг хөнжилд ордог байсан.

Наоко толгойгоо хэд хэд сэгсрээд намайг ширгсэн чигтээ:

- Чи Кизүки бид хоёрыг яагаад дотносоогүйг асууж байсан даа. Энэ тухай мэдмээр л байна уу?

- Мэдсэн нь дээр байх аа.

- Энэ хорвоог орхисон хүн эргээд ирэх биш. Харин бид амьдарна.

Рэйко гитараа дарж, Наоко үсээ задалж хавчаараа эргүүлнэ.

- Кизүки бид хоёр хэн хэнээ хүсч байсан болохоор хэд хэдэн удаа оролдсон юм. Гэсэн ч чадаагүй. Яагаад болоогүйгээ одоо ч ойлгодоггүй. Кизүкид хайртай болохоор охин биеэ зориулья гэж бодсон ч болоогүй.

Наоко үсээ хавчаад үргэлжлүүлээ. Цонхны цаанаас тэргэл сар тусна.

- Бие минь хөндий хоосон юм шиг л норохгүй. Элдвээр үзсэн ч өвдөнө гэж жигтэйхэн. Кизүкиг хэд хэдэн удаа гараараа, амаараа энхрийлж байлаа. Ватанабэ, би энэ болгоныг сэтгэлдээ тээгээд үлдье гэж бодсон ч дотор давчдаад байх юм. Тэр шөнө би өөрийн эрхгүй норчихсон.

- Тийм ээ.

- Хорин насны минь төрсөн өдөр тохиосон тэр өдөр чамтай уулзмагцаа л хүсэх болсон. Чамд тэврүүлэхийг хүссэн. Энхрийлж таалуулж, нэгэндээ уусан шингэхийг хичнээн их хүссэн гээч. Амьдралдаа анх удаа л хуял тачаалдаа автах шиг болсон. Кизүкид хайрлаж байсан ч яагаад ингэснээ ойлгохгүй юм.

- Өөр хүнийг хайрладаг ч намайг хүсчээ дээ?

- Намайг өршөөгөөрэй. Чамайг гомдоохыг хүсээгүй юм шүү. Кизүки бид хоёр хар багын л тоглож өссөн. Үргэлж цуг байж, их ч ярилцана. Тэр хэрээр нэг нэгнээ ойлгоно. Зургаадугаар ангидаа анх үнсэлцсэн. Сарын тэмдэг ирэхэд Кизүкид л хэлж байлаа. Ийм дотно болохоор энэ хорвоог орхиход нь өрөөл бусдыг хайрлах байтугай өөрийгөө ч мэдэхээ байсан. Хүнийг хайрлана гэж юу болохыг мэдэхээ больсон.

Наоко ширээн дээр тавьсан хундагаа авах гээд унагалаа. Дарс хивсэн дээр асгарч, би хундагыг нь авч ширээн дээр тавиад “Дахиад уух уу?” гэсэнд хариу өгөөгүй ч гэнэт чичирч, төдхөн хоёр гараараа нүүрээ даран мэгшиж эхлэв. Тэр нэгэн шөнө цөхрөнгөө баран уйлж байсан Наоко нүдэнд үзэгдлээ.

Рэйко гитараа хойш тавьж, түүний нуруугаар зөөлөн илнэ. Мөрөөр нь тэврэхэд Наоко хүүхэд шиг энгэрт нь шигдэв.

- Ватанабэ, чи хэсэгтээ гадуур явж байгаад ирээч. Би Наоког тайвшруулья.

Би толгой дохин босч ноосон цамцаа давхарлаж өмсөөд “Уучлаарай” гэсээр гарахад Рэйко “Санаа зоволтгүй. Чиний буруу гэж юу байхав.

Удахгүй тайвширна” хэмээн үлдлээ.

Дүүрэн сарны туяанд цайрах жимээр төгөл рүү орж, харсан зүгтээ алхахад байгал дэлхийн чимээ анир тэртээд цуурайтаа.

Хааяахан навчис сэрчигнэнэ. Амьтай бүхэн явж өнгөрөхийг минь хүлээн, ойн гүнд сэм мярайн гэтэх шиг анир чимээгүй. Модон дундаас гарч жижиг довын энгэрт суугаад, Наокогийн байшинг харлаа. Цонхных нь цаанаас лааны бүдэгхэн гэрэл сүүмэлзэх өрөө нь тэр үзэгдэнэ. Ер хөдлөлгүй тэр гэрлийг ажиг нэлээд суув. Тэр гэрэл шатаж дуусах сүнсний сүүлчийн анивалзаа мэт санагдлаа. Жэй Гэтсби үдэш бүр нөгөө эрэгт анивалзах гэрэл ажиглаж суудаг шиг би энэ бүдэгхэн гэрлийг харна.

Гучаад хормын дараа байшинд дөхөж очвол Рэикогийн гитарын дуу эгшиглэнэ. Шатаар алгуурхан өгсөж, хаалга тогшоод орвол Наоко байсангүй. Хивсэн дээр суугаад гитараа тоглох Рэико унтлагын өрөө рүү зангаад гитараа хойш нь тавьж, буйдан дээр суулаа. Намайг хажуудаа суу гээд, үлдсэн дарсаа хоёр хундаганд хийж:

- Наоко зүгээр ээ гээд өвдгөн дээр минь зөөлөн цохив.

- Хэсэг хэвтээд тайвшрах биз. Хоёулаа түр гарах уу? гэсээр намайг дагуулан гарлаа.

Рэико бид хоёр гэрэлтүүлэгтэй замаар явж, сагсан бөмбөгийн талбайн хажуугийн сандал дээр тухлав. Рэико сандал доороос бөмбөг авч эргүүлээд “Чи теннис тоглож чадах уу?” хэмээнэ. Би цохиур барихаас хэтэрдэггүй хүн л дээ.

- Чадах нь чадна. Гэхдээ тааруухан.

- Сагсан бөмбөг тоглодог уу?

- Муухан гэвэл Рэико инээгээд:

- Чамд бүсгүйчүүдийн толгойг эргүүлэхээс өөр хийж чадах байна уу? гэхэд нь би жаахан эмзэглэж:

- Би тэгж их хүүхэн шуухан эргүүлдээд байдаг хүн биш шүү дээ гэлээ.

- Битгий уурла. Тоглосон юмаа. Чамд бузгай сайн мэддэг юм байгаа л биз дээ?

- Тийм юмгүй ээ. Дуртай юм бол бий.

- Юунд дуртай гэж?

- Ганцаараа аялах, усанд сэлэх, ном унших дуртай.

- Ганцаараа хийдэг юманд дуртай юм биз дээ?

- Тийм ч юм уу? Олуулаа тоглодог тоглоом энэ мэтийг оролдож явсан ч сонирхож байсангүй.

- Чи өвөл ирээрэй. Өвөл бид цанаар гулгадаг. Чамд таалагдана аа. Өдөржингөө гулгах ч сайхан шүү.

Рэйко эртний хөгжмийн зэмсэг харах мэт баруун гараа гэрэлд ажиглана.

- Наокогийн сэтгэл их хямардаг уу?

- Тийм ээ, хаа нэг ингэх нь бий гэх Рэйко зүүн гараа ширтэнэ.

- Цаадах чинь хааяахан уйлна. Гэлээ гээд зүгээр л дээ. Уйлж сэтгэлээ онгойлгох хэрэгтэй. Дотроо бүгшээд байвал хэцүү. Хуралдсаар байгаад өөрийгөө үгүй хийх нь бий.

- Би буруу юм хэлчихэв үү?

- Үгүй ээ. Санаа зоволтгүй. Сэтгэлээ нээж илэн далангүй ярилцах нь чухал. Нэгнээ шархлуулж, саяных шиг хямрааж байсан ч энэ нь хамгийн сайн арга. Наоког эргээд хэвэнд нь оруулья гэж бодож л байвал илэн далангүй ярилцах нь зүйтэй. Нэг нэгэндээ туслах хэрэгтэй гэж хэлж байсан даа. Өөрөөр хэлбэл эндхийн эмчилгээний гол арга барил нь өөр хоорондоо сэтгэлээ онгойтол илэн далангүй ярилцах. Өөр орчинд хүн тэр бүр сэтгэлээ нээдэггүй.

- Ойлголоо.

- Энд өнгөрөөсөн долоон жилийн хугацаанд олон хүн орж гарахыг харлаа. Сүүлдээ нэг хараад л эдгэрэх эсэхийг нь мэдчихнэ. Гэхдээ Наокогийн хувьд хэлж мэдэхгүй юм. Хэзээ мөдгүй эдгэрээд явж мэдэх ч олон жил шаналах магадлалтай. Тийм учраас илэн далангүй хандаж тус дэм бол гэхээс өөр хэлэх юм алга.

- Наокогийн тухай хэлж мэдэхгүй байна гэдэг чинь юу гэсэн үг вэ?

- Наоког хайрладаг болохоор сэтгэл хоёрдоод эрүүл саруул нүдээр харж чадахгүй байгаа болов уу. Наокогийн хувьд нэлээд адармаатай нөхцөлд орсон, үүнийг нь тайлахад хугацаа шаардлагатай. Олон жил шаналж мэдэхээс гадна хялбархаан сэргэж болох ч талтай. Гол нь тэвдэж сандарч болохгүй. Чамд зөвлөх юм энэ л байна. Ямар ч үед итгэл найдвараа алдаж болохгүй. Шавдуулж хүчилж болохгүй. Хугацаа орно гэдгийг ухаарч тайвуу хандах нь чухал. Ингэж чадах уу?

- Оролдоод үзнэ ээ.

- Үүнээс гадна сар жил өнгөрсөн ч Наокогийн сэтгэл тайтгарахгүй байж мэднэ шүү. Чи энэ талаар бодсон л биз?

Би толгой дохилоо. Рэико бөмбөг залангаа ярьж суулаа.

- Хүлээнэ гэдэг ямар хэцүүг би мэднэ ээ. Ялангуяа чам шиг залуу хүнд ямар олиг байхав.

- Ямар ч баталгаагүй.

- Хайр сэтгэл чинь энэ бүхнийг даван туулж чадах уу?

- Мэдэхгүй юм даа. Үнэндээ хэн нэгнийг сэтгэлээсээ хайрлах гээчийг ухааж ойлгож амжаагүй л явна. Чадах чинээгээрээ Наокод туслах сан л гэж бодох юм. Хаа явахаа ч мэдэхгүй нь. Таны хэлдгээр Наоко бид хоёр хэн хэнээ түшиж тулах хэрэгтэй биз ээ.

- Тааралдсан бүсгүйчүүдтэйгээ унтсаар л байх уу?

- Энэ талаар ч бодож үзсэнгүй. Ер нь, яавал дээр вэ? гар хангалга хийгээд хүлээнэ гэдэг сэтгэлд багтахгүй юм гэсэнд Рэико бөмбөгөө газар тавьж, өвдгөн дээр минь алгадаад:

- Бүсгүйчүүдтэй өвөр түрийдээ ороход муу нь юу байхав. Чиний амьдрал хойно би юу хэлэх вэ. Чи өөрөө шийдэх нь зүй. Арван ес, хорин насанд хүний зан чанар төлөвшиж тогтдог болохоор энэ үед дэмий хэрэг хийвэл яваандаа буруудна. Буруу замаар будаа тээвэл буцахдаа шороо тээнэ гэдэг шиг өтөл насандаа зүдэрнэ. Энэ үнэн шүү. Чи сайн бодоорой. Наоког чин сэтгэлээсээ хайрлаж байвал өөрийгөө ч хайрлах хэрэгтэй.

- Мэдлээ.

- Би ч хорьтой явсаан. Залуу ч байж, сайхан ч байж. Чи итгэхгүй дээ?

- Итгэлгүй дээ.

- Нээрээ гэж үү?

- Үнэн гэм.

- Наокотой зүйрлэхгүй ч залуудаа дажгүй хөөрхөн байлаа. Одоогийнх шиг үрчлээгүй.

Рэикогийн үрчлээнүүд түүнд жигтэйхэн зохиж гэвэл “Баярлалаа” гэсээр инээд алдлаа.

- Эмэгтэй хүнд ингэж хэлдэг хүн гэж байдаг аа. Өөр хүнд л хэлж болдоггүй юм шүү. Би ч баярлана л даа.

- Ойлголоо.

Рэико түрийвчнээсээ цанын хувцастай арваад настай охины өнгөт зураг гаргаж үзүүлээд:

- Хөөрхөн байгаа биз. Миний охин. Оны эхээр явуулсан зураг нь. Одоо дөрөвдүгээр ангид сурдаг гэлээ.

- Тантай адилхан инээмсэглэдэг юм байна.

Зургийг нь буцааж өгвөл Рэико далд хийгээд тамхи асаав.

- Залуудаа мэргэжлийн төгөлдөр хуурч болох санаатай байлаа. Авьяастай ч байж. Өөд уруугүй магтуулаад л. Уралдаан тэмцээнд түрүүлж, сайн ч сурч байлаа. Төгсөөд Германд сурахаар тогтсон юм. Бодож санах юмгүй залуу нас аа гэж. Санасан бүхэн сэтгэлчлэн бүтээд сайхан байж дээ. Болж бүтэхгүй зүйл гарвал эргэн тойрныхон тусална. Гэтэл нэг өдрийн явдал энэ бүхнийг минь үгүй хийсэн. Хөгжмийн сургуулийн дөрөвдүгээр курсэд юмдаг. Нэг томоохон тэмцээнд бэлдээд сууж байтал зүүн гарын чигчий хуруу гэнэт хөдлөхөө байчихдаг юм байна. Яасан юм бүү мэд. Хуруугаа ер хөдөлгөж чаддаггүй. Иллэг хийж, халуун хүйтэн жин тавих, хоёр гурав хоног завсарлага авах гээд элдвээр л үзлээ. Болсонгүй. Үхтлээ айгаад эмнэлэгт очиж өдий төдий шинжилгээ өгсөн ч яасан нь мэдэгддэггүй. Хуруу маань хэвийн, мэдрэлийн судал нь зүгээр. Хөдлөхгүй байх учиргүй. Сэтгэл санаанаас чинь болж байж магад гэхээр нь сэтгэл зүйчтэй уулзлаа. Гээд шалтгааныг нь тогтоож чадсангүй. Тэмцээн уралдаан гэж сандраад хямарсан гэснээс өөр юм хэлсэнгүй. Хэсэгтээ төгөлдөр хуураа битгий дар гэдэг юм байна.

Рэико тамхиа сорж, толгойгоо хэдэнтээ сэгсрэв.

- Хэсэг чимээ аниргүй амаръя гэж бодоод Изүд байдаг эмээгийн дээ очлоо. Тэмцээн уралдаанаа мартаж, хоёр долоо хоног төгөлдөр хуураасаа холдож, бас бус ажил төрлөө амжуулъя гэж шийдлээ. Гэсэн ч юу л хийнэ төгөлдөр хуур санаанд буугаад. Өөр юм бодох сөхөөгүй. Хуруу минь энэ чигтээ хөдлөхгүй болвол яана гэхээс сэтгэл үймэрнэ. Төгөлдөр хуураа дарж чадахгүй баймааж нь яаж амьдрах вэ? гэсэн бодол толгойноос гардаггүй. Өдий хүртэл энэ хөгжмөөр амьдарч байлаа. Дөрөвтэйгээсээ л тоглосон хүн арга ч үгүй биз. Өөр бодох санах юм ч байсангүй. гар хуруугаа хайрлаад гэрийн ажил гээчийг огт мэдэхгүй. Хавь ойрынхондоо сайн тоглодог гэж магтуулдаг, төгөлдөр хуураар амьдарч байсан хүүхэд түүнээсээ холдохоор яах нь ойлгомжтой шүү дээ. Юу үлдэх вэ? Дотор харанхуйлаад л явчихсан. Ухаан мэдрэлгүй болсон гэлтэй.

Рэйко тамхиа хаяж, гишгэж унтраалаа.

- Төгөлдөр хуурч болох мөрөөдөл минь ингэж бүтэлгүйтэж билээ. Хоёр сар эмнэлэгт хэвтээд хуруу маань аажмаар хөдлөх болж, сургуульдаа буцаж орж яаж ийгээд төгссөн ч сэтгэлд нэг л сэвтэй. Намайг хөдөлгөж байсан хөшүүрэг хугарчих шиг болсон. Эмч намайг мэргэжлийн төгөлдөр хуурч болоход сэтгэлийн тэнхээ муутай хүн юм, больсон нь дээр гэдэг юм байна. Сургуулиа төгсөөд хүүхдүүдэд гэрээрээ төгөлдөр хуур зааж явсан ч гунигтай байлаа. Хорь ч хүрээгүй насандаа амьдрал гэдэг утга учиргүй санагдаж эхэллээ. Аймшигтай биз? Амьдрал нүд ирмэхийн завдалгүй өөрчлөгдөж, алга ташилт, магтаал сайшаал дуулж, дэмжлэг хүлээхээ больсон. Гэртээ суугаад, ойр хавийн хэдэн хүүхдэд өдрөөс өдөрт хэдэн этюд, сонат заахаас өөр хийх юмгүй. Золгүйдээ гутарч, өнжилгүй нулимс дуслуулна. Надаас дор нэгэн тэмцээн уралдаанд дэд байранд орсон, аль нэг соёлын төвд бие даасан тоглолтоо тавьж байна гэхийг дуулаад жигтэй гомдоно. Аав, ээж минь анхаарал халамж тавьж бөөцийлөх ч ялгаагүй шанална. Байж суух газраа олж ядна. Хамт амьдардаг хүнийхээ юу мэдэрч байгааг хүн мэддэг дээ. Бусдад сайрхуулдаг охин нь мэдрэлийн эмнэлгээс салахгүй, хань ижил ч үгүй болохоор аргагүй биз. Энэ бүхэн дээрээс дарж давчдуулах шиг болдог байлаа. Галзуурахад ганц хуруу дутуу гэдэг тэр байх. Хавь орчныхон миний тухай л шивэр авир ярьж байгаа гэж эмээсэндээ гадуур гарахаа ч больсон. Тэгээд хорин дөрөвтэйдээ долоон сар сувилалд хэвтэв ээ. Хашаа хороотой, хаалга нь цоожтой, төгөлдөр хуургүй, бохир гэж жигтэйхэн, эндхээс тэс ондоо орчин. Шантарч, яах ийхээ мэдсэнгүй. Хурдхан гарах юмсан гэсэндээ тэсч суулаа. Долоон сар гэдэг урт хугацаа! Үрчлээ ч нэг нэгээрээ нэмэгдсэн.

Энэ үед Рэйко үл ялиг инээмсэглэв.

- Эмнэлгээс гараад нөхөртэйгээ учирч, нэг гэрт орсон юм. Надаас нэгээр дүү, онгоцны үйлдвэрийн инженер. Үнэхээр сайн хүн. Дуу цөөтэй, сэтгэл сайтай, жудагтай залуу. Хагас жил төгөлдөр хуур заалгаад нэг өдөр гэрлээ гэдэг байгаа. Нэг өдөр хичээл тараад цайлж суунгаа гэнэтхэн сууя гэсэн гэхэд чи итгэх үү? Уулзаж учрах нь байтугай, гар гараасаа барилцаж үзээгүй хүн ингэж хэлмэгц гайхсан

гэж жигтэйхэн. Тиймдээ ч гэрлэж чадахгүй нь гэлээ. Хүн сайтай, өөрт нь татагддаг ч хэд хэдэн шалтгааны улмаас нэг гэрт орж чадахгүй нь гэсэнд шалгаахаар нь хоёр ч удаа сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэвтэж байснаа, өдгөө болоод цаашдаа хэрхэхээ мэдэхгүй гэдгээ ний нуугүй хэллээ. Мань хүн “Тайван бодъё” гэхээр нь “Тэг тэг. Сайн бод. Яарах зүйлгүй” гэлээ. Долоо хоногийн дараа ирэхдээ өнөө саналаа ахиад хэлдэг юм

байна. Би гурван сар хүлээхийг хүссэн. Энэ зуур уулзаж учраад үзье. Тэгээд хүсэл нь хэвээр байх аваас суух эсэхээ ярилцъя гэлээ.

Бид хоёр гурван сарын турш долоо хоногтоо нэг уулзаж, олон ч газраар зугаалж, нэлээдгүй зүйлийг ярилаа. Би түүнд татагдсан шүү. Түүний дэргэд л амьд хүн гэдгээ ахин мэдэрсэн. Хамтдаа байхад сэтгэл тайтгарч, муу бүхнээ умартана. Төгөлдөр хуурч болж чадалгүй эмнэлэгт хэвтсэн ч амьдрал утга учиртай болж, нүд тайлах шиг болсон. Бодол санааг минь өөрчилсөнд битүүхэндээ түүнд талархаж явлаа. Гурван сарын дараа нөхөр маань гэрлэх хүсэлтэйгээ дахиад хэлдэг юм байна. Би надтай дотносох хүсэлтэй бол татгалзах юмгүй гээд “Би хүнтэй дотно харилцаанд орж үзээгүй ч чи надад таалагддаг. Намайг хүсч байвал би түлхэхгүй. Гэлээ ч гэрлэлт гэдэг үүнээс ондоо. Гэрлэвэл зовлон зүдгүүрээ хуваах хэрэгтэй. Санаснаас чинь хэцүү байх вий. Гэлээ гээд хамт байхыг хүснэ гэж үү?” гэсэнд бүхнийг зөвшөөрлөө.

Надтай зүгээр нэг дотносоод өнгөрөхгүй гэрлэж, бүхнээ хуваалцах хүсэлтэй гэж билээ. Сэтгэлийн үгээ хэлсэн. Сэтгэлдээ мэдэрснээ хэлж түүнээ хэрэгжүүлдэг, за гэвэл ёогүй залуу. “Тэгвэл хоёулаа гэрлэе” гэхээс өөр үг надад олдоогүй. Бид хоёр дөрвөн сарын дараа гэрлэсэн юм уу даа? Надаас болж эцэг эхтэйгээ муудалцаж, холбоо харилцаагаа тасалсан. Тэднийх Шикокугийн удам судар сайтай айл болохоор хоёр ч удаа сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэвтсэнийг маань олоод мэдчихсэн юм. Тиймдээ ч эсэргүүцэж, ам зөрсөн хэрэг. Тэгэхээс аргагүй. Бид хоёр хуримын ёслол хийлгүй, гэрлэлтээ батлуулж, гурав хоног Хаконэд амарч тэрүүхэндээ тэмдэглэсэн. Гэхдээ л жаргалд умбаж байлаа. Гэрлэхээсээ өмнө, хорин тав хүртлээ эр хүнтэй дотносож үзээгүй гэвэл хүн итгэхгүй.

Рэйко санаа алдаад, бөмбөг барин яриагаа үргэлжүүллээ.

- Хоёулаа байхад асуудалгүй, өвчин сэдрэхгүй гэж бодож байлаа. Сэтгэлийн зовиуртай хүнд түшиж тулах хүн ус агаар шиг хэрэгтэй. Ийм хүн итгэл даана. Байдал аягүйдвэл даруйхан анхааруулж халамжилна. Тушиж тулах итгэлтэй хүнтэй гэмээнэ бидний өвчин сэдрэхгүй. Жаргалдаа булхаж, амьдрал ийм гайхалтай сайхан гэж үү? гэж бодож явлаа. Эгээтэй л хүйтэн хайруу далай тэнгисээс аврагдаж, ноосон хөнжлөөр хучуулаад дулаахан оронд хэвтэх мэт санагддаг сан. Хоёр жилийн дараа охинтой болж, хүүхдээ асарч тойглох гээд ажилд дарагдаж, өвчин зовлонгоо ор тас мартсан. Өглөө босч гэр орны ажил, хүүхэд шуухад, хоол унд гэсээр өдөр хоногийг өнгөрөөх ч жаргалтай байжээ. Орой нөхрөө ирэхэд хоол ундыг нь өгнө. Одоо бодох нь ээ, амьдралын минь хамгийн жаргалтай үе тэр. Хэдий удсан юм бэ? Гучин нэг хүртлээ тэр хоёрыгоо бодож явлаа. Тэгээд нэг л өдөр хэрэг бишдсэн.

Рэйко тамхиа асаалаа. Салхи намдаж, тамхины утаа дээш хөөрч, аажмаар замхарна. Дээш харвал тэнгэрт түг түмэн нүд цоо ширтэнэ.

- Юу болоо вэ?

- Их сонин зүйл болсон. Аймшигтай ч гэмээр. Занганд орчих шиг л болсон. Одоо бодоход бие зарсхийдэг.

Рэйко тамхи бариагүй гараараа чамархайгаа илээд:

- Наоког эргэж ирсэн хүнд өөрийнхөө тухай яриад болж байна уу? гэвэл би:

- Санаа зоволтгүй. Та цааш нь яриач хэмээв.

- Охиноо цэцэрлэгт орсны дараа би төгөлдөр хуураа тоглох боллоо. Бусдад биш өөртөө зориулж. Бах, Моцарт, Скарлаттигийн богинохон аязуудыг тоглож эхэллээ. Хөгжим тоглолгүй багагүй хугацаа өнгөрсөнд мэдрэмж алдагдаж, гар хуруу хөшсөн ч ахин тоглож байна гэхээс жигтэйхэн хөөрнө. Төгөлдөр хуураа дарах зуур хөгжимд хэдий

дуртайгаа эс бүрээрээ мэдэрч, олон жилийн ангаа цангаагаа тайлах шиг болж билээ. Өөртөө тоглох хичнээн сайхан байв!

Би дөрөвтэйгээсээ тоглож эхэлсэн ч бодоод үзэх нь ээ, шалгалт шүүлэг, тэмцээн уралдаан, концерт тоглолтонд бэлдэж, бусдад гайхуулж явснаас өөрөө өөртөө тоглосон удаагүй. Хөгжмийн зэмсэг тоглож сурахад энэ мэдээж чухал. Гэхдээ нас явахын хэрээр хөгжимчин хүн өөрөө өөртөө тоглож эхэлдэг юм байна. Хөгжим гэдэг ийм мөн чанартай. Гучин нэг, хоёртойдоо л үүнийг ухаарсан. Охиноо цэцэрлэгт өгч, гэрийнхээ ажлыг амжуулчихаад нэг хоёр цаг дуртай аязаа төгөлдөр хуураар дарж суухад буруу нь юу байхав. Тийм биз?

Би ч толгой дохив.

- Ингээд нэг өдөр мэнд мэдэлцдэг зүс таних эмэгтэй орж ирээд охин нь надаар төгөлдөр хуур заалгах хүсэлтэй учир шавиа болгооч гэдэг юм байна. Манайхтай нэг дүүрэгт аж төрдөг ч яльгүй зайтай тул би охиныг нь танихгүй. Охин нь манай хажуугаар явж байгаад төгөлдөр хуур тоглохыг минь сонсоод сурья гэж бодсон юм байж. Охин нь намайг эртнээс мэддэг, хүндэлдэг. Дунд сургуулийн хоёрдугаар ангид сурдаг. Урьд нь хэдэн газар заалгаж байсан ч элдвийн шалтгаанаар олигтой сураагүй юм гэлээ.

Би хэдэн жил төгөлдөр хуур дараагүй болохоор анхан шатны мэдэгдэхүүнтэй хүүхдэд бол яая гэхэв, хэдэн жил сурсан хүнд бол зааж чадахгүй, тэгээд ч гэрийн ажилтай амжихгүй гээд хүүхдээ харах хэрэгтэй гэлээ. Өөрт нь хэлээгүй ч олон багшийн гар дамжсан хүүхдэд юм заагаад нэмэргүй. Гэсэн ч нөгөө эмэгтэй бууж өгөхгүй, охинтойгоо уулзахыг гуйсаар байлаа. Төрөлхийн шантардаггүй байрын эмэгтэй. Татгалзсан ч гуйж гувшаад байхаар нь хүүхдийг нь бодоод уулзъя гэлээ. Ингээд гурван өдрийн дараа охин нь манайд ганцаараа хүрээд ирэв ээ. Сахиусан тэнгэр шиг хөөрхөн. Гялалзаж гялтганасан хөөрхөн охин. Урт, тас хар үстэй, туяхан гар хөлтэй, нүд нь гялалзсан, сийлсэн мэт уран уруултай. Би хармагцаа хэлэх үгээ олж ядаж билээ. Санай зочны өрөө орд харш шиг санагдсан сан. Нүд гялбах шиг болно. Тэр охин одоо ч санаанаас гардаггүй.

Рэйко охиныг төсөөлөх мэт хэсэгтээ нүдээ анилаа.

- Сургууль соёл, дуу хөгжим гээд элдвийн юм ярилцаж кофе уунгаа цаг хэртэй суулаа. Хараажийн ухаалаг охин шиг санагдсан юм. Яриа хөөрөөтэй, өөрийн үзэл бодолтой, төрөлхийн хүн татах чадвартайг нь анзаараад анхандаа эмээсэн. Эхэндээ айх гайхах зэрэгцсэн гэхэд ер буруудахгүй. Ухаалаг охин юм гээч гэж бодсоноос цаашгүй. Түүнтэй ярих зуур ухаан бодол самуурна. Цовоо сэргэлэн, үс зүс сайтай нь нэг бодлын дарамт болсон. Би гэж хүн хажууд нь харьцуулшгүй хачин муухай гэлтэй. Дотроо жаахан дургүйлхснээ анзаарсан даруйдаа буруу ташаа зүйл санасандаа өөрөөсөө ичнэ.

Рэйко толгойгоо хэдэнтээ сэгсрээд:

- Би тэр охин шиг царайлаг, ухаантай байсан бол арай дээр хүн болох байлаа. Өв тэгш бие хаа, эрүүл саруул ухаантай хүнд өөр зүйл хэрэгтэй сэн үү? Хэн хүнгүй өөрийг нь бөөцийлж явахад сул дорой, зүс тааруу бусдыг дорд үзэж, гутааж болохгүй биз дээ? Ингэх шалтгаан нэгээхэн ч үгүй...

- Охин танд муу юм хийжээ дээ?

- Үнэнийг хэлэхэд тэр охин жигтэйхэн худалч нэгэн байлаа. Ерөөсөө худлаа ярьдаг өвчтэй. Санаснаа л бурна. Түүндээ өөрөө ч итгэдэг шиг. Худал хэлснээ нуухын тулд хавийн юмыг холбоно. Толгой сийрэг болохоор тэр дор нь сэтгэх тул үнэн худлыг нь ялгахын эцэсгүй. Ярьсан бүхэн нь худал гэж хэн ч бодохгүй. Тийм хөөрхөн охин ам ангайх бүрдээ худал ярина гэж санах хүнгүй дээ. Би ч эндсэн. Зургаан сар болоход тоймгүй олон түүх сонссон ч ер гадарлаагүй. Ярьсан бүхэн нь худал хуурмаг байсан ч итгэсээр л. Үгүй мөн тэнэг хүн ээ!

- Тэгээд юун тухай ярьдаг байв?

- Эсэн бусын юм. Хүн гэдэг амьтан нэг худал хэлбэл зогсож чадахгүй явчихдаг гэсэн дээ. Тийм өвчин байдаг. Ийм өвчтэй хүмүүс бусдад гэм хоргүй худал ярих тул эргэн тойрныхон нь мэдчихдэг. Гэлээ ч тэр охины хувьд өөр. Өөрийгөө хаацайлахын тулд яахаас ч буцахгүй. Өрөөл нэгэнд халгаатай үг хэлэх нь энүүхэнд. Байж болох бүх л арга чаргаар худал хэлнэ. Цаад хүнээсээ хамаараад янз бүрийн байдлаар ярина. Ээж, аав, хамаатан садан гээд баригдаж болзошгүй хүмүүстээ

худал хэлэх нь бага, хамжааргатай харилцана. Алсдаа баригдахгүй юм л ярина. Баригдвал бөнжигнөтөл нулимс дуслуулж, өөрийгөө зөвтгөж, уучлал гуйгаад л аргална. Тэгэхээр түүнд уцаарлах хүнгүй.

Ямар учраас намайг зольсныг өдгөө ч ойлгохгүй юм. Чухамдаа намайг золих гэсэн үү, хэн нэгнийг түшиж тулах гэсэндээ худлаа ярьсан уу, хэлж мэдэхгүй нь. Мэдлээ гээд энэ бүхэн эргэх биш. Бүх зүйл дуусч, би гэдэг хүн ийм болсон.

Хоёул хэсэгтээ нам гүмхэн суулаа.

- Ээжийнхээ хэлснээр гэрийн хажуугаар өнгөрөхдөө төгөлдөр хуур дарахыг минь сонсож, гудамжинд хэдэнтээ таараад “Биширсэн” гэсэн. Ингэж хэлэхийг нь дуулаад би улайсан шүү. Хүүхэлдэй шиг ийм хөөрхөн хүүхэд биширсэн гэхэд улайхгүй яах билээ? Гэхдээ хэлсэнд нь үнэний ор байсан шиг. Гуч гарсан би түүн шиг гоо үзэсгэлэнтэй, ухаалаг биш, авьяас чадлаар гайхуулахгүй ч сэтгэлийг нь татсан байх талтай. Тэр охин сэтгэлдээ дутаж явсан зүйлээ надаас эрсэн байж магад. Тийм ч учраас намайг сонирхоо биз. Одоо бодоход ийм учиртай шиг. Гэхдээ чамд гайхуулах гээгүй юм шүү.

- Ойлгож байна аа.

- Охин ноотоо авчирсан гээд “Бахыг тоглож болох уу?” гэхээр нь “Тэг” гэвэл нэг аязыг нь дарлаа. Их сонирхолтой, сонирхолтой гэхээсээ өвөрмөц маягаар тоглосон. Тийм сайн тоглоогүй. Хөгжмийн сургуульд сурдаггүй, дур нь хөдлөхөөр заалгаж байсан хүүхэд тэгэхээс яахав. Мэргэжлийн сургуулийн шалгалтанд иймэрхүү тоглоход тэнцэхгүй ч тоглохыг нь сонсоход илүүдэхгүй. Ерэн хувьд нь тааруухан тоглож хөг алдсан ч үлдсэн арван хувь буюу гол гол хэсгүүдийг нь тун дажгүй дарлаа. Бахын аяз шүү дээ! Тийм ч учраас сонирхлыг минь татсан. Энэ чинь ямар гээчийн хүүхэд вэ? гэж бодсон шүү.

Бахыг тэр охиноос хавьгүй дээр тоглодог хүүхэд бишгүй л бий. Бүр хэдэн арав дахин сайн тоглох хүүхэд мундахгүй ч түүн шиг сэтгэлээ шингээж тоглосныг би санахгүй юм. Аялгуу нь цаанаа л хүйтэн хөндий дуулддаг. Тааруухан тоглосон боловч сэтгэлийг минь татсан. Тийм ч учраас тэр охиныг тов хийтэл тоглож сургахаар сэтгэл

шулуудлаа. Эхнээс нь зааж мэргэжлийн төгөлдөр хуурч болгохын тухайд саналтгүй ч өөр шигээ сэтгэлээ сэргэтэл

тоглодог болгохыг хүссэн гэх үү дээ. Гэлээ гээд тэр санаа минь үргүй мөрөөдөл төдий байж. Охин өөрийнхөө төлөө хичээж чармайхаас илүүтэй бусдад тоогдож, магтуулж сайлуулах дуртай хүүхэд байлаа. Магтаал сонсоход яах учиртайг нэгд нэгэнгүй мэднэ. Сонирхлыг минь татахын тулд яаж тоглохоо ч андахгүй. Нарийн тооцоолсон байгаа юм. Тиймдээ ч гол хэсгүүдийг нь өөриймшүүлэн сураа биз. Үүнд эргэлзэх юмгүй.

Гэхдээ энэ бүхнийг нь мэдэх ч эргэн санахад тэр охин сайхан тоглосон. Мэргэжлийн хувьд тааруухан, ов зальтай худалч гэдгийг нь мэдэх ч өдгөө тоглохыг нь сонсвол зүрх булгилах нь гарцаагүй.

Рэйко хоолойгоо засаад дуугаа хураав.

- Тэгээд Та тэр охинд төгөлдөр хуур заасан уу?

- Тийм ээ. Долоо хоногт нэг удаа Бямба гарагийн өглөө хичээллэх болсон юм. Сургууль нь хагас сайнд хичээлгүй. Тэр охин хичээлээсээ хоцорч, тасалдаггүй байсан нь хачирхмаар. Хөгжмөө ч сайн давтана. Хичээлийнхээ дараа хоёул жигнэмэг идэж цайлна.

Ингэж хэлээд Рэйко цагаа харан:

- Ингэсгээд буцах уу даа? Наокод зовоод байх чинь. Чи ч бүр мартжээ.

- Яалаа гэж дээ. Таны яриаг сонсоод анзаарсангүй.

- Үргэлжлэлийг нь сонсмоор байвал маргааш ярьж өгье. Нэг удаа яриад дуусахгүй урт түүх ээ.

- Та ч Шехерезада шиг юмаа гэхэд Рэйко:

- Тэгэлгүй яахав. Чамайг Токио явуулахгүй дээ гэсээр инээмсэглэн бослоо.

Бид хоёр ирсэн замаараа явсаар өрөөндөө ирэхэд лаа бөхөж, зочны өрөөний чийдэнг унтраажээ. Унтлагын өрөөний хаалга онгорхой, орны хажуугийн чийдэнгийн бүдэг гэрэл сүүмийнэ.

Наоко халат өмсөөд буйдан дээр өвдгөө тэврээд суух аж. Рэйко дөхөж очоод:

- Одоо зүгээр үү? гэсээр духыг нь иллээ. Наоко:

- Зүгээр ээ. Намайг өршөөгөөрэй. Сандарсан уу? гэсээр над руу харав.

- Жаахан сандарсан шүү.

- Энд суугаач.

Хажууд нь суухад Наоко “Намайг уучлаарай” гэж шивнээд жаал холдон:

- Заримдаа учраа олохгүй юм гэсэнд:

- Би ч тэгдэг л юм гэлээ.

Түүнээс эндхийн аж байдал, өдөрт юу хийдгийг нь сонирхсонд өдрийг яаж өнгөрөөдгөө товч тодорхой ярив. Өглөө зургаад босч, эндээ ундаалан, шувууны байр цэвэрлээд, ихэвчлэн талбайд ажиллахаар явдаг ажээ. Үдийн хоолны өмнө, эсхүл үдээс хойш эмчтэйгээ цаг хэртэй ганцаарчлан уулзаж, эс бол хэсэг бүлгээрээ ярилцана. Үдээс хойш сонирхсон хичээлдээ сууж, спортоор хичээллэж, эс бөгөөс гадаа ажиллана. Наоко франц хэл, нэхмэл, төгөлдөр хуур, эртний түүхийн хичээлд суудаг.

Рэйко төгөлдөр хуур, гитар заадаг. Эндхийнхэн чадах мэдэх бүхнээ нэг нэгэндээ зааж сургадаг. Хэн хэнийхээ багш, шавь. Франц хэлтэй нь хэлээ, түүхийн багш нь түүхээ, нэхэж чаддаг нь түүнээ заагаад сургуультай их төстэй. Харамсалтай нь, би гэж хүн бусдад заах юмгүй.

- Энэ талаараа бид хоёр ижилхэн бололтой.

- Гэхдээ би энд их сургуульд байхаасаа илүү хичээж байгаа шүү. Хичээлүүд маань их сонирхолтой.

- Оройн хоолны дараа юү хийдэг вэ?

- Рэйкотой ярилцана. Ном уншиж, пьнз сонсоно. Хөршүүдтэйгээ тоглоно гэхэд Рэйко:

- Харин би гитар тоглож дурсамж бичдэг дээ гэв.

- Дурсамж аа?

- Тоглосон юм. Арав гээд унтдаг юм. Эндхийн амьдралын хэмнэл зөв биз? Нойроо ханатал сайхан унтана.

Цагаа харвал ес болж байлаа.

- Ингэсгээд унтах юм байна даа.

- Өнөөдөр жаахан оройтоход гэмгүй ээ. Чамтай ойрд уулзаагүй болохоор ярьж суумаар байна.

- Өдөр энд ганцаараа байхдаа хуучны явдлуудаа дурсаж суулаа. Кизүки бид хоёр чамайг эмнэлэгт эргэж очсоныг санаж байна уу? Далайн эргийн эмнэлэгт. Ахлах сургуулийн хоёрдугаар ангид байх аа?

- Саналгүй яахав. Цээжиндээ хагалгаа хийлгэсэн шүү дээ. Кизүки та хоёр мотоциклээр ирсэн. Та хоёрын авчирсан хайлсан шоколадыг идэх гэж ёстой үгээ хэлсэн шүү. Тэр үеэс хойш олон жил өнгөрсөн шиг санагдах юм.

- Чи тэгэхэд нэг их урт шүлэг бичсэн байсан гэсэнд Наоко:

- Өсвөр насандаа охид шүлэг бичдэг шүү дээ ээд жуумалзав.

- Юу болоод тэр үеийг санав аа?

- Мэдэхгүй юм. Гэнэтхэн л далай тэнгис, цэгцүүхэйн үнэр санаанд буусан. Кизүки чамайг байнга эргэдэг байсан уу?

-Ү гүй чиш. Үүнээс болж бүр муудаад авсан удаатай. Эхлээд ганцаараа, дараа нь чамтай хоёр удаа л эргэсэн. Өөдгүй гэдэг нь. Анх ирэхдээ тогтож чадахгүй арван минут бололгүй яваад өгсөн. Учир нь олодохгүй юм амандаа бувтнаж, авчирсан жүржээ хальсалж өгчихөөд л явсан. Хүүхэд шиг эмнэлэгт дургүй гэдэг байсан даа. Хэн хүнгүй л эмнэлэгт дургүй болохоор хэвтсэн улсын сэтгэлийг сэргээх гэж эргэдгийг Кизүки мэддэггүй байсан байх аа.

Надтай очиход зүгээр л байсан даа.

-Дэргэд чинь тэгээ байлгүй. Чамд сул талаа мэдэгдэхгүй гэж их хичээдэг байлаа. Чамд их сайн болохоор аль болох сайн сайхан бүхнээ харуулахыг хичээнэ. Харин надтай бол биеэ барихгүй. Ааш авир нь хурдан өөрчлөгдөхийг яана. Юм ярьж байгаад л яах ийхийн зуургүй бухимдана. Хар багын тийм зантай байсан ч өөрийгөө өөрчлөхийг оролддог байлаа.

Наоко хөлөө солбиж суугаад ярьлаа.

- Кизүки зан авираа өөрчлөх гэж их хичээсэн. Тэгээд болохгүй болохоор цухалдана. Сайн чанар олонтой ч өөртөө итгэлгүй, ингэх учиртай, өөрчлөгдөх хэрэгтэй л гэж боддог байсан юм. Одоо бодоод өөрийн эрхгүй хар буух юм.

- Би Кизүкигийн сайн сайхан зан чанаруудыг л мэддэг байлаа. Сайн сайхан бүхнээ харуулах гэж хичээсэн нь тэр байж гэхэд Наоко үл ялиг инээмсэглэв.

- Кизүки мэдсэн бол баярлах байсан даа. Чи газар дээрх ганц найз нь байсан шүү дээ.

Тэр ч миний цорын ганц найз минь байсан. Урьд хожид түүн шиг сайн нөхөртэй явсангүй.

Гурвуулаа байхад Кизүки байдаг чадлаараа хичээдэг болохоор чамтай хамт байх дуртай байлаа. Чамд ямар байсныг мэдэхгүй ч сэтгэл уужраад сайхан байдаг сан.

- Тэр үед чамд эвгүй байх гэж бодохоос өөр юм санаанд ордоггүй байсан шүү.

- Гурвуулаа байнга уулзаад байх боломжгүйд л хамаг учир байсан юм. Бид гурвын хэн хэн нь үүнийг мэдэж байсан шүү дээ гэхэд би толгой дохилоо.

- Би үнэндээ Кизүкиг чин сэтгэлээсээ хайрладаг байлаа. Сайнтай муутай тэр чигт нь. Сул дорой хүн байсан шүү дээ. Өөрт нь энэ тухай хэлэхээр “Наоко минь, хоёулаа гуравтайгаа биесээ мэдэх учир чи сайн, мууг минь ялгаж салгахаа больж” гээд ер итгэхгүй. Гэсэн ч түүнийгээ хайрласаар, өөр хүн сонирхдоггүй байж.

Бид хоёрын харилцаа жирийн нэг охид, хөвгүүдийнхээс тэс ондоо байж билээ. Холдсон ч үндэс нэгтэй мод шиг бие биедээ тэмүүлсээр л. Тийм ч учраас Кизүки бид хоёр өөрийн эрхгүй дотноссон. Бодож санах, ялгаж сонгох юмгүй. Арван хоёртойдоо анх үнсэлцэж, арван гуравтайгаасаа нэг нэгнээ энхрийлж таалж эхэлсэн. Нэг нэгнийдээ ирээд хоёр биенээ энхрийлдэг байлаа. Дэндүү эрт ийм харилцаанд орлоо гэж боддоггүй байж дээ. Жамаараа явж байна л гэж боддог байлаа. Энгэр цээжээ задгайлж энэ биеэ зориулсан. Ингэлээ гээд хэн нэгэн загнавал гайхаж ундууцах байсан биз ээ. Угаасаа бид хоёр буруу зүйл хийгээгүй. Хайр сэтгэлтэй хоёр хэзээ нэгэн цагт хийдгийг хийж байна гэж бодож явлаа. Хэн хэнээсээ бие хаагаа нуулгүй харуулна. Гэхдээ жирэмслэхээс айгаад сүйдтэй дотносоогүй л дээ. Яаж хамгаалахаа ч сайн мэдэхгүй. Бид хоёр ингэж өссөн болохоор өсвөр насны адармаатай асуудлуудыг тойроод өнгөрсөн гэлтэй, Ойлгож байна уу?

- Ойлгох шиг боллоо.

- Бид хоёр үнэндээ салж чаддаггүй байсан юм. Кизүки байсан бол хоёр биенээ хайрласан ч золгүй байх биз ээ.

- Яагаад золгүй гэж?

Наоко үсээ задгайлж, хэд хэд илээд:

- Бусдын дайраад гардаг өсвөр насны хүн хэцүү үеийг тойроод өнгөрсөн болохоор төлөөс төлөх байсан биз. Тийм ч учраас Кизүки энэ хорвоог орхиж би гэдэг хүн энд ирсэн болов уу. Эзэнгүй арал дээр соёл иргэншлээс хол өссөн хүүхдүүд шиг л байсан. Өлсвөл гадил идэж, уйтгарлавал тэврэлдээд унтчихна. Гэхдээ үргэлжид ийм байх боломжгүй. Өсч торнихын хэрээр өнгөт орчлонтой танилцахын эрхэнд чамтай нөхөрлөсөн. Чи бидний хувьд маш чухал хүн, гадаад ертөнцтэй холбох гүүр нь болсон юм. Чамаар дамжин гадаад ертөнцтэй ижилсэхийг хэрэндээ хичээсэн. Гэлээ ч бүтсэнгүй.

Чамайг ашигласан гэж битгий бодоорой. Кизүки чамд их сайн байсан. Дотно нөхөрлөсөн анхны хүн нь чи шүү дээ. Кизүки нөгөө ертөнцөд одсон ч миний хувьд чи орчлон хорвоотой холбогдох гүүр минь болсоор ирсэн дээ. Кизүки бид хоёр хоёулаа чамайг хайрладаг байсан. Би өөрийн мэдэлгүй чамайг гомдоосон байж ч мэднэ. Өөрийн мэдэлгүй чамайг гомдоосон ч байж мэднэ. Ирээдүйд ингэнэ чинээ бодож явсангүй.

Наоко дуугаа хурааж толгойгоо гудайлгахад Рэико “Какао ууцгаах уу?” гэсээр орж ирлээ.

- Тэгье.

- Би брэнди авчирсан. Хэд балгахад зүгээр биз дээ? гэвэл Рэико:

- Тэг ээ. Надад бас нэг хийчих гэлээ.

Рэико бид хоёр хундага харшуулан брэнди ууж, тэрээр мөдхөн какао буцалгахаар гал тогоо руу оров.

Наоко “Хөгжилтэй юм ярья” гэсэн ч санаанд олигтой юм орсонгүй. Довтлогч байсан бол ч паян тасрахгүй дээ гэсэн юм бодогдлоо.

Ярих юмгүйдээ огиудас хүрсэн ч оюутны байрны ундуй сундуй байдлыг ширхэгчлэн өгүүлбэл тэр хоёр эгээ л урьд хожид сонсоогүй мэт элгээ хөштөл инээнэ. Дараа нь Рэико мэдрэлийн өвчтэй хүмүүсийг дуурайж бид хоёрыг зугаацууллаа.

Арван нэгэн цаг болж, Наоко эвшээлгэж эхэлсэнд Рэйко буйдан дэлгэж, надад ор засаж өгөөд:

- Наоко зүүн талын орон дээр унтдаг шүү. Шөнө андуурав гэсээр гудас хөнжил авчирлаа. Наоко:

- Худлаа яриад бай. Би баруун талд нь унтдаг гэсээр угаалгын өрөө ороход Рэйко:

Маргааш хэдэн цагийн чөлөө авсан болохоор гурвуулаа зугаалъя. Энүүхэнд нэг сайхан газар байдаг юм хэмээв.

- Болж байна аа!

Наоко тэр хоёрыг хэвтмэгц би жаал брэнди ууж хажуулдан, уртаа мэт санагдах энэ өдрийн үйл явдлыг эргэн дурслаа.

Өрөөнд сарны гэрэл тусах ажээ. Унтлагын өрөөнд хаа нэг ор чохарна. Нүдээ анивал өдрийн дүр зураг харагдаж, Рэйкогийн гитарын аялгуу сонстоно. Би уулын замын хоёр хажуугаар ургасан уд модод зүүдлэн гүн нойронд автлаа. Ширүүн салхи дэгдсэн ч уд моддын мөчир хөдөлсөнгүй. Сайтар харвал мөчир болгон дээр нь шувуу суужээ.

Шувууд нисч, модод найгахыг харах гэсэндээ нэг мөчрийг саваагаар цохисон ч шувууд үргэсэнгүй, төмөр болон хувираад, тас тас хийн газарт унах юм.

Нүдээ нээсэн ч зүүд үргэлжлэх шиг. Өрөөнд сарны бүдэг гэрэл тусч, өөрийн эрхгүй шалан дээр унасан шувууны дүрстэй төмрүүдийг эрэв. Наоко өлсөж ундаассан жаалхүү шиг өвдгөө тэврээд цонх руу ширтэн, хөлд минь сууж байлаа. Дэрний хажууд тавьсан цаг минь олдсонгүй. Сарны гэрэл ажихад шөнийн хоёр гурван цаг болж байгаа янзтай.

Ам нэлээд ангасан ч Наоког ажигламаар санагдлаа. Цэнхэр халатаа өмсөөд үсээ хойш хавчсан учир магнай

нь гэрэлтэнэ. Сонин юм даа. Унтахдаа хавчаараа авсан шүү дээ.

Наоко саран авхайн гэрэлд татагдсан бяцхан амьтан шиг харагдлаа. Уруулынх нь сүүдэр уртасч, зүрх цохилох мэт, эс бол сэтгэлийн хөдөлгөөнийх нь аясаар үл ялиг чичирхийлнэ. Харанхуйн тийш шивэгнэх мэт. Ам ангаж шүлсээ залгивал энэ чимээ тодхон дуулдана. Наоко гэнэтхэн босч, орны толгойд дөхөж ирээд өвдөглөн суулаа. Нүд рүү нь ширтвэл юуг ч үл өгүүлэх ч, ер бусын тунгалаг байх ажээ. Ширтээд ширтээд үзэгдэх юмгүй. Энэхэн бие нь энүүхэнд ч сэтгэл зүрх нь тэртээ хол тэнүүчлэх шиг.

Наоко сунгасан гараас минь дальдчиж, уруул нь чичигнээд, халатныхаа товчийг тайлж эхэллээ. Жижиг цагаан долоон товч тайлагдахад халат нь төдхөн унаж, хэнхдэг цээжийг нь нүцгэлэв. Наоко өвдөглөсөн чигтээ өөдөөс минь ширтэнэ. Турьхан бие нь сарны гэрэлд туяарч, хөдлөх бүрнээ сүүдэртэнэ.

Зүйрлэвэл, алганд багтам хөх, хүйсний нүх, бэлхүүсэн дээр нь туссан сүүдэр, умдаган дээрх үснийх нь сүүдэр нуурын усны толио жирэлзэх мэт үл ялиг хөдлөх ажээ.

Наоко төгс төгөлдөр бие цогцостой болжээ. Тэр нэгэн хаврын шөнө тэвэрт минь эрхэлсэн Наокогийн бие хаа өөрчлөгджээ. Тэр үест биеэ бариад, эв хавгүй байсан сан. Би түүний гүйцэд боловсроогүй бие цогцост шунан дурлаж байлаа.

Тэр нэгэн шөнө Наоког тэвэрч, нэгэн бие болон уусахдаа үг хэлээр илэрхийлэхийн аргагүй сэтгэлийн нандин мэдрэмжээ бодь биеэрээ өгүүлэхийг хичээсэн юм.

Гэсэн хэдий ч би түүнийг чанга гэгч нь тэврэхдээ ам нээж зүрхлээгүй. Харин өдгөө өмнө минь өвдөглөн суух Наокогийн бие хаа дүүрэн сарны гэрэлд огт ондоо харагдлаа.

Кизүкийг нас барсны дараа түүний охин бие бүсгүй хуний хэлбэр галбиртай болжээ. Наокогийн төгс төгөлдөр бие цогцос, тас хар үс, энгэр цээжийг нь хараад ханамгүй.

Тав зургаан хормын дараа Наоко халатаа өмсөөд унтлагын өрөөндөө явж орлоо. Би нэлээд удсаны эцэст шалан дээр унасан цагаа олж

харвал гурван цаг дөчин минут болжээ.

Гал тогоонд орж ус уугаад үүр цайтал цурам хийсэнгүй. Гэгээ орсны дараа зүүрмэглэж байхад Рэйко “Өглөө болсон шүү” гэсээр хацарт минь зөөлөн хүрлээ.

Рэйко ор дэр хурааж, Наоко ус буцалган талх хэрчинэ. Өнгөрсөн шөнө өмнө минь нүцгэлснээ ор тас мартсан шиг санагдав.

Наоко:

- Нүд чинь яагаад улайчихаа вэ? гэвэл би:
- Шөнө сэрээд унтаж чадсангүй хэмээлээ.
- Бид хоёр хурхираагүй биз дээ?
- Үгүй ээ.
- Ашгүй дээ.

Рэйко:

- Чамайг ирсэн болохоор хурхираагүй байх аа гэсээр эвшээлгэнэ.

Рэйкогийн хажууд гэрэвшсэндээ Наоког юу ч болоогүй царайлж байна гэж бодсон боловч гарсан хойгуур нь аанай л анзаарсан шинжгүй.

- Сайхан амарсан уу? гэхэд Наоко:
- Сайхаан гэхээс өөр юм хэлсэнгүй.

Өглөөний цай уунгаа сэм ажиглавал Наоко инээд алдан:

- Ватанабэ, юу хараад байгаа юм бэ? хэмээн хачирхана. Рэйког:
- Дурласан л юм шиг байна гэхэд Наоко:
- Дурласан гэнэ ээ? гээд инээмсэглэх юм.

Би “Магадгүй л юм” гээд инээд алдаж, өнгөрсөн шөнийн явдлыг тоолгүй кофе уулаа.

Удалгүй тэр хоёр ажлын хувцас өмсөөд теннисний талбайн ард байх шувууны байранд шувуу хооллоно гэсэнд би дагаж явлаа. Шувууны байранд тахиа, тагтаа, тоть, тогос гээд төрөл бүрийн шувуу байна.

Моддын сүүдэрт хэд хэдэн сандал байх агаад гуч эргэм насны хоёр эрэгтэй унасан навчис түүнэ. Рэйко, Наоко хоёр тэдэнтэй мэндэлж, нөгөө хоёр Рэйкогийн хөгжилтэй ярианд инээмсэглэнэ. Цэцгийн мандалд цэцэгс алаглах бөгөөд эндхийнхэн модоо сайтар арчилдаг бололтой. Шувууд Рэйког хараад ганганалдана.

Тэр хоёр үүдний хажуугийн жижигхэн агуулахаас шуудайтай хоол, хаймран хоолой гаргаж ирэв. Наоко шлангаа усны хоолойтой холбож, шувууны байрыг услахад Рэйко шалыг нь сойздоно.

Усны дуслууд наранд гялтганаж, тогос шувууд ийш тийш гүйлдэнэ. Цацагт хяруул хялав хийж, хажуугийн модон дээр суусан тоть хашгична.

Рэйко тоть руу муур шиг дуугарвал өнөөх нь “Баярлалаа, тэнэг амьтан минь. Далд ор” гэсээр буланд шигдэв. Наоко:

- Хэн ийм юм заадаг байна аа? гэсээр санаа алдахад Рэйко:

- Би л лав биш шүү гээд муур шиг гийнаад: -Энэ нэг удаа муурнаас үхтлээ айгаад одоо үзэж чаддаггүй юм гэлээ.

Тэр хоёр цэвэрлэгээ хийж, хоолны саванд нь тэжээл хийв.

Өглөөдөө шувуу хооллодог юм уу? хэмээн Наокоогоос асуувал:

Тийм ээ. Шинээр ирсэн эмэгтэйчүүд шувуу хооллодог юм. Туулай харах уу? гэсээр шувууны байрны архан талд байх туулайн байранд орлоо.

Энд арваад туулай сүрлэн дээр хэвтэнэ. Наоко шалыг нь шүүрдэж, туулайнуудаа хооллоод нэг бүжин авч эрхлүүлнэ.

-Хөөрхөн байна уу? Бариад үзээч.

Бүжинг барихад айсандаа чичирч энгэрт наалдана. Наоко “Битгий ай. Энэ чинь сайн ах” гэсээр бүжинг илэв. Наоког чин сэтгэлээсээ инээмсэглэхийг үзээд өөрийн эрхгүй сэтгэл хөөрлөө.

Өнгөрсөн шөнө өмнө минь нүцгэлсэн Наоко яав ч зүүд байгаагүй гэж бодсоор шуудайтай тэжээл, багаж хэрэгслүүдийг нь агуулахад буцааж хийлээ. Наоко:

- Өглөө болоход бүх юм шинээр эхлэх шиг санагддаг юм. Харин үд өнгөрч харуй бүрий болоход гуниглана. Эндхийн өдөр нэг иймэрхүү л өнгөрдөг гэхэд Рэйко:

- Ингэж бодвол нэг мэдэхэд л над шиг хөгширнө шүү хэмээв.

- Танаар бол хөгшрөх сайхан ч юм уу? гэхэд Рэйко:

- Нас нэмэх гунигтай ч залуу зандан ахуйдаа эргэж очихыг хүсэхгүй юм хэмээн инээмсэглэнэ.

- Яагаад?

- Тэр бүхнээ дахиж туулахыг хэн хүсэх вэ гээд Рэйко Proud Mary дуу аялсаар шүүр, тосгуураа хураалаа.

Өрөөндөө буцаж ирээд хоёул гутлаа сольж, талбайд ажиллахаар гарав. Хүмүүстэй цуг ажиллах учраас намайг үлд гэлээ. Рэйко:

- Угаалгын өрөөнд баахан дотуур хувцас байгаа, угаачихна биз дээ хэмээн тоглоом шоглоом хийнэ.

- Тоглоод байна уу даа?

- Тэгэлгүй яахав. Хүүхэд шиг гэнэн гэдэг нь.

- Герман хэлээ давтаад сууж байя.

- Тэг дээ. Бид хоёр үдийн алдад эргээд ирнэ гэсээр хоёул явлаа. Хүмүүс ажилдаа гарах нь дуулдана.

Хоёр эмэгтэй амьдардаг гэхэд угаалгын өрөөнд нь тэжээлийн тос, уруулын тос, нарны тос, чийгшүүлэгчээс өөр гоо сайхны хэрэглэл байсангүй.

Би хумсаа авч, нүүр гараа угаагаад кофе хийж уулаа. Ингээд герман хэлний үйл үгийн хувирлын хүснэгтийг цээжилж эхлэв.

Арван нэг гучид Наоко, Рэйко хоёр эргэж ирээд шүршүүрт орж, хувцсаа солиод, гурвуул хоолонд орлоо.

Бид гурвыг төв хаалган дээр ирэхэд манаач хооллож суув. Радиогоор нь дуу эгшиглэнэ.

- Сайн байна уу?

Рэйко зугаалахаар гарч байгаагаа хэлээд, гурван цагийн дараа эргээд ирнэ гэхэд манаач өвгөн:

- Тэнгэр тогтуун болохоор яв даа. Эрэг нурсан байна лээ. Тэр хавиар явсны хэрэггүй шүү гэлээ.

Рэйко сувиллаас гадуур гарсан хүмүүсийн нэрсийн жагсаалтанд өөрийн болон Наокогийн нэрийг бичээд цагаа тэмдэглэлээ. Манаач өвгөн:

- Сайхан зугаалаарай гэсээр биднийг үдэв.

Рэйко манаачийг толгойдоо жаахан юмтай гэж билээ.

Цэлмэг тэнгэрт цагаан будагтай бийрээр хэд хэд татаад авсан шиг нарийн үүлс хөвнө.

Гурвуул Амирёгийн хашаа дагаж яваад, нарийн жимээр уул өөд өгслөө. Рэйко эндхийг арван хуруу шигээ мэддэг боллолтой газарчилна. Би Наокогийн намирсан үсийг харан араас нь явж байлаа. Наоко

байсгээд инээмсэглэн эргэж харна. Рэйко урагшилсаар л. Ойрд явган яваагүйдээ амьсгаа давхцав.

- Та хэд ойр ойрхон зугаалдаг уу? гэхэд Наоко:

- Хоёр долоо хоногт нэг гарна. Ядарч байна уу? гэнэ.

- Бага зэрэг гэхэд Рэйко:

- Одоохон хүрлээ. Жаахан тэвчих гэсээр урагшилна.

- Ойрд явган явсангүй гэвэл Наоко:

- Хүүхэн эргүүлэхээ багасгавал таарна хэмээн зэмлэнгүй хэллээ.

Хааяахан нисч өнгөрөх улаан залаатай шувууд хөх тэнгэрт тодорч үзэгдэнэ. Ойн цоорхойд цагаан, шар, цэнхэр өнгийн цэцэгс алаглажээ. Хаа сайгүй зөгий дүнгэнэнэ. Арваад хормын дараа нэг довцог дээр гарч, ус ууж амсхийхэд Рэйко нэг навч хуйлаад түүгээрээ шүгэлдэв.

Гурвуул зэгсний бутан дундуур нарийн жимээр уруудвал замд нэг суурин таарлаа. Хун амьтан үзэгдэхгүй, эл хуль байхыг ажвал орхигдсон тосгон бололтой. Зарим байшингууд нь юу ч үгүй нурсан байхад зарим нэг нь хүн амьдарч болохоор дажгүй хэвээрээ. Замаас гарахад Рэйко:

- Эндхийн хүмүүс долоо найман жилийн өмнөөс нүүсэн юм. Өвөлдөө цас ихтэй, үржил шим муутай хөрстэй болохоор амьдрахад хэцүү байсан биз дээ. Хотод ажил хийвэл хөөрхөн амьдарчих тул нүүцгээсэн.

- Зарим байшингууд нь гайгүй байна шүү.

- Нэг хэсэг хиппинүүд байсан ч өвөл болуут явчихсан юм.

Суурингаас холхон хашаа хороотой бэлчээр газар байх агаад тэнд хэдэн адуу өвс хазлана. Гэнэт нэг нохой гарч ирээд Рэйко, Наоко хоёрт эрхэлж гарлаа. Намайг шүгэлдсэнд ойртож ирээд шиншлэх юм. Наоко:

- Энэ бэлчээрт байдаг нохой. Хориод настай байх шүү. Шүд муутай, хатуу юм идэхгүй. Хүн харвал эрхлэх гээд гүйгээд ирнэ гэсээр толгойг нь илнэ.

Рэико:

- Арван сарын сүүлээр энэ адуу малыг голын адагт байдаг хашаанд оруулмагц энэ маань удахгүй явна даа. Зундаа энд өдөртөө хориод жуулчин ирдэг юм. Эндхийн кафед орж юм уух уу? гэсээр үүргэвчнээсээ бяслаг гаргаж нохойд өглөө.

- Тэгье.

Хуучин цагаан байшин дээр аягатай кофений зураг өлгөжээ. Нохой байшингийн саравчинд гүйж ороод үүдэнд хэвтлээ. Бид гурвыг саравчинд суухад биеийн тамирын цамц, цагаан жийнстэй бүсгүй инээмсэглэсээр гарч ирэв. Рэико:

- Энэ Наокогийн найз хэмээн намайг танилцуулахад хоёул мэнд мэдлээ.

Тэр гурвыг хууч хөөрөх зуур би хөгшин нохойн хүзүүгээр илж маажив.

- Нохой чинь ямар нэртэй вэ?

- Пепе.

Би “Пепе” гэж дуудсан ч нохой хөдөлсөнгүй. Бүсгүй:

- Хөгшрөөд дүлий болчихсоон. Чанга дууд хэмээн Киотогийн аялгаар хэллээ.

Чанга дуудвал нохой дав хийн босоод хуцах юм.

- Одоо болно оо. Хэвтээд унт гэж бүсгүйг хэлэхэд өнөө нохой хөлөнд минь хэвтээд өгөв.

Наоко, Рэико хоёр мөстэй сүү, харин би шар айраг авлаа. Бүсгүй фм-ийн радиогоо асаавал Spinning Wheel-ийн Blood, Sweat and Tears дуу

эгшиглэнэ. Рэйко:

- Үнэндээ энд фм сонсох гэж ирдэг юм. Манайд радио байхгүй болохоор дэвэн дэлхийд ямар хөгжим сонсож байгааг эндээс л мэдэх юм хэмээв.

Би үйлчлэгч бүсгүйгээс:

- Өдөржингөө энд суудаг уу? гэвэл:

- Үгүй дээ. Оройдоо бэлчээрийн ажилчдад кафегаа захиад хот явдаг. Өглөө буцаад ирдэг юм гээд холхон байх жийп рүү зангалаа.

- Хүмүүс цөөрч байна уу?

- Харин тийм ээ.

Рэйко нөгөө бүсгүйтэй тамхи татангаа:

- Чамайг явчихаар хэсэгтээ л уйдна даа гэвэл бүсгүй:

- Ирэх жилийн таван сард буцаад ирнэ шүү дээ гэсээр инээмсэглэнэ.

Радиоогоор Creamхамтлагийн White room, хагас сайнд үзсэн The Graduate киноны Scabourough Fair дуу эгшиглэв. Рэйкоогоос:

- Та энэ дууны киног нь үзсэн үү? гэвэл:

- Хэн тоглосон юм бэ? гэлээ.

- Дастин Хофман гэхэд Рэйко мөрөө хавчаад:

- Ёстой мэдэхгүй. Энд хорвоо ертөнцөөс тасарчих юм даа гэх юм.

Рэйко бүсгүйгээс гитар авчрахыг гуйхад бүсгүй хуучин гитар барьсаар гарч ирлээ. Нохой гитарыг шиншлэвэл Рэйко хэзээний багш аятай:

- Иддэг юм биш ээ гээд гитараа хөглөхөд би:

- Яг л Sound of music кинон дээр гардаг шиг харагдаж байна хэмээн өөрийн эрхгүй дуу алдав.

Рэйко Scarborough Fair дууг хөг алдан дарсан ч төд удалгүй хөгөө тааруулж сайхан тоглолоо. Гурван удаатоглоод донж маягаа нэмсхийн шаггүй тоглох боллоо.

- Сонгол сайтай шүү. Ямар ч дууг гурав сонсоод л ноотгүй дарчихна гэсээр нүдээ ирмэнэ.

Бид гурав алга ташихад мань хүн:

- Дээр үед Моцартын концерт тоглож байхад арай илүү алга ташсан даа гэсээр мэхийн ёслоно.

Үйлчлэгч бүсгүй Битлзийн Here Comes the Sun-ыг тоглож өгөхийг хүсээд сүүгээр дайлна гэсэнд Рэйко хуруугаараа “Окей” гээд энэ дууг дарлаа. Рэйко сайхан хоолойтой юмаа.

Энэ дууг сонсоход сэтгэл бүлээцнэ. Рэйко гитараа хойш тавьж, фм асаагаад Наоко бид хоёрыг цаг хэртэй ойр хавиар зугаалаад ир гэлээ.

- Та хоёр гурваас өмнө ирээрэй. Би хөгжим сонсоод сууж байя.

- Хоёулхнаа явж болох уу? гэхэд:

- Болохгүй л дээ. Тэгэхдээ зүгээр ээ. Та хоёр ямар хүүхдүүд биш. Би ч гэсэн амармаар байна. Энэ хол ирээд нүүр нүүрээ харж ярилцахгүй бол ямар хэрэг байхав гэсээр тамхиа асаалаа.

Өнөө нохой бид хоёрыг хашааны хажуугаар хэсэгтээ дагаж, удалгүй буцаад гүйчихэв. Наоко заримдаа гараас минь хөтөлж намайг сугадна.

- Эртээ үед хамт зугаалж байсан маань санаанд орлоо.

- Эртээ гэж энэ хавар шүү дээ. Арав хорин жилийн өмнө бол өөр хэрэг.

- Өчигдөр сэтгэл үймрээд уйлсанд уучлаарай. Тэр холоос ирж байхад би гэж хүн усан нүдлээд.

- Зүгээр ээ. Бид хоёрын хэн хэн нь сэтгэлээ нээх хэрэгтэй юм шиг. Хэн хэндээ итгэж байж л илүү ойлгоно.

- Намайг ойлголоо гээд юу болох вэ?

- Гол нь түүндээ биш. Хүн бүр өөр өөрийн хүсэл сонирхолтой. Чамайг сонирхдог хүн бас байна шүү дээ.

- Хобби юм биз дээ?

- Тэгж хэлмээр байвал тааллаараа л бол. Гэхдээ хүмүүс үүнийгээ “хайр дурлал” гэдэг юм билээ.

- Ватанабэ, чи Кизүкид сайн байсан биз дээ?

- Мэдээж.

- Харин Рэйко чамд таалагддаг уу?

- Рэйко ч надад таалагддаг. Сайн хүн шиг санагдсан.

- Чамд яагаад Кизүки, Рэйко бидэн шиг толгойдоо юмтай, сэтгэлийн хатгүй гэмээр хүмүүс таалагддаг юм бэ? Жирийн хүмүүс таалагддаггүй гэж үү?

- Кизүки, Рэйко та нарыг би юмтай гэж боддоггүй. Толгойдоо юмтай гэмээр хүмүүс хаа сайгүй эрх чөлөөтэй явж л байдаг.

- Би юмтай гэдгээ мэднэ ээ.

Бид хоёр тал талаасаа ой модоор хүрээлэгдсэн хээр талд хүрлээ. Би Наоког энгэртээ нааж зогсов.

- Хааяа шөнө сэрээд эдгэрэхгүй чигтээ энд үлдвэл яана даа гэж бодох юм. Амьдрал гээчийг мэдрэхгүй хөгширнө гэж бодохоор бие арзасхийдэг. Заримдаа Кизүки “Наоко, хүрээд ирээч” гээд дуудаад байх шиг санагдах юм.

- Тэгээд чи яадаг вэ?

- Ватанабэ минь, чи зөвөөр ойлгоорой.

- Би ойлгоно оо.

- Тийм үед би Рэиког сэрээгээд өвөрт нь ордог. Рэико дулаацтал минь намайг илж тайвшруулдаг. Бид хоёр муу юм хийгээгүй биз дээ?

- Хаанаас даа. Гэхдээ Рэикогийн оронд чамайг тэвэрдэг сэн бол сайхан л байна гэхэд Наоко:

- Намайг одоо тэвэр л дээ гэсээр өвсөн дээр суулаа.

Өтгөн өвсөн дунд суухад тэртээ дээр хөх тэнгэр цэлийнэ. Би Наоког тэвэрч уруул дээр нь үнслээ.

Наокогийн халуун, зөөлөн бие намайг урин дуудах шиг болсон сон.

- Ватанабэ, намайг хүсч байна уу?

- Тэгэлгүй яахав дээ.

- Намайг хүлээж чадна биз дээ?

- Чадалгүй дээ.

- Бие чинь чангарчихаж.

- Тэгэлгүй яахав.

- “Тэгэлгүй яахав” гэхээс өөр үг мэддэггүй юм уу даа?

- Тэгвэл тэгж ярихаа больё.

- Бие чинь чангараад хэцүү байна уу?

- Юү ч гэмээр юм бэ.

- Би чамд туслах уу?

- Гараараа юу?

- Дээрээс хатгаад хэцүү байна.

Би доошилж хэвтээд:

- Наоко, надад туслаач гэхэд тэр өмдний минь цахилгааныг буулгаж, хөвчирч чангарсан эрхтнийг минь “Ямар халуун юм бэ?” гэсээр барьлаа.

Би Наокогийн цамцны товчийг тайлж, хөхөвчийг нь суллаад хоёр хөхийг нь үнсэхэд Наоко нүдээ аниад намайг энхрийлнэ.

- Чи сурамгай юм гэвэл Наоко:

- Кизүки ч бас тэгдэг байсан гэсээр намайг үнслээ. Бие минь тавирч, би Наоког үнслээ. Хөхөвч, цамц хоёрыг нь товчилж өгөөд өмднийхөө цахилгааныг татав.

- Одоо зүгээр үү?

- Зүгээр ээ.

- Тэгвэл хоёулаа жаахан зугаалах уу?

- Тэгье.

Бид хоёр нэг ойн цоорхойгоос нөгөө рүү алхлаа. Энэ үед Наоко өөд болсон эгчийнхээ тухай “Надаас зургаан насаар эгч, өөр зан ааштай ч бид хоёр их дотно байлаа. Ер муудалцаж байсангүй” гэсээр өгүүлсэн юм.

Эгч нь юм юманд манлайлагч, нийтэч нэгэн байжээ. Ийм учраас багш нар болоод хөвгүүд түүнд их сайн, олон ч гавьяа шагнал авдаг байж.

Сургууль болгонд нэг ийм хүүхэд бий. Гэсэн хэдий ч эгч нь сэхүүн зангүй, даруу төлөв охин байсан юмсанж.

-Тийм ч учраас би багаасаа хөөрхөн болох юмсан гэж боддог байлаа. Эргэн тойрныхон маань эгчийг сурлага, спортод сайн гээд үргэлж магтана. Харин би эгчээсээ царайлаг төрсөн болохоор аав, ээж маань намайг сайхан бүсгүй болгох гэж байдгаа барина. Тэгээд л охидын сургуульд оруулсан юм. Сургуульдаа дэгжин хувцаслаж, лакан гутал өмсөж явахын зэрэгцээ төгөлдөр хуур, балетаар хичээллэнэ. Эгч минь намайг “Миний хөөрхөн, бяцхан дүү” гээд л их хайрладаг байлаа. Жижиг сажиг юм өгч байнга л дагуулж явна. Хичээл хийхэд тусална. Найз залуутайгаа уулзахдаа нэг удаа дагуулж явсан шүү. Тэгээд яг л Кизүки шиг амиа хорлочихсон. Яагаад ингэх болсныг хэн ч мэдээгүй. Тэр жил эгч минь арван долоотой байсан юм. Манайхан ийм юм болно чинээ санаагүй. Яг л Кизүки шиг өнгөрсөн...

Бүгд л ном уншсаар байгаад толгой нь эргэсэн гэж билээ. Өөд болсных нь дараа тэр номнуудаас уншиж үзсэн чинь их гунигтай зохиолууд байсан. Номон дээрээ тэмдэглэл хийж, цэцэг, найз залуугийнхаа захиаг хүртэл хавчуулсан байсныг хараад би цурхиртлаа уйлж билээ.

Эгч маань тус дэм авах дургүй, бүх юмаа бие дааж хийдэг хүн байсан юм. Бардам зантайдаа ч биш, биеэ даасан үзэл бодолтой байсан гэх үү дээ. Аав, ээж маань эгчийн занг мэдэх учир хэрэг явдалд нь хошуу дүрэхгүй. Харин би сав л хийвэл эгчээсээ элдвийг лавлаж асуудаг хүүхэд байсан даа. Эгч минь надад чадах бүхнээ хэлж өгдөг ч өөрөө бусдаас зөвлөгөө авдаггүй. Бухимдаж, дургүй хүрснээ огт мэдэгдэхгүй, өрөөндөө яваад орчихно. Хоёр гурван сардаа нэг удаа хэд хоногоор өрөөнөөсөө гарахгүй. Сургуульдаа ч явахгүй, юм идэхгүй суугаад л байна. Гэхдээ намайг сургуулиасаа ирмэгц дуудаж оруулаад ярьж хөөрнө. Харин эзгүйд минь өрөөндөө л суугаад байна. Хэдэн өдрийн дараа буцаад л хэвэндээ орчихно. Бараг дөрвөн жил энэ мэт явсан. Аав, ээж хоёр эхлээд эмнэлгээр дагуулж явсан ч хоёр хоноод зүгээр болчихоор нь тоолгүй орхисон юм. Ухаалаг охин болохоор эгчид их итгэнэ. Эгчийг өөд болсны дараа аав, ээж хоёр авга ахын тухай ярьж байхыг би сэм сонссон юм. Аавын бага дүү нь толгой сайтай залуу байсан ч арван долоон настайгаасаа хорин нэг хүртлээ гэрээсээ ч гараагүй гэсэн. Тэгээд нэг өдөр гэрээсээ зугтаад галт тэргэнд дайруулсан юм билээ. Аав “Манай удамд л нэг юм байна” гэсэн.

Наоко зэгсний навчис тасалж салхинд хийсгээд мөчрийг нь хуруундаа орооно.

- Эгчийгээ амьсгал хураасныг би анх харсан юм. Тэр үед би бага сургуулийн зургадугаар ангид сурч байлаа. Арван нэгэн сарын бороотой жихүүн өдөр. Эгч минь ахлах сургуулийн гуравдугаар ангид сурч байлаа. Төгөлдөр хуурын хичээлээ тараад зургаа гучид гэртээ ирвэл ээж хоол хийгээд эгчийгээ дууд гэдэг юм байна. Би дээшээ гарч өрөөг нь тогшвол таг чиг. Унтаж байгаа байх гээд өрөөнд нь орсон чинь эгч толгойгоо гилжийлгээд цонх руу хараад зогсчихож. Өрөө нь тас харанхуй, юм бодоод зогсоо юм болов уу гээд “Юу хийтээд байгаа юм бэ? Ээж хоолоо ид гэж байна” гэсэн чинь эгч өсгийтэй гутал өмсөөд тэр үү, юман дээр гараад зогссон юм уу, өндөр болчихсон байсанд жигтэйхэн гайхаад очтол өөрийгөө дүүжилчихсэн байсан. Таазанд тогтоосон олс нь хөвчирч татагдаад ямар аймшигтай харагдсан гээч. Эгч минь саарал бошинз, цагаан цамц өмссөн байсан юм. Балет бүжиж байгаа юм шиг өлмийгөө жийчихэж. Шалнаас хориод санжийн зайтай байсан болов уу. Би өөрийн эрхгүй нүүр лүү нь хараад ээжийгээ дуудах гэсэн ч дуу гардаггүй, эгчийгээ буулгах гээд учраа олохгүй. Ээж гарч ирээд “Та хоёр юу хийгээд байна?” гэхэд л сая сэхээ орсон.

Тэр өдрөөс хойш гурван өдөр үг ч дуугарч чадахгүй, үүлгэртэж хэвтээд л байлаа. Захиандаа би чиний бодсоноос илүү хүнд өвчтэй гэж бичсэн дээ. Тийм болохоор намайг орхисон нь дээр биз. Найз охинтой бол. Амьдралаа хөө. Чамд садаа болмооргүй байна. Хааяахан эргэж ирээд намайг мартаггүй байвал болох нь тэр. Өөр хүсэх юм алга.

- Чамайг эргэж тойрохоос илүүтэйг хүсч байна шүү дээ.

- Надтай зууралдаж амьдралаа үрээд яахав.

- Тийм биш ээ.

- Би эдгэхгүй бол хүлээгээд л байх хэрэг үү? Арав, хорин жил өнгөрсөн ч хүлээнэ гэж үү?

- Чи юм болгоноос айх юм. Өнгөрснөө мартаж хэрэгтэй. Тэгвэл нэг мэдэхэд л зүгээр болно.

- Болдог сон бол мартаг сан.

- Эндээс гармагц хоёулаа нэг гэрт орьё. Хар дарсан зүүд, айдас хүйдсийг чинь хөөж, дэргэдээс чинь түшиж тулж явья гэхэд Наоко:

- Тэгдэг бол сайхан л байна гэсээр гараас минь чанга атгалаа.

Бид хоёр гурван цагийн үед кафед эргэж ирэхэд Рэйко ном уншингаа Брамсын төгөлдөр хуурын хоёрдугаар концертийг сонсож суулаа. Хүн зонгуй энэ зэлүүд газар сонгодог хөгжим эгшиглэх нь сүрдмээр. Рэйко:

- Би энэ пянзыг нэг хэсэг цоортол нь сонссон. Ноот бүрийг нь цээжилсэн гэсээр Наоко бид хоёрыг ширтээд:

- За тэгээд сэтгэлээ ханатал ярьж чадав уу? гэсэнд бид хоёр “Чадсаан” гээд халуун кофе захиалбал Рэйко:

- Тэр ажилдаа ямар болохыг нь дараа хэлнэ биз гэдэг юм байна.

Наоко минчийтлээ улайгаад:

- Бид хоёр яагаа ч үгүй гэхэд Рэйкогийн санаа амрахгүй:

- Тийм байх даа? гээд над руу харав.

- Яагаа ч үгүй гэвэл:

- Ингэвэл сонирхолгүй шүү дээ хэмээн санаа алдана.

Би “Хэлээд юү гэхэв!” гэсээр кофегоо оочлоо.

Сувиллын оройн хоолны төрөл зүйл өөрчлөгдсөнийг эс тооцвол бусад зүйл нь яг өчигдрийнх шиг хэвээрээ. Жингүйдлийн орчинд ялгарах ходоодны хүчлийн талаар урьд орой нь ярьж суусан өнөөх эр манай ширээнд сууж, тархины үйл ажиллагаа болоод эзлэхүүний талаар ам хамхилгүй ярина. Бид “Гамбург маягийн” давтсан мах идэнгээ Бисмарк болоод Наполеоны тархины эзлэхүүний тухай сонсов. Нөгөө эр тавгаа түлхэж, цаас харандаа гаргаж ирээд хүний уураг тархийг зурж үзүүлээ. Ингэхдээ тэр хэд хэдэн удаа “Өө энэ биш” гээд ахин

дахин зурав. Тэр хүн зургаа эвхэж, энгэрийн халаасандаа хийсэн бөгөөд халаасанд нь гурван бал, нэг харандаа, гурвалжин шугам байх аж. Мань эр хооллож дуусаад аанай л өчигдрийнх шигээ “Эндхийн өвөл сайхан даа. Заавал ирээрэй” гэсээр явж одов.

Рэйкоогоос энэ хүнийг эмч үү, өвчтөн үү? гэж асуувал:

- Чи харин хэн гэж бодож байна даа? гэлээ.

- Ялгахгүй нь. Гэхдээ лэрүүл хүн гэхэд хэцүү юм гэхэд Наоко:

- Мията эмч гэх нь тэр. Харин Рэйко:

- Гэхдээ л эндхийн хүмүүсээс хамгийн их юмтай гэж хэлж болохоор хүн дээ гэнэ. Наоког:

- Манаач Омүра бас сонин хүн шүү гэхэд Рэйко:

- Бас нэг зүгээргүй хүн дээ гэсээр ногоо иднэ.

- Өглөө болгон нэг их дасгал хийгээд л орилоод байна. Наоког ирэхээс өмнө Киносита гэж нэг нягтлан байсан юм. Тэгсэн тэр нөхөр амиа хорлох гэдэг байгаа. Золоор гайгүй өнгөрсөн дөө. Өнгөрсөн жил Токүсима гэдэг нэг сувилагчийг архидан согтуурсан гээд ажлаас нь халсан гэхийг нь сонсоод би өөрийн эрхгүй:

- Танай эндхийн эмч, өвчтнүүд ялгагдахаа больсон болтой хэмээн уулга алдав.

- Чиний хэлдэг ч зөв шүү. Одоо л чи хорвоо ертөнцийг ойлгож эхэлж байна.

- Тийм болтой дог оо гэхэд Рэйко:

- Бид юмтайгаа мэдэх болохоор чамайг зүгээр гэдгийг мэдэж байна даа гэсээр гурвуул өрөө рүүгээ буцлаа.

Наоко бид хоёр хөзөр тоглох зуур Рэйко гитараараа Бахын аяз дарж сууснаа:

- Чи маргааш хэдийд буцах вэ? гээд тамхиа асаав.
- Өглөөний цай уугаад есийн автобусанд сууна. Орой ажилтай.
- Уг нь хэд хоносон бол сайхан байлаа гэхэд нь би инээд алдан:
- Хэд хоновол эндхийн өвчтөн болж мэдэх л юм гэлээ.

Энэ үед Рэйко Наоко руу хараад:

- Мартсанаас Окагаас усан үзэм авахаа марчихаж гэдэг юм байна.

Намайг “Хамт явах уу?” гэхэд Рэйко:

- Дургүйцэхгүй бол Ватанабэг дагуулаад явлаа шүү хэмээгээд намайг сугадан:
- Өчигдрийнхөө эхэлснийг дуусгана аа гэсээр гарлаа.

Наоко “Өөрсдөө л мэд” гэсээр тас тас инээсээр үлдсэн юм.

Тэнгэр хүйт дааж, жихүүн салхи үлээнэ. Рэйко задгай энгэртэй хөх цамц өмсөөд гараа халаасандаа хийжээ. Дээш харж хамраа мушийлгаад “Бороо орох нь” гэсээр холгүйхэн байх төгөл рүү алхлаа. Чийг үнэртэхгүй ч тэнгэр бүрхжээ.

Рэйко ажилчдын байрны өмнө ирээд, хүлээж бай гэчихээд нэг байрны хонхыг дарлаа. Төд удалгүй нэг эмэгтэй үзэгдэж, Рэйкотой инээлдээд гэрээсээ томоо ууттай юм барьсаар гарч ирэв. Рэйко нөгөө эмэгтэйд “Баярлалаа. Сайхан амраарай” гээд:

- Усан үзэм өгч байна. Дуртай биз? гэсээр өөдөөс минь ирлээ.
- Дуртай шүү гэвэл Рэйко нэг багцыг өгөөд:
- Угаачихсан болохоор шууд идчих гэлээ.

Бид хоёр усан үзэм идэн алхлаа.

- Хүүд нь төгөлдөр хуур заадаг болохоор энэ хоёр хотоос виски гээд л элдвийн юм авчирч өгдөг юм.

- Өчигдрийн түүхээ ярьж дуусгаач.

- Орой болгон гарч яваад байвал Наоко хар буруу санахгүй байгаа?

- Зүгээр ээ. Юу болсныг нь мэдмээр байна.

- Тэгвэл нэг газар оръё. Жиндүү байх чинь.

Бид хоёр теннисний талбайн зүүнтээ байх агуулахад орж, гэрлийг нь асаалаа. Энэ агуулахад цана чарга, цас цэвэрлэдэг багаж хэрэгсэл, эм тариа хураажээ.

- Ганцаараа баймаар санагдсан үедээ энд ирж гитар тоглодог байлаа. Тухтай газар шүү?

Рэйко эмтэй шуудайн дээр сандайлж намайг дэргэдээ суулгалаа.

- Тамхи татвал зүгээр биз?

- Зүгээр ээ.

Рэйко:

- Энэ тамхи гээчийг хаяж чадахгүй юм гэсээр хэд хэд сорохыг нь ажвал түүн шиг тамшаалан тамхи татах хүн энэ хорвоод үгүй мэт. Би усан үзмээ нэг нэгээр нь идэж, хальс, үрийг нь хогийн сав болгосон цаасан хайрцганд шидлэн суув. Рэйког:

- Өчигдөр аль хүрээд зогслоо? гэсэнд:

- Салхи шуургатай тэр нэгэн шөнө цохио хадан дээр байрлах хараацайн үүрийг сүйдлэхээр мацсан гээд дууссан даа гэвэл:

- Тоглоомтой гэдэг нь. Хүн цаашлуулахдаа жигтэйхэн нухацтай царайлахыг нь яана. Инээд хүрмээр юм. Бямба гарагийн өглөө төгөлдөр хуур заах болсон гэсэн дээ?

- Тэгсээн.

- Энэ хорвоогийн улс амьтныг сурган хүмүүжүүлэх авьяастай, үгүйгээр нь ангилбал би эхнийхэд нь орох юм шиг. Залуудаа ч үүнээ анзаардаггүй, энэ тухай эргэцүүлж тунгаадаггүй байж. Гээд нас яваад туршлага суухын хэрээр энэ чадвараа мэдсэн юм. Хүнд юм заах чадвартайгаа шүү дээ. Үнэндээ л муугүй багш болж билээ.

- Би ч таныг тэгж бодсон юм!

- Өөрийгөө бодвол бусдад илүү хүлээцтэй хандаж, аливаа нөхцөл байдлаас сайн сайхныг нь олж харах чадвартай гэж хэлж болохоор. Одоо бодох нь ээ, би иймэрхүү хүн болтой шүү. Жишээ нь, чүдэнзний хайрцагны зурдаг хэсэг байна аа. Энэ зурдаг хэсэгт муу муухай гэхээр юм алга. Тийм биз? Миний хувьд хэр тааруухан чүдэнз байснаас дээд зэргийн зуруул байсан нь дээр. Ингэж санавал тэр охинтой хичээллэж эхэлмэгцээ энэ чанараа мэдсэн гэлтэй. Залуудаа мөнгө төгрөг гучуухан үедээ цагаар багшилж байсан ч тэр бүр өөрийгөө ойлгодоггүй байлаа. Тэр охинд төгөлдөр хуур заахдаа л “Би ч сурган хүмүүжүүлэх авьяастай юм” гэж анх бодсон хэрэг. Сургалт маань их урагштай байж билээ.

Охин тааруухан тоглодог байсныг өчигдөр хэлсэн дээ. Гэлээ гээд мэргэжлийн төгөлдөр хуурч болохгүй хойно би бага багаар зааж байлаа. Үүнээс гадна сурч байсан охидын сургуульдаа дундаж дүнтэй байхад их сургуульд шулуухан орчих боломжтой. Төгөлдөр хуураа гойд анхаарах онцын шаардлагагүй, ээж нь ч “Салхинд хөөгдсөн биш тааваараа сур” гэсэнд би ч ингэ тэг гэж хүчилсэнгүй. Ер нь хүнд шахуулж дарамтлуулах дургүйг нь анх уулзмагцаа л мэдэрсэн. Нүүрэн дээрээ аан уун гээд толгой дохих ч нэг л дургүй бол түүнээ яалаа ч хийхгүй хүүхэд. Тиймээс дураар нь тоглуулдаг байлаа. Нэг аялгууг хэд хэдэн янзаар тоглож сонсгоод аль нь илүү тухай мэтгэлцэж, дараа нь өөрөөр нь тоглуулахад урьдынхаасаа илүү тоглоно. Их аятайхан хувилбарыг нь олоод харчихдаг сэргэлэн охин.

Рэйко амьсгаа авч, тамхиныхаа утааг ажих зуур би усан үзмээ үг дуугүй идэж суув.

- Өөрийгөө хувьдаа хөгжимд гайгүй авьяастай гэж бодож явсан ч тэр охин надаас хол давуу байж билээ. Билиг авьяасыг нь бодмогц хар бууна гээч. Багадаа сайн багшаар системчлэн заалгасан бол сайн хөгжимчин болох талтай ч гавьтай үр дүнд хүрэх нь эргэлзээтэй. Өөрийгөө дайчлахдаа тааруухан. Ийм хүмүүс бас байна шүү. Зарим хүмүүс авьяас чадвартай байгаад хичээл зүтгэлгүй тул амжилт олдоггүй. Ийм улстай бишгүй л таарч явлаа. Жишээлэхэд, хүндхэн аялгууг ноотоо нэг хараад алдаа мадаггүй тоглодог улс бий. Тоглох тоглохдоо сайн тоглоно шүү. Би бол яаж ч хичээгээд дөнгөхгүй. Гэтэл энэ хүмүүс үүнээс цааш ид шидгүй. Яагаад гээч? Ердөө хичээл зүтгэлгүй болоод л тэр. Авьяас чадвараа зүтгэл гаргаж баталгаажуулдаггүй булшилдаг. Хар багаасаа аливаа зүйлийг хурууны үзүүрээр хийдэг ийм хүүхдүүд магтаал сайшаалд толгой нь эргэж, биеэ дайчлах зэрэг нь огт хэрэггүй, инээдтэй зүйл мэт санагдана. Өөр хүүхдүүд гурван долоо хоног нүдэж байж сурдаг аялгууг хоёр дахин бага хугацаанд сурчихад багш нь авьяас чадвартайг нь хараад дараагийн шатанд шилжүүлнэ. Өнөө хүүхэд маань тэр шатаа ч богино хугацаанд өөриймшүүлж цааш ахина... Ингэсээр эцсийн дүндээ хувь хүн болон төлөвших нэгээхэн чухал үеэ алгасаад өнгөрчихнө. Үнэхээр харуусмаар. Сайтар бодвол би ч энэ үеийг туулаад гарсан. Гэхдээ азаар багш минь чанга хатуу хүн байж, би гэдэг хүн багахан ч атугай амжилтанд хүрсэн.

Тэгэвч тэр охинд төгөлдөр хуур заах таатай байлаа. Чадал ихтэй спорт машин хөлөглөөд хурдны замаар шунгинуулан давхих мэт мэдрэмж төрдөг сөн. гар хуруугаа хөдөлгөв үү, үгүй юу хэлэх гэснийг минь өлгөөд авна. Хэт хурдлаад байна уу гэж бодогдох үе ч байлаа. Ийм хүүхдийг сургахад хамгийн гол нь хэт магтаж болохгүй. Хар багын магтаал сайшаалд чих нь дөжирсөн учраас магтлаа гээд нэмэргүй. Сүүлдээ баярлахаа ч болино. Хаа нэг урамшуулахад хангалттай. Үүн дээр нэмээд аливаа зүйлийг тулгаж шавдуулахын хэрэггүй.

Өөрөөр нь сонголт хийлгэх учиртай. Урагш нь туулгүй, түр азнуулж мэдсэн сурсныг нь шингээлгэвэл болох нь тэр. Ингэвэл эцэстээ амжилт олох нь баараггүй.

Рэйко янжуураа унагаж дэвслээ. Ингээд тайвшрах гэсэн аятай санаа алдав.

- Хичээлийн дараа бид хоёр цайлангаа хууч хөөрнө. Хааяадаа би жааз хөгжим тоглож, түүнд заана. Энэ нь Bud Powell, тэр нь Thelonious Monk гээд л. Гэхдээ охин ярих нь илүүтэй. Сонирхол татахуйц яриа хөөрөөтэй охин шүү. Ихэн голдуу санаасаа зохиож ярьдаг байсныг нь өчигдөр чамд хэлсэн дээ. Гэлээ ч яриа хөөрөө нь сонирхолтой. Хачин гярхай, аливааг голыг нь онож хэлэхийн сацуу хэгжүүн үг хэл нь сэтгэлд хүрэхийг яалтай. Бусдын сэтгэлийг хөндөх онцгой чадвартай. Өөрөө ч үүнээ мэдэх тул энэ чанараа чадах чинээгээрээ тун чамбай ашиглана. Яриа хөөрөөгөөрөө хүмүүсийг уурлуулж, гуниглуулж, өрөвдүүлж, гансруулан баярлуулна. Өөрийнхөө чадварыг мэдрэх гэсэндээ бусдын сэтгэлээр тоглодог байж. Энэ тухай нь би хэзээ хойно мэдсэн.

Рэйко толгой сэгсэрч, хэдэн усан үзэм идлээ.

- Мэдрэлийн өвчтэй байсан юм билээ. Энэ өвчин нь ойр хавийн хүмүүстээ халдварлаж, эгээ л ялзарсан алим шиг дотроос нь иднэ. Өвчнийг нь хэн ч эдгээж дийлэхгүй. Ийм өвчтэй хүмүүс насан туршдаа энэлэн шаналдаг гэж бодохоор нэг бодлын өрөвдмөөр. Тэр охины урхинд ороогүй сэн бол би ч өрөвдөх байж. Тэр охиныг бусдын адил золиос болсон гэж бодох байлаа.

Рэйко усан үзэм идэнгээ хэрхэн үргэлжлүүлэн ярихаа тунгаасан гэлтэй.

- Бид хоёр хагас жил орчим гайгүй сайхан харилцсан ч хааяахан хачин жигтэй зан авир цухалзана. Нэг удаа ярилцаж суух нь ээ, хэн нэгнийг ор үндэсгүй туйлгүй үзэн ядаж явдгийг нь мэдээд дотор арзасхийж билээ. Сэргэлэн цовоо учраас заримдаа санаа бодлыг нь таашгүй... Гэхдээ хэн хүнгүй л алдаа дутагдалтай шүү дээ? Тэгээд ч би төгөлдөр хуур заахаас хэтрэхгүй учир тэр охины мөн чанар, ааш аягийг нь бодох сөхөөгүй явж. Хичээгээд сурч байвал миний хувьд болох нь тэр. Үүнээс гадна би тэр охинд жигтэйхэн сайн байлаа.

Гэхдээ ямартаа ч хувийн амьдралаа дэлгээд хэрэггүй гэж шийдсэн юм. Зөнгөөрөө л тэгж санасан. Надаас элдвийг шалгаадаг ч би сэтгэлээ нээсэнгүй. “Хэрэгт дурлаад байвал эрт хөгширнө шүү” гэсгээд өнгөрөөнө. Гэр орон, сургууль соёл гээд л шалж гарна. “Өөрийнхөө тухай ярь л даа” гэхээр нь “Энэ тухай мэдэх хэрэг байна уу? Сонирхоод байх юмгүй жирийн л амьдрал, эр нөхөр, үр хүүхэд, ахуй амьдралтай...” гэвэл хариуд нь өөдөөс цоо ширтээд “Та надад хачин их таалагддаг. Жаахан ч атугай яриач” гээд салахгүй. Салахгүй шалаад байх нь надад тэгж их тээртэй санагдаагүй ч илүү дутуу юм ярьсангүй.

Энэ явдал таван сарын нэг өдөр болж билээ. Хичээлийн үеэр нөгөө охины бие гэнэт эвгүйрхдэг юм байна. Хартал царай нь цонхийгоод, хүйтэн хөлс нь цутгачхаж. “Тэртээ харих уу?” гэвэл “Эндээ түр хэвтэж болох уу? Гайгүй болох биз” гэлээ. Би ч “Тэг дээ. Наашаа ирээд орон дээр хэвт” гэлээ. Манайх жижиг буйдантай тул тэврэх нь холгүй явсаар унтлагын өрөөндөө оруулж, орон дээрээ хэвтүүллээ. “Танд төвөг удсанд өршөөгөөрэй” гэхээр нь “Зүгээр дээ. Санаа зоволтгүй” гэсэн сэн. “Ус уух уу?” гэвэл “Уухгүй ээ. Баярлалаа. Хажууд минь түр суугаач” гэдэг юм байна. Би ч “Тэгье дээ” гээд дэргэд нь суулаа.

Хэсэг хугацааны дараа шаналсан байртай өөдөөс минь ширтэж “Нурууг минь илээд өгөөч” гэдэг юм байна.

Нэлээд хөлөрсөн байхаар нь санаа зовоод нурууг нь илж байтал “Хөхөвчийг минь тайлаад өгөөч. Давчдаад байх юм” гэхээр нь арга буюу тайллаа. Бариу цамцных нь товчийг тайлж, хөхөвчийг нь султгалаа. Арван гуравтай охин гэхэд том хөхтэй, өсвөр насны охидын өмсдөгөөс ондоо, том хүний жигтэйхэн үнэтэй хөхөвч өмсчээ. Би ч надад юуны хамаа гэж бодоод нуруугаар нь илж суув. Охин байсхийгээд л “Намайг өршөөгөөрэй, би гэж тэнэг хүн юм” гэхээр нь “Зүгээр ээ” гээд тайвшруулна.

Рэйко тамхины үнсээ унагааж, би ч усан үзэм идэхээ болиод ярианд нь ууслаа.

- Хэсэг азнатал нөгөө охин гэнэтхэн уйлав аа. Би ч яав ийв гэтэл “Зүгээр” гэх юм. “Зүгээргүй л байна даа. Алив хэлж ярих юм байвал хэл” гэсэнд “Заримдаа ингэдэг юм. Өөрийгөө барьж дийлэхгүй нь.

Ганцаардаад сэтгэл үймэрдэг. Итгэж найдах хүнгүй. Хэн ч намайг сонирхдоггүй. Ийм л юм болоод байх юм. Шөнөдөө нойр хулжина. Хоол идэх ч хүсэлгүй. Тантай байхад л сайхан байдаг” гэхээр нь “Сэтгэлээ онгойтол ярь. Сонсьё” гэлээ.

Гэртээ сэтгэл нь тогтдоггүй, эцэг эхдээ хайргүй, тэд ч түүнд хайргүй. Аав нь өөр хүүхэнтэй учир ургуулж, гэрийн бараа харахгүй болсонд ээж нь эгээ л ухаан самуурч, өдөр болгон уур унтуугаа түүнд гаргадаг. Гэртээ харихаас айдаг гээд цурхиртал уйлахад сайхан нүдэнд нь нулимс дүүрлээ. Үүнийг харсан хэн бугай ч сэтгэл өмрөхгүй байхын аргагүй. Би түүнийг тайвшруулж, хичээлээс гадна хүссэн үедээ ирж бай гэхээс өөр хэлэх үг олдсонгүй. Гэтэл өнөө охин “Намайг өршөөгөөрэй. Тантай таараагүй сэн бол учраа олохгүй байлаа. Намайг битгий түлхээрэй. Та намайг орхивол надад очих газаргүй” гэв.

Би ч учраа олохгүй толгойг нь илж “Тайвшир” гээд тэвэрч суувал охин намайг тэврээд нурууг минь илж гарлаа. Аажимдаа тун сонин мэдрэмж төрөв. Бие халуу дүүгээд ч байх шиг. Тэгэхгүй гээд яах билээ? Зураг шиг сайхан охинтой ор дэрэн дээрээ тэврэлдэж, нуруу туруугаараа илүүлж суухад сэтгэл хөдлөх нь гарцаагүй. Нөхөртэй минь зүйрлүүлшгүй. Биеийг минь илэх бүр дотор байх пүрш аажуухан сунах мэт. Бүхий л биеэрээ татагдсан сан. Нэг мэдсэн чинь охин цамцыг минь тайлж, хөхөвчийг минь задгайлаад, хоёр хөхийг минь оролдоход л ижил хүйстэн гэдгийг нь мэдсэн. Урьд ахлах сургуулийн төгсөх ангидаа энэ мэт хүмүүстэй таарч явлаа. “Ингэж болохгүй. Боль” гэхэд нөгөө охин “Танаас гуйя. Түрхэн зуур шүү дээ. Үнэндээ маш их ганцаардах юм. Худлаа хэлээгүй шүү. Надад танаас өөр хүн байхгүй. Битгий намайг хөөгөөч” гээд гарыг минь хөхөн дээрээ тавьдаг юм байна. Хөхийг нь барьтал миний хөхийг базах шиг боллоо. Би чинь эмэгтэй хүн шүү дээ! гэж бодоод өөртөө “Ингэж болохгүй” гэж ахин дахин хэлсэн ч сэрэл хөдлөх шиг болоод хөдөлж чадсангүй. Уг нь ахлах ангидаа өөрийгөө хамгаалчихсан хүн шүү дээ. Гэтэл энэ удаад болдоггүй. Бие минь хөдөлдөггүй. Охин зүүн гараараа гараас минь барьж хөхөн дээрээ тавиад, хөхний минь товчийг үнсэж, баруун гараараа нуруугаар минь доош иллээ. Арван гуравхан настай охиноор хувцсаа тайлуулж, үнсүүлж таалуулан хэвтсэнээ санахад одоо ч итгэмгүй. Мулгуу тэнэг гэлтэй. Учраа олохгүй үүлгэртэх зуур охин

намайг барагтай бол нүцгэлчихсэн байж билээ. Илбэдүүлсэн гэмээр ухаан санаагаа алдсан. Нөгөө охин “Ганцаардаж байна. Танаас өөр хүн алга. Намайг битгий хөө л дөө. Гуйж байна” гээд энгэр цээжийг минь үнсэхэд би “Ингэж болохгүй шүү дээ” гэхээс өөр юм хэлж чадсангүй.

Рэйко үгээ тасалж, янжуураа асаагаад:

- Үнэнийг хэлэхэд энэ тухай анх удаа л эр хүнд дэлгэсэн нь энэ. Чамд яривал дээрдэх болов уу гэсэндээ л нуршиж сууна. Тэрнээс биш ярихад ичгэвтэр л юм гэсээр өөдөөс минь ширтсэнд:

- Зүгээр ээ гэхээс өөр хэлэх үг олдсонгүй.

- Охин хэсэгтээ цээжийг минь үнсээд доошилж, өмд рүү гараа шургууллаа. Гэтэл би тэгэхэд норчихсон, тэсвэр алдаж байлаа. Өөрийгөө тэгнэ чинээ санаагүй. Энүүхэндээ гэхэд урьд хожид тэр өдөр шиг сэрэл хөдөлж явсангүй. Өөрийгөө хүйтэн хүүхэн л гэж бодож явлаа. Гэтэл үг хэлээ алдтал толгой эргэж байдаг. Охин булбарай сүмбэн хуруугаа өмдөн дотуур шургуулж, тэрүүхэнд нь оролдож эхэлсэн... Чи ойлгоо байлгүй. Би хэлж чадахгүй нь... Эр хүн оролдохоос тэс ондоо мэдрэмж. Үгээр дамжуулахын аргагүй. Өдөөр гижигдэх мэт. Бодох санах юмгүй үлдэх вий гэж айсан сан. Гэлээ ч ингэж болохгүй. Нэгэнтээ энэ мэт аяглавал ээлж дараалан үргэлжлэх болно. Чингэвэл үүнээ нуухаас өөр замгүй. Тэгсэн тохиолдолд толгой тархи минь дүйнгэтнэ гэдгийг сэхээрч байлаа.

Хойно нь охиноо бодлоо. Харьж ирээд намайг харвал яана? Бямба гарагт охин маань гурав хүртэл эмээ өвөөгийн дөө байдаг ч эртхэн ирвэл яалтай? гэж бодоод биеэ хүчлэн байж босоод “Одоо боль” гэж хашгирлаа.

Гэтэл өнөө охин дотуур өмдийг минь шувтлаад амаараа... Ичингүйрээд нөхөртөө ч ингэхийг зөвшөөрдөггүй хүн атал арван гуравтай охинтой ингэж байдаг... Цочролд орж билээ. Тэнгэрт дүүлэх шиг таашаал эдэлсэн дээ.

Салахгүй болохоор нь “Болиоч!” гэсээр байдаг чадлаараа алгадаж байж холдуулсан. Тэгэхэд л больсон. Өндийж суугаад өөдөөс минь

хараад хоёул хэсэгтээ л нүцгэн чигтээ гөлөрцгөөлөө. Арван гуравтай охин, гучин нэгтэй эмэгтэй... Биеийг нь хармагц дотор зарсхийж байснаа өдгөө ч мартдаггүй. Арван гуравтай охин ийм бие хаатай гэдэгт итгэмээргүй. Хажууд нь миний муу бие уйлмаар өрөвдөлтэй санагдсаныг нуугаад яахав.

Хэдийн дуугаа хураасан надад энэ мөчид ч хэлэх үг олдсонгүй.

- Охин “Танд таалагдсан биз дээ. Би анхнаасаа л мэдэж байсан. Таалагдсан биз дээ? Би мэднэ ээ. Бүгдийг мэднэ. Эр хүнтэй байхаас энэ нь хавьгүй дээр. Тийм биз? Та норчихсон байна шүү дээ. Таныг үүнээс ч сайхан болгож чадна. Нээрээ шүү. Та хайлж урсана гээд л бод. Та хүсэж байгаа шүү дээ?” Үнэндээ эр нөхөртэйгээ амрагласнаас түүнтэй хамт байх нь илүү байж билээ. Ахиад энхрийлээсэй гэж хүсээд байлаа. Гэсэн ч ингэж болохгүй. Охин “Хоёулаа долоо хоногт нэг удаа уулзаж байя. Ганцхан удаа. Хэн ч мэдэхгүй. Бид хоёрын бяцхан нууц болог” гэсэн ч би босч хувцсаа өмсөөд “Одоо харь! Дахиж ирсний хэрэггүй” гэлээ. Над руу хараад л байсан.

Нүд нь нэг л хөндий хоосон болчихож билээ. Хямдхан цаасан дээр усан будгаар ур муутайхан зурсан нүднээс өөрцгүй. Хий хоосон харцаар удаан гэгч нь намайг ширтэж, хувцас хунараа цуглуулж, харуулах гэсэн аятай алгуурхан өмсөөд, төгөлдөр хууртай зочны өрөөнд орж, цүнхнээсээ сам гаргаж үсээ самнаад, аман дээрх цусаа нусны алчуураар арчиж, гутлаа өмсөөд гарсан юм. Үүдэнд очоод “Та үнэндээ ижил хүйстэн. Өөрийгөө хичнээн хуураад нэмэргүй. Үхэн үхтлээ ийм байх болно” гээд явсан.

- Та тэгээд ижил хүйстэн гэж үү? гэсэнд Рэико уруулаа жимийлгээд их л бодлогошронгуй:

- Тийм ч байж мэднэ. Үгүй ч байж мэднэ. Тэр охинтой хамт байхад нөхөртэйгээ амрагласнаас таатай байсан нь үнэн. Тиймдээ ч хэсэгтээ ижил хүйстэн биш байгаа гэж шаналж явлаа. Өдий болтол үүнээ мэдрээгүй явсан ч юм билүү? Эм хүнийг ор тас хүсдэггүй гэж хэлэхгүй ээ. Бодох үе бишгүй л бий. Гэхдээ би ижил хүйстэн биш. Эмэгтэй хүн хараад хүсч тачаадаж явсангүй. Ойлгож байна уу? гэсэнд би толгой дохилоо.

- Аливаа эмэгтэй надад талтай хандахыг би мэдэрдэг. Үүнээс цаашгүй. Наоког тэврэхдээ ч элдвийн юм боддоггүй. Халуун цагт бид хоёр гэртээ нүцгэн байдаг. Хамтдаа усанд орж, нэг орон дээр унтаж байсан ч гаж хүсэл төрдөггүй. Элдвийн зүйл болдоггүй. Наоко сайхан биетэй гээд шунаж тачаадсан зүйлгүй. Нэг удаа тоглоом шоглоомоор хоёр биенээ илж таалсан ч гижиг хүрэхээс өөр мэдрэмж төрөөгүй. Тэр тухай ярих уу?

- Тэгээч.

- Энэ явдлаа Наокод ярьсны дараа цаадах чинь намайг таалах гэж үзсэн юм. Бид хоёр нэг нэгнээсээ юмаа нуух биш. Хоёулаа нүцгэллээ. Гэсэн ч сэрэл төрдөггүй. Үхтлээ гижиг хүрч билээ. Одоо санахад ч гижиг хүрэхийг яана. Наоко энхрийлж таалах тухайд мэдлэг муутай. Тийм болохоор санаа зовсны хэрэггүй.

- Ашгүй дээ.

- Ийм л явдал болсон юм. Нөгөө охин явсны дараа би хэсэгтээ буйдан дээр гөлийж суугаад яах учраа олсонгүй. Зүрх минь түг түг цохилох нь дуулдана. Хөл гар хөшиж, ам хатсан гэж тоймгүй. Охиноо удахгүй эргэж ирэхийг санаад усанд орлоо. Тэр охины хүрч долоосон бүх л хэсгийг зулга угаахыг хүссэн сэн. Гэтэл шүлс шиг наалдамхай шингэн нь савангаар үрээд үрээд угаагддаггүй. Сэрэл хөдлөөд ингэж байна гэж санаад гараараа өөрийгөө хангах гээд ч бүтсэнгүй. Тэр шөнө нөхөртэйгээ ойртсон ч өдрийн явдлын тухай мэдээж ам нээгээгүй. Яаж ч хэлэх билээ. Амраглая гээд урьдынхаасаа удаан хийхийг хүссэн юм. Нөхөр минь ч чадлаараа хичээсэн. Би биеэ сул тавиад л гиншиж байлаа. Гэрлэснээс хойш тэр шөнийх шиг таашаалтай байсан нь үгүй. Яагаад гээч? Тэр охины гар хурууг бодох болгонд сэрэл хөдөлнө. Тэгээд л тэр. Энэ тухай ярихад ичмээр юм даа. Бүр хөлөрчихлөө шүү.

Рэйко жимийсэн чигтээ чимээгүйхэн инээмсэглэнэ.

- Хоёр, гурав хоносон ч гар хурууг нь мартдаггүй. гарахдаа хэлсэн үгс нь чихэнд цуурайтна.

Бямба гараг болж сэтгэл төвдөн хүлээсэн ч нөгөө охин ирсэнгүй. Хаа нэгтээг гөлөрч суугаад гэрийн ажлаа хийж чадсангүй. Тэр охин ирээгүй ээ. Яаж ч ирэх билээ? Түүн шиг их зантай хүн хөөгдөж гараад ирэх үү? Хоёр долоо хоног, сар өнгөрсөн ч охин үзэгдсэнгүй.

Цагийн аясаар энэ тухай мартана гэж бодох ч бүтсэнгүй. Гэртээ ганцаараа үлдэхэд сэтгэл хоёрдоод, тэр охин хааяагүй үзэгдэнэ. Төгөлдөр хуураа ч тоглож чаддаггүй. Ухаан бодлоо ч төвлөрүүлж дөнгөдөггүй. Сар гаруйн дараа зарим нэг зүйлийг анзаарах сөхөөтэй болдог юм байна. Гэтэл гудамжинд хүмүүс нэг л биш, надаас дөлөөд ч байх шиг. Надтай мэндлэх ч цаанаа л хүйтэн хөндий. Орж гардаг хөршүүд маань жийрхээд ч байх шиг. Гэлээ ч аахар шаахар зүйл анзаараад яалтай гэж санаад төдий л тоосонгүй. Үймрээд эхэлвэл өвчин сэдрэхийн дохио.

Ингээд нэг удаа танил бүсгүй минь манайд ирдэг юм байна. Надтай нас чацуухан, ээжийн минь найзын охин. Хүү нь манай охинтой цуг нэг цэцэрлэгт явдаг тул бид хоёр гайгүй сайн харилцаатай.

Манайд ирээд миний тухай цуу яриа тарсныг гадарласан эсэхийг минь лавлахад би толгой сэгсэрлээ. “Ямар цуу тардаг билээ?”

- “Шуудхан хэлэхэд эвгүй юм.”

- “Эвгүй ч гэлээ нэгэнт ам нээснийх зоволтгүй хэл” гэсэнд аанай л хулгавал тулгасаар байгаад яриуллаа. Танил бүсгүй маань арга ядахдаа өөр яриа өдөхийг хичээж билээ. Түүний хэлснээр би гэдэг хүн хэзээний нэртэй ижил хүйстэн, хэд хэдэн удаа сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэвтэж байжээ. Төгөлдөр хуур заадаг охиноо элдвээр оролдож, хувцсыг нь тайлаад, эсэргүүцэхээр нь хөх эрээн болтол нь нүүр нүдгүй зодсон гэсэн цуу тарж. Итгэмээргүй худал яриа. Эмнэлэгт эмчлүүлж явсныг минь олж мэдсэнд танил маань гайхширч байлаа.

“Таныг эртнээс сайн мэдэхийн учир энэ бүхнийг үгүйсгэж явсан ч тэр охины эцэг эх энэ ярианд нут итгэж, хавь ойрдоо тарааж, охиныг нь оролдоод зогсохгүй сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэвтэж байсныг тань олоод мэдчихэж”

Түүний ярьснаар, охин манайхаас явсан өдрөө уйлж унжсаар бүлцийтлээ хавдаж, гэртээ ороход аав, ээж нь шалгааж гарчээ. Нүүр нь бэлцийгээд, хагарсан уруулаас нь цус дусалж, цамцных нь товч тасраад, дотуур өмд нь норсон байж. Чи төсөөл дөө. Аав, ээждээ худал хэлж, намайг гүтгэх гэсэндээ тэгээ биз. Цамцаа цусдаж, хөхөвчнийхөө товчийг тасалж аваад, нүдээ бүлцийтэл уйлж, үсээ сэгсийлгээд намайг гүжирдсэн нь мэдээж.

Чингэлээ гээд түүнд итгэсэн болгоныг үзэн ядаж болохгүй. Би ч тэдний оронд байвал итгэж үнэмшинэ. Хүүхэлдэй шиг хөөрхөн, хэл амтай охин ирээд “Юу ч ярьмааргүй байна. Ичиж байна” гэвэл хэн хүнгүй л үнэмшинэ. Дээрээс нь эмнэлэгт хэвтсэн минь үнэн юм хойно ойр хавийнхан тэр цуу ярианд итгэж. Түүнийг зодоогүй гэвэл итгэх хүн олдох уу? Нөхрөөс минь өөр хүн эргэлзэх нь лав.

Хэдэн өдөр шаналаад нөхөртөө хэлбэл нөхөр минь намайг ойлгосон. Тэр өдрийн бүхий л явдлыг нэгд нэгэнгүй ярилаа. Ижил хүйстнүүд лугаа надтай зугаацаж, түүнийг алгадсанаа ч хэллээ. Сэрэл хөдөлснөө нуусан л даа. Нөхөр минь жигтэйхэн унтууцаж “Энэ чинь ямар учиртай хэрэг вэ? Уулзаж учир зүйгээ олъё. Гэр бүлтэй, үр хүүхэдтэй хүнийг ижил хүйстэн гэж байдаг. Арай ч дээ” гэдэг юм байна.

Гэсэн ч би нөхрөө явуулсангүй. Хэрэггүй гэлээ. Ингэлээ гээд сэтгэл үймрэхээс цаашгүй. Тэр охин өвчтэй байсныг би тэгэхэд л ухаарсан. Энэ яваа насандаа тийм өвчтэй хүнтэй бишгүй таарч явсан хүн шүү дээ. Охин тэр аяараа ялзарсан. Сайхан үс зүсийг нь сөхөв үү, үгүй юу илжирсэн дотор тал нь ил болно. Үнэндээ тийм. Үүнийг нь гадарлах хүнгүй учраас өдөр хоногийг энэ мэт өнгөрөөсөөр явна. Тэр охин томчуулын сэтгэлээр тоглох шиг болдог. Гэтэл бид үүнийг эсэргүүцэх хүчгүй. Арван гуравтай охин гучин нэгтэй эмэгтэйг оролдсон гэхэд ер үнэмших хүн бий сэн үү? Яаж ч учирлаад хүмүүс итгэхийг хүссэн зүйлдээ л итгэдэг. Өөрийнхөөрөө зүтгээд хэрэг бишдэхээс цаашгүй.

Нөхөртөө өөр газар луу нүүе гээд “Эндээ үлдвэл дарамт шахалтыг нь дийлэлгүй, өвчин минь сэдэрнэ. Одоо ч учраа олохгүй ядаж байгаа хүн алгуурлавал бишдэнэ. Таних хүнгүй холоо газар явъя” гэсэн ч нөхөр минь хөдөлсөнгүй. Хэрэг явдал хэдий ноцтойг ухаараагүй биз ээ. Нөхөр маань ажилдаа дурлаж, жижигхэн ч гэсэн байшинтай болоод,

охин маань цэцэрлэгтээ дасч, ажил төрөл нь бүтэмжтэй байсанд “Түрдээ харзная. Гэнэтхэн нүүчихэж болохгүй шүү дээ... Шинэ газар очлоо гээд ажилд ороход ярвигтай, байшин саваа худалдаж, охиндоо шинэ цэцэрлэг хайх хэрэг гарна. Шалавлалаа гэхэд хэдэн сарын ажил бий” гэлээ.

“Алгуурлавал би тэсэхгүй нь. Тэгвэл ахиж сэргэхгүй. Чамайгаа айлгахыг хүсэхгүй ч гэлээ ингэх нь гарцаагүй” гэж билээ. Үнэндээ тэр үед би хий юм сонсож, нойр хулжих болсон юм. Нөхөр минь “Чи түрүүлээд явж бай. Би эндэх ажлаа төвхнүүлээд араас чинь очъё” гэсэнд “Ганцаараа явмааргүй байна. Чамайг орхиод явбал хоёулаа салж магад. Одоо л чи надад хэрэгтэй. Ганцааранг минь бүү орхи” гэлээ.

Нөхөр минь чадлаараа тэсээрэй гэсээр чанга тэвэрлээ. Ядахнаа сар тэсвэл ажлаа эмхлүүлж, хүлээлгэж өгөөд, байшингаа худалдаж, хүүхдийн цэцэрлэгээ зохицуулаад, аз таарвал Австралид ажиллана гэсэн сэн. Сар л тэсчихвэл бүх зүйл тэгширнэ гэсэнд сөргөж зүрхэлсэнгүй. Гуйж гувшвал улам ганцаардах биз гэж сэтгэсэн юм.

Рэйко санаа алдаж, адарт дэнжигнэх чийдэнг хараад яриагаа үргэлжлүүлэв.

- Гэлээ ч сар хүрэлгүй өвчин минь сэдэрч, би тэсч чадалгүй тайвшруулах эм уугаад, хийн хоолойгоо нээж амиа егүүтгэхээр завдсан ч эмнэлэгт сэхээ орж билээ. Ингээд бүх юм дууссан. Хэдэн сарын дараа учраа олохтойгоо болж, нөхөртөө хоёр тийш больё гээд “Ингэвэл хэн хэндээ, үр хүүхдэд минь ч ээлтэй” гэвэл манай хүн хэсэгтээ зөвшөөрсөнгүй.

“Хоёулаа эхнээс нь эхлэе. Шинэ газар очоод гурвуул сайхан аж төрье” гээд ятгана.

“Одоо нэгэнт оройтсон. Сар хүлээ гэхэд би тэсвэр алдсан. Эхнээс нь эхлэхийг хүссэн аваас чи тэр үед хүлээ гэхгүй. Хаа ч явсан, холдож одсон ч энэ бүхэн давтагдана. Охин, та хоёрыгоо зовоомооргүй байна” гээд салсан юм. Хүчилсээр байгаа хоёр тийш болж билээ. Нөхөр маань хоёр жилийн өмнө хүнтэй гэрлэсэн. Тэр нь ч оноо биз. Би ч энэ чигээрээ өнгөрөхөө ойлгосон. Бусдыг зовоогоод яахав. Өвчин нь хэзээ

сэдрэх бол гэсэн мөнхийн түгшүүртэй амьдралд өрөөл нэгнийг уруу татаад хэрэг юун.

Халамжтай хүнтэй учирлаа. Итгэлтэй, чадалтай, тэсвэр хатуужилтай, миний хувьд төгс эр хүн. Намайг чадлаараа эмчлэхээр зүтгэж, би ч түүнээ, хүүхдээ бодоод хэрэндээ хичээсэн. Сайн хүнтэй таарч, зургаан жил сайхан амьдарлаа. Зууны ерэн есөн хувьд зөв зүйтэй алхам хийдэг хүн. Гээд ганцхан буруу зүйлээс болж хайран амьдрал минь нурсан. Цогцлоож босгосон бүхэн минь нэг л хар эгшинд юу ч үгүй болтлоо нурж унасан. Тэр охиноос болж ингэсэн гэхэд буруудахгүй.

Ингэж хэлээд Рэйко унтраасан тамхиныхаа ишийг түүж, цаасан хайрцганд хийгээд:

- Гунигтай л түүх. Сэтгэлээ эмнэх гэж чамгүй зүтгэсэн ч бий бүхэн минь эргэж харахын завдалгүй нэг эгшинд нурдаг. Нүд ирмэхийн зуур юу ч үгүй болсон гээд босч гараа халааслан:

- Одоо буцъя. Оройтлоо гэсээр гарч явав.

Тэнгэр бүрхэж, сар далдраад, чийг үнэргэнэ. Барьж яваа гялгар уутан дахь шинэхэн усан үзэмний үнэр чийгийн үнэртэй холилдоно. Рэйко:

- Ийм учраас эндээс явж чадахгүй нь... Бодит амьдралтай нүүр тулахаас эмээх юм... Зүсэн зүйлийн хүмүүс, элдвийн үзэл бодлоос айх юм гэлээ.

- Ойлгож байна аа. Гэхдээ Та амьдралд хөлөө олж чадах байх гэхэд Рэйко үл ялиг инээмсэглэв.

Бид хоёрыг буцаж ирэхэд Наоко ном уншиж суув. Урсан орох үг хэллэгийг тэмтэрч буй мэт хуруугаа чамархайдаа хүргэжээ. Том том дусалтай бороо шаагиж, цахилгаан цахихад түүний эргэн тойрон гэрэл анивалзана. Рэйкотой хэсэг зуур хөөрөлдсөний дараа Наокогийн залуу халуун насыг эс бүрээрээ ахин мэдрэх шиг боллоо. Рэйко:

- Бид хоёр оройтчихов уу даа? гэсээр Наокогийн толгойг илнэ.

- Та хоёр хөгжилтэй байв уу?

- Мэдээж.

- Тэгээд та хоёр юу хийгээ вэ? гэж асуувал:

- Хэлэхэд эвгүй л юм гэлээ.

Наоко тас тас хөхрөөд номоо хойш тавьж, усан үзэм идэнгээ тог тог хийх бороон дуслуудад чих тавин:

- Бороо ороод л энэ хорвоод бид гурваас өөр хүнгүй мэт санагдах юм. Энэ бороо мөнхөд орж, гурвуулаа энд сууж байдаг бол сайхан аа гэхэд Рэйко:

- Та хоёрыг тэврэлдэж суухад би бараа бологч шиг дэвүүр бариад л, гитараа дараад хажууд чинь зогсох юм биз дээ? Тэр ч бүтэхгүй ээ гэвэл Наоко:

- Хааяадаа Ватанабэг зээлж болно шүү гэлээ.

- Тэгвэл ч өөр хэрэг. Бороо минь ороорой гэж хэлэх Рэйко инээсээр.

Бороо цутгасаар, усан үзмээ идэж дуусмагц Рэйко урьдын адил орон доороос гитараа гаргаж ирээд тошов. Desafinado, The Girls From Iranema, Бакарак, Леннон, Маккартни нарын дууг эгшиглүүлнэ.

Рэйко бид хоёр дарс ууж, дуусмагц нь үлдэгдэл брэндигээ уув. Энэ мэт элдвийг ярьж суух таатай байлаа. Энэ бороо мөнхөд асгардаг сан бол юутай сайхан.

- Чи дараа ирнэ биз дээ?

- Ирэлгүй дээ.

- Захиа бичих үү?

- Бичилгүй яахав. Долоо хоног болгон бичнэ гэхэд Рэйко:

- Надад бас бичээрэй хэмээн үг хавчуулна.

Ингээд арван нэг болмогц Рэико өчигдрийн адил ор засч өгөөд гурвуул унтахаар хэвтлээ. Миний нойр хүрсэнгүйд үүргэвчнээсээ гар чийдэн авч асаагаад Шидэт уул-аа уншив.

Арван хоёр цагийн алдад унтлагын өрөөний хаалга онгойж, Наоко чимээгүйхэн орж ирээд “Нойр хүрдэггүй” гэсээр хажуугаар шургалаа. Өнгөрсөн шөнөтэй харьцуулбал тэс өөр Наоко. Би гар чийдэнгээ унтрааж Наоког тэврээд зөөлөн үнслээ.

- Рэико яасан бэ?

- Унтчихсан. Санаа зоволтгүй. Нэг унтвал сэрэхгүй. Чи дахиад ирэх үү?

- Ирэлгүй яахав.

- Чамд тусалж чадахгүй байлаа ч ирнэ гэж үү?

Би толгой дохиод бие хааг нь сэтгэл санаандаа буулгах гэсэн шиг зөөлөн тэмтэрлээ. Удалгүй Наоко духан дээр минь үнсээд өрөө рүүгээ оров. Би шаагин асгарах бороон чимээнд чих тавьсаар унтлаа.

Өглөө болоход нарийн ширхэгтэй бороо цайрсаар л. Шалбааган дээр дусах дуслууд, дээврээс урсах ус л бороо орж буйг илтгэнэ.

Нүдээ нээхэд манан татсан байсан ч нар мандмагц сарнин алга болов. Бид гурав цай ууж, өчигдрийнх шигээ шувууд хооллохоор гарлаа. Гурвуул цув нөмөрсөөр шувууны байр ороход гадаа сэрүүхэн байлаа.

- Сэрүүсч байна даа.

- Энд тэгдэг юм. Энэ бороо аажимдаа цас болж өвөл болно. Япон тэнгисээс ирсэн үүлс эндхийг цасан бүрхүүлээр хучаад алга болно.

- Өвөл шувуунуудаа яах вэ?

- Шувууны байранд шилжүүлнэ.

Торыг нь цохивол нэг тоть “Мангар амьтан, баярлалаа, тэнэг минь” гэж хашгирахад Наоко:

- Энийг харин гадаа өвөлжүүлэх хэрэгтэй. Өглөө болгон элдвээр орилно хэмээнэ.

Бид гурав шувууны байр цэвэрлээд өрөөндөө эргэж ирлээ. Хувцас хунараа эмхэлж, гурвуул хамт гараад теннисний талбайн хажууд салцгаав.

Хоёр бүсгүй баруун эргэж, би үүргэвчээ үүрээд сувиллын төв хаалга руу алхлав. “Баяртай. Би ирнэ ээ” гэсээр явахад Наоко ялимгүй инээмсэглээд эргэж харалгүй одлоо.

Замд таарсан хэдэн хүн Наоко, Рэико хоёрынх шиг шаргал цув өмсчээ. Бороонд юмсын өнгө будаг тодорч, газар харлаад, моддын өнгө сэргэжээ. Шар цувтай хүмүүс багаж хэрэгсэл барин чимээгүйхэн зөрнө.

Манаач өвгөн нэрийг минь мартаагүй бололтой дэвтэртээ тэмдэглэл хийгээд:

- Токиогоос ирсэн юмаа даа? Би нэг очиж үзсэн. Гахайн мах нь их амттай байсан шүү гэвэл би юм мэддэггүй царайлж:

- Тийм үү? гэвэл манаач:

- Бусад хоол нь амт муутай ч гахайн мах нь сайхан юм билээ. Тусгай тэжээл өгдөг байх аа? гэсэнд би анх удаа Токиогийн гахайн мах амттай болохыг дуулснаа ний нуугүй хэллээ.

- Та хэзээ Токиод очив?

- Хэдэн он юм бэ дээ? Ханхүү гэрлэсэн жил байх. Токиод байдаг хүү маань намайг урьсан юм.

- Тэр үед амттай байх нь аргагүй.

- Одоо амтгүй болсон хэрэг үү?

Би энэ тухай сайн мэдэхгүйгээ хэлбэл өвгөний сэтгэл гонсойх шиг боллоо. Манаач өвгөн хэд гурван үг солих сонирхолтой байсан ч би автобусандаа суухаар яаран гарав.

Зам дагуу хэсэг бусаг манан салхинд нүүнэ. Эргэн харж санаа алдан сэтгэлдээ гуниг тээсээр автобусанд суув. Ингээд оройн дөрвөн цаг хагаст оюутны байрандаа ирж, хувцсаа солиод Шинжюкүд байрлах пянзны дэлгүүр лүү ажилдаа гарлаа. Би зургаан цагаас арав гуч хүртэл дэлгүүрт ажилладаг байлаа.

Дэлгүүрийн цонхоор эрээлжлэн өнгөрөх гэр бүлийн хоёр, дурлалт хос, охид хөвгүүд, хиппи залуус, архичин гуйлгачин, баарны үйлчлэгч зэргийг нэг хэсэгтээ ажиглан суув.

Хард рок хөгжим тавьтал хэдэн хиппи залуу, будаг шингэлэгч үнэртэн мансуурах гуйлгачин байрын хүмүүс цугларч бүжиглэнэ. Харин Тони Беннетийн пянзыг тавьсанд тэд алга болов.

“Насанд хүрэгчдийн тоглоом” хэмээх хажуугийн дэлгүүрийн дунд хэрийн насны эр хэн, хэзээ хэрэглэх бол гэмээр элдвийн юм худалдах бөгөөд дэлгүүрт нь хүн амьтны хөл татрахгүй.

Гудамжны нөгөө захад над шиг нэг оюутан шартсан бололтой бөөлжинө. Эсрэг талын тоглоомын газарт хажуугийн зоогийн газрын тогооч бинго тоглох юм. Үүдээ барьсан нэгэн дэлгүүрийн үүдэнд царай нь харласан гуйлгачин сууна.

Уруулаа ягаанаар буцсан дунд сургуулийн сурагч охин орж ирээд Роллин Стоун-ы пянз тавиулж, хэсэг бүжиглээд надаас тамхи сураглав. Зохион байгуулагчийн үлдээсэн Lark тамхинаас нэгийг авч өгсөнд охин хээв нэг сороод, пянз эргэж дуусмагц гараад явчихав.

Гэнэт түргэн тусламжийн, эс бөгөөс цагдаагийн машины гэмээр дохио жингэнэж, халамцуу гурван эр тас тас хөхөрсөөр гудамжинд үзэгдэв. Энэ мэтийг харж суутал цайндаа гарсан зохион байгуулагч:

- Ватанабэ, уржигдар нөгөө хувцасны дэлгүүрийн сайхан амьтныг үзсэн шүү гэсээр эргэж ирлээ.

Зохион байгуулагч зэргэлдээх дэлгүүрийн худалдагч бүсгүйд унаж тусаад байн байн пянз бэлэглэдэг байлаа.

- Хөөх, баяр хүргэе! гэвэл мань хүн үйл явдлаа нэгд нэгэнгүй хүүрнэж эхэллээ.

- Бүсгүй хүнийг өвөртөө оруулья гэвэл бэлэг сэлтээр дарж байгаад согтоох хэрэгтэй. Тэгээд л өвөртөө оруулчихна. Хялбархан даа.

Энэ өдрийн ажил тарж байрандаа ирвэл эл хуль. Унтахаар хэвтээд Наоко хэзээ мөдгүй өвөрт минь ороод ирэх шиг сэрвэлзлээ. Нүдээ анивал Наокогийн зөөлөн бие, энгэр цээж, халуухан амьсгал, моддын үнэр, бороон чимээ сэтгэлд тэмтрэгдэх шиг. Тэргэл сартай тэр нэгэн шөнө өмнө минь нүцгэлсэн Наоког санаж, шаргал цуваа нөмрөөд шувууны байр цэвэрлэх нь нүдэнд үзэгдэнэ. Жигтэйхэн ядарсан ч унтаж чадсангүй. Орноосоо босч цонхоор хараад, Наоког яаж шуухан байгаа бол хэмээн бодлоо. Наоко үл ойлгогдох тэрхэн ертөнцдөө нойрсож буй. Тэр минь сэтгэлийг нь эмтлэх хар дарсан зүүд л бүү зүүдлээсэй билээ.

Долоодугаар
БҮЛЭГ

Амирёгоос ирсний маргааш биеийн тамирын хичээл орж, би тавин метрийн усан санг хэд хэдэн удаа хөндлөн гулд сэлэв. Эрчтэй дасгал хөдөлгөөн толгой тархи сэргээж ходоод хонхолзлоо.

Оюутны гуанзанд ахиухан хоол идэж, хүмүүнлэгийн тэнхимийн номын сан орвол Мидоритой тааралддаг юм байна. Мидори нүдний шилтэй нэг бүсгүйтэй хамт явж байсан ч намайг хармагцаа:

- Хаачих нь вэ? гэсээр дөхөж ирлээ.

- Номын сан ордог юм уу.

- Дараа бол оо. Явж хоол идье.

- Би дөнгөж сая юм идсэн.

- Дахиад идчих л дээ.

Ингээд бид хоёр хажуугийн цайны газар орж Мидори карри авч, би кофе уулаа. Мидори цагаан даавуун цамцан дээрээ шар ноосон хантааз өмсөөд нарийхан алтан гинж, Диснейн цаг зүүжээ. Карригаа ум хумгүй идээд гурван аяга усаар даруулав.

- Чи ойрын хэд хоног хаа яваа вэ? Би чам руу хэд хэд залгасан.

- Хэрэг гараа юу?

- Үгүй ээ. Зүгээр л залгасан юм.

- Аан.

- Юу аан гэж?

- Юу ч биш ээ. Зүгээр. Танай тэр хавьд өөр юм шатаагүй биз дээ?

- Шатаагүй ээ. Тэр өдөр ч хөгжилтэй байсан шүү. Утаа хаялаад сүрдмээр.

Мидори усаа гуд гудхийн залгилаад, амьсгаа авч намайг харна.

- Ватанабэ, чи чинь яачихсан юм бэ? Байдгаараа барайчихаж.
Сэтгэлээр унасан амьтан шиг л байх юм.

- Зүгээр дээ. Аяллаар яваад ядраа байлгүй.

- Хий үзэгдэл харсан юм шиг л байх юм. Үдээс хойш хичээлтэй юу?

- Герман хэл, теологийн хичээлтэй.

- Тасалж болно биз дээ?

- Герман хэл дээр тесттэй болохоор болохгүй ээ.

- Хэзээ тарах юм бэ?

- Хоёр цагт.

- Тарсны чинь дараа хот орж нэг газар сууя.

- Өдрийн хоёр цагт уу?

- Хааяа болно биз дээ? Юм увал сэтгэл чинь сэргэнэ.

- Би ч уумаар байна. Явъя л даа гэсэнд санаа алдан:

- Явъя аа гэлээ.

- Тэгвэл хоёр цагт хүмүүнлэгийн тэнхимийн үүдэнд хүлээж байя.

Герман хэлний хичээлийн дараа бид хоёр автобусаар Шинжюкү хүрч,
Кинокүниягийн номын дэлгүүрийн доорх DUG хэмээх бааранд ороод,
тониктой зуу татлаа.

- Өдөр ууж суухад амар болохоор би хааяа энд ирдэг юм.

- Өдөр болгон уудаг юм уу?

- Хаа нэг. Амьдрал утга учиргүй санагдсан үедээ ууна аа.
- Утга учиргүй санагддаг гэнэ ээ?
- Заримдаа тэгдэг юм. Элдвийн асуудал байна аа.
- Жишээ нь ямар?
- Гэр бүл, найз залуу, сарын тэмдгийн мөчлөг алдагдах гээд л бий бий.
- Дахиад нэгийг авах уу?
- Тэгье.

Зөөгч дуудаж архи, ус захиаллаа.

- Тэр өдөр, бүтэн сайнд чамд үнсүүлээд сайхан байсан шүү.
- Сайхан байсан бол болж дээ гэвэл Мидори үгийг минь давтаж:
- Чи гэж хэг ёг хийсэн яриатай хүн юмаа гэсэнд би:
- Тийм гэж үү? гэхээс өөр юм хэлсэнгүй.
- Тэр үнсэлт анхны минь үнсэлт байсан бол хачин сайхан байлаа гэж бодсон шүү. Цаг хугацааг эргүүлэх шидтэй сэн бол тэр үнсэлтийг анхныхаа үнсэлт болгох байлаа. Энэ хорвоод хүн болж мэндэлснээс хойш анх үнсэлцсэн Ватанабэ минь одоо тавин наймтай. Яаж яваа бол? гээд л бодож суух байлаа. Гоё биз дээ?
- Гоё юмаа гэж хариулах зуураа би самар хальсалж суув.
- Ватанабэ, яагаад уруу царайлаа вэ?
- Энэ хорвоог ойлгож ухаарахгүй юм. Бүх зүйл нэг л хуурамч санагдах юм.

Мидори эрүүгээ тулж суугаад над руу ширтлээ.

- Жим Морисон ингэж дуулдаг байх аа.

People are strange when you are a stranger.

- Яг зөв. Их сургууль, гэр бүл, найз нөхдөө орхиод хамт Уругвай руу явбал ямар вэ?

- Дажгүй л санаа байна.

- Хааяадаа ч бүхнээ орхиод, огт танихгүй газар очмоор санагдах юм. Чамтай хамт холоо явж, тугал шиг эрүүл чийрэг хөөрхөн хүүхдүүд төрүүлж өгөөд жаргалтай амьдрах сан. Хүүхдүүд маань гэрээр гүйлдээд л.

Би тэсэлгүй инээд алдан гуравдахь хундагаа хөнтөрлөө.

- Хүүхэдтэй болохыг хүсдэггүй юм уу?

- Ямар хүүхэд гарах бол гэхээс сонин л байна.

Мидори самар идэнгээ:

- Хүсэхгүй бол тэр л биз. Жаахан уусан чинь толгой эргээд элдвийн юм ярьчихлаа. Гэхдээ Уругвайд ч амьдрал энэ янзаараа.

- Магадгүй ээ.

- Дэлхий бөөрөнхий хойно хаа сайгүй ялгаагүй.

Мидори бид хоёр газрын самар идэж суулаа.

- Тэр өдөр чамтай хамт тагтан дээр гарч түймэр ажиж, шар айраг уугаад, дуу дуулж суухад сэтгэл амарсан шүү. Тэгж амралгүй их удаж. Эргэн тойронд нэг л шахаж шаардсан хүмүүс. Харин чи өөр.

- Хоёулаа хэн хэнээ шахаж шаардахаар дотносоогүй шүү дээ.

- Тэгвэл дотноссон хойноо бусдаас ялгаагүй шахаж шаардах нь ээ дээ?

- Магадгүй л юм. Хүмүүс ингэж л амьдардаг.
- Чи тийм хүн биш ээ. Үзэл бодлоо хүнд тулгаж, эсхүл хэн нэгний нөлөөнд орохгүй гэдгийг чинь зөнгөөрөө мэдэж байна. Тийм ч учраас хажууд чинь сэтгэл амар байдаг. Өрөөл бусдыг дарамталж, өөр нэгний шахалтанд орсон хүмүүс хааяагүй л бий. Энэ болгонд дургүй хүрэх юм.
- Чамаас хүмүүс юу хүсдэг юм бэ? гэвэл Мидори мөс хүлхээд:
- Намайг илүү сайн мэдмээр байна уу?
- Мэдмээр байна.
- Дургүй хүрсэн ч хамаагүй мэдмээр байна уу?
- Чи хүний дургүй хүргэхээр муу хүн гэж үү?
- Зарим талаараа тийм ч байж магад. Дахиад нэг нэгийг ууя гээд захиалга өгөх зуур Мидори шанаагаа тулна. Кафед Thelonious Monk хамтлагийн Honeysuckle rose дуу эгшиглэх бөгөөд биднээс гадна тав зургаан хүн суух юм. Гэсэн ч Мидори бид хоёр л архи ууна.
- Чи энэ бүтэн сайнд завтай юу?
- Орой зургаа хүртэл завтай гэж хэлж байсан даа.
- Тэгвэл хоёулаа уулзъя.
- Тэгье.
- Өглөө байранд чинь очъё. Хэдийд очихоо хэлж мэдэхгүй нь. Гэхдээ хүлээж байгаарай.
- Мэдлээ.
- Ватанабэ, би яг одоо юу хүсч байна гээч?
- Ёстой бүү мэд.

- Юун түрүүнд зөөлөн, том орон дээр хэвтмээр байна. Хажууд минь чи хэвтээд, хувцсыг минь аажуухан тайлаад л. Яг л эх хүн нялж хүүхдийнхээ хувцсыг тайлах мэт болгоомжтой.

- Хмм...

- Надад таалагдсан ч би гэв гэнэт ухаан орсон юм шиг “Ватанабэ, боль. Би чамд сайн ч найз залуутай. Боль л доо” гэхэд чи ер тоосон шинжгүй.

- Би ч тэгвэл болино оо.

- Мэдэж байна аа. Мөрөөдөхөд мөнгө төлдөггүй гэдэг биз дээ? Дараа нь чи надад нөгөөдөхөө харуулна. Тэгмэгц нь би нүднийхээ булангаар харсан ч “Ватанабэ, болиоч. Ийм том, хатуу юм яаж орох вэ?” гээд л харцаа буруулна.

- Минийх том биш ээ. Байдаг л хэмжээтэй.

- Мөрөөдөж байхад тэр ямар хамаа байна аа? Тэгээд чамайг уруу царайлахад би “Хөөрхий амьтан” гээд л аргадна.

- Тэгээд яг одоо ингэмээр байгаа юм биз дээ?

- Аахан.

Би “Ямар аймаар юм бэ?” гээд тэсэлгүй инээлээ.

Тэр өдөр бид хоёр тав таван хундага архи уусан юм. Тооцоо хийх гэсэнд Мидори гарыг минь тас хийтэл алгадаж түлхээд:

-Ч амайг дуудсан болохоор би тооцоо хийнэ ээ. Тэгээд ч ажлынхаа хөлсийг авсан байгаа. Гэхдээ эмэгтэй хүн даах дургүй фашист байсан бол өөрөөр ярина шүү гэсээр шоо шинэ арван мянгатын дэвсгэрт гаргаж ирээд -Тэгээд ч чи эр хүний үүргээ биелүүлээгүй гэсээр зөөгчид өглөө.

- Минийх хатуу, том гэдгийг чи мэднэ дээ гэхэд Мидори:

- Мэднэ ээ. Хатуу, том гэсээр гарч явлаа.

Мидори ялимгүй халамцаж, шат хий гишгээд золтой л унасангүй. Тэртээ дээр цэнхэртэж, жаргах нарны улбар туяа тусчээ. Мидори бид хоёр Шинжюкүгээр зугаалахад тэр модон дээр авирахаар зүтгэв. Хааны цэцэрлэгт хүрээлэн үүдээ барьсан тул хоёул гудамж сүлжин, дэлгүүрийн шилэн хорго харан алхлаа.

- Чамтай уулзаад энэ хорвоо арай дээрдэх шиг боллоо гэвэл Мидори өөдөөс минь ширтээд:

- Тийм байна. Нүд чинь сэргэчихэж. Надтай уулзах тустай байгаа биз?

- Тустай юмаа.

Тав гучид Мидори харьж оройн хоолоо бэлдэнэ гэхэд би байрандаа автобусаар буцах тул Шижюкүгийн буудалд хүргэж өгөөд хоёул тэндээс саллаа.

Мидори явахаасаа өмнө:

- Би яг одоо юу хүсч байна гээч? гэсэнд:

- Бодлыг чинь таахын аргагүй гэлээ.

- Хоёулаа далайн дээрэмчдэд баригдаад, тэд биднийг нүцгэлж, өөд өөдөөс нь наалдуулж зогсоогоод олсоор хүлчихнэ.

- Тэгж яах нь вэ?

- Завхай дээрэмчид.

- Чи ч тэднийг дагуулахгүй шиг ээ.

- Бас болоогүй цагийн дараа хоёуланг минь далайд шидэх тул энэ янзаараа ханатлаа цэнгэ гээд агуулахад орхиод явчихна.

- Тэгээд?

- Хоёулаа цагийн турш ханатлаа жаргана. Ийш тийш өнхрөөд л, биеэ займчаад л...

- Одоо үүнийг л хүсч яваа юм биз дээ?

- Тийм ээ гэсэнд би:

- Тийм бий гэсээр толгой сэгсэрлээ.

Мидори ням гарагийн өглөө ес хагаст ирлээ. Хэвтэж байтал байрны залуу “Ватанабэ, чамтай нэг охин уулзана гээд ирчихэж” гэж хашгирвал гараад очтол Мидори богинохон банзал өмсч, хөлөө ачаад эвшээгээд сууж байлаа. Өглөөний цайндаа гарах залуус Мидоригийн тэгшхэн хөлөнд нүд унагана. Хөл нь аргагүй сайхан юм.

- Арай эрт ирчихэв үү дээ. Чи босоогүй байв уу?

- Гар нүүрээ угаагаад, сахлаа хусаад буугаад ирье. Арван таван минут хүлээж бай, болох уу? гэвэл Мидори:

- Болно оо. Харин энэ залуучууд хөл хараад болохгүй байна.

- Эрчүүдийн дотуур байранд ийм богинохон банзалтай ирэхэд тэгэлгүй дээ.

- Тэгэхдээ гоё дотуур өмд өмссөн болохоор зүгээр. Ягаан торон... гэсэнд би:

- Тэгвэл бүр ч нүд унагана гээд толгой сэгсэрсээр өрөөндөө орлоо.

Өрөөндөө орж гар нүүрээ угаагаад, сахлаа хусч, цэнхэр товчтой цагаан цамцан дээр саарал даавуун хүрмээ өмсөөд Мидоритой гарав. Хүйтэн хөлс цутгасан гэж жигтэйхэн.

- Хүүе, энэ залуучууд бүгдээрээ гар хангалга хийдэг гэж үү?

- Бараг л бүгд.

- Тэгээд гар хангалга хийхдээ эмэгтэй хүн боддог уу?

- Тэгэх байлгүй дээ. Үнэт цаас, үйл үгийн хувирал, Суэцийн суваг бодоод таашаал авдаг эр хүн гэж байдаггүй биз дээ?

- Нэг тодорхой эмэгтэйг төсөөлдөг үү?

- Чи найз залуугаасаа асуу. Би чамд ийм юм ярих хүн мөн үү, биш үү?

- Сониучирхаад л асуулаа. Ийм юм асуухаар найз залуу маань бүсгүй хүн ийм юм мэдэж яах нь вэ? гээд уурлаад байдаг юм.

- Зөв л хэлсэн байна.

- Сонин байна шүү дээ. Жишээ нь, чи гар хангалга хийхдээ нэг бүсгүйг төсөөлдөг үү?

- Би бол тэгдэг. Харин бусад нь юу төсөөлдгийг мэдэхгүй юм.

- Намайг төсөөлж байсан уу? Үнэнээ хэлээрэй. Би гомдохгүй.

- Үгүй ээ.

- Би тийм царай муутай юм уу?

- Үгүй дээ. Чи сэтгэл татам, хөөрхөн. Тэгээд ч энэ зан ааш чинь чамд зохидог.

- Тэгвэл яагаад намайг төсөөлдөггүй юм бэ?

- Чамайг анд нөхрөө гэж боддог болохоор сексийн элдэв төсөөлөлдөө хольж хутгамааргүй байна. Тэгээд ч...

- Төсөөлөх хүнтэй юм биз дээ?

- Тийм гэх үү дээ.

- Ийм ёс суртахуунтай болохоор л чи надад таалагддаг. Гэхдээ өнөө орой ч юм уу, нэг удаа намайг төсөөлөөд үзээч. Би ямар өөр хүнээс гуйлтай биш. Үнэндээ бид хоёр нэг хөнжилд орж болохгүй.

- Би үүрэг даалгавар авсан шиг гар хангалга хийж үзээгүй ээ.

- Үзээд алдаач.

- Тэгэхээс.

- Ватанабэ, намайг гаж донтой ч юм уу, хүн өдөх дуртай гэж битгий бодоорой. Охидын сургуульд сурч байсан болохоор эрчүүдийн тухай сайн мэдмээр байх юм. Эмэгтэйчүүдийн сэтгүүлд энэ тухай дорвитой юм бичдэггүй. Туршлага суумаар байна гэх үү дээ. Найз залуудаа хэлэхээр шүлсээ хаялаад “Гаж донтой юмтай юм уу?” гээд уурлана. Амаараа үзье гэхээр ерөөсөө зөвшөөрдөггүй.

- Хм.

- Чи бас дургүй юм уу?

- Дургүй гэх нь ч хаашаа юм бэ.

- Тэгвэл дуртай юу?

- Дуртай л даа. Хоёулаа одоо ийм юм ярихаа больё. Өөр зүйл ярья. Найз залуу чинь манай сургуульд сурдаг уу?

- Үгүй ээ. Өөр сургуульд. Ахлах сургуульд дугуйланд явж байхдаа танилцсан. Сургуулиа төгсөөд үерхэж эхэлсэн. Ватанабэ, чи...

- Юү гэж?

- Дараагийн удаа намайг төсөөлөөрэй.

Би аргаа бараад:

- Хичээе ээ гэлээ.

Бид хоёр метронд сууж Очяномизү орлоо. Өглөөний цайндаа орж амжаагүй учраас би Шинжюкүгийн буудлаас унаа сэлгэх зуураа сэндвич идэж, кофе авлаа.

Ням гарагийн өглөө метрогоор дүүрэн зугаалгаар явах гэр бүл, дурлалт хосууд, бейсболын цохиуртай хүүхдүүд явна. Богино банзалтай бүсгүйчүүд байсан ч Мидоригийнхоос арай урт юм.

Мидори байн байн банзлаа доошлуулах ч ер санаа зовсон шинжгүй. Хэдэн залуус хөлөнд нь нүд унагаж явсанд эвгүй санагдлаа.

Ичигая хүрэхэд Мидори:

- Би сая юу бодсон гээч? гэдэг юм байна.

- Бурхан минь, энэ хүмүүсийн чих алт болно шүү дээ гэвэл Мидори:

- За, за. Жигтэйхэн гоё юм санаанд орсон юмсан гэсээр санаа алдлаа.

- Очяномизүд хаа хүрэх юм бэ?

- Очоод мэднэ ээ.

Очяномизүгийн гудамж урьдчилсан шалгалт, бэлтгэл ангийн хичээлд суухаар ирсэн дунд сургуулийн сурагчдаар дүүрчээ. Мидори нэг гартаа цүнхээ барьж, намайг хөтөлсөөр шуугисан олны дундуур гарлаа.

- Ватанабэ, чи англи хэлний үйл үгийг өнгөрсөн, одоо цагаар хувиргаж чадах уу? хэмээн гэнэт асуусанд би:

- Чадах байлгүй дээ гэвэл Мидори:

- Наадах чинь өдөр тутмын амьдралд хэрэг болох уу? гэдэг юм байна.

- Өдөр тутмын амьдралд хэрэг болох нь бага ч гэлээ сэтгэлгээ хөгжүүлж, юм тогтооход дөхөм болдог биз гэвэл тэрээр хэсэг зуур бодолхийлээд:

- Чи ёстой мундаг юмаа. Би энэ үйл үгийн хувирал, дифференциал, Менделеевийн хүснэгт зэргийг ер тоодоггүй явж. Буруу л бодож байж дээ?

- Тоодоггүй байсан?

- Тийм ээ. Синус, косинусыг ч мэдэхгүй.
- Тэгээд яаж яваад сургуулиа төгссөн юм бэ дээ?
- Ватанабэ минь, жаахан мэдрэмжтэй, сэргэлэн байхад их сургуулийн шалгалт шиг амархан юм үгүй. Би ч айхтар совинтой шүү. Гурван хариултаас зөвийг нь сонгох бол бодож байгаад л бөглөчихдөг.
- Би чам шиг сэргэлэн биш ээ. Хичээлээ давтаж, системчлэн тогтоохгүй бол горьгүй. Шаазгай модны хөндийд шилний хагархай цуглуулдаг шиг л.
- Ингэлээ гээд дараа нь хэрэг болох уу?
- Харин л дээ. Заримдаа ч тусаа өгнө дөг өө.
- Жишээ нь ямар тохиолдолд?
- Метафизикийн шинжлэх ухаан, гадаад хэл сурахад ингэх нь чухал. Тэр үедээ хэрэг нь гарахгүй ч ингэснээр хүн гэдэг амьтан тархи толгойгоо сэргээж, амьдралд хөл тавихад суралцдаг шиг санагддаг юм.
- Чи юм тайлбарлахдаа гаргууд юмаа. Энэ тухай олон хүнээс асууж байсан ч хэлэх юмаа олж ядаад “Тэнэг юм уу?” гэсэн шиг л хардаг. Чи Капитал-ыг уншсан уу?
- Дуусгаагүй ээ. Бусдын адил талыг нь уншсан.
- Тэгээд ойлгосон уу?
- Хэсэг бусаг ойлгосон. Гэхдээ марксизмыг ойлгохын тулд бас бус мэдлэгтэй байх шаардлагатай.
- Ийм юм уншиж үзээгүй нэгдүгээр курсийн оюутан Капитал-ыг ойлгох болов уу?
- Бараг л ойлгохгүй вий.

- Би их сургуульд ормогцоо дуулах хүсэлдээ хөтлөгдөж фолк клубт бүртгүүлэв ээ. Тэгсэн тэр клуб гэж хачин сонин амьтад цугласан газар болж таарлаа. Фолк урсгал нийгэмтэйгээ хөл нийлүүлэх учиртай гээд Марксын ботийн нэг хэсгээс унш гэдэг юм байна. Гэртээ ирээд уншсан чинь юу ч ойлгодоггүй. Маргааш нь клубын цугларалт дээр юу ч ойлгосонгүй гэсэн чинь намайг нийгмийн ухамсаргүй, тэнэг амьтан гэцгээх болсон доо. Ном ойлгоогуй гэсний төлөө арай дэндүү биз?

- Харин тийм байна.

- Тэр тухайгаа чухал царайлаад, их юм мэддэг шинжтэй ярилцахыг нь яана. Би ойлгохгүй болохоор “Наад яриад байгаа империалист мөлжлөг гээч чинь юу юм бэ? Зүүн Энэтхэгийн компанитай ямар нэг сэжмээр холбоотой юу? Educational-industrial complex-ийг үгүй хийнэ гэхээр их сургуулиа төгсөөд компанид ажилд орж болохгүй гэсэн үг үү?” гээд асуухаар тайлбарлаж өгөхгүй загнах нь халаг.

“Ийм юм ойлгохгүй байж өдөр хоногийг яаж өнгөрөөдөг байна аа, Мидори” гээд л. Тийм юм гэж хаа байхав. Би толгой сайтай биш, жирийн л хүн. Эцсийн эцэст энэ орчлон хорвоог над шиг жирийн хүмүүс л хөдөлгөж явдаг даа? Энгийн хүмүүсийн ой тойноос хэтийдсэн үг яриагаар өөрчлөлт шинэчлэл хийх нь юу л бол. Нэг нэгнээ дарлаж, мөлжиж болохгүй гэдгийг мэддэг болохоор тэр хэцүү нэр томъёонуудыг нь лавлаж асуудаг байлаа.

- Тэгээд юу болсон бэ?

- Тэднийг сайхан үг ярьсан худалч, мулгуу амьтад юм л гэж бодсон. Жигтэйхэн уран илтгэх хэрнээ үнэндээ нэгдүгээр курсийн охидын хормой хотон доогуур орохоос өөр юм бодох чадваргүй. Дөрөвдүгээр курсэд ороод үсээ тайруулж Мицүбиши, IBM, TBS эс бөгөөс Фүжи банканд ажилд ороод, Марксын тухай дуулаа ч үгүй бүсгүйтэй гэрлэж, үр хүүхэдтэй болоод жигтэйхэн гоё нэр хайрлана. Тэр яриад байсан өөрчлөлт шинэчлэлтийг нь бодохоор инээд хүрмээр. Нэгдүгээр курсийнхэн ч ихэнх нь дүр эсгэсэн хүмүүс. “Ойлголоо, мэдэж байна” гээд л толгой дохиод бай гэнэ дээ. Нэг удаа бүр хачин юм болсон. Ярьчих уу?

- Тэг л дээ.

- Тэр орой цуглаантай байсан юм. Тэгээд бүсгүйчүүдийг хорь хорин о-нигири (будаатай ороомог, орч) хий гэдэг юм байна. Нөгөө яриад байсан эмэгтэйчүүдийн эрхээ зөрчсөн байгаа биз? Гэсэн ч би ундууцаад яахав гэж бодоод даршилсан чавгатай ороомог хийгээд очлоо. Тэгсэн нөгөөдүүл чинь Мидори будаандаа чавганаас өөр юм хийгээгүй, холиод идчихмээр юм авчраагүй гэдэг байгаа. Зарим охид ороомгондоо загас, түрс хийж, өндөг шараад авчирсан байж л дээ. Өөрчлөлт шинэчлэлт гээд том том ярих мөртлөө авчирсан ороомгийг голоод л. Тийм л байсан бол Энэтхэгийн тэр олон өлсөж ундаассан хүүхдүүдийг бодож болно шүү дээ.

Би тэсэлгүй инээд алдлаа.

- Тэгээд тэр клубээ яасан бэ?

- Дургүй хүрээд зургадугаар сараас гарсан. Манай сургуулийнхан гэж толгой хоосон гэж хэлүүлэхгүй гэсэндээ юм мэддэг царайлсан хүмүүс. Бүгд л нэг ижил ном уншиж, Жон Колтрейнийг сонсож, Пазолинигийг киног үзнэ. Энэ чинь өөрчлөлт шинэчлэл мөн үү?

- Харин... Нүдээрээ үзээгүй болохоор хэлж мэдэхгүй юм.

- Тэр өөрчлөлт шинэчлэл гээч нь энэ юм бол надад лав хэрэггүй. Будаандаа чавганаас өөр юм хийгээгүй гээд намайг буудаж мэдэх л улс. Чамайг ч юмны учир начир ойлгодог гээд буудчихаж магадгүй.

- Магадгүй л юм.

- Ватанабэ минь, бидэн шиг жирийн хүмүүс хувьсгалтай хувьсгалгүй амьдарсаар л байх болно.

Хувьсгал гарлаа гээд энд тэндхийн нэр хаяг өөрчлөгдөхөөс өөр юмгүй. Тэр том том ярьдаг улс үүнийг ойлгохгүй юм даа. Чи татварыг байцаагчтай уулзаж явсан уу?

- Үгүй ээ.

- Манайд хэд хэд ирж байсан. Хаалга тогшилгүй орж ирээд омгорхож гарна. “Та нар чинь худалдаа наймаа хийдэг юм уу, юү хийдэг юм бэ? Тайлан ч гэж авах юмгүй. Үүнийг зарлага гээд байгаа юм уу? Алив, баримтуудаа аваад ир” гээд л их дээрэнгүй. Бид хэд буланд шигдээд л, оройн хоолны цаг дөхмөгц дээд зэргийн сүши захиалж дайлна. Гэхдээ аав маань нэг ч удаа татвараас бултаж яваагүй. Ном ёсоор нь төлдөг. Их хуучинсаг хүн. Гээд татварын байцаагчид “Ашиг муутай л байна даа” гээд байн байн ирэхийг нь яана. Сонсоод суух нь ээ, шар хөдөлж “Манайхаас чинээлэг айлд очоод наад үгээ хэлээч” гэж хашгирмаар санагдана. Хувьсгал гарвал татварынхан нүүрээ хувиргах байх даа.

- Тэр ч юу л бол.

- Тэгвэл хувьсгал хийгээд хэрэг байна уу даа. Би харин хайр дурлалд итгэдэг шүү.

- Хоёулаа хаа хүрч явна?

- Эмнэлэгт очно. Аав эмнэлэгт хэвтсэн. Өнөөдөр би сахих ээлжтэй.

Би гайхсандаа:

- Аав чинь Уругвай яваагүй бил үү? гэхэд Мидори хүүхэд шиг царайлаад:

- Худлаа ярьсан юм. Уругвай явна гэж эртнээс ярьдаг боловч Токиогоос гарч чадахгүй болсон.

- Бие нь гайгүй юу?

- Хоног өдрөө хүлээж байгаа гэхэд болно.

Хоёул хэсэг чимээгүй алхлаа.

- Хоёр жилийн өмнө ээж минь энэ өвчнөөр өөд болсон учир би сайн мэднэ. Аав бас тархины хавдартай болчихно гэж хэн санах вэ?

Ням гараг болоод ч тэр үү, их сургуулийн эмнэлгийн хашаанд эргэлтээр ирсэн хүмүүс, хөнгөн өвчтөнүүд зугаална. Ариутгах бодис,

цэцэг жимс, эм тан холилдсон эмнэлгийн үнэр ханхийж байлаа.
Сувилагч бүсгүй өсгийгөөрөө тог тог хийн үүдээр орно.

Мидоригийн аав хоёр ортой өрөөний үүдэн талын орон дээр
Рингерийн уусмал залгуулаад хажуулдан хэвтэнэ. Бие жижигтэй,
туранхай хүн юм.

Толгойдоо боодолтой, гаран дээр нь хаа сайгүй зүүний мөр үзэгдэнэ.
Бид хоёрыг ороход улайсан нүдээрээ хэдэн хором ажиглаад хажуу
тийш гөлрөв. Нүднийх нь гал бөхөж, тамир тэнхээгүй болсон нь илт.
Эд хогшлыг нь зөөж гаргаад хэзээ мөдгүй нураах хуучин байшингаас
ялгамгүй.

Хатсан уруул дээгүүр нь хэдэн сахал цухуйжээ. Амьдралын эрч хүчгүй
болсон ч сахал үс нь ургаад байх юм даа гэсэн бодол толгойд оров.

Мидори цонхны хажуугийн орон дээр хэвтэх хижээл эртэй мэндлэхэд
нөгөө эр ярьж чадахгүй бололтой инээмсэглээд толгой дохино. Хижээл
эр хэд ханиалгаж, орны толгойд тавьсан аягатай уснаасаа хэд балгаад
цонх руу эргэж харлаа. Бүртийх ч үүлгүй цэлмэг тэнгэр, цахилгаан
дамжуулах шугамнаас өөр юм цонхоор харагдсангүй. Мидори аавдаа
ойртоод:

- Таны бие гайгүй юу? гэвэл аав нь:

- Яахав ээ. Толгой... гэж хэлэхдээ арай ядан ам нээж байгаа нь илт.

- Толгой нь өвдөөд байна уу?

- Тийм ээ.

Аав нь олон үг хэлэх тэнхэлгүй болжээ.

- Дөнгөж хагалгаа хийлгэсэн болохоор өвдөх нь мэдээж. Жаахан
тэсээрэй. Энэ миний найз Ватанабэ.

- Сайн байна уу? гэхэд аав нь намайг харж ам ангайсан ч үг хэлсэнгүй.

Мидори орны хажууханд байх хулдаасан зөөлөвчтэй сандал дээр намайг суу гэлээ. Мидори аавдаа ус уулгаж, жимс идэх үү гэсэнд аав нь татгалзлаа. Жаахан ч гэсэн юм идэх хэрэгтэй гэвэл аав нь саяхан юм идсэн гэх аж.

Орны толгойн ширээн дээр данх, аяга, жижигхэн цаг байна. Мидори ширээн доорх уутнаас цэвэрхэн дотуур хувцас гаргаж ирээд үүдний хажуугийн шүүгээнд хийв. Уутанд хоёр тоор, жимсний цэлцэгнүүр, гурван өргөст хэмх байсанд:

- Өргөст хэмхээр яадаг байна аа? Эгчид утсаар хэлээд байхад өргөст хэмх авч яах нь вэ? гэв.

Киви гэснийг чинь кюри (японоор өргөст хэмхийг кивитэй бараг ижил кюри хэмээдэг, орч) гэж сонссон юм байлгүй гэвэл Мидори:

- Тийм л байх. Тэгсэн ч өвчтэй хүн өргөст хэмх идэхгүй гэж мэдмээр дээ. Аав аа, өргөст хэмх идэх үү?

- Үгүй ээ.

Мидори орны толгойд суугаад зурагт нь эвдэрч засварчин дуудсан, Такайдогийн нөгөө эмэгтэй хэд хоногоос эргэж ирнэ, эмийн сангийн Миява дугуйтай явж байгаад онхолдсон гээд ойр зуурын юм ярихад аав нь дуугүй л толгой дохино.

- Аав аа, юм идэхгүй юм уу?

- Үгүй ээ.

- Ватанабэ, чи тоор идэх үү?

- Үгүй ээ.

Удалгүй Мидори намайг амралтын өрөө рүү дагуулж ороод тамхи татлаа. Энд гурван эр зурагтаар ярилцлага үзэж сууна.

- Тэр суга таягтай цэнхэр хувцастай, нүдний шилтэй нөхөр хөлөнд минь нүдээ унагаах нь ээ.

- Ийм богинохон банзалтай байхад харалгүй дээ.

- Энэ уйтай газар залуу бүсгүйн хөл гар харахад гэмгүй. Сэрэл нь хөдлөөд хурдан илаарших ч юм бил үү?

- Эсрэгээрээ болчихгүй л байгаасай.

Мидори тамхины утаа ажиглан ийн ярьлаа.

- Аав маань сайн хүн. Үе үе хачин аяглах ч сэтгэл сайтай, ээжийг үнэн сэтгэлээсээ хайрладаг байсан. Худалдаа наймаанд одтой гэхээргүй ч зөв амьдарсан. Худал ярьж, хуурч мэхэлж хөрөнгө мөнгөтэй болсон хүмүүсээс хувь илүү. Би зөрүүд зантайдаа аавтайгаа муудалцана аа. Гэхдээ аав минь муу хүн биш ээ.

Мидори гарыг минь авч хөлөн дээрээ тавьж, хэсэгтээ өөдөөс ширтэв.

- Ватанабэ, эмнэлэгт эвгүй ч гэлээ надтай жаахан суугаач.

- Тав хүртэл сууя. Би чамтай байх дуртай. Тэгээд ч өөр хийх юм байх биш.

- Чи бүтэн сайнд ер нь юү хийдэг вэ?

- Хувцас хунараа угааж индүүднэ.

- Ватанабэ, чи найз охиныхоо тухай ярихгүй юм уу?

- Ярихад хэцүү. Яаж хэлэхээ мэдэхгүй байна.

- Тэгвэл би найз охиныг чинь яаж төсөөлдгөө хэлэх үү?

- Тэгээч. Найз охиныг минь ямар хүн гэж боддог вэ?

- Чи нөхөртэй хүнтэй уулздаг байх.

- Юу?

- Гучин нэг, хоёртой чинээлэг айлын дэгжин хүүхэн байх. Булган шуба, Чарльз Жорданы гутлаар гангардаг.

Торгон дотуур хувцас өмсдөг, хуял тачаалаа барьж дийлдэггүй. Тэгээд элдвийг туршдаг. Ажлын өдрүүдэд өдрийн цагаар чамтай уулзаад, бүтэн сайнд нөхөр нь байх тул гэртээ суудаг. Зөв үү?

- Ёстой ярив аа.

- Гараа хүлүүлж, нүдийг чинь боогоод биеэ нилэнхүйд нь үнсүүлдэг байх. Тэгээд элдэв янзаар амраглаж, зураг хөргөө даруулдаг.

- Хөгжилтэй л юм.

- Сексийн хувьд ханаж цадахгүй тул элдвийг эрэлхийлж, “Ватанабэг дараа ирэхэд ингэнэ ээ” гээд л сууна. Тэгээд та хоёр нэг удаадаа янз бүрийн байрлалаар хоёр, гурван удаа хурьцдаг биз. “Би сайхан биетэй байгаа биз? Залуу охид чамд таалагдахгүй дээ. Ямар байна?” гээд л.

- Чи ч порно кино их үзжээ дээ.

- Магадгүй л юм. Би порно кинонд дуртай. Дараа хамт үзье, тэгэх үү?

- Завтай бол үзье.

- Нээрээ гэж үү? Садо-мазохист маягийн кино үзье. Болно биз дээ?

- Тэгье.

- Ватанабэ, порно кинотеатрын юу нь надад таалагддаг гээч?

- Юу нь?

- Кино үзэж байгаа хүмүүс шүлсээ залгих нь.

Ингэж хэлээд Мидори бид хоёр өрөөнд буцаж орлоо.

Мидори элдвийн юм шулганаж, аав нь аан, уун гэх агаад нэг тийшээ гөлөрч хэвтэнэ.

Арван нэгэн цагийн үед нөгөө эрийн эхнэр ирж, нөхрийнхөө хувцсыг солиод жимс цэвэрлэж өгөв. Ааштай байрын энэ хүүхэн Мидоритой хэд гурван үг солилоо.

Удалгүй сувилагч Рингерийн уусмалыг нь шинэ уусмалаар сольж, Мидори, нөгөө хүүхэн хоёртой хэсэг ярилцаад гарав. Би хийх юмгүйдээ өрөөг нь ажиглаж, цонхоор харж суулаа. Мидори аавынхаа хөлсийг арчиж, амыг нь цэвэрлэнгээ дуслыг нь шалгаж, нөгөө хүүхэн бид хоёртой үг солино.

Арван нэг гучид эмч ирж, Мидори бид хоёр түүнийг дагаж гарав.

- Эмч ээ, аав ямар шуу байна даа?

- Хагалгаа хийгээд удаагүй. Өвчин намдаах тариа тарьж байгаа учир нэлээд тамирджээ. Хоёр гурав хоногоос мэдэгдэнэ. Үр дүнтэй бол сайн л байна. Үгүй бол өөр эмчилгээ бодно доо.

- Дахиад хагалгаа хийхгүй биз дээ?

- Харан байж болно. Чи өнөөдөр яасан богинохон банзал өмсөө вэ?

- Дажгүй байгаа биз?

- Шатаар яаж гарах болж байна?

- Алхаад л гарна. Харах дуртай нь харж л байг.

Мидоригийн хэлэхэд сувилагч өөрийн эрхгүй жуумалзав. Эмч:

- Эмнэлэгт хэвтүүлж эрүүл эсэхийг чинь үзэх юмсан. Цахилгаан шатаар яваарай даа. Тэртээ тэргүй олон хүнтэй байхад наадахаас чинь болж элдвийн юм болвол дэмий шүү! гэсээр цааш явлаа.

Эмчийн үзлэг дуусмагц сувилагч тэрэг түрсээр үдийн хоол авчрав. Төмсний зутан, жимс, загасны ясгүй мах, ногооны нухаш байлаа. Мидори аавынхаа орны толгойг өргөж зутан халбагадаж өгсөнд аав нь тав зургаа халбагадаад боллоо гэх юм.

- Юм идэх хэрэгтэй шүү дээ.

- Дараа больё.

- Юм идэхгүй бол тэнхээ орохгүй. Бие засах уу?

- Үгүй ээ.

- Ватанабэ, хоёулаа хоолонд оръё.

Би юм идэх хүсэлгүй ч Мидориг дагаж гарлаа. Цайны газрын том танхим эмч, сувилагч, эргэлтийн улсаар дүүрчээ. Үе үе цагаан хоолойгоор эмч, сувилагчдын нэрсийг дуудна.

Ширээ олох зуур Мидори хачиртай хуушуур, төмсний салат, хэрчсэн байцай, ногоотой шөл, будаа, мисо шөл зэргийг хөнгөн цагаан тавиур дээр тавиад ирлээ. Би талыг нь л барж билээ. Харин Мидори хоолоо дуустал нь идэв.

- Ватанабэ, чи өлсөхгүй байна уу?

- Цадчихлаа.

- Эмнэлэгт эхлээд хоол идэж чаддаггүй юм. Эм тангийн үнэр танар, өвчтэй хүмүүс, зовлон зүдгүүр, эмч сувилагчдыг харахаар тэгдэг юм. Яваандаа дасна даа. Сайн идэхгүй бол хүнээ асарч чадахгүй. Эмээ, өвөө, ээж, аавыгаа асарч байсан болохоор би сайн мэднэ. Хоолонд орж амжихгүй үе байх учраас боломжтой байвал идээд авах хэрэгтэй.

- Тэр ч тийм шүү.

- Хамаатнууд маань аавыг эргэж ирэхэд энд хооллодог юм. Чам шиг л талыг нь үлдээж, намайг хараад “Чи ч хоол ундандаа сайн юмаа. Би бол идэж чадахгүй нь” гэнэ. Тэд хааяа л үзэгдэхээс биш өтгөн шингэнийг нь зөөхгүй шүү дээ. Тэгсэн мөртлөө хоолоо идчихээр “Хоол ундандаа сайн юмаа” гээд л зэмлэнгүй харна. Надаас илүү оймс элээсэн байж ийм юм ойлгохгүй юм даа. Хэл үгээр ямар тус болох биш дээ. Заримдаа ядарч үхмээр санагдах үе ч байна. Мэс засал хийх тоолонд дээрдэх болов уу гэж бодох ч улам л дордоод байх юм. Ухаан

санаа нь ч самуураад байх шиг. Цуглуулсан мөнгө ч дуусч байна. Гурван жилийн төлбөрөө яаж төлөх юм, бүү мэд. Эгч ч хүнтэй сууж чадахгүй.

- Чи долоо хоногт хэд ирдэг вэ?

- Дөрвөн өдөр. Цөөхөн хэдэн сувилагч нь ажлаа дийлэхгүй. Уг нь сувилагчид нь сайн асардаг юм. Эгч дэлгүүртээ суудаг болохоор би заримдаа хичээлээ таслаад ирдэг. Эгч гурав өнжөөд нэг ирдэг. Зав гарвал болзоонд явна. Нэг иймэрхүү л байна.

- Ийм завгүй байж надад бас цаг гаргаж байдаг гэвэл Мидори цаасан аяга базангаа:

- Чамтай байхад сайхан байдаг гэлээ.

- Чи хоёр цаг хэртэй гадуур яваад ир. Би аавыг чинь харж байя.

- Яах нь вэ?

- Эндээс холдоод, ганцаараа юм бодолгүй жаахан зугаалаад ир. Дотор уужирдаг юм.

Мидори хэсэг зуур бодолхийлээд толгой дохив.

- Тэгсэн нь дээр ч юм уу. Харин чи чадах уу?

- Чамайг харснаас хойш алзахгүй ээ. Дуслыг нь шалгаж, өтгөн шингэнийг нь зөөгөөд, хөлсийг нь арчина. Мэдэхгүй юм гарвал сувилагчаас асуучихна.

- Өөр юу хийхэв. Аав заримдаа хачин юм яриад байдаг болчихсон. Анзаарсны хэрэггүй шүү.

- Зүгээр ээ.

Өрөөндөө ирээд Мидори аавдаа намайг үлдээгээд гарчихаад ирье гэсэнд аав нь дуугарсангүй. Охиныхоо хэлснийг ойлгосон уу, үгүй юү, бүү мэд. Тааз ширтэн хэвтээд нүдээ цавчлахаас өөрөөр хөдөлсөнгүй.

Нүд нь хөлчүүрхсэн хүнийх мэт улайж, гүнзгий амьсгал авахад самсай нь хөдөлнө. Хөгшин Мидориг сонсохгүй, хөдлөхгүй байлаа. Аав нь энэ мөчид юу бодож хэвтээ бол?

Мидориг явсны дараа аавтай нь хууч хөөрье гэсэн боловч ярих юм олдсонгүй. Удалгүй аав нь унтаад өглөө. Орны толгойд сандал дээр суунгаа битгий л энэ чигтээ өнгөрчихөөсэй блээ гэж залбирсан сан. Би Мидоритой “Драмын түүх”-ийн лекцэнд хэдэн удаа хамт сууж байснаас цаашгүй бөгөөд дөнгөж танилцсан энэ өдөр охиноо гарсан хойгуур энэ хөгшин амьсгал хураавал үнэхээр аймшигтай.

Аав нь гүн нойрсож байсанд сэтгэл уужирч, хажууд суух эмэгтэйтэй хууч хөөрлөө. Эмэгтэй намайг Мидоригийн найз залуу гэж бодсон бололтой, түүний тухай л ярина.

- Сайн охин шүү. Аавыгаа ч сайн асардаг. Эелдэг, тусч, хөдөлмөрч, царайлаг охин. Алдчихав даа. Тэр болгон зам дээр таараад байдаг охин биш шүү.

- Мэдлээ.

- Манай охин хорин нэгтэй, хүү маань арван долоотой. Эмнэлэгт ер ирдэггүй. Ням гараг болуут серфингээр гулгана, болзоонд явна гээд л мөнгө аваад алга болно.

Эмэгтэй нэг гучид дэлгүүр орохоор гарахад хоёр өвчтөн унтаж байлаа. Үдийн нар өрөөнд тусч, нүд анилдана. Цонхны дэргэдэх ширээн дээр цэцэгтэй сав байх агаад өрөөгөөр нэг жигнэсэн загасны үнэр таржээ. Хонгилоор сувилагч бүсгүйчүүд хольхилдон, нэг нэгнээ дуудаж, хааяахан өрөөгөөр шагайж, хоёр өвчтөнг хараад инээмсэглэн явна.

Ном эргүүлж суувал цаг нөгцөөхөд амар юм уу? хэмээн бодсон ч өрөөнд ханан дээрх хуанлигаас өөр юмгүй. Тэргэл сарны гэрэлд тэр шөнө өмнө минь нүцгэлсэн Наоког саналаа. Өвчин нь сэдэрч өөрийн мэдэлгүй хажууд минь ирсэн юм болов уу, эс бөгөөс би зүүдэлсэн үү?

Наокогийн амьдрах тэр бяцхан ертөнцөөс холдох тусам тэр шөнийн явдлын учир начрыг олохгүй байлаа. Төсөөлөл гэхэд дэндүү тод

томруун боловч Наокогийн бие, сарны гэрэл хоёр бодитой гэхэд дэндүү сайхан байсан даа. Наокогийн бие, сарны гэрлийн аль алин.

Гэнэт Мидоригийн эцэг сэрж ханиалгахад энэ бодол минь замхарч, амыг нь ариун цэврийн цаасаар арчаад, духных нь хөлсийг алчуураар дарж авав.

- Ус уух уу? гэсэнд хөгшин толгойгоо үл ялиг дохив.

Би жижиг шилэн савтай бүлээн усыг уулгасанд хатсан уруул нь чичигнэж, хоолой нь ялимгүй хөдөлнө. Хөгшин шилэн саван дахь усыг ууж дуусмагц “Дахиад уух уу?” I гэсэнд сулхан дуугаар “Болсоон” гэлээ. Дуу нь улам суларчээ.

- Та юм идэх үү? Өлсөж байна уу? гэвэл хөгшин мөн л толгой дохиж би Мидори шиг орных нь толгойг өргөөд ногооны нухаш, жигнэсэн загаснаас ээлжлэн халбагадаж өглөө. Нэлээд хугацааны дараа хөгшин хоолныхоо талыг идэж дуусгаад толгой нь их өвдөж байгаа бололтой үл ялиг сэгсэрлээ. “Жимс идэх үү?” гэсэнд хөгшин “Үгүй ээ” гэнэ.

- Хоол нь амттай байна уу?

- Амтгүй ээ.

- Эмнэлгийн хоол амтгүй байгаа л даа гээд би инээмсэглэлээ.

Хөгшин нүдээ аних уу, болих уу гэсэн аятай өөдөөс ширтэнэ. Ингэхэд хэн болохыг минь гадарлаж байгаа болов уу гэсэн бодол төрөв. Мидоритой байснаас өөр хүнтэй байсан нь түүнд амар байх шиг санагдлаа. Хөгшин намайг хэн нэгэнтэй андуурсан гэлтэй.

Би сандал дээр хөлөө ачиж суугаад Мидоригийн аавтай ярьлаа.

- Өнөөдөр тэнгэр хангай сайхан байна. Намрын бүтэн сайны сайхан өдөр гэсэн шиг гадуур хаа сайгүй хүн хөлхөнө. Ийм өдөр гэртээ амар суусан нь дээр. Хүнтэй газраар явахаар ядардаг даа. Би бүтэн сайнд өдөртөө хувцас хунараа угааж, байрныхаа дээвэр дээр дэлгэдэг. Оройдоо цуглуулж аваад индүүднэ. Юм индүүдэх дуртай. Үрчийсэн

юм тэнийгээд аятайхан шүү. Эхэндээ ч эвээ олохгүй хөглөсөн ч яваандаа сурсан. Бүтэн сайн өдрийг нэг иймэрхүү өнгөрөөдөг. Өнөөдөр ч юм угаахад яг таарсан өдөр байна. Маргааш эртхэн босоод юмаа угаана аа. Та санаа зовсны хэрэггүй шүү. Угаасаа ням гарагт хийх юмгүй тул маргааш юмаа угааж, хатаачихаад арван цагт хичээлдээ явна аа. Мидори бид хоёр “Драмын түүх”-ийн лекцэнд хамт суудаг. Одоо Эврипидийн тухай үзэж байгаа. Та Эврипидийг мэдэх үү? Грек хүн л дээ. Эсхилл, Софокл энэ гурвыг Эртний Герегийн эмгэнэлт жүжгийн гурван ноён оргил гэдэг юм. Македонд байхдаа нохойд уруулж нас нөгчсөн гэдэг ч маргаантай. Хүн болгоны хүсэл сонирхол өөр болохоор надад Софокл нь илүү санагддаг. Софоклын зохиолын баатрууд хачин жигтэй зүйлтэй уулзаж учирдгаараа ялгаатай. Бүгд л өөрийн замаар аз жаргал, үнэн мөнийг эрэлхийлж, элдэв нөхцөл байдалтай тулгарч, хаашаа ч хөдөлж чадахаа болино. Ойлгож байна уу? Өөр өөрийн асуудал, учир шалтгаан, үзэл бодолтой олон хүн гарна. Өөрийн гэсэн аз жаргал, шударга ёсыг эрэлхийлнэ. Тэгээд эцсийн дүндээ ацан шалаанд орно. Толгойтой болгон аз жаргалд умбаж, үнэн мөнөөр явах боломжгүй. Тийм ч учраас үймээн самуун дэгдэж, үйл явдал яаж эргэнэ гээч? Ерөөс энгийн. Эцэст нь Бурхан гарч ирнэ. Бурхан чи тийшээ оч, чи нааш ир, чи түүнтэй хамт бай, чи эндээ хэсэг дуугүй сууж бай гэхчлэн хүн болгоны үүрэг хариуцлага, байр суурийг зааж өгнө. Энэ бурхныг *deus ex machina* ч гэж нэрлэдэг. Эврипид ч энэ бурхны тухай өгүүлдэг.

Үнэндээ ийм бурхан байдаг бол дэлхий ертөнц амар жимэр байх сан. Хүнд хэцүү үед тэнгэрээс бурхан бууж ирээд л зохицуулчихна. “Драмын түүх”-ийн лекцээр ийм юм үздэг хэмээн элдвийг хүүрнэх зуур Мидоригийн эцэг ойлгосонгүй бололтой өөдөөс минь ширтсээр байлаа.

Би өөрөө өөртөө “Peace” гэж хэлээд ходоод хонхолзов. Өглөөний унд уугаагүйн зэрэгцээ үдийн хоолоо хам хум идсэн.

Шүүгээнд далайн байцай, цуунаас өөр юм байсангүй. Цаасан уутанд тоор, өргөст хэмх байлаа.

- Өлсөөд байх юм. Энэ өргөст хэмхийг идчих үү? гэсэнд хөгшин хариу хэлсэнгүй.

Би угаалгын өрөөнд гурван өргөст хэмхээ угааж ирээд далайн байцайнд ороож, шар буурцагны амтлагчинд дүрээд идвэл амттай гэж жигтэйхэн.

Сайхан амттай өргөст хэмх байна. Шинэхэн. Кивигээс хамаагүй дээр гээд хоёр өргөст хэмх идэв. Өргөст хэмх зажлахад хүр хүр хийх дуу өрөөгөөр нэг дуулдана. Ингээд хонгилд байх хийн плиткан дээр ус буцалгаж цай уулаа.

- Та цай, шүүс уух уу?

- Өргөст хэмх.

Би инээмсэглээд “За. Далайн байцайнд ороох уу?” гэсэнд хөгшин толгой дохино. Үлдсэн өргөст хэмхээ жижиглэж, далайн байцайнд ороогоод, шүдний чигчлүүрт хатгаж аманд нь хийлээ. Хөгшин хэд зажлаад залгив.

- Ямар вэ дээ? Амттай байна уу?

- Амттай...

Юм амталж байна гэдэг чинь амьд байна аа гэсэн үг. Хөгшин бүтэн өргөст хэмх идэж, ус уугаад давсгаа суллая гэлээ. Би хөгшнийг шилэнд шээлгэж, ариун цэврийн өрөөнд асгаад шилээ сайтар угаав. Эргэж ирээд цайгаа ууж:

- Таны бие гайгүй юу? гэвэл хөгшин:

- Толгой бага зэрэг... гэнэ.

- Бага зэрэг өвдөөд байна уу? гэвэл хөгшин үл ялиг ярвайна.

-Хагалгаа хийлгэсэн хойно өвдөх байх аа. Би хагалгаанд орж үзээгүй болохоор сайн мэдэхгүй л дээ.

- Тасалбар.

- Ямар тасалбар?

- Мидори... Тасалбар...

Хөгшин юу гэснийг би ойлгосонгүй. Хөгшин “Гуйж байна” гэх шиг болоод над руу харна. Юу хэлэх гэснийг нь би ойлгосонгүй.

- Үэно. Мидори.

- Үэногийн буудал уу? гэсэнд хөгшин толгой дохилоо. “Тасалбар-Мидори-гуйж байна-Үэногийн буудал” гэснийг бодоод хэлсэн ярьснаа ойлгохгүй байх шиг байна даа гэж бодсон ч хөгшний нүд урьдынхаасаа сэргэжээ.

Хөгшин дусал залгаагүй гараа чадан ядан өргөж, өөдөөс минь ширтэнэ. Үрчлээтсэн гарыг нь барихад тэр “Гуйжбайна” хэмээн ахин дахин шивнэнэ.

-Тэр тасалбарын тухай Мидорид хэлье. Санаа зоволтгүй гэсэнд хөгшин гараа суллаж нүдээ анилаа.

Хөгшин унтмагц би өрөөнөөс гарч цай буцалгаж уув. Хэзээ мөдгүй нөгөө ертөнцөд очих болсон энэ туранхай хөгшнийг бодох тусам сэтгэл эмтэрнэ.

Удалгүй нөгөө эрийн эхнэр эргэж ирлээ. “Гайгүй юу?” гэсэнд би “Гайгүй ээ” гэлээ. Мидори гурав өнгөрөхийн алдад:

- Цэцэрлэгт хүрээлэнд сууж байгаад ирлээ. Хэлснээр чинь хэнтэй ч ярилгүй ганцаар жаал суулаа гэсээр орж ирэв.

- Сэтгэл онгойв уу?

- Дээрдэх шиг боллоо. Чамд их баярласан шүү. Ийш тийшээ самгардсаар байгаад ядарснаа ч мэдээгүй явж.

Мидоригийн аав дуг хийх зуур хоёул автоматаас кофе авч, амралтын өрөөнд орлоо. Аав нь унтаж сэрээд үлдсэн хоолоо идэж, намайг өргөст хэмх идэхийг хараад мөн нэгийг идэж, давсгаа суллаад буцаад унтсан гэвэл Мидори:

- Чи ёстой мундаг юмаа. Аавыг хооллох гэж үйлээ үздэг байхад чи өргөст хэмх хүртэл өгсөн байдаг гэх нь тэр.

- Намайг идэхийг хараад идмээр санагдсан биз.

- Чи дэргэдэх хүмүүсээ тайвшруулж чаддаг болохоор тэр ч юм бил үү?

- Хаанаас даа. Хажуу хавирганыхан маань бухимдах нь их.

- Аав маань ямар санагдав?

- Надад таалагдсан шүү. Олигтой юм ярьж чадаагүй ч сайн хүн шиг санагдсан.

- Элдвийн ааш гаргаагүй биз?

- Үгүй ээ.

- Долоо хоногийн өмнө аав бухимдаад элдвээр загнасан. “Тэнэг амьтан, далд ор” гээд над руу аяга шидээд. Ийм өвчтэй хүмүүс хааяа хачин авир гаргадаг юм. Ээж минь бас цухалдаад “Чи миний охин биш. Яв цаашаа” гэж байсан юм. Хавдартай хүмүүс ой ухаанаа хянаж чадахгүй болоод цухалдаж, элдвийн юм ярьдаг л даа. Өвчин нь тийм. Өөрийн мэдэлгүй авирлаж байгааг нь мэдэх ч асарч халамжилж байгаад ингэж хэлүүлэх гэж дээ гээд гомдох юм.

Би “Ойлгож байна аа” гээд тасалбар болоод Үэногийн буудлын тухай ярьлаа.

- Тасалбар, Үэногийн буудал гэнэ ээ? Ёстой бүү мэд.

- Дараа нь “Мидори, гуйж байна” гэсэн.

- Миний төлөө л нэг юм гуйж дээ.

- Үэногийн буудлаас метроны тасалбар авах гэсэн юм болов уу? Хэдэн үг хэлэхээр нь би ойлгосонгүй. Үэногийн буудал гэхээр чамд санаанд орох юм бий юү?

- Үэногийн буудал уу? Бага сургуулийн гурав, тавдугаар ангид байхдаа би хоёр удаа гэрээсээ зугтааж байлаа. Касснаас мөнгө авч, Үэногийн буудлаас Фүкүшима руу явсан. Юу ч билээ нэг хэрэг мандаад, уур хүрч өсөрхсөндөө зугтсан. Тэнд авга эгч маань байдаг л даа. Эгчдээ их сайн болохоор тэднийд очсон хэрэг. Аав хоёр удаа Фүкүшима орж намайг авсан. Бид хоёр галт тэргэнд сууж, савласан хоол аваад Үэнод ирдэг байлаа. Тэр үед аав Кантогийн газар хөдлөлт, дайны он жил, намайг төрсөн тухай түг таг хийгээд ярьж өгдөг байлаа. Одоо бодоход өөр үед бид хоёр аминчлан ярилцаж яваагүй юм байна. Аав Кантогийн газар хөдлөлтийн үеэр Токиогийн төвд байсан ч газар хөдөлснийг мэдээгүй гэсэн.

- Үгүй байлгүй дээ.

- Үнэн гэм. Коишикавад чиргүүлтэй дугуй унаад явж байсан юм билээ. Гэртээ харьсан чинь хавийн айлын дээврийн вааран хавтан нураад, айж сандарсан улс багана түшиж байсан гэдэг. Аав газар хөдөлснийг мэдээгүй “Та нар чинь юу хийгээд байгаа юм бэ?” гээд их гайхсан гэнэ лээ. Аав гоц гойд гэхээр юм ер ярихгүй. Түүний тухайд Японд сүүлийн тавь жаран жил сүйдтэй юм болоогүй шиг л санагдана. 2-р сарын 26 (1936 оны 2-р сарын 26-нд явган цэргийн сонсогчид Ерөнхий сайдын ордон, цагдаагийн газар луу дайрч Дотоод хэрэг, Сангийн яамны сайдуудыг хороосон бөгөөд бослого 2-р сарын 29-нд дарагдсан, орч), Номхон далайн дайныг нэг иймэрхүү юм болсон гээд л ярина. Инээдтэй шүү. “Мидори минь, хорвоо бөөрөнхий учир хаа ч явсан адилхан” гэдэг байлаа. Би бага байсан болохоор үгэнд нь итгэнэ.

- Үүнээс өөрөөр Үэногийн буудалтай холбоогүй юм биз дээ?

- Тийм ээ. Харин чи гэрээсээ зугтааж байсан уу?

- Үгүй ээ.

- Яагаад?

- Зугтаая гэж бодож явсангүй гэвэл Мидори ихэд гайхсан байртай:

- Чи их сонин хүн юмаа гэлээ.

- Харин л дээ.

- Аав чамд надад санаа тавиарай гэж хэлэх гэсэн байх аа.

- Тийм гэж үү?

- Би мэдэлгүй дээ. Аавыг тэгэхээр нь чи юм хэлэв үү?

- Сайн ойлгоогүй болохоор тэр тасалбар, чиний төлөө санаа тавина. Тайван амар даа гэхээс өөр юм хэлээгүй.

Энэ үед Мидори их л төв царайлж өөдөөс минь ширтээд:

- Аавд миний төлөө санаа тавина гэж амласан юмаа даа? гэвэл би сандарсандаа:

- Үгүй ээ. Учрыг нь ойлгохгүй болохоор... гээд ээрч муурлаа.

- Тоглосон юм. Санаа зовсны хэрэггүй. Чи барьц алдахдаа эгдүүтэй гэдэг нь.

Мидори бид хоёр кофе уугаад, өрөөнд эргэж ирвэл хөгшин унтсаар л.

Нар хэвийж, шувууд хэсэг бүлгээрээ цахилгааны утсан дээр суугаад үргэж ниснэ. Хоёул өрөөний буланд шивэр авир ярилцаж суулаа.

Мидори алгыг минь үзээд зуун тав насалж, гурван удаа гэрлээд машины ослоор нас барахыг минь зөгнөв. Энэ тохиолдолд би гэж хүн ихээхэн баялаг амьдрах нь тодорхой.

Хөгшин дөрөв өнгөрөөд сэрэхэд Мидори хөлсийг нь арчиж, ус уулгаад толгой нь хэр өвдөж байгааг асуув. Удалгүй сувилагч бүсгүй ирж, халууныг нь хэмжээд Рингерийн уусмал шалгаад гарч явлаа. Би амралтын өрөөнд хөл бөмбөгийн тэмцээн үзэж суугаад тав болмогц:

- Ажилдаа явъя даа гээд Мидоригийн аавд: -Би зургаагаас арав гуч хүртэл Шинжюкүгийн пянзны дэлгүүрт ажилладаг юм гэвэл хөгшин толгойгоо үл ялиг дохив.

Мидори:

- Ватанабэ, өнөөдөр энд ирсэнд чинь үнэхээр их баярлалаа. Би баярлаж талархсанаа сайн хэлж чаддаггүй хүн гэсээр намайг үдэв.

- Зүгээр дээ. Хэрэг болвол дараагийн Ням гарагт ч ирмээр байна. Аавтай чинь дахиж уулзмаар байна.

- Энд ирмээр байна гэж үү?

- Дотуур байранд дөрвөн хана ширтэхээс өөр ажил байх биш. Энд бол өргөст хэмх ч болтугай олоод идчих юм байна.

Мидори элгээ тэврээд, гутлынхаа өсгийгөө хулдаасан шал товшингоо:

- Чамтай ууж суумаар байх юм гэлээ.

- Нөгөө порно киногоо яах болж байна?

- Кино үзээд ууж болно шүү дээ? Тэгээд хачин сонин юмаа ярина.

- Чи л тийм юм ярьдаг даа?

- Хэн ч ярьсан ялгаа юун. Ямартаа ч элдвийг ярингаа ууж халамцаад, тэврэлдээд унтана аа.

- Тэгээд юу болохыг би ч төсөөлж л байна. Чамайг чангаавал аягүй бол түлхэнэ вий гэхэд Мидори:

- Мэдээж хэрэг гээд инээлээ.

- Дараагийн Ням гарагт манай байранд хүрээд ирээрэй. Тэгээд хамт ирье.

- Арай урт банзал өмсөх үү?

- Тэр нь дээр.

Гэсэн ч би Ням гарагийн өглөө эмнэлэгт ирсэнгүй. Учир нь Мидоригийн эцэг Баасан гарагийн өглөө амьсгал хурааж билээ.

Тэр өдрийн өглөө зургаа гучид Мидори над руу ярьж энэ тухай дуулгасан юм. Утасны дуудлага ирснийг мэдэгдэх дохио дуугарахад унтлагын хувцсан дээрээ товчтой ноосон цамцаа хөдрөөд лобби руу бууж харилцуураа авлаа. Гадаа хүйтэн бороо шивэрнэ.

- Аав дөнгөж сая өнгөрлөө гэх Мидоригийн сулхан дуу сонстов.

- Надад туслахаар юм байна уу? гэсэнд:

- Зүгээр дээ. Чамд дуулгах гэсэн юм. Ажил явдалд нь ирсний хэрэггүй. Өөр газар уулзья гэсээр санаа алдав.

- Мэдлээ.

- Надтай кино үзнэ биз?

- Үзнэ ээ гэвэл Мидори:

- Тэгвэл дараа ярья гээд харилцуураа тавьлаа.

Гэсэн ч дараагийн долоо хоногт Мидоригоос сураг гарсангүй. Хичээлдээ ирж, утсаар ярьсангүй. Нэг шөнө Мидориг төсөөлж өөрийгөө хангах гэж үзсэн ч болж өгсөнгүй. Наоког төсөөлсөн ч нэмэр болсонгүй. Удалгүй виски ууж, шүдээ угаагаад унтаж билээ.

Ням гарагийн өглөө би Наокод захиа бичлээ. Үүндээ Мидоригийн аавын тухай дурслаа.

“Би лекцэнд хамт суудаг оюутан бүсгүйн эмнэлэгт хэвтсэн аавыг нь эргэж очихдоо өргөст хэмх идсэн юм. Тэр хөгшин ч өргөст хэмх идсэн бөгөөд тав хоногийн дараа насан эцэслэжээ.

Хөгшин тэр өргөст хэмхийг хүр хүр хийн идэж байсныг би тодхон санаж байна. Үхэл гэдэг бяцхан мөртөө гайхалтай дурсамж үлдээдэг хачин эд юм.

Өглөө сэрэхдээ Рэико та хоёрын шувууны байрыг санах юм. Тогос, тагтаа, тоть, цацагт хяруул, туулайнуудыг ч ялгаагүй дурсдаг. Бороо шивэрсэн тэр өглөө хэн хүнгүй өмссөн тэр шаргал цув нүдэнд харагдах шиг.

Орондоо хэвтээд чамайг тэврээд унтаж байгаагаар төсөөлөхөд сэтгэл бүлээцэх юм. Чамтай хамт байсан сан бол хичнээн сайхан.

Заримдаа гансарч ганцаарддаг ч өглөө болгон өөрийгөө цэнэглэдэг. Энэ нь Рэико та хоёр өглөө бүрийд шувуу хооллохтой ижил санж. Өглөө босч, гар нүүрээ угааж, сахлаа хусч ундлаад, хувцсаа сольж сургууль орох замдаа баадуугаа эцэст нь тултал эргүүлж өөрийгөө цэнэглэнэ. Өнөөдрөөс сайхан амьдаръя гэж өөртөө хэлдэг. Дэргэд чинь байж чадахгүй ч чи минь энүүхэнд бий гэсэн бодлоор Токиогийн энэ эцэс төгсгөлгүй өдрүүдийг өнгөрөөх юм. Сүүлийн үед би өөрийн мэдэлгүй өөрөө өөртэйгээ яриад байх шиг боллоо. Бодвол баадуугаа чангалангаа үглэдэг биз ээ.

Өглөө бүр чамайг бодох тул хүн шиг амьдрах хэрэгтэй гэж өөртөө хэлдэг юм. Чи минь тэнд хичээж байхад би ч энд зүтгэх учиртай.

Өнөөдөр бүтэн сайн учраас баадуугаа эргүүлэх шаардлагагүй. Хувцсаа угааж дуусаад энэ захиаг тэрлэж сууна. Марк наагаад шуудангийн хайрцганд хийчихвэл болох нь тэр. Хичээлтэй өдрөө цаг заваараа номын санд сууж хичээлээ давтдаг учраас амралтын өдрүүдэд чөлөөтэй.

Энд Ням гарагийн үдээс хойш нам гүм байх агаад ганцаар хөгжим сонсож, ном уншихаас өөр ажилгүй. Заримдаа бид хоёрын зугаалж явсан Токиогийн гудамжнуудыг нэхэн дурсаж, элдвийг бодож хэвтдэг. Өмссөн хувцсыг чинь хүртэл тод санахыг яана. Бүтэн сайны үдээс хойш би үнэхээр олон зүйл эргэн дурсдаг.

Рэйкод мэнд дамжуулаарай. Оройдоо түүний гитарын аялгууг санагалзах нь олонтаа.”

Би захиагаа 200 алдын цаана байх шуудангийн хайрцганд шургуулж, өндөгтэй сендвич аваад колагаар даруулж идлээ. Ингээд цэцэрлэгт

хүрээлэнд бейсбол тоглох хүүхдүүдийг ажин цаг нөгцөөв.

Цаг цаашлах тусам тэнгэр цэнхэртэж хязгаар нь үгүй цэлийнэ.

Үдээс хойш өрөөндөө ирж, ном уншлаа. Төвлөрч чадахаа болиод тааз ширтэн Мидориг бодсоор хэвтлээ. Мидоригийн аав надаас охиндоо санаа тавихыг хүссэн гэж үү? Би түүний хэлэх гэснийг ухаж ойлгож чадаагүй дээ. Эс бөгөөс хөгшин намайг өөр хүнтэй андуурсан биз. Зүсрээ бороотой Баасан гарагийн өглөө өөд болсон хөгшин чухам юу хэлэх гэснийг өдгөө мэдэхийн аргагүй. Өвчиндөө зовж шаналахын хэрээр жижгэрч, эдүгээ атгахан үнс болон хувирчээ.

Хөгшин энэ хорвоод жижигхээн номын дэлгүүр, хоёр охиноо (ямартаа ч нэг нь их этгээд) үлдээгээд явжээ. Ой ухаан нь орж гаран, өвчин зовлондоо шаналж хэвтэхдээ сэтгэлдээ юу тээж өөдөөс минь харсан бол?

Мидоригийн аавыг бодох тусам сэтгэл гундаж, дээвэр дээр дэлгэсэн угаасан хувцсаа хамж аваад Шинжюкү орохоор гарлаа.

Олон холхисон гудамжинд гараад дотор жаал уужрав. Би Кинокүниягийн номын дэлгүүрээс Фолкнерын Найман сарын гэрэлийг авч дуу шуу, хөл үймээнтэй жааз хөгжмийн клубээр шагайж, кофе уунгаа номоо дэлгэлээ.

Ингээд тав гучид тэндээс гарч, хөнгөн хооллоод, энэ насандаа хэдэн арав, хэдэн зуун Ням гарагийг ийм нам гүмхэн, ганцаардмал орчинд өнгөрөөх бол хэмээн бодлоо. Ням гарагт би баадуугаа чангалдаггүй.

Наймдугаар

Бүлэг

Энэ долоо хоногийн дундуур би пянзны тавиурын тусгаарлагч шил цуурсныг мэдэлгүй гараа нэлээн гүнзгий зүссэн юм. Нэлээд цус алдаж билээ. Зохион байгуулагч хэдэн алчуураар гарыг минь боосон ч тогтсонгүй. Ингээд шөнө ажилладаг түргэн тусламжийн төв бий эсэхийг утсаар лавлаж өглөө. Зохион байгуулагч олиггүй эр ч гэлээ аминд тулсан үед даруй арга хэмжээ авдаг. Золоор холгүйхэн эмнэлэг байж таараад тийш очих зуур алчуур цусаар нэвчиж, засмал зам дээр дусална. Хүлээн авахын үүдний хүмүүс айсан шинжтэй дотогш орууллаа. Зодоон цохионы шарх гэж бодсон бололтой. Өвдсөн юмгүй ч цус гоожсоор.

Эмч цусыг минь тогтоож, ариутгал хийгээд оёдол тавин, маргааш ирээрэй гэлээ. Дэлгүүртээ буцаж очсонд зохион байгуулагч харь гэж, би автобусанд суугаад, байрандаа ирж Нагасавагийн өрөөгөөр шагайв. гараа зүссэндээ бухимдаж, хэн нэгэнтэй ярьмаар, тэгээд ч түүнтэй ойрд уулзаагүй.

Нагасава зурагтаар испани хэлний хичээл үзэнгээ шар айраг ууна. Намайг хармагцаа “гараа яагаа вэ?” гэсэнд би “Сүйдтэй юм биш ээ” гэлээ. Намайг дайлсан ч би татгалзлаа. Тэрээр “Одоохон дууслаа” гэсээр испани үг давтаж хэлнэ. Энэ зуур би ус буцалгаж, цай хийж уув. Испани бүсгүй жишээ өгүүлбэр уншина. “Анх удаа л ийм ширүүн бороо орлоо. Барселонад хэд хэдэн гүүр урсжээ” гэсэнд Нагасава “Аймшигтай жишээ байна. Хэлний хичээлийн жишээ нь гэж иймэрхүү л байх юм. Ёстой нэг...” гэх аж. Удалгүй нэвтрүүлэг дуусч, Нагасава зурагтаа унтрааж, жижиг хөргөгчнөөсөө ахиж шар айраг гаргаад:

- Ороод ирсэн чинь болж дээ. Уйдаад хийх юмаа олж ядаж суулаа. Уугаач гэсэнд би “Уумааргүй байна” гэлээ.

- Сониноос нөгөө шалгалтандаа тэнцсэн шүү.

- Гадаад яамны шалгалтанд уу?

- Албан ёсоор бол “Дипломат албаны ажилтан шалгаруулж авах анхан шатны шалгалт” гэж байгаа. Би:

- Баяр хүргэе! гэсээр зүүн гараа сунгалаа.
- Баярлалаа.
- Чи тэнцэх нь тодорхой байсан л даа.
- Тийм л дээ. Гэхдээ албан ёсны үнэлгээ авахад сайхан л юм.
- Яаманд ороод шууд гадаад явах уу?
- Эхлээд нэг жил дотооддоо дадлагажаад, дараа нь гадаад явдаг юм билээ гэх зуур би цайгаа оочиж, мань хүн шар айргаа тамшаалан ууна.
- Эндээс гарахдаа хөргөгчөө чамд өгнө өө. Хүйтэн шар айраг ууж суухад үүн шиг хэрэгтэй юмгүй. Авна биз дээ?
- Авалгүй яахав. Гэхдээ байр хөлслөхөөр чамд хэрэг болно биз дээ?
- Битгий мулгуутаад бай л даа. Эндээс гараад том хөргөгч аваад хүн шиг амьдарна аа. Дөрвөн жил энд суусан болохоор гараад шинэ орчинд сайхан амьдарна. Зурагт, радио гээд хэрэглэж болох юм байвал чамд өгөөд явна даа гэвэл би:
- Өгснийг чинь авна аа гээд ширээн дээрх испани хэлний сурах бичгийг эргүүлэн:
- Чи испани хэл үзэж эхлээ юү? гэлээ.
- Хэлтэй бол хөлтэй гэдэг дээ. Би багаасаа хэл сурахдаа сайн. Франц хэлийг өөрөө сурсан. Тоглоомтой л ижил. Зарчмыг нь нэг ойлгочихсон байхад хэдийг ч сурсан бүгд адил. Охин эргүүлэхээс өөрцгүй.
- Бүх юмыг л охин эргүүлэхтэй зүйрлэх юм.
- Нэг “бут авна” биз дээ?
- Арай дахиад “ан хийхгүй” биз?

- Үгүй ээ. Хацүмитэй гурвуулаа тансаг газар орж сайхан сууя. Тэртээ тэргүй аав даана.

- Тэгвэл Хацүми та хоёр явсан нь дээргүй юу?

Нагасаваг “Чамтай явбал тухтай, тайван байна” гэхэд Кизүки, Наоко хоёртой цуг явсан үе минь санаанд орлоо.

- Би Хацүмигийнд очиж хононо. Тийм болохоор иймээ тиймээ юм болохгүй.

- Тэгвэл хамт явна аа. Дадлагаа дуусаад хэдэн жилээр гадаад явбал Хацүми яах вэ? гэвэл Нагасава шар айраг задлан:

- Тэр бол миний санаа зовох юм биш. Хацүми өөрөө мэднэ биз.

Сайн ойлгосонгүй гэвэл Нагасава хөлөө ширээн дээр тавьсан чигтээ шар айраг балгаж эвшээлгээд.

- Надад хүнтэй суух санаа алга. Үүнийгээ ч Хацүмид хэлдэг. Хүсвэл хүнтэй суу, үгүй бол хүлээгээд байж бай гэдэг дээ. Муухай байна уу?

- Хэлээд юү гэхэв.

Нагасава:

- Үнэндээ энэ хорвоод шударга ёс гэж байхгүй. Дэвэн галаваас л ийм байсан. Би Хацүмиг хуурч яваагүй. Энэ талаар над шиг муу хүн байхгүй болохоор хүсвэл хоёр тийшээ больё гэсэн хэмээгээд шар айргаа дуусгаж, тамхи асаалаа.

- Чи ер нь айдас гээчийг мэдэх үү?

- Хүн болсон хойно айж эмээх үе гаралгүй яахав.

Би аманд орсон шар тосоо алдахгүй гэж хэрэндээ хичээдэг ч илүү дутуу юманд шунадаггүй. Хүссэнээ авч, хүсээгүйгээсээ холуур явна. Энэ чинь л амьдрал биз дээ? болж бүтэхгүй зүйл тохиолдвол хэсэгтээ

бодолхийлнэ. Хүн болгон адилхан боломж бололцоогүй энэ нийгэмд нөгөөтэйгүүр өөрийн чадал чансаагаа харуулж болно.

- Хувиа хичээсэн хүн шиг санагдаад байх юм.

- Би тэнгэрээс жимс унаад ирээсэй гээд өлийж суудаггүй. Чамаас хэд дахин илүү хичээл зүтгэл гаргадаг шүү.

- Тэр ч тийм л дээ.

- Ойр тойрныхон маань гоншигонохоос цаашгүйг хараад заримдаа бухимдана. Хичээл зүтгэлгүй мөртлөө ялархахыг нь яалтай?

Эгдүүцэж Нагасаваг ажлаа.

- Миний хувьд хүмүүс өдөр шөнөгүй ажиллаад байх шиг санагдах юм. Эсхүл би харалган болж уу?

- Тэр чинь зүтгэл биш, зүгээр л ажил. Хүн алсаа харсан, ул суурьтай зорилго өөд тэмүүлэх учиртай гээд байгаа ухаантай.

- Жишээ нь, чиний хувьд бусдыг налайх зуур испани хэл үзэх нь зүтгэл юмаа даа?

- Яг зөв. Хавар гэхэд испани хэл маань дажгүй болчихно. Англи, герман, франц хэлийг муугүй сурсан. Итали хэл маань овоо болж байгаа. Хичээл зүтгэлгүй бол ингэж чадахгүй дээ?

Нагасаваг ийн хэлээд тамхи татах зуур би Мидоригийн эцгийг бодлоо. Өдрөөс өдөрт борви бохис хийлгүй ажиллаж, охиныхоо араас Фүкүшима руу явж байсан тэр хөгшин ажил төрөл, хичээл зүтгэл хоёрыг ялгаж салгаж байсан нь юу л бол. Тэр байтугай зурагтаар испани хэл үзэж болно гэж төсөөлөөгүй явсан буй заа. Нагасаваг:

- Бямба гарагт оройн хоолонд орвол болно биз дээ? гэхэд би:

- Болно оо гэсээр өрөөндөө орлоо.

Ингээд Бямба гараг болж Нагасава Хацүми бид хоёрыг Азабүд байрлах франц зоогийн газар дагуулж ирсэн юм. Хоёул Хацүмиг хүлээх зуур шар айраг балгаж, Жозэф Конрадын зохиол бүтээлийн тухай яриа өрнүүлэв. Нагасава хараажийн үнэтэй саарал өнгийн дэгжин хослол, харин би бор бааздуу жирийн хүрэм өмссөн байлаа.

Арван таван минутын дараа Хацүми ирлээ. Дэгжин маягийн хөх даашинз өмсөөд, алтан ээмэг зүүж, улаан туфль углажээ.

- Ямар тансаг газар вэ?

- Аав Токиод ирэх болгондоо энд ордог юм. Би уг нь ийм үнэтэй хоолонд дургүй л дээ.

- Хааяа ороход муу нь юу байхав. Тийм ээ, Ватанабэ?

Нагасава:

- Аав Токиод уулздаг эмэгтэйгээ ийш нь дагуулж ирдэг юм гэсэнд Хацүми:

- Хөөх, тийм үү? гээд уулга алдав.

Харин би чихгүй царайлж, дарс ууж суулаа. Төдхөн зөөгч орж ирээд бид гурав шөл, нугасны мах, алгана загастай хоёрдугаар хоол захиалав. Хоол авчрах зуур гурвуул дарс балгаж, Нагасава Гадаад яамны шалгалтын тухай ярина. Түүний хувьд шалгалт өгсөн хүмүүсийн ихэнх нь нийгмийн хог шаар бөгөөд хэдхэн тооны эрүүл саруул ухаантай улс байжээ. Нагасава:

- Хаа сайгүй л ийм байх юм даа гэсээр дахин нэг шил дарс захиалж, өөртөө шотланд виски авав.

Хацүми урьд нь хэдэнтээ дуулгаад амжсан “доод курсийнхээ хөөрхөн охинтой” танилцуулна гэхэд би аанай л булзааруулав.

- Сайн охин шүү. Царай зүсээрээ ч гологдохгүй. Дараа нэг дагуулаад ирье. Чамд таалагдана.

- Хэрэггүй дээ. Над шиг ядуу амьтан танай сургуулийнхантай ярих юм олдохгүй.

- Хаанаас даа. Даруухан, сайн охин гэвэл Нагасава:

- Ватанабэ, ямар нэг оронд орох гэж байгаа биш уулзаад үзээч гэнэ.

- Тэгэлгүй яадаг юм бэ. Онгон охин шүү дээ. Чиний мөнгөтэй эсэх нь огт хамаагүй. Хэтэвч хардаг охид байдаг ч хоёр зуун тавин иений хоолонд ордог энгийн хүмүүс бас байна.

- Хацүми, чи бод доо. Манай сургуульд 120, 100, 80 иений үдийн хоол байдаг. 120 иений хоол авсан хүнийг өрөөл бусад нь нүдээ бүлтэртэл харна. Мөнгө хүрэхгүй бол 60 иений гоймон авч иддэг. Ийм байхад бид хоёрын яриа нийлэх үү? гэсэнд Хацүми тас тас хөхрөөд:

- Хямдхан л хоолтой юм байна. Гэхдээ Ватанабэ, чам шиг сайн залуу тэр охинтой хэл амаа олно доо. Тэр охинд 120 иений хоол таалагдах ч юм бил үү?

- Тэр ч юу л бол. Өөр юмгүй болохоор л хүмүүс иддэгээс биш амт муутай хоол шүү дээ.

- Хүнийг идсэн хоолоор нь тодорхойлж болохгүй. Манай сургуульд чинээлэг айлын охид сурдаг ч амьдрал ойлгодог хүмүүс бас бий.

Энэ үед Нагасава:

- Ватанабэ ярьдаггүй л болохоос биш найз охинтой л доо. Тэр нь хэний ч мэдэхгүй нууц юм байх аа гэсэнд Хацүми:

- Үнэн үү? гээд амаа ангайв.

- Үнээн. Нууцлаад байх юу байхав. Бид хоёр бага зэрэг асуудалтай байгаа болохоор яриад байдаггүй юм.

Хацүмиг:

- Осолтой хүүхэн юм биз дээ? Чи ярь л даа гэсэнд би аанай л дуугарсангүй. Харин Нагасава:

- Ватанабэ, хэлэхгүй л гэсэн бол ам алдахгүй гэсээр гурав дахь хундага вискигээ балгахад Хацүми:

- Тэр охинтой найзалсан бол дөрвүүлээ сайхан уулзахгүй юу? гэсээр нухаш идлээ.

Энэ үед Нагасава:

- Тэгээд согтотлоо уугаад найз охидоо солих байсан, тийм биз? гэхэд Хацүми:

- Нагасава, наад хэл амаа мэдмээр юм хэмээн ундууцав.

- Ватанабэ чамд талтайг мэдээд хэлж байхад.

- Талтай гээд Ватанабэ чиний бодсон шиг хүн биш. Дотно хүнээ хүндэлдэг гэдгийг нь мэдэх учир хүнтэй танилцуулах санаатай.

- Ватанабэ бид хоёр танилцсан охидоо сольж явсан хойно би мэдэлгүй дээ. Тийм биз? Зүгээр ээ, Хацүмид хэлчих.

Нагасава архины халуунд бусдыгаа эвгүй байдалд оруулах нь их бөгөөд өнөөдөр Хацүмиг шоглохоор шийджээ. Хацүми сэрээгээ хойш тавиад:

- Үнэн үү? Ватанабэ, хэл л дээ гэнэ.

Би балмагдсандаа хэлэх үгээ олж ядвал Нагасава:

- Эмээлгүй ярь. Хамаагүй шүү дээ гэлээ.

- Халамцуу явсан юм гэвэл Хацүми:

- Тэгээд юу болсон юм бэ? гэхэд нь би ээрч мууран:

- Нэг удаа Шибүягийн бааранд хоёр бүсгүйтэй танилцаад, дөрвүүлээ хажуугийн буудалд орсон юм.

Бүгд л халсан байсан. Тэгээд шөнө дунд Нагасава хаалга тогшоод бүсгүйчүүдээ сольё гэхээр нь өрөөнд нь яваад орсон хэмээв.

- Тэр бүсгүйчүүд чинь юм хэлээгүй гэж үү?

- Халамцуу болохоор хэнтэй байгаагаа ч мэдэхгүй гэхэд Нагасава:

- Солих шалтгаан байсан гэх нь тэр.

- Ямар шалтгаан?

Тэр хоёрын нэг нь царайлаг, нөгөө нь жаахан тиймэрхүү. Би царайлаг нэгтэй нь, Ватанабэ нөгөө бүсгүйтэй нь нэг өрөөнд орсон л доо. Хүн болсон хойно Ватанабэ ч гэсэн хөөрхөн бүсгүйтэй нэг хөнжилд орохыг хүснэ биз дээ? Тэгээд л өрөөгөө сольсон. Тийм ээ, Ватанабэ?

- Тийм ээ.

- Үнэнийг хэлэхэд Нагасавагийн царай муутай гэсэн бүсгүй нь надад таалагдаж билээ. Аятайхан ааштай, ухаалаг бүсгүй байлаа. Тэр бүсгүйтэй эргэж хөрвөөж, хөгжилтэй яриа өрнүүлж хэвтгэл Нагасава хаалга тогшсон юм. Нөгөө бүсгүйд Нагасавагийн саналыг хэлбэл намайг царай зүс сайтай найзтай нь хамт байхыг хүсэх нь мэдээж гээд зөвшөөрсөн дөө.

- Тэгээд чамд таалагдсан уу?

-Бүсгүйчүүдтэй ингэж явах нь таалагддаг гэхэд ч хаашаа юм бэ.

Хацүмиг:

- Тэгээд яах гэж ингэдэг юм бэ? гэвэл Нагасава:

- Би л уруу татсан нь тэр гэсэнд:

Ватанабэг асууж байхад дуугаа тат хэмээн ундууцав.

-Заримдаа хүнтэй унтмаар санагдах юм. Тэгээд л явдаг.

- Чи найз охинтой гээ биз дээ? Хамт байдаггүй гэж үү?

- Юу ч гэмээр юм бэ. Хэцүү л дээ.

Хацүми санаа алдана. Зөөгч хоёрдугаар хоол авчирч, Нагасавагийн урд шарсан нугас, Хацүми бид хоёрын урд алгана загас тавьлаа. Ногоо таваглаж, сүмсээр амтлав. Зөөгч гармагц гурвуул үлдлээ. Нагасава нугасны махаа хэрчиж, амаа олохгүй иднэ. Харин Хацүми хоолондоо хүрсэнгүй.

- Ватанабэ, чамд ийм явдал ер зохихгүй юм шиг ээ.

- Мэдээд л байна.

- Тэгээд боль л доо.

- Үнэндээ зарим үед ганцаардсандаа бүсгүй хүний халуун дулаан илчийг мэдэrmээр санагдах юм.

Энэ үед Нагасава:

- Товчхондоо, Ватанабэ найз охинтойгоо уулзаж учраад байх боломжгүй дэг. Тэгээд л өөр хүнтэй секс хийж явдаг. Залуу насаа гар хангалга хийсээр өнгөрөөж боломгүй гэсээр дундуур орлоо.

Хацүми:

- Гэхдээ Ватанабэ тэр охиндоо үнэхээр сэтгэлтэй бол тэвчиж болно доо гэвэл Нагасава:

- Чи эрчүүдийн ор хөнжлийн явдлыг ойлгохгүй л дээ. Би гэхэд чамтай үерхээд гурван жил болж байна.

Гэхдээ л өөр бүсгүйчүүдтэй унтаж хэвтдэг. Нэг шөнийг өнгөрөөхөөс биш сэтгэлд үлдсэн нэгээхэн ч хүнгүй. Энэнд буруу юу байна?

- Чиний энэ хувиа хичээсэн занд үнэндээ дургүй хүрэх юм. Гол нь өөр нэгэнтэй зугаа цэнгэл хөөхдөө биш...

- Энэ чинь зугаа гэхээсээ илүү тоглоом шүү дээ. Хэн ч зовж шаналахгүй.

- Чи намайг бодохгүй байна гэж уу? гэсэнд Нагасава дуугаа хурааж хэсэгтээ хундагаа эргүүлж суугаад:

- Би угийн ийм шуналтай хүн гэх үү дээ. Чамайг гомдооё гэсэндээ зугаа цэнгэл хөөж явсангүй. Сурсан юмыг сураар боож болохгүй юм.

- Тэгвэл ядаж Ватанабэг битгий уруу тат.

- Ватанабэ бид хоёр өрөөл бусдыг сонирхдоггүйгээрээ адилхан. Хүмүүсийн хэлдгээр хувиа хичээсэн гэлтэй. Ватанабэ энэ зангаа сайн мэдэхгүй болохоор л хаданд хавчуулсан аятай сэтгэлээ зовоож явдаг юм.

- Зовлон зүдүүргүй амар амгалан хүн гэж хаа байна? Чи ч шаналдаг даа?

- Тэгэлгүй яахав. Хүний л ижил эргэлзэнэ, шанална. Гэхдээ би энэ бүхнийг зовлон гэхээсээ илүү жам ёсны сорилт туршилт гэж боддог. Хулгана хүртэл тогоор цохиулаад байвал заасан замаар явж сурна аа даа. Хацүмиг:

- Гэхдээ хулгана чинь хайр гээчийг мэдэхгүй шүү дээ гэхэд Нагасава над руу хараад:

- Хулгана хайр гээчийг мэдэхгүй гэж мундаг хэллээ дээ. Араас нь хөгжим дуугарвал бүр сүртэй. Хоёр босоо ятгатай найрал... гэв.

- Битгий тоглоод бай. Санаснаа л хэлж сууна.

- Хооллож суухад ийм юм ярьсны хэрэггүй биз дээ, Хацүми. Ватанабэ ч байна.

“Явдаг юм уу даа” гэж хэлбэл тэр хоёр “Нэг ирснийх сайхан хооллоод гаръя” гэсэнд арга буюу үлдлээ.

Би алгана загасаа идэж, Хацүми талыг нь үлдээв. Нагасава галууны махаа идэж бараад виски ууна.

- Загасны мах ч амттай байна шүү гэвэл тэр хоёр дуугарсангүй. Удалгүй нимбэгтэй мөхөөлдөс, кофе авчирсанд энэ хоёр аанай л гар хүрсэнгүй. Би мөхөөлдсөө идэж, кофеогоо уулаа. Хацүми гараа ширээн дээр тавиад ажиглана. гар нь өмссөн зүүснээс нь өөрцгүй тансаг аж. Энэ зуур Наоко, Рэико хоёрыг юу хийж суугаа бол хэмээн бодлоо. Наоко буйдан дээр хэвтэн ном уншиж, Рэико Норвегийн ой-г дарж байж мэднэ. Түүний гитарын аялгууг дурсан нам гүмхэн өрөөнд нь хамт байхыг сэтгэлийн чинадаас хүсч, би гэж хүн энд чухам юу хийж суугаагаа ойлгож ухаарсангүй. Нагасава:

- Ватанабэ бид хоёр бусдад долоон булчирхайгаа тоочиж, хүчээр санаагаа тулгаж шахаж шаарддаггүйгээрээ адилхан. Бусад хүмүүс аль байдгаа ярьж дэлгэдэг бол бид өөр. Хүмүүс биднийг ойлгосонгүй гээд элдвийн юм бодохгүй. Өөрийн бодол өөртөө зөв гэсэн зарчимтай гэлээ.

Хацүмиг “Тийм гэж үү?” гэхэд би:

- Хүн болгон намайг ойлгохгүй бол хэцүү л дээ. Зарим нэгэнтэй нь сэтгэлээ нээмээр байдаг. - Хүмүүс намайг ойлгодоггүйг би мэддэг л дээ. Гэлээ гээд яахав. Өрөөл бусдын оюун бодол надад огт хамаагүй гэж хэлэхгүй ээ.

- Миний хэлсэнтэй бараг таарч байна даа. Нэг юмыг өөр өөр өнцгөөс яриад байна л даа.

- Би чамайг ойлгодог эсэх нь чамд огт хамаагүй юмаа даа? гэж Хацүмиг хэлэхэд Нагасава:

- Хэлээд байхад чи ойлгохгүй юм. Хүн гэдэг амьтан цаг нь болохоор өөр нэгнээ ойлгоно уу гэхээс хүссэн үед нь таньж мэдэх аргагүй хэмээн сөргүүлнэ.

- Тэгэхээр хэн нэгнээс, жишээ нь, чамаас намайг ойлгооч ээ гэх нь буруу юм биз дээ?

- Буруу гэх нь ч хаашаа юм бэ. Хүмүүс энэ хүслээ “хайр дурлал” гэдэг. Гэхдээ энэ нь миний амьдралын чиг хандлагаас ангид зүйл.

- Чи надад хайргүй гэх гээд байна уу?

Нагасава “Миний бодлоор...” гэж ам нээвэл Хацүми “Тэр үзэл бодолтойгоо тонил” гэж хашгираад хаалга саван гарч одов.

Хацүми урьд хожид үүн шиг дуугаа өндөрсгөж байсангүй.

Нагасава зөөгчийг дуудан картаар тооцоо хийж, “Ватанабэ, уучлаарай. Би Хацүмиг дөхүүлж өгье. Чи явчихна биз?” гэсээр гарлаа. “Зүгээр дээ. Сайхан хоол байлаа” гэснийг минь хэн ч анзаарсангүй.

Нагасаваг такси барих зуур Хацүми “Чамтай байх хүсэл алга. Дайлсанд баярлалаа. Ватанабэ намайг хүргээд өгөх байлгүй” гэж билээ.

- Өөрөө л мэд. Гэхдээ Ватанабэ надаас ялгаагүй дээ. Зөөлөн сэтгэлтэй ч хэн нэгнийг чин сэтгэлээсээ хайрлах нь юу л бол. Дур хүслээс цаашгүй гэдгийг нь би мэдэлгүй дээ.

Такси барьж Хацүмиг суулгаад “Би дөхүүлээд өгье” гэвэл Нагасава “Хөгшнийгөө уучлаарай” гэсээр үлдлээ.

“Чи харих уу?” гэвэл Хацүми толгой сэгсэрнэ. “Тэгвэл нэг тийшээ орж ганц хундага тогтоох уу?” гэсэнд толгой дохиод буланд шигдэв. Таксины жолоочид “Шибүя орё” гээд Токиогийн гудамжаар салхи татуулан давхилаа.

Хацүмигийн хөх даашинз машины арын суудалд тусах гудамжны бүдэгхэн гэрэлд дур булаам харагдах ажээ. Түүнийг ажиглангаа Нагасава чухам ямар учраас энэ бүсгүйг онцолсныг ойлгох шиг.

Хацүмигээс царайлаг бүсгүй олон ч түүн лугаа хүмүүний сэтгэлийг хөвсөлзүүлж чадах нь хуруу дарам цөөн. Тэрээр залуусын сэтгэлийг

татах гэж хуруу хумсаа хугалдаггүй байлаа. Шибүяд очих зуур Хацүмиг ажингаа энэ бүсгүй чухам юуны учраас сэтгэлийг минь гижигддэгийг ойлгох гэж хичээлээ.

Энэ мөчөөс хойш арван хоёр, гурван жилийн дараа би Нью Мексикогийн Санта Фе-д нэгэн уран зураачаас ярилцлага авах далимд пиццаны газар орж, жаргахын улаан наранд шар айраг амсангаа энэ сэрэл мэдрэхүйгээ ухаарч билээ. Эргэн тойрны эд зүйлс, гар хуруу, аяга таваг, ширээ сандал дээр улбар туяа туссан сан. Хацүми чухам энэхэн үест тэртээ ард үлдсэн хүүхэд насны минь баяр баясгалан лугаа санаанд буусан юм.

Хүүхэд ахуйн гэрэл гэгээтэй үе минь Хэдийн улирч, би гэдэг хүн энэ олон жил эргэж харалгүй амьдарчээ. Хацүми гэнэн томоогүй насны минь гэгээн дурсамжийг санагалзуулдаг байж дээ. Тэр үнэндээ онцгой нэгэн байсан бөгөөд хэн нэгэн түүнийг аврах учиртай байжээ.

Гэсэн хэдий ч Нагасава бид хоёр түүнд нөмөр нөөлөг болж, аварч чадаагүй. Нагасаваг Герман явснаас хойш хоёр жилийн дараа Хацүми эрд гарч, аанай л хоёр жилийн дараа судсаа ханасан юм.

Энэ эмгэнэлт мэдээг би Боннд суух Нагасавагаас дуулж билээ. “Хацүмигийн үхэл над шиг хүнийг ч гансарч гуниглахад хүргэлээ” гэсэн Нагасавагийн захиаг урж хаяад, түүнтэй холбоо тасарсан юм.

Тэртээ өдөр Хацүмитай хоёул нэг газар орж, шар айраг уугаад эрдэнэ шиш идэнгээ хэлэх ярих юмгүй болсон хос хоёр шиг удтал ам нээгээгүй сэн. Удалгүй бааранд хөл үймээн ихсэж, хоёул гарч гудамжаар алхлаа. Хацүмиг тооцоо хийнэ гэхэд “Би урьсан шүү дээ” гэсээр өөрөө тооцоо хийв.

Оройн сэрүү бууж, жиндүүхэн болжээ. Бүдэг саарал товчтой ноосон цамц нөмөрсөн Хацүми хажууд чимээгүй алхана. Би гараа халааслаад зорьсон газаргүй нэлээд алхлаа. Эгээтэй л Наокотой алхаж явсан лугаа.

- Ватанабэ, энэ хавьд биллиард тоглочих газар бий юү?

- Чи биллиард тоглодог юм уу?

- Дажгүй тоглоно шүү. Чи тоглоно биз?

- Тааруухан даа.

- Тэгвэл явж биллиард тоглоё.

Бид хоёр гудамжны мухарт байх жижигхэн газар орж, хэд хэдэн удаа биллиард тоглосон юм. Хацүми шиг дэгжин хээнцэр бүсгүй, над мэтийн борогдуу хувцасласан залуутай мухрын нэг газарт биллиард тоглох нь хүний нүдэнд тусч байсан ч Хацүми ер ажирсангүй.

Хацүми сайн тоглох агаад би биллиардад сайнгүйн дээр гар минь боолттой тул хоёр удаа хожигдлоо.

- Чи сайн тоглодог юм байна.

- Намайг хараад тэгж хэлэмгүй дээ?

- Хэзээ ингэж тоглож сураа вэ?

- Аавын аав, өвөө маань биллиарданд хорхойтой хүн байсан юм. Гэртээ биллиардын ширээтэй. Ахтайгаа очоод л тоглодог байлаа. Ах бид хоёр өсмөгц өвөө сайн зааж өгсөн. Өвөө маань ухаантай, сайхан хүн байсан. Нью-Йоркод Диана Дурбинтэй уулзаж явснаа гайхуулдаг байж билээ.

Хацүми гурван бөмбөг дараалж оруулаад, дөрөв дэхээ алдав. Би нэг бөмбөг чүү ай оруулсан ч дараа нь мөн л алдлаа. Тэр өдөр сайн тоглож чадсангүй.

- Гар чинь гэмтсэн болохоор аргагүй.

- Үгүй ээ. Биллиард тоглосонгүй хоёр жил таван сар болж.

- Ямар сайн санаж байна аа.

- Сүүлийн удаа биллиард тоглосон тэр шөнө найз минь өнгөрсөн юм. Тиймээс ч санаанаас гардаггүй.

- Тэгээд л биллиард тоглохоо болио юу? гэсэнд хэсэг бодолхийлээд:

- Үгүй ээ. Тоглох боломж гарсангүй гэлээ.

- Найз чинь яасан юм бэ?

- Автын осолд орсон.

Хацүми хэдэнтээ цохилоо. Нүдээ онийлгон бөмбөгөө онилж, ээлж дараалан оруулах бөгөөд сайхан янзалсан үсээ хойш болгож, алтан ээмгээ гялтгануулан, савхан хуруугаараа хилэн ширээг тулж зогсох нь энэ жижигхэн газрыг биллиардын тансаг клуб болгох мэт. Түүнтэй анх удаа хоёул байхад амьдрал минь нэг шатаар ахих шиг болж билээ.

Гурав дахь удаагаа тоглоход Хацүми мөн л илт давуу хожиж, шархнаас минь цус шүүрээд, хоёул гарлаа. Хацүми санаа нь зовсон байртай “Уучлаарай, биллиард тоглох хэрэггүй байж” гэсэнд “Зүгээр дээ. Сүртэй юм биш. Харин ч хөгжилтэй байлаа” хэмээв. Биллиардын газраас гарахад эзэн нь бололтой дунд эргэм насны эмэгтэй Хацүмид “Бүсгүй минь, та ч авьяастай юм” гэсэнд Хацүми “Баярлалаа” гээд тооцоо хийлээ.

- Гар чинь өвдөж байна уу?

- Гайгүй ээ.

- Шарх нь задарчихаагүй байгаа?

- Үгүй байлгүй.

- Ер нь манайд очъё. Боолтыг чинь сольж өгье. Манайд боолт, ариутгалын бодис бий. Энүүхэнд ойрхон гэхэд нь тэгтлээ санаа зовох юм биш хэмээсэн ч зөрсөөр гэртээ дагуулж ороод боолтыг минь солив.

Хацүмигийнх Шибүягаас Эбисү чиглээд 15 минут алхаад хүрэх зайтай. Тансаг гэхээргүй ч дориун, жижигхэн лоббитой, цахилгаан шаттай. Намайг гал тогооныхоо өрөөнд оруулж, өөрөө хажуу өрөөндөө орж хувцсаа солиод гарч ирэв. Малгайтай бэлтгэлийн цамц, даавуун өмд өмсөөд, ээмгээ авчээ. Хаанаас ч юм бэ эмийн сав авчраад, боолтыг

минь задалж, шархыг минь харж, тэрүүхэнд нь ариутгаад тун эвлэгхэн боолоо. Ингээд хөргөгчнөөс хоёр лааз шар айраг гаргав. Би нэг бүтэн, түүний үлдээсэн тал лааз айргийг уулаа. Хацүми доод курсийн оюутан охидын зураг үзүүлж:

- Найз охинтой болмоор байвал хэлээрэй гэнэ.

- Хэлнэ ээ.

- Чиний бодлоор Нагасава бид хоёр яавал дээр вэ?

- Миний бодол чамд сонин байна гэж үү?

- Бодож санаснаа ний нуугүй хэл.

- Чиний оронд байсан бол Нагасавагаас холдож, арай зөөлөн сэтгэлтэй нэгэнтэй найзална. Нагасава сайн залуу ч гэлээ бүсгүй хүнд жаргал өгөх хүн биш. Аз жаргалтай амьдрал гээчид хүсч тэмүүлдэг хүн огт биш. Чи түүнтэй гурван жил үерхсэнд би үнэндээ гайхдаг. Цаадах чинь тал талын сонирхолтой, хамт байхад дажгүй хүн. Над шиг хүн бараадах ч үгүй хүсэл тэмүүлэл, хичээл зүтгэлтэй. Гэсэн ч ингэж амьдарч болохгүй шүү дээ. Хажууд нь байхад тэр өсч дэвжээд, би гэдэг хүн ахисан юмгүй нэг газраа дэвхцээд байх шиг санагддаг. Ийм болохоор сэтгэл хоосордог. Биднээс тэс ангид хүн. Гадаад яаманд дадлага хийгээд олон жилээр гадагшаа явбал чи хүлээгээд л суух уу? Нагасава гэр бүлтэй болох хүсэлгүй хүн.

- Би мэднэ ээ.

- Тэгвэл өөр хэлэх юм алга. Би айлын ганц хүүхэд учир урьд нь энэ тухай эргэцүүлж байгаагүй ч өнөөдөр чам шиг биллиард сайн тоглодог, ухаантай, дэгжин дүүтэй сэн бол мөн ч сайхан гэж бодлоо.

Хацүми хөгжилтэй нь аргагүй инээмсэглээд:

- Энэ жил сонссон хамгийн сайхан үгийг чи хэллээ гэж билээ.

- Чамайг аз жаргалтай байгаасай л гэж хүссэндээ тэр. Чам шиг бүсгүй хэнтэй ч учраа олно. Яагаад Нагасавагаас холдож чаддаггүй юм бэ?

- Өөрөө ч мэдэхгүй юм. Нагасава “Надад ямар хамаа байна. Өөрөө учраа ол” гэх вий.

- Тэр ч мэдээж.

- Ватанабэ минь, би гэнэн, зөрүүд ч гэмээр хүн. Хань ижил, үр хүүхэдтэй болж, шөнө болгон тэвэрт нь эрхлэхээс өөр хүсэх юм алга.

- Харин цаадах чинь үүнээс тэс ондоо юманд тэмүүлдэг хүн.

- Гэхдээ хүн өөрчлөгддөг дөө?

- Амьдралын нугачаанд хал үзэж, хашир сууна гэх гээд байна аа даа?

- Надаас холдвол ойлгох болов уу?

- Жирийн хүн бол бодож магад. Гэхдээ Нагасава өөр хүн шүү дээ. Энгийн бидний толгойд орохгүй элдвийн үзэл баримтлал, чиг хандлагатай. Өдрөөс өдөрт үүндээ уусч явдаг. Нагасавагийн хувьд бусдад муугаа үзүүлэхээс хорхой шавж залгих нь хавьгүй дээр. Ийм хүнийг хүлээгээд дэмий биз дээ.

- Гэлээ ч надад хүлээхээс өөр арга алга, Ватанабэ.

- Чи Нагасавад тийм их хайртай гэж үү?

Хацүмиг “Ухаангүй хайртай” гэхэд би “Хэн нэгнийг хоёргүй сэтгэлээр хайрлах ч сайхан байх даа” гээд уртаар санаа алдсан сан.

Удалгүй би гутлаа өмсч гарахад Хацүмигийн утас жингэнэлээ. Тэр утас руугаа нэг харж, намайг ширтсэн бөгөөд хаалга хаагдах тэр мөчид харилцуураа авах Хацүмиг би сүүлийн удаа харж билээ.

Арван нэг гучид байрандаа эргэж ирээд Нагасавагийн өрөөг тогшвол эзгүй байлаа. Өнөөдөр чинь бямба гараг. Нагасава бямба гараг бүр хамаатныдаа хонох нэрээр чөлөө авдаг болсон юм.

Өрөөндөө ирж хувцсаа тайлаад унтахаар хэвтсэнд маргааш өнөөх л Ням гараг болохыг саналаа. Хоёр долоо хоногийн дараа би гэдэг хүн

хорин нас хүрнэ. Ханан дээрх хуанлиг ширтэн гунигтайхан бодолд дарагдлаа.

Ням гарагийн өглөө кофе уунгаа Майлз Девисийн хуучин пянз тавиад, урьдын адил Наокод захиа бичихээр суув.

Бороо зүсэрч, өрөөнд хүйтэн гэж жигтэйхэн. Шүүгээнээс гаргасан зузаан ноосон цамцанд шавж устгах бодис шингэжээ. Цонхны дээхэн талд нэг том тарган ялаа суугаад ер хөдлөхгүй юм. Тогтуун тул төрийн далбаа Ромын сенаторын нөмрөг шиг баганаа даган унжжээ. Хаанаас гарч ирсэн нь мэдэгдэхгүй туранхай шар нохой цэцгийн мандал шиншлэн гүйнэ. Наокод гараа зүссэн болоод Нагасава, Хацүми хоёртой Нагасавагийн төрийн албанд тэнцсэн баярыг тэмдэглэсэн тухайгаа бичлээ. Хацүмитэй биллиард тоглож, өөрийн эрхгүй Кизүкиг санагалзсан тухай хэлэх эсэхэд бишгүй эргэлзсэн ч бичихээр шийдлээ.

“Тэр өдөр Кизүки хамгийн сүүлийн бөмбөлгөө нэлээд ур дүйтэй оруулсан бөгөөд үнэндээ түүнийг ононо гэдэгт би эргэлзэж байлаа. Кизүки ширээний захаас цагаан бөмбөлгийг цохиж, сүүлчийн бөмбөлгөө чадмаг гээч нь оруулсан юм. Биллиард тогловол энэ бүхэн эргэн дуурсагдаж, сэтгэлийг минь хөндөнө гэсэндээ би хоёр жил гаруй биллиардын ширээний ард зогсоогүй.

Гэсэн хэдий ч Хацүмитэй тоглосон тэр өдөр эхний сетээ тоглож дуусаад автомат машинаас ундаа авч уухдаа л Кизүкиг саналаа. Кизүки бид хоёрын ордог биллиардын газарт яг ийм автомат машин байж билээ.

Ундаа уухдаа л андыгаа дурссанаас болоод тэр үү, Кизүкиг энэ бүх хугацаанд ор тас мартсан шиг хачин мэдрэмж төрсөн дөө.

Тэр өдрөөс хойш хоёр жил хагас өнгөрсөн хэдий ч Кизүки арван долоотой хөвүүн чигээрээ үлджээ. Он цаг улиран өнгөрч, дотны андын минь дурсамж дурдатгал ой тойноос минь баларч гэвэл эндүүрсэн хэрэг. Эдүгээ бид хоёрын хүүхэд ахуй насны зарим агшнууд урьд урьдынхаасаа тодорсон гэлтэй.

Өдгөө би гэдэг хүн хорь хүрч байна. Эргэж харах нь ээ, арван долоо, наймтай ахуйн Кизүки бид хоёрыг холбож байсан зарим нэгэн зүйлс ор мөргүй алга болжээ. Гашуун ч гэлээ энэ бол үнэн. Үүнийг хэрхэн тайлбарлахаа ухаж мэдэхгүй ч чамаас өөр ойлгох хүн үгүй буй заа.

Чиний тухай урьдынхаас илүүтэй бодох болжээ. Өнөөдөр бороотой тул хувцас хунар угааж, дээвэр дээр сууж, гадуур зугаалах боломжгүй. Kind of Blue цомгийг ахин дахин тавьж, цонхоор ширтэхээс өөр хийх юмгүй. Би ням гарагт өөрийгөө цэнэглэх шиг баадуугаа чангалдаггүй. Тийм ч учраас нэлээн урт захиа бичлээ. Гуанз орж үдийн хоолоо идлээ.

Баяртай."

БСДҮГЭЭР
БҮЛЭГ

Маргааш өдрийн лекдэнд Мидори ирсэнгүй. Арав хоногийн өмнө утасдсанаас хойш түүнээс сураг ажиг гараагүйд хэрэндээ гайхаж, өөрөө ярина гэснийг нь санаад залгасангүй.

Ингээд Пүрэв гарагт цайны газарт Нагасаватай тааралдахад тэрээр эвгүй зан гаргасандаа хүлцэл өчив.

- Зүгээр дээ. Эвгүй юм болсон ч хоол нь амттай юм билээ.

- Хэлээд юү гэхэв.

Хоёул хэсэгтээ хоолоо идэв.

- Хацүми бид хоёр учир зүйгээ олсон.

- Болж дээ.

- Би чамд бас хатуу үг хэлсэн байна лээ.

- Чи чинь гэмшээд юу болов? Бие чинь зүгээр үү? гэсэнд Нагасава толгойгоо хэд хэд дохиод.

- Мэдэх юм алга гэлээ.

- Чи Хацүмид надаас холдсон нь дээр гэжээ дээ?

- Тэгсээн.

- Уг нь ч зөв.

Би шар буурцагны зутан уугаад:

- Хацүми сайн бүсгүй гэхэд Нагасава:

- Мэднэ ээ. Над шиг хүнд дэндүү сайн бүсгүй гэсээр санаа алдана.

Хоолны дараа өрөөндөө ороод унтаж байтал утсаар хүн ярихад дуугардаг хонх жингэнэлээ. Бөх нойрноос цочмогхон сэрсэндээ толгой

дүйнгэтэж, цагаа харвал зургаа арван тав өнгөрчээ. Өглөө, орой нь бүү мэд, гараг усаа ч мартсан бололтой. Цонхоор харсанд төрийн далбаа хэдийн буужээ. Энэ ёслол бас хэрэгтэй эд юм. Харилцуурын цаанаас:

- Ватанабэ, чи завтай юу? гэх Мидоригийн дуу сонсогдлоо.

- Өнөөдөр чинь хэд дэх өдөр билээ?

- Баасан.

- Одоо орой болж байна уу?

- Тэгэлгүй дээ. Сонин хүн шүү. Одоо зургаан арван найм болж байна.

Би номоо дэлгээд нам унтсан байжээ. Баасан гарагийн орой ажилгүйгээ санаж:

- Завтай. Чи хаа байна? гэвэл Мидори:

- Үэногийн буудал дээр. Хоёулаа Шинжюкүд уулзъя. Болох уу?

Ингээд хоёул DUG бааранд уулзахаар болзож, хүрч очвол Мидори тэйкний буланд суугаад коктейль ууна. Эрэгтэй хүний үрчгэрдүү цагаан цув, цэнхэр жийнс, шар ноосон цамц өмсөөд, хоёр бугуйвч зүүжээ.

“Юу ууж байна?” гэсээр Мидоритой мэнд мэдэлцэхэд өөдөөс “Том Коллинз” гэсэнд би виски захиаллаа. Мидори хөлөндөө томоо цүнх тавьжээ.

- Нара, Аомори яваад дөнгөж ирлээ.

- Нэг удаадаа хоёр тийш явчихсан хэрэг үү?

- Яалаа гэж дээ. Би гажиг ч гэлээ энэ хоёр газар луу арай ч нэг удаадаа явчихгүй шүү. Нара руу найз залуутайгаа, Аомори рүү ганцаараа явсан.

- Ажил явдалтай нэлээн ядрав уу? хэмээн Мидоригийн тамхийг асааж өгвөл:

- Үүнд ядрах юу байхав. Хар хувцас өмсөөд л сууж байвал бусдыг нь хүмүүс хийчихнэ. Хамаатнууд хоол унд бэлдэж, аавын хувцас хунарыг хувааж авсан. Өдөр болгон өвчтэй хүн асрахыг бодвол ажил явдал гэдэг чинь зугаалгаар явахтай л адил. Эгч бид хоёр аавыг өвдөж шаналахыг харсаар байгаад амьсгал хураахад нь нулимс унагах тэнхэлгүй болсон. Хүмүүс бид хоёрыг хатуу сэтгэлтэй гэж бодох шиг болно билээ. Тэр тусмаа тэдэнд нулимсаа харуулахгүй гэж бодсон шүү. Эгч бид хоёр өөр зан ааштай ч энэ талаараа усны дусал шиг адилхан.

Мидори гартаа зүүсэн хоёр бугуйвчаа хангинуулан зөөгчийг дуудаж коктейль, самар захиаллаа.

- Орой нь эгч бид хоёр шил хагас сакэ уугаад жаал тайвширсан. Хавь ойрынхноо жаал баалж сэтгэлээ сэргээлээ.

- Тэгнэ дээ.

- Согтоод орондоо орж нам унтсан. Утсаа ч авалгүй сайхан унтсан. Сэрээд сүши захиалж идээд цаашдаа яах ийхээ ярилаа. Бишгүй шаналсных түр ч атугай дураараа байя гэсэндээ эгч найз залуутайгаа хэд хонож, би ч найзтайгаа аяллаар явъя гээд дэлгүүрээ түр хаахаар шийдсэн юм. Ингэж ярих ч нүгэл байх даа.

- Зүгээр дээ. Чи Нарад дуртай юмаа даа?

- Нара сайхан газар шүү.

- Найз залуутайгаа сайхан аялав уу?

- Зочид буудалд ороод цүнхээ тавив уу, үгүй юү сарын тэмдэг ирээд гэлэнмаа шиг сууж байгаад л ирлээ.

- Би тэсэлгүй инээд алдлаа.

- Долоо хоногийн өмнө ирнэ гэж хэн мэдэх вэ дээ. Уур ч хүрэх шиг. Гэхдээ би хүсээд сарын тэмдгээ ирүүлчихсэн биш, яалтай ч билээ?

Найз залуу маань бухимдаад. Огцом ууртай л даа. Хэцүүхэн л яваад ирсэн.

- Та хоёр тэгээд юу хийв?

- Буга хооллож, энэ тэрүүгээр зугаалаад, муудалцаад эргэж ирсэн. Дахиж уулзаагүй. Ирээд гэртээ хэд хоноод, ганцаараа тайван аялъя гэж бодоод Аомори явсан. Хиросакид байдаг найзындаа хоёр хоноод, Шимокита, Таппигаар хэд хоног аяллаа. Нутгийн газрын зурагт нь тайлбар бичиж байсных очиж үзмээр санагдсан юм. Чи тэнд очиж байсан уу?

- Үгүй.

- Ганцаараа тэнэж явахдаа чамайг санасан шүү. Хүн чинь таалагддаг нэгнийхээ дэргэд байхыг хүсдэг дээ.

- Чи найз залуутай шүү дээ?

- Найзтай гээд чамайг санаж болохгүй нь ээ?

- Үгүй дээ...

- Ватанабэ, энэ сар сэтгэл тавгүй байлаа. Элдвийн юм яриад байвал уйлчихна шүү. Дотор давчдаад нулимсаа барьж ядаж байхад чимээгүй л сууж бай.

Би толгой дохиж, самар цөмөнгөө хоёр хундага виски захиаллаа. Шейкерийн хангинах, хундага харших дуун энд тэндээс хадаж, Сара Воны хайрын дуу эгшиглэнэ. Мидори найз залуугийнхаа тухай ийн ярьлаа.

- Ариун цэврийн хэрэгслийн тухай нэг удаа ярьснаас болоод бид хоёр таарахаа больсоон.

- Юу ярьсан гэж?

- Бид хэдэн найзтайгаа ууж байгаад хөрш эмэгтэй маань ариун цэврийн хэрэгслээ унатал нь найтайлгасныг тоглоом шоглоом болгоод

ярьсан чинь л мань хүн уурлачихсан. Найзууд нь хөгжилдөж байхад цухалдаж уурлаад, муухай биз дээ?

- Хм.

- Уг нь сайн залуу. Гэхдээ иймэрхүү юм ойлгодоггүй. Ийм нэгэн залуу Мидориг хайрладаг нь хачин жигтэй санагдсан ч ам нээсэнгүй.

Мидориг бодож өөрийгөө хангах гэж оролдсоноо хэлбэл нүд нь сэргэж:

- Тэгээд болсон уу? гэдэг юм байна.

- Болоогүй ээ.

- Босохоо больчихсон хэрэг үү?

- Тийм ээ.

- Юундаа тэгдэг байна аа. Садар юм төсөөлөөд л болно шүү дээ. Дараа утсаар ярихдаа ааа... яг наана чинь... сэрэл хөдлөөд жигтэйхэн... би тэвчихгүй нь... битгий, битгий... гэе. Чи сонсонгоо хийгээрэй.

- Дотуур байрны утас үүдэнд байдаг. Орж гарах хүмүүсийн дэргэд тийм юм хийвэл комендантад зодуулах вий.

- Тийм үү? Балай юм.

- Гэхдээ дараа нэг үзнэ ээ.

- Хичээгээрэй.

- Мэдлээ.

- Би тачаангуй эмэгтэй биш байх аа даа?

- Үгүй дээ. Бид хоёр өөр харилцаатай болохоор тэр биз гэвэл Мидори:

- Би нуруундаа их сэрэлтэй. Зөөлхөн илмэгц сэрэл хөдөлчихнө.

- Ойлголоо.

- Хоёулаа явж порно кино үзье гэсээр баарнаас гарлаа.

Хоёул могой загасны мухлаг орж, загас идээд, Шинжюкүд байх зургаан кино театрын нэгэнд орлоо. Гурван кино нэг дор үзэх тасалбар авав. Сониноос харсанд зөвхөн энд л садо-мазохист кино гардаг гэх аж. Гарал үүсэл нь тодорхойгүй эхүүн үнэр танхимаар нэг ханхийж, төд удалгүй кино эхлэв. Эгч, дүү хоёр бүсгүйг хэдэн эр хулгайлж хориод, элдэв янзаар тамлах ажээ. Эрчүүд дүүг нь хүчиндэнэ хэмээн сүрдүүлж, эгчийг нь элдэвлэнэ. Яваандаа эгч нь жинхэнэ мазохист болж, дүү нь энэ бүхнийг харсаар ухаан солиорно. Би эхэндээ харж суусан ч удалгүй нэгэн хэвийн үйлдлээс залхаж, Мидориг ширтлээ. Мидори “Дүүгийнх нь оронд байсан бол ухаан самуурах манатай. Сайн хараад авах байсан юм. Ахлах ангийн онгон охин гэхэд хөхнийх нь товч арай л бараан юм. Хөөрхий амьтан, тэр хараач. Гурвуулаа зэрэг дайраад, муухай зэрлэг хүмүүс юмаа. Ватанабэ, хэн нэгэн намайг ингэвэл ч мөн сайхан аа!” гэж уулга алдсаар үзэж суух нь киноноос хавьгүй сонирхолтой. Энэ маягаар шимтэн үзвэл төлсөн мөнгөө эргүүлээд авснаас өөрцгүй.

Удалгүй кино завсарлаж, үзэгчдийг ажвал Мидоригоос өөр эмэгтэй хүн алга. Бидний хажууд суусан оюутан залуу Мидориг хараад холдосхийн суулаа.

- Ватанабэ, ийм кино үзмэгц сэрэл чинь хөдөлдөг үү?

- Хаа нэг хөдөлнө өө.

- Тэгвэл энд байгаа бүх эрчүүлийн нөгөө юм нь босчихдог хэрэг үү? Гуч дөчөөд “тийм юм” босоод гэж бодохоор сонин санагдахгүй байна уу?

Би “Бага зэрэг сонин л юм” гэлээ.

Хоёрдахь кино нь гаж донтонгүй ч ер утга учиргүй байлаа. Танхимд байн байн орь дуу тавих дуун хадаж, би гэж хүн энэ гажиг ертөнцөд хүн болж төрсөндөө гутрах шиг боллоо.

- Хэн гээч нь энэ гаж дуу авиаг бодож олдог байна аа? гэвэл Мидори:

- Сайхан л сонсогдож байна гээд шимтэн үзнэ. Танхимд янаг амрагийн ажил болоод ор чахрах дуун хадах агаад би энэ бүхэн ийм их чимээтэйг урьд нь анзаарч явсангүй. Эрэгтэй нь аахилж, эмэгтэй нь гиншиж “Сайхан байна. Бүр хүчтэй” гэхээс өөр юм хэлэхгүй. Энэ маягаар нэлээд удаан үргэлжлэв. Мидори хэсэгтээ чимээгүйхэн үзээд залхсан бололтой намайг чирсээр гарлаа. Шинжюкүгийн гудамж тэр танхимаас хавьгүй цэнгэг агаартай юм.

Мидори:

- Хөгжилтэй байлаа. Дараа ахиад хамт явъя гэсэнд:

- Дараа үзлээ гэхэд ялгаагүй л ийм байна гэвэл:

- Гэлээ гээд бид ч нэг л төрлийн юм хийдэг шүү дээ гэлээ.

- Үнэндээ ч тийм.

Хоёул нэг газар орж би виски, Мидори үл мэдэх коктейлиэс гурав дөрвийг уувал согтох нь тэр. Тэндээс гармагц Мидори модон дээр авирахаар зүтгэв.

- Энэ хавьд ямар мод байхав. Тэгээд ч гуйвж дайвсан хүн авирч чадах уу?

- Үргэлж ухаантай юм ярьж сэтгэлээр унагах юм. Согтмоор санагдсандаа л уулаа. Юу нь буруу байна? Гэлээ ч авирч дөнгөнө. Модонд авираад хүмүүсийн дээрээс шээе.

- 00-д ормоор байгаа юмаа даа?

- Тийм ээ.

Дагуулсаар төлбөртэй ариун цэврийн өрөөнд очиж, задгай мөнгө төлөн оруулбал Мидори арван таван минут гарч ирсэнгүй. Оройн сонин уншингаа хэсэг хүлээлээ. Хойноос нь оръё гэтэл царай нь цайчихсан Мидори:

- Сууж байсан чинь унтчихаж гэсээр гарч ирлээ.

Цуваа нөмрүүлээд:

- Гайгүй юу? гэвэл

- Сайнгүй ээ гэв.

- Гэрт чинь дөхүүлээд өгье. Сайхан усанд ороод унтвал дээр. Ядраа биз гэвэл:

- Би харихгүй ээ. Эзэнгүй гэрт юү хийхэв. Нэг газар орж хамт хоноё гэж байна.

- Анхнаасаа л надтай хамт хонох гэжээ дээ?

- Мэдээжийн хэрэг.

- Найз залуугаа дуудсан нь дээргүй юу? Найз залуутайн хэрэг юү билээ?

- Чамтай л баймаар байна.

- Болохгүй ээ. Арван хоёр цагаас өмнө байрандаа орохгүй бол комендантад банга авахуулна. Урьд нь нэг удаа чөлөө аваагүй гадуур хоноод хэрэг мандсан. Тэгээд ч би бүсгүй хүний хажууд тэвчихгүй.

- Гарыг минь хүлээд хүссэнээ хий л дээ.

- Тоглоомтой гэдэг нь.

- Үнэндээ би ганцаардах юм. Эрхэлж тунирхах хүн хайсандаа чамд элдвийн юм ярьж чангааж байгаагаа мэдээд л байна. Хорь наслахдаа дураар дургиж үзсэнгүй. Аав, ээж маань авч хэлэлцэхгүй. Найз залуудаа эрхлэхээр уурлана. Тэгээд л хэрүүл дэгдэнэ. Үнэндээ одоо ядраад түүртчихсэн явна. Сэтгэл зовиуртай болохоор намайг эрхлүүлж аргадаад унтуулахад л хангалттай. Өглөө сэргээд дахиж ийм тэнэг юм гуйхгүй.

- Гэлээ ч би чадахгүй гэвэл Мидори:

- Тэгвэл би энд уйлж сууж байгаад таарсан хүнтэйгээ хамт хононо гэхэд нь арга буюу Нагасаватай ярьж, нэг бүсгүйтэй хамт буйгаа хэлээд үүдний пайзыг өрөөндөө хүнтэй мэт сольж тавихыг гуйлаа. Нагасава өглөө цонхоор ороод ир гээд дуртай нь аргагүй зөвшөөрөв.

Би:

- Хөгшнийгөө ойлгоорой. Баярлалаа гээд утсаа таслав.

Мидориг “Зохицуулчихав уу?” гэсэнд “Боллоо” гэвэл

“Цаг эрт байна. Дисконд орьё” гэх юм.

Бид хоёр нэг газар орж, хэсэг бүжиглээд Мидори өлссөнөө гайхан пицца идэхээр гарлаа.

- Саяхан л унаж тусаад байсан гэхэд бие чинь гайгүй болжээ дээ?

- Чамайг хамт байна гэхээр сэтгэл сэргээд л явчихлаа.

- Танайх эзгүй гэсэн байх аа?

- Тийм ээ. Эгч ганцаараа үлдэхээс айдаг болохоор найз залуугийндаа хононо гэсэн.

- Тэгвэл танайд очсон нь дээр. Зочид буудалд орохоор өглөө нь эвгүй байдаг юм.

Мидори хэсэг бодолхийлээд “Тэгье. Манайд хоноё” гэсээр босов.

Ингээд бид хоёр метронд сууж Оцүка руу явлаа. Дэлгүүрийнхээ хаалтан дээр “Түр ажиллахгүй” гэсэн бичиж наажээ. Хэдэн өдөр нээгээгүй учир нилдээ хуучин цаасны үнэр шингэжээ. Буцаахаар боож багласан сонин сэтгүүлүүд хаа сайгүй өрөөстэй.

- Та хоёр дэлгүүрээ ажиллуулахаа болио юу?

- Зарахаар болсон. Эгчтэйгээ мөнгөө хувааж аваад мөр мөрөө хөөнө. Эгч ирэх жилээс нөхөрт гарна. Олсон мөнгө маань сургуулийн гурван жилийн төлбөрт хүрэлцэх байх. Заваараа ажил хийгээд, эгчтэйгээ байр хөлсөлж сууна даа.

- Тэгээд зарагдах уу?

- Болох байх аа. Нэг танил маань нэхмэлийн утасны лангуу нээнэ гээд сураглаж байсан. Аавыгаа л өрөвдөх юм. Дэлгүүрээ нээх гэж хэрэндээ л зүтгэж, өр шир тавьж байж дарсан юм. Одоо харин ааваас минь гэхээр юм үлдсэнгүй.

- Чи гэж хүн байна гэхэд Мидори:

- Би юу? гэж хэлээд: -Дээшээ гаръя. Энд хүйтэн байна гэсээр шатаар өгслөө.

Бид дээд давхарт гарч, Мидори намайг ширээнд суулгаад, шүршүүрийн усаа халаав. Тэр зуур би цай чаналаа. Хоёул өөд өөдөөсөө харан цай уух зуур цагийн зүү чаг чаг хийж, хөргөгч дүнгэнэх агаад арван хоёр цаг болж байлаа.

- Ватанабэ, чи их дэггүй царайтай шүү.

- Тийм гэж үү?

- Надад ер нь царайлаг хүмүүс таалагддаг ч чамайг харах тусмаа ийм байсан нь дээр гэж бодох юм.

- Би ч хааяадаа тэгж санадаг л юм.

- Эв хавгүй хэлсэн бол уучлаарай. Санаснаа эвлүүлж хэлэхээр зарим нь буруугаар ойлгочихдог юм. Чи надад таалагддаг л гэж хэлэх санаатай.

- Мэднэ ээ гэвэл Мидори:

- Би эрчүүлийг бага багаар ойлгох гэж оролдож л байна гээд хайрцаг Марльборо гаргалаа.

- Сурах юм их байна аа.

- Тийм дээ.

- Аавын минь өрөөнд орж хүж барьж өгөөч гэсэнд хоёул тийш орж, хүж асааж, залбирал үйлдэв.

- Би нэг өдөр аавын зурагны өмнө нүцгэлсэн. Хувцсаа тайлаад биеэ удаан гэгч нь харуулсан. Иог хийж байгаа мэт суугаад, энэ хөх, энэ бэлэг эрхтэн гээд...

- Тэгдэг нь ямар учиртай юм бэ?

- Зүгээр харуулмаар санагдсандаа л. Энэ биеийн минь тал ааваас бүрэлдсэнийх харуулахад буруу юу байхав. Гэхдээ жаахан халсан байсан л даа.

- Хм.

- Эгч орж ирээд хөшиж орхисон. Аавын зурагны өмнө хөлөө дэлгээд нүцгэлсэн хойно аргагүй.

- Тэгж таарна.

- Би ч эгчид тайлбарлаж хэлсэн. Ийм учиртай тул Момо та ч өөрийгөө харуул гэж. Гэхдээ эгч тэгээгүй. Гайхаж байгаад л гараад явсан. Эгч маань хуучинсаг хүн л дээ.

- Чамайг бодвол энгийн л хүн юм.

- Аав минь чамд ямар санагдсан бэ?

- Би нүүрэмгий биш л дээ. Харин аавтай чинь хэл амаа дороо олсон шүү. Элдвийг хууч хөөрсөн.

- Та хоёр юу яриа вэ?

- Эврипидийн тухай.

Мидори “Хэзээ мөдгүй амьсгал хураах дөхсөн өвчтэй хүнтэй Эврипидийн тухай ярьж байдаг хүн чамаас өөр байдаг болов уу?” гэсээр тас тас хөхөрнө.

Мидори хонх цохиж:

- Аав минь, санаа зоволгүй тайван амар. Эгч бид хоёр хөлөө олчихно. Та минь энэ хорвоог орхисон болохоор өвчин зовлонгоосоо ангижирсан биз ээ. Үгүй бол бурханд гомдол мэдүүлээрэй. Тэнгэрийн оронд ээжтэй уулзаад халуун янагаар амраглаарай. Шээхэд чинь туслахдаа боожгойг чинь харж байсан. Бас л сүртэй эд байна лээ. Тийм болохоор үзүүлээд өгөөрэй. Сайхан амраарай.

Удалгүй хоёул ээлж дараалан усанд орж, би аавынх нь өмсөөгүй шахам унтлагын хувцсыг өмсөв. Мидори надад аавынхаа өрөөнд ор засч өглөө.

- Энэ өрөөнд айхгүй биз дээ?

- Муу юм хийсэн биш юунаас нь айхав.

- Г эхдээ унтгал минь тэвэрч байгаад яваарай, мэдэв үү?

- Ойлголоо.

Нарийн орон дээр нэг гараараа Мидориг тэвэрч хэвтэхэд богинохон үс нь хамар загатнуулна. Би хэдэнтээ унах дөхөж, нэг гараараа орны хүрээнээс зуурч хэвтлээ. Мидори энгэрт минь нүүрээ наагаад намайг тэвэрнэ.

- Сэтгэл сэргээхээр юм хэлээч.

- Юу тэр вэ?

- Хамаагүй ээ. Сэтгэлд таатай л бол болох нь тэр.

- Чи их хөөрхөн юм.

- Мидори гээд нэрээр минь дууд л даа.

- Мидори минь, чи их хөөрхөн юм.
- Хэр зэрэг хөөрхөн гэж?
- Сүмбэр уул нурж, сүн далай татармаар хөөрхөн. Мидори өндийгөөд өөдөөс ширтэв.
- Чам шиг ярьдаг хүн ховор шүү. Дахиад нэг сайхан үг хэлээч.
- Мидори минь, би чамд маш их хайртай.
- Маш их гэж хэр зэрэг вэ?
- Хавар ичээнээсээ гарсан бамбарууш ямар өхөөрдөм байдаг билээ. Яг л түүн шиг хайрладаг.
- Ичээнээсээ гарсан бамбарууш гэнэ ээ?
- Урин хавар тал хээрээр зугаалж явахад чинь ойн захаас дүрлэгэр нүдтэй, хамба хилэн шиг зөөлөн үстэй, дөнгөж төрсөн бамбарууш дөхөж ирээд “Чамтай тоглоё” гээд л зүлгэн дээгүүр бөмбөрч эрхэлбэл эгдүүтэй биз дээ? Энэ бамбаруушийг хайрладаг шиг чамдаа хайртай. Мидори энгэрт минь наалдаж:
- Ямар сайхан юм бэ? Ийм их хайртай хойно хэлснийг минь сонсож намайг зэмлэхгүй биз?
- Хаанаас даа.

Мидориг “Намайг халамжилж яваарай” гэхэд би “Тэгнэ ээ. Бүх юм сайхан болно” хэмээгээд зөөлөн үсийг нь илбэв.

- Гэхдээ л би айх юм.

Би түүнийг унтгал нь тэвэрч хэвтээд, чимээгүйхэн босч гал зуухны өрөөнд шар айраг ууж суулаа. Нойр хулжиж, өрөөнөөс нь ном олж харья гэсэн боловч Мидориг сэрээхээс эмээнэ.

Номын дэлгүүрт ирснээ гэнэт санаж, доош бууж үзвэл сонирхол татахуйц уран зохиолын ном байсангүй. Ингээд зарагдаагүй удсанаас шил нь шарласан Герман Гессегийн Дугуйн дор хэмээх номыг авч, лангуун дээр нь мөнгөө үлдээгээд дээш гарлаа. Кобаяшигийн номын дэлгүүрийн нэг ч атугай юм зарагдлаа.

Гал тогоонд шар айраг уунгаа номоо дэлгэлээ. Би дунд сургуульд орсон жилээ энэ зохиолыг уншиж байсан бөгөөд даруй найман жилийн дараа найзынхаа гал тогоонд, насан эцэслэсэн эцгийнх нь унтлагын хувцастай дахин уншсан нь энэ юм.

Хувь заяаны тохиолоор энд ирээгүй аваас энэ номыг дахиж сөхөх нь юу л бол.

Амьдралаас тасарсан хэсэг бүлэгтэй ч дажгүй ном. Чимээгүй орчинд гал зууханд суун, энэ номын мөр бүрийг шимтэн уншив. Тавиур дээр тоосонд дарагдсан брэндигээс хэд балгасан ч нойр хүрсэнгүй.

Гурван цагийн алдад Мидоригийн өрөөгөөр шагайвал гудамжнаас тусах цагаан гэрлийн туяанд бөх нойрсоно. Ойртоод сонсвол аавтайгаа адилхан намуухан амьсгалах аж. Аяллын цүнх нь орны хажууд, цагаан цув нь сандал дээр тавиастай. Ширээ нь эмх цэгцтэй бөгөөд ханан дээрээ Снүпигийн зурагтай хуанли наажээ.

Хөшгийг нь ялимгүй ярж, цонхоор өнгийвөл лангуунууд төмөр хаалтаа буулгаад, архины мухлагийн өмнөх хэдэн автомат үзэгдэнэ. Холын тээврийн хүнд даацын ачааны машины дуу хаа нэг хадна. Гал тогоонд орж, хундага брэнди хөнтрөөд, номоо уншлаа.

Үүрийн шаргал гэгээнээр ус буцалгаж, кофе найруулж уугаад ширээн дээр байх цаасан дээр ном худалдаж аваад жаахан брэнди ууснаа, өглөө болж харихаар явснаа бичиж үлдээв. Эцэст нь “Унтаж байхдаа чи их хөөрхөн юм” хэмээн нэмж бичлээ. Кофе уусан аягаа угааж, гал тогооных нь гэрлийг унтраагаад бууж, хаалтыг нь аажуухан өргөөд гарав.

Хавь ойрын улсад харагдаж сэжиглэгдэх вий гэж эмээсэн ч зургаан цагт гудамжинд нэг ч хүнгүй. Ганц хоёр хэрээ л дээвэр дээр суугаад,

гудамж ажиглана. Бүдэг ягаан хөшигтэй Мидоригийн өрөөний цонх өөд хэсэг харж зогслоо. Ингээд буудал хүрч унаанд суун, эцсийн зогсоол дээр буугаад байр луугаа алхлаа. Замдаа онгорхой кафегаар орж, халуун будаа, мисо шөл, ногооны шанцай, шарсан өндөг авч идэв. Ингээд байрныхаа араар тойрч, Нагасавагийн цонхыг тогшлоо.

Нагасава тэр дороо цонхоо нээж, намайг оруулаад кофегоор дайлах гэсэн ч би “Хэрэггүй” гээд, өрөөндөө орж хувцсаа тайлаад бөх гээч нь унтлаа.

Долоо хоног бүр Наокод захиа бичих авч тэрээр арван нэгэн сар болж оройдоо сэрүүссэн гэхээс өөр зүйлгүй богинохон хэдэн захиа илгээсэн юм.

“Чи налгар намрыг дагуулан Токио руу буцжээ. Чамаас хол болоод тэр үү, эс бөгөөс цаг цаашлаад тэгсэн үү, гансарч суух нь их боллоо. Рэйко бид хоёр чиний тухай их ярьдаг. Чамд мэнд дамжууллаа. Рэйко байгаагүй сэн бол эндхийн өдөр хоногийг өнгөрөөх аргагүй.

Ганцаардаж гиюүрсэн сэтгэлээ нулимсаар угаахыг хичээвч болж өгөхгүй нь. Ингэж суухад эгч минь болоод Кизүкигийн сүнс харуй бүрийгээс наашлан надтай ярих шиг болох юм. Тэд миний л адил ганцаардаж, хань татах шиг болдог.

Ийм үед захиаг чинь ахин дахин уншиж, сэтгэлээ хуурахыг хичээнэ. Гадаад ертөнцийн юм бүхэн аймшигтай санагдах энэ мөчид чиний захидлууд орь ганц итгэл найдвар минь болох юм.

Рэйко бид хоёр захиа зангаг чинь хэдэнтээ уншдаг. Мидоригийн эцгийн тухай дуулаад сэтгэл их хөдөллөө. *Долоо хоногтоо нэг ирэх захиа чинь бидний хувьд гэрэл гэгээ.*

Гэсэн хэдий ч үзэг бариад суух гэхээр сэтгэл нэг л уйтай. Рэйко хариу бичихгүйд минь зэмлэж л суудаг. Хэлж ярих юм үй олон боловч тэр бүхнээ цаасан дээр буулгаж чадахгүй нь.

Мидори хэмээх тэр нэгэн бүсгүй их хөгжилтэй нэгэн бололтой. Чи түүнд таалагддаг биз ээ. Рэйко нэгэнтээ “Ватанабэ надад ч гэсэн

таалагддаг” гэж хэлж байсан нь санаанд орлоо.

Ойрын хэдэн өдөр бид өдөр өнжилгүй мөөг, туулайн бөөр түүж, оройдоо туулайн бөөр, мацүтакэ мөөгтэй будаа идэх болсон. Их амттай. Рэико бага иддэг ч тамхиа баагиулсан хэвээр. Шувуудаа өвлийн байранд оруулсан.

Баяртай.”

Хорин нас хүрсний гурав хоногийн дараа Наокоогоос илгээмж ирсэнд хүрэн улаан өнгөтэй ноосон цамц байлаа. “Чамдаа хорин насны төрсөн өдрийн баярын мэнд хүргэе! Миний хувьд хорин нас минь хар бараан зурвас татуулан өнгөрлөө. Гэсэн ч чи минь хоёр биенийхээ өмнөөс аз жаргалтай байвал болох нь тэр.

Энэ цамцыг Рэико бид хоёр нэхсэн юм. Ганцаараа нэхвэл Валентиний баяраар дуусах шинжтэй. Арай дөнгүүр нэхээстэй нь Рэикогийнх, тааруухан шиг нь миний хийсэн ажил.

Рэико алтан гартай хүн юм. Хажууд нь би гэж амьтан хийж чадах юм гэж алга.

Биеэ бодоорой. Баяртай.”

Үүнээс гадна Рэико “Амьдрал дажгүй юу? Чиний хувьд Наоко тэнгэрийн амьтан бол миний хувьд юм хийж чадахгүй цагаан гартан юм. Гэхдээ л төрсөн өдрөөр чинь энэ цамцыг нэхэж дуусгалаа. Хээ хуарыг нь бид хоёр сонгосон юм. Таалагдаж байна уу? Төрсөн өдрийн баяр хүргэе!” гэсэн богинохон зурвас илгээжээ.

Аравдугаар

БҮЛЭГ

Миний хувьд 1969 он хөл алдам намаг шиг санагддаг юм. Алхах бүр гутал сугарчих шиг болж, нүд алдам намаг дундуур туучиж, хүмүүсийн бараа сураггүй энэ хүйтэн хөндий орчинд өдөр хоногийг ганцаар туулж явлаа.

Хорвоо ертөнц өөрчлөгдөж, хаа сайгүй өөрчлөлт шинэчлэлийн хуй салхи дэгдэвч нүдэнд үзэгдэж, гарт баригдахаар юм болсонгүй.

Харин би гэдэг хүн хаяа хязгааргүй энэ намаг дундуур толгой гудайлган туучиж явлаа. Энэтээгээс тэртээ хүртэл уудам их зайд сунаж тогтсон энэ орчинд хаа хүрэхээ мэдэхгүй хөлөө зөөсөөр л.

Хорьж болохгүй хорин насны минь намар шувтарч, цас мөстэй өвөл хаяанд ирлээ. Амьдралын хүрдэн эргэсээр, алаг өдрүүд ээлжилсээр байлаа. Долоо хоногтоо гурван өдөр ажиллаж, хааяахан АугааГэтсби-г сөхөж, ням гараг болуут Наокод захиа илгээж, угаалга хийнэ. Заримдаа Мидоритой уулзаж, амьтны хүрээлэн, кино театр орно.

Кобаяшигийн номын дэлгүүр шинэ эзэнтэй болж, Мидори эгчтэйгээ Мёгадани буудлын ойролцоо хоёр өрөө байр хөлсөлж суув. Эгч нь нөхөрт гармагц Мидори нүүнэ гэж билээ.

Тэр хоёр наран талдаа цонхтой, цэвэрхэн байр олжээ. Мидори номын дэлгүүрийн дээд давхарт амьдарч байснаасаа хавьгүй сэтгэл хангалуун байлаа.

Нагасава хэд хэдэн удаа “анд явахаар” уруу татсан ч би завгүй хэмээн бултав. Эмэгтэй хүнийг хүсэмжилж байсан ч таарч тохирох бүсгүйн эрэлд шөнийн гудамжаар сэлгүүцэж, архи дарсанд мансуурч, охид бүсгүйчүүдийн толгойг эргүүлж, ор хөнжилд орно гэхээс нэг бодлын залхаж билээ. Энэ адармаатай үйлийг ахин дахин гүйцэлдүүлэхийг тэмүүлэх Нагасавад гайхшрав.

Хацүмигийн хэлснийг дурсах бүр нэр усыг нь мэдэхгүй бүсгүйчүүлтэй нэг шөнийг өнгөрөөхөөс илүүтэй Наоког санагалзан суухад дотор уужирна. Хээр талд эрхлэн наадсан намрын тэр налгар өдөр санаанд тодхон үлджээ.

Арван хоёрдугаар сарын эхээр Наокод өвлийн амралтаараа очиж болох талаар захиа бичсэнд Рэико хариу илгээлээ. Наокогийн өмнөөс хариу илгээсэн ч хоёул намайг тэсэн ядан хүлээж буй гээд Наокод санаа зоволтгүй, бага зэрэг тавгүйрхнээс цаашгүй гэжээ.

Ингээд өвлийн амралт эхлэнгүүт би хувцсаа цүнхэлж, өвлийн гутлаа өмсөөд Киото руу гарлаа. Нөгөө эмчийн хэлсэнчлэн цасан нөмрөгтэй уулс ажин түжин дүнсийх нь зүйрлэшгүй сайхан ажээ.

Би урьдын адил тэр хоёрын өрөөнд хоёр хонож, өмнөхөөсөө ялгаагүй гурав хонолоо. Оройдоо Рэикогийн гитарын аялгуунд хууч хөөрч, өдөртөө цанаар гулгав.

Нэг цаг гулгахад хөлс цувж, амьсгал давхцана. Үүний сацуу цаг заваараа цас цэвэрлэхэд гар бие оролцов. Үдийн хоолны үеэр Мията эмч манай ширээнд сууж, хүний гарын дунд хуруу ямар учраас долоовор хуруунаас урт хийгээд хөлийн дунд хуруу долоовор хуруунаасаа богино байдгийн учрыг тайлбарлалаа. Манаач өвгөн Омүра мөнөөх л Токиогийн гахайн махны тухай яриа дэлгэнэ. Рэикод пянз бэлэглэсэнд магнай хагартлаа баярлаж, хэд хэдэн шинэ дууг нь ноотолж аваад гитар дээр тоглоно.

Намраа бодвол Наоко дуу цөөтэй болжээ. Гурвуулаа байхад “Санаа зоволтгүй ээ. Ийм үе байдаг. Ярихаасаа илүү сонсож суумаар байна” хэмээн хаа нэг үг унагаж, буйдан дээр инээмсэглэн суух агаад Рэико ам хамхилгүй ярина.

Рэико гарсан хойгуур Наокогийн булбарай уруул, энгэр цээжийг үнсэн таалахад тэр минь урьдын адил хагсаж тачаадсан сэтгэлийг минь тайтгаруулна. Өөрийг нь төсөөлөөд гар хангалга хийж байснаа хэллээ.

- Чи өөр хүнтэй дотносоогүй гэж үү?

- Үгүй ээ гэвэл Наоко:

- Тэгвэл энэ мөчийг битгий мартаарай хэмээгээд доош бууж өмдний минь цахилгааныг буулгаад зөөлөн хэлээрээ намайг энхрийлэхэд үс нь

гэдэс гижигдэнэ. Би хоёр дахиа дур тавилаа.

Наоког “Мартахгүй биз дээ?” гэж асуухад би “Хэзээ ч мартахгүй санаж явна аа” хэмээн хариулсан сан. Түүний жижигхэн төгөлд гараа хүргэвэл хуурай байлаа. Наоко толгой сэгсрээд гарыг минь холдууллаа.

- Би энэ хавраас байр хөлсөлж суухаар шийдсэн. Оюутны байранд байхаас залхаж байна.

- Ажил хийвэл амьдарч болох юм билээ. Чи надтай хамт амьдрах уу? Намар ирэхдээ хэлж байсан даа.

- Баярлалаа. Ингэж хэлж байгаад чинь үнэхээр баярлаж байна.

- Энд нам гүм аятайхан л газар. Рэйко ч сайн хүн. Гэлээ гээд удаад байх газар биш. Удах тусам эндээс явахад хэцүү.

Наоко будрах цасан ажиглан цонхны дэргэд чимээгүй зогсоно. Газар, тэнгэр хоёрын савслаганд хэсэгхэн орон зай л үлджээ.

- Би гурван сард байрнаасаа нүүх байх. Сайн бодоод хүссэн үедээ ирээрэй гэхэд Наоко толгой дохино. Хэврэг шилэн эдлэл барих мэт түүнийг зөөлөн тэвэрвэл хоёр гараараа хүзүүгээр минь ороов.

Би нүцгэн, Наоко цагаан жижиг дотуур өмд өмссөн байлаа. Сайхан бие цогцсыг нь хараад ханамгүй.

- Сэрэл мэдрэхүй минь чамтай учирсан тэр шөнөөс хойш дахиж сэргэсэнгүй. Би зөвхөн тэр өдөр л норсон. Хорин насныхаа төрсөн өдрөөр.

- Сэтгэл санаанаас болоо биз. Тайван байвал аандаа болно. Яарах хэрэггүй.

- Миний бүх асуудал сэтгэл санааных шүү дээ. Насан туршдаа хөрчихвөл, секс хийж чадахгүй болвол чи намайг хайрласаар л байх уу? Үргэлж гараараа, амаараа хийлгэхийг тэвчих үү? Эсхүл өөр эмэгтэйтэй унтаж шийдэх үү?

- Амьдралд өөдрөг байх хэрэгтэй гэхэд Наоко футболк, цамц, цэнхэр жийнсээ өмссөнд би ч хувцаслалаа. Наоко:

- Чамтай хамт амьдрах тухай сайн бодъё. Чи ч бодож үзээрэй хэмээв.

- Тэгнэ ээ. Чи сая гайхалтай байлаа гэхэд яльгүй улайж инээмсэглэв.

- Кизүки ч бас тэгж хэлдэг байлаа гэсэнд:

- Бид хоёр санаа бодол нийлэх нь их шүү гээд инээлээ. Хоёул гал тогоонд кофе уунгаа хуучнаа дурсав. Наоко аажмаар Кизүкигийн талаар ярьж чаддаг болсон юм. Энэ гурван өдөр цас бударч нар цухуйсангүй. Гурван сард эргэж ирнэ гээд явахад минь Наоко “Баяртай” гэсээр хоцорч билээ.

Төдхөн 1970 он гарч, өсвөр нас минь тэртээ хол одох шиг боллоо. Би ондоо нэг намагт алхаж орлоо. Хичээлээ таслалгүй идэвхитэй сууж, курсийн шалгалтуудаа амжилттай өглөө.

Үймээн самуунд нэгдсэн хэсэг оюутан байрандаа хамгаалалтын төмөр малгай, труба нууж, комендантын нөлөөнд байдаг тамирчин оюутнуудтай сөргөлдөн, хоёр ч хүн гэмтэж, зургаан залууг байрнаас хөөв. Дотуур байранд байн байн жижиг сажиг зодоон гарах болж, нэг удаад би өртөөд, тамирчин залуусын нэгэнд зодуулангаа алдвал Нагасава зохицууллаа.

Шалгалтаа өгөөд, дотуур байрнаас нүүхээр сэтгэл шулуудаж, долоо хоногийн дараа Кичижоүжид байрлах бэсрэгхэн байшин оллоо. Ёстой азаар олсон гэж болно. Том газрын нэг буланд цэцэрлэгийн манаачийн байр аятай торойсон ганц байшин байх агаад орхигдсон цэцэрлэгийн нөгөө захад байшингийн эзэд сууна. Тэд хашааны урд хаалгаар, би хойд хаалгаар орж гарах тул хэн хэндээ амар.

Хувцасны том шүүгээтэй унтлагын өрөө, жижиг гал тогоо, ариун цэврийн өрөө, бас болоогүй цэцэрлэг рүү харсан тагттай энэ авсаархан байшинг гэр бүлийн хоёр хөгшин ач хүү нь ирэх жил Токиод буцаж ирж болзошгүй, тэгсэн тохиолдолд чөлөөлж өгөх болзолтойгоор хямд хөлслүүлсэн юм. Гэрийн эзэд ааш сайтай, элдвийн болзол тавилгүй

дураараа амьдар гэлээ. Нагасава хаанаас ч юм бэ ачааны тэрэг хөлсөлж амласнаараа хөргөгч, зурагт, халуун сав зэргээ бэлэг болгон нүүхэд минь хамжив. Миний хувьд подхийсэн бэлэг.

Нагасава хоёр хоногийн дараа Мита руу нүүж билээ.

- Хоёулаа хэсэгтээ л уулзахгүй болов уу. Г эхдээ хорвоо бөөрөнхий хойно дээр хэлсэн шиг олон жилийн дараа хаа нэгтээ таарна вий.

- Болох биз дээ.

- Одоо бодоход зочид буудалд өрөөгөө сольсон тэр өдөр царай муутай бүсгүй нь хамаагүй дээр байсан санагдана.

- Би ч тэгж бодсон. Гэхдээ чи Хацүмид санаа тавьсан нь дээр. Сайн хүний сэтгэл сэвтэх нь амархан гэдэг.

- Бодох л юм. Хацүми надаас холдож чамтай нийлбэл сайхан л байх сан.

- Тоглох юмаа мөн олж дээ гэхэд Нагасава инээмсэглээд:

- Тоглосон юм. Ямартаа ч аз жаргал хүсье. Элдэв асуудал байгаа л бололтой. Гэхдээ чи чадалтай хүн амьдралд хөлөө олно. Зөвлөгөө гэмээр юм хэлэх үү?

- Хэл л дээ.

- Өөрийгөө өрөвдөж л болохгүй. Ухаан дутуу, харалган улс л өөрийгөө өрөвдөж явдаг юм.

- Санаж явъя.

Бид гар барин салцгаав. Нагасава шинэ ертөнцдөө хөл тавьж, харин би нөгөө л эцэс төгсгөлгүй үргэлжлэх намган дундаа үлдэх шиг боллоо.

Оюутны байрны ундуй сундуй байдал, толгой нь эргэсэн этгээдүүдээс нэг мөр холдож, шинэ газарт нүүсэн тухайгаа би гурав хоногийн дараа Наокод бичлээ. Энд сэтгэлээ сэргээж, шинэ амьдралд хөл тавина гэв.

“Байшин маань том цэцэрлэгтэй. Энд ойр хавийн муур нохой цуглах нь олонтаа бөгөөд завтай үедээ саравчинд сууж, наранд биеэ ээх муурнуудыг ажигладаг. Шинэ хүн ирсэнд дургүй байх шиг ч хуучин бяслаг өгвөл хэд хэдээрээ ирээд идэх юм. Чих нь унжсан нэг муур манай байрны коменданттай жигтэйхэн адилхан. Хэзээ мөдгүй төрийн далбаа мандуулах шиг санагдахыг нь яана.

Сургууль нэлээн зайтай ч өглөө хичээлгүй тул болж л байна. Метронд явах зуураа ном унших боломжтой учраас хол байсан нь дээр гэлтэй.

Энүүхэндээ долоо хоногт гурав дөрвөн өдөр ажиллаад байх газар олчихвол товхийтэл амьдарчих боломжтой.

Чамайг шавдуулмааргүй байвч хаврын улиралд аливаа зүйлийг эхлэх нь алсдаа өлзийтэй. Дөрөвдүгээр сараас нэг гэрт орвол сайхан л юм. Чи сургуульдаа эргээд орж болно. Хамт байхад төвөгтэй гэвэл хажууханд байр хөлсөлчих. Гол нь бид хоёр ойрхон байх нь чухал. Чи энэ хавар гэлтгүй зундаа ч ирэх боломжтой.

Удахгүй ажилд орж, сав суулга ч атугай авах хэрэг гарах нь. Ганцаараа амьдрахад аар саар зүйл хэрэг болох нь их юм. Гэсэн ч гуравдугаар сард Киотод очих завтай.

Чи боломжтой үедээ захиа бичээрэй. Чамтайгаа уулзах тэр өдрийг тэсэн ядан хүлээнэ.”

Би энэ хэдэн өдөр Кичижоүжигийн захаас аахар шаахар зүйл цуглуулж, хоолоо хийдэг боллоо. Ойрхон мухлагаас шахмал хавтан авч хөрөөдүүлээд бичгийн ширээ урлав. Хооллохдоо ч энэ ширээндээ суучихна. Тавиур хийж, төрөл бүрийн хоол амтлагч авлаа. Төдхөн зургаан сартай болов уу гэмээр нэг муужгай тэжээх болж, Цахлай хэмээн нэр өглөө.

Удалгүй холгүйхэн орших будгийн газарт хоёр долоо хоногийн турш туслахаар ажиллах болов. Цалин сайтай ч хүндхэн ажил байлаа. Будаг шингэлэгчийн үнэрт орой болгон толгой эргэнэ.

Ажлаа тараад хямдхан цайны газарт хооллож, шар айраг уугаад, харьж ирээд муужгайгаа эрхлүүлэн унтахаар хэвтэнэ. Хоёр долоо хоног өнгөрсөн ч Наокогоос сураг чимээгүй.

Ингээд нэг өдөр будаг түрхэх зуураа Мидориг гэнэт саналаа. Бодоод байх нь ээ, нүүх тухайгаа цухас дурдсанаас хойш гурван долоо хоног түүнтэй холбоо барьсангүй.

Утасны автоматаас Мидори рүү залгавал эгч нь бололтой бүсгүй харилцуур авч нэрийг минь асуугаад “Жаахан хүлээж байгаарай” гэсэн ч Мидори надтай ярьсангүй.

Мидори их ууртай байна. Өөртэй чинь ярьмааргүй байна гэнэ. Сураг ажиггүй алга болж болж гэв гэнэт гарч ирдэг сонин хүн юмаа. Мидори нэг уурлавал тайтгардаггүй хүн дээ. Одоо яая гэхэв гэдэг юм байна.

- Мидоритой уулзаж ярилцах гэсэн юм. Та дуудаад өгөөч.

- Тайлбар сонсмооргүй байна гэнэ.

- Тэгвэл хэлснийг минь дамжуулаад өгөөч.

- Би ямар нохойнд барьдаг мод уу? Эр хүн байж өөрөө учраа олно биз гэсэнд арга буюу уучлал эрж харилцуураа тавьлаа. Мидори бухимдах нь аргагүй.

Нүүдэл суудал, ажил төрөл гэсээр би Мидори байтугай Наоког тоотой хэдэн удаа бодсон. Хар багын л унтах нойр, идэх хоолоо умартан зорилго өөдөө тэмүүлдэг байлаа.

Мидори хэл үггүй нүүгээд гурван долоо хоног сураг чимээгүй болвол би ч яриангүй гомдоно. Хэдийгээр бид хоёр хайр сэтгэлтэй хосын адил уулзаж учирч яваагүй ч зарим талаар хос хоёроос илүүтэй нэгнээ ойлгох дотны андууд болжээ. Сэтгэлд минь ойр хүнээ санаандгүй гомдоосондоо гуниглаж гэмшив.

Ажлаа дуусгаад гэртээ ирж, ширээндээ суугаад Мидорид захиа бичлээ. Бодсоноо шулуухан буулгав. Өөрийгөө зөвтгөж тайлбар тавилгүй,

анзааргагүй загнасандaa уучлал эрж, гэртээ авчрахыг чин сэтгэлээсээ хүсч буй, хариу хүлээж суугаагаа хэллээ. Захиагаа шуурхай шуудангаар илгээсэн боловч хүлээгээд хүлээгээд хариу ирсэнгүй.

Тэр хавар миний хувьд захиа занaa хүлээсэн хавар байж билээ. Гэртээ харьж, аялал зугаалгаар явалгүй, цагийн ажил хийлгүй Наокогийн хариу захиаг хүлээж суулаа. Өдөртөө Кичижоүжигийн кино театрт кино үзэж, эс бөгөөс жааз хөгжмийн клубт ном уншиж сууна. Хэн нэгэнтэй уулзаж, үг сольсонгүй. Долоо хоног бүр Наокод будагчны өдөр тутмын ажил, Цахлай муужгай, дүфү худалдаалдаг сайхан сэтгэлтэй эмгэн, ногооны лангууны ааш муутай хүүхэн, цэцэрлэгт ургах тоорын мод, ганц бие эрийн хийж болох хоол ундны талаар бичих ч хариу нэхэж шавдуулсангүй. Гэсэн ч хариу ирсэнгүй.

Аажимдаа би хөгжим сонсож, ном шагайхаас залхаж, цэцэрлэгээ арчлах болов. Байрны эздээс шүүр, тосгуур, хүрз, савар, модны хайч олж аваад зэрлэгийг нь зулгааж, зүлэг ногоо, бут сөөгөө тэгшилж тордлоо. Жаахан торвдол цэцэрлэг маань тун аятайхан болов.

Хөрс шороотой зууралдах зуур байрны эзэн намайг дуудаж, саравчиндаа тухлан цай цүү болов. Тэрээр нэгэн компанид ажиллаж байгаад гавьяаныхаа амралтанд гарч, хойно нь даатгалын компанид жил хэртэй зүтгээд, хоёр жилийн өмнө ажлаа хүлээлгэн өгчээ. Хүүхдүүд нь тус тусын амьдралаа хөөж, хоёр хөгшин аялал зугаалгаар яван амар жимэр амьдрах болжээ.

- Сайхан юмаа гэвэл хөгшин:

- Их аялахаар уйдна. Ажилтай бол хамаагүй дээр гэнэ.

Тэр хавьд цэцэрлэгч байхгүйгээс хоёр хөгшин зүлэг ногоо, бут сөөгөө зөнд нь орхижээ. Өвгөн бага багаар тордож болох ч саяхнаас харшил нь хүндэрч, гар хүрэхээ байжээ. Хөгшин “Талархал гэх нь хаашаа юм бэ. Гэхдээ энд байгаа юмнаас хэрэгтэй юм байвал авч болно шүү” гэв. Амбаарт нь дээр үеийн модон ванн, хүүхдийн усан сангаас авахуулаад бейсболын цохиур зэрэг элдэв зүйл овоолоостой. Би хуучин дугуй, хоёр сандалтай хоолны ширээ, толь болон гитар олоод “Эдгээрийг түр авч болох уу?” гэсэнд хөгшин “Дуртайгаа ав даа” гэлээ.

Зэвэрч хуучирсан дугуйг өдөржин зүлгэж тослоод дугуйг нь хийлж, арааг нь тохируулаад, засварын газарт троссыг нь солиулаад гялалзсан дугуйтай болоод авав. Ширээнийх нь тоос шороог арчиж лакдлаа. Гитарын утаснуудыг сольж, самбарыг нь наагаад, тэвхний зэвийг төмөр сойзоор эвтэйхэн зүлгэж цэвэрлээд хөглөвөл дажгүй дуугарч байна.

Ахлах сургуулиа төгссөн жилээ гитар барьж байсан ч тэр үед тоглож сурсан аялгуу санаанд үлджээ. Тагтан дээрээ суугаад The TrifTERS-ийн Up on the roof -ийг аядуухан тоглож үзэв. Гайхалтай нь ихэнх хэсэг нь мартагдаагүй аж.

Шуудангийн хайрцаг урлаж, улаанаар будаад нэрээ бичиж, үүдэндээ өлгөлөө. Дөрөвдүгээр сарын гурван хүртэл ирсэн ганц захиа нь Кизүкитэй хамт сурч байсан ангийн нөхдийн уулзалтын зар. Тэгэвч ангийнхантайгаа уулзах хүсэл даанч төрсөнгүй. Учир нь тэр ангид би Кизүкитэй хамт сурч байлаа. Тэр захиаг би шуудхан хогийн саванд чулуудав.

Харин дөрөвдүгээр сарын дөрвөнд Рэйкоогоос захиа ирлээ. Дугтуйны ард Ишида Рэйко гэжээ. Муу совин татаж захиаг задалвал үнэндээ сайн мэдээ дуулгасангүй.

Наокогийн сэтгэл тавгүйтэж, захиа занга бичиж чадахааргүй болжээ. Рэйко өмнөөс нь хариу илгээе гэсэн боловч тэрээр өөрөө бичнэ гээд халгаагаагүй юмсанж.

“Сар гаруй хариу хүлээлгэсэнд өршөөгөөрэй. Энэ зуур Наоко нэлээд хүндхэн байлаа. Цаадах чинь тайвшрахыг хичээж байгаа ч байдал сайнгүй л байна. Арван хоёр сарын сүүл, нэг сарын эхээр захиа бичиж чадахаа больж, хий юм сонсож эхэлсэн юм. Одоо бодоход, энэ нь өвчин сэдэрсний анхны шинж тэмдэг байж. Үзэг бариад суухад нь элдвийн яриа дуулдаж, үг үсгээ холбож чадахгүй болсон. Чамайг ирэхэд энэ байдал хүн анзаарахуйц байгаагүй. Сэтгэлийн өвчтэй улс хааяахан хий юм үзэж дуулах нь бий.

Гэсэн ч явснаас чинь хойш Наоко өдрөөс өдөрт сэтгэлээр унаж, өдгөө ойр зуурын юм ярихдаа ч ээрч муурдаг боллоо. Өөрөө үүндээ сэтгэл

зовниж, айж шаналдаг болоод хий юм сонсох нь ихсээд байна.

Бид хоёр өдөр болгон эмчтэй ярилцаж байгаа боловч үр дүн муутай л байна. Чамтай хамт дөрвүүл ярилцъя гэсэн ч Наоко дургүйлхсэн. Өвчин зовлонгоосоо ангижирч, сэтгэлдээ сэвгүй чамтай уулзах хүсэлтэй юм. Аль болох хурдан эдгэх нь чухал гэж ятгаад дийлсэнгүй.

Энд хэдий мэргэжлийн эмч нар зөвлөгөө өгдөг ч эрчимтэй эмчилгээ хийдэггүй бөгөөд энэ байдал нь даамжирвал Наоког эмнэлэгт шилжүүлэхээс өөр аргагүй. Хэсэг хугацаанд эмчилгээ хийлгэж байгаад буцаад ирж болно л доо. Эмчилгээ нь үр дүнтэй байваас эмнэлгээсээ шууд гарах ч боломжтой. Ямартаа ч бид бүгд Наокод тусалж байна. Наоко ч хичээх юм. Чи ч мөн адил түүний төлөө залбираарай. Урьдын адил захиа бичиж байгаарай.

3-р сарын 31.

Ишида Рэйко”

Би Рэйкогийн захиаг уншиж дуусаад цэцэрлэг рүү харсаар байлаа. Урин хавар ирж, хөгшин уц цэцэглэжээ. Сэвшээ салхи үлээж, нар дулаан илчээ илгээнэ. Төдхөн Цахлай гүйж ирээд, тагтны шалыг хэсэг маажилж байгаад хөлд тэрийгээд унтлаа.

Энэ тухай бодож эргэцүүлсэн ч оюун санаагаа төвлөрүүлж дөнгөсөнгүй. Цаг нь ирэхээр болно хэмээн сэтгэлээ тайтгаруулж, өдөржин гадаа суулаа.

Тамираа барсан хөгшин шиг жаргах наран, үдшийн бүрий, сакүрагийн цэцэгсийг ажиглан суулаа. Цахлай Хэдийн нэг тийш оджээ. Харанхуйд сакүрагийн модод арьсаа түрсэн мах мэт үзэгдэнэ. Ялзарсан махны үнэр цэцэрлэгээр нэг тарна. Наокогийн төгс бие цогцсыг санагалзлаа. Харанхуйд хэвтэх биеэс нь түмэн нахиа ургасан нь үл мэдэг салхинд чичрэн найгана. Байгаль эхийн урлан байж бүтээсэн энэ бүсгүй юуны учраас өвчин зовлонд энэлэн шаналах учиртай юм бэ? хэмээн хэдэнтээ бодож билээ.

Өрөөндөө орж хөшгөө хаасан ч хаврын үнэр анхилна. Хавар айлчилж, хаа сайгүй навч ногооны анхилуун үнэр тархах ч сэтгэл минь ялзрах мэт. Энэ хаврын дайж ирсэн гашуун мэдээ биеэр минь нэвчиж, эхээс төрсөн тэр цагаас хойш мэдэрч байгаагүй үзэн ядах сэтгэлийг өдөөгөөд явлаа.

Би тэнгисийн ёроолоор алхах мэт орчин тойрноос тасарч, өлсвөл ус ууж, тааз ширтэн гөлийж хэвтээд, гуниглавал виски балгаж унтсаар гурав хонолоо. Өнгөт орчлонгоос тусгаарлагдаж, хэн бугай ч надад хүрч мэдэрч чадахгүй мэт санагдах болов.

Үүний сацуу 4-р сарын 6-нд Мидоригоос захиа ирлээ. Аравны өдөр их сургуулийн цэцэрлэгт хүрээлэнд уулзъя гэжээ. Арванд хичээлийн шинэ жилийн цагийн хуваарийг зарлах учиртай.

Мидори намайг хэл үггүй алга болсонд унтууцаж, сэтгэлээ зогоох гэсэндээ зориуд хэд хоног шаналгаад хариу бичсэн нь энэ байж. Түүнийхээр ингэснээр хайнцсан юмсанж. Тийм ч учраас одоо эвлэрье. Ганцаардаж байгаа тул андын холбоогоо сэргээж, хоолонд орё гэжээ. Захиаг нь дөрвөнтөө уншсан ч энэ хэдэн өгүүлбэрийн учир начрыг ойлгосонгүй. Энэ захиа ямар учиртай сан билээ? Үг өгүүлбэрүүдийн утга агуулга нь авцалдахгүй гэлтэй. Лекцийн хуваарь зарлах өдөр уулзах нь бид хоёрын хайнцсантай хамааралтай сан уу? Ямар учраас хамт хооллоё гэв? Би ч эргүү болсон дог оо.

Тэр өдрүүдэд толгой дүүрч эргээд, байх суух газраа олж ядаж явлаа.

Чухам энэ үед энэ мэт сууж болохгүйгээ ухаарч, Нагасавагийн “Өөрийгөө бүү өрөвд” гэснийг санаж сэхээрсэн юм. Нагасава минь, чи голыг нь олж хэлжээ. Санаа алдаад өндийлөө.

Ингээд хэдэн өдөр гар хүрээгүй орон байраа эмхэлж цэгцлээд усанд орж, үс зүсээ янзлаад, дэлгүүр орж хүнсээ цуглуулж, хоол хийж идлээ. Хэдэн өдөр өлсгөсөн Цахлайгаа ч цатгав. Шар айрагнаас өөр хатуу ундаа уусангүй, хагас цаг дасгал хийлээ. Сахлаа хусахаар толинд харвал энэ хэдэн өдөр би гэж хүн чамгүй туржээ.

Маргааш өглөө нь дугуйгаар нэлээн хол явж ирээд Рэйкогийн захиаг дахиж уншив. Алсдаа хэрхэх тухайгаа нухацтай бодлоо. Энэ захиа Наокотой хамт байхыг тэмүүлж хөөрсөн сэтгэлийг минь царцаасан юм. Наоко эртнээс сэтгэлийн зовиуртай болсноо хэлж байсан ч хоёр удаа очиход илаарших мэт санагдаж билээ. Уг нь бодит ертөнцтэй нүүр тулж чадваас эдгэрэх нь гардаагүй хэмээн бодсон сон. Гагцхүү энэ бүхнийг даван туулах эрч хүч, хүсэл эрмэлзэлтэй байхад ард нь гарч л таарна.

Ийнхүү төсөөлж цогцлоон бүтээсэн орд харшийг минь Рэйкогийн захиа юу ч үгүй нураажээ. Энэ удаа Наоко эдгэрлээ ч урьд урьдынхаасаа илүүтэй шанална гэдгийг би гадарлахтай. Гэсэн ч оюун бодлоо хурцалж, амьдралыг сөрж, Наоког илааршихыг хүлээхээс өөр аргагүй.

Кизүки минь, чамаас ялгаатай нь би зөв амьдрахаар шийдлээ. Чамд хэцүү байсан ч чи энэ будант орчлонд Наоког орхиж явсан учраас надад ялгаагүй хүнд байна. Гэлээ ч би Наоког орхихгүй. Би түүнд хайртай, түүнээс эрч хүчтэй. Энэ бие сунаж, эрийн цээнд хүрч, ухаан тэлж, уужим хорвоог туулах болно. Үүнээс өөр нэгээхэн ч зам үгүй.

Эдүгээ хүртэл арван долоо, наймтай хөвгүүн чигтээ үлдэхийг хүсч явсан ч өдөр хоногийг элээх тусам үүрэг хариуцлага гээчийг ухамсарладаг болох юм. Кизүки минь, бид хоёрын нөхөрлөж явсан арван долоон нас минь Хэдийн ард хоцорчээ. Хорь хүрч хотол олны дунд орох үе минь хаяанд иржээ.

- Ватанабэ, чи чинь ямар их тураа вэ?

- Турсан байна гэж үү?

Мидориг “Нөгөө нөхөртэй бүсгүйтэйгээ их наргижээ дээ” гэсэнд би инээд алдан толгой сэгсэрлээ.

- Арван сараас хойш бүсгүй хүний өвөрт орсонгүй гэвэл Мидори дуу шуутай исгэрээд:

- Хагас жил тийм юм хийгээгүй гэж үү?

- Тийм ээ.

- Бүр нүднээс гарчихаж.

- Буурь суусан байлгүй.

Мидори мөрөн дээр минь гараа тавиад, өөдөөс ширтэж хэсэг ширтээд, хөмсгөө зангидаж байснаа инээмсэглэлээ.

- Нэг л өөр болжээ.

- Том болоод тэр биз.

- Сүрхий юм боддог хүн буурь суух нь аргагүй ээ. Өлсчихлөө, явж хоолонд оръё гэсээр сургуулийн арын жижиг цайны газар орлоо.

Хоёул иж бүрдэл захиалж энгүүн ярилцав.

- Хариу бичихгүй удсанд уурлав уу?

- Хаанаас даа.

- Чамайг сураг чимээгүй болохоор нь зориуд удсан юм. Чамайг уучлал гуйгаад байхад арай ч дэндүүлэв үү? Юу гэж бодож байна?

- Миний буруу хойно яая гэхэв.

- Эгч намайг ууч сэтгэлгүй, хүүхэд шиг аашлаад гээд загнаж байна лээ.

- Одоо бол надаас хариугаа авч санаа амарсан биз?

- Тийм ээ.

- Тэгвэл болж дээ.

- Уужуухан хүн юмаа. Чи үнэндээ хагас жил иймээ тиймээ болоогүй гэж үү?

- Тийм ээ.

- Тэгвэл манайд хоносон тэр өдөр их л хүссэн байх даа.

- Магадгүй л юм.

- Тэгээд яаж...

- Чи бид хоёр дотно андууд болсноос хойш тийм харьцаанд орж алдмааргүй санагдсан.

- Тэр шөнө чи намайг оролдсон бол би ч буцахааргүй байсан шүү.

- Миний нөгөө юм томоо гэдгийг чи мартжээ дээ гэвэл Мидори инээд алдан гараас минь хөтөллөө.

- Би аль хэдийн чамд бүрэн итгэдэг болсон. Тэгээд л тэр шөнө тайван унтсан. Дэргэдээ байхад юунаас ч айхгүй шүү. Тэр шөнө нам унтсан байна лээ.

- Тийм ээ.

- Гэхдээ л чи “Мидори, чамайг хүсч байна. Бүх юм сайхан болно” гэсэн бол өвөрт чинь яваад л орох байлаа. Чамайг өдье гэсэндээ ингэж хэлээгүй шүү. Тэр үед үнэндээ тэгж л бодсон.

- Би мэднэ ээ.

Мидори бид хоёр энэ жил хоёр хичээлд хамт суухаар болжээ. Энэ нь долоо хоногт хоёр удаа уулзана гэсэн үг. Мидори эгчтэйгээ шинэ байрандаа айвуу тайвуу орчинд дасах гэж чамгүй уджээ. Аавыгаа асрах, дэлгүүрээ ажиллуулах гээд толгой өндийх завгүй байсан бүсгүйчүүлд тааваараа амьдрах нь их л сонин санагдсан гэдэг.

- Хүн гэдэг амьтан ингэж эрх дураараа амьдрах шиг сайхан юм үгүй биз дээ. Эхлээд хийх юмгүй санагддаг байсан ч эгч бид хоёр дэндүү давчуухан орчинд амьдарч байсан юм билээ. Хэзээ мөдгүй тэр өдрүүд эргээд ирнэ гэхээс тайвширч чадахгүй байлаа. Одоо бага багаар дасч л байна. Зовох цаг байхад жаргах өдөр ирдэг гэж үнэн юм.

- Та хоёр шиг улс чадна аа. Эгч чинь юу хийж байна?

- Найз охин нь саяхан гоёл чимэглэлийн дэлгүүр нээсэн. Тэнд долоо хоногтоо гурван өдөр ажиллаж байгаа. Чөлөө заваараа хоол хийж сураад, найз залуутайгаа уулзаж кино үзнэ. Гэртээ суугаад их л баяртай байгаа.

Мидори аж байдлыг минь асууж, би байрныхаа зохион байгуулалт, цэцэрлэг болоод Цахлай муужгай, байрны эздийн талаар ярьлаа.

- Тэнд хөгжилтэй байна уу?

- Дажгүй шүү.

- Тэгээд юу болоод уруу царайлаа вэ?

- Харин тийм ээ, хавар болсон ч...

- Хайртай бүсгүйнхээ нэхэж өгсөн улаан цамцыг өмссөн ч барайгаад л суух юм.

Гайхсандаа “Чи яаж мэдсэн юм бэ?” гэвэл Мидори:

- Гэнэн гэдэг нь. Харваас л илт байхад. Юу болоод барайчихаа вэ?

- Уг нь хөгжилтэй л байгаа юм сан.

- Чи амьдралыг хайрцагтай жигнэмэг л гэж бодох хэрэгтэй.

- Хэлснийг чинь заримдаа ойлгохгүй би гэж хүн тэнэг юм шиг байна аа даа.

- Хаанаас даа. Жишээ нь, тэр хайрцганд чиний дуртай болоод дургүй төрөл бүрийн жигнэмэг байлаа гэж бодъё. Дуртайгаа эхлээд идчихвэл дургүй жигнэмэг нь үлдэнэ. Амьдрал үнэндээ хайрцагтай жигнэмэгээс огт ялгаагүй шүү дээ. Зовж шаналсан үедээ би энийг даваад гарчихвал сайхан цаг ирнэ дээ гэж боддог доо.

- Амьдралын тухай нэг ёсны үзэл бодол юмаа даа.

- Ингэж бодвол хүн сэргээд л явчихна. Би ч хал үзэж, хашир суусан хүн шүү.

Бид хоёрыг кофе уух зуур Мидоригийн ангийн бололтой хоёр бүсгүй орж ирээд, гурвуул цагийн хуваариа харж, герман хэлний шалгалт шүүлэг, улс төрийн бүлгэмийнхний үймээн самуун, хэн нэгний дэгжин гутлын тухай хэд гурван үг солилоо. Бүсгүйчүүдийн яриа орчлонгийн нөгөө захаас дуулдах шиг хол хөндий сонсогдоно. Кофе уунгаа цонхоор ширтлээ.

Уд модод цэцэглэж, хаврын урь орсон энэ өдөр шинэхэн оюутнууд сурах бичгээ сугавчилж явна. Энэ жил сургуульдаа орж чадаагүй Наоког санахуйя харуусмаар. Бүх зүйл гэв гэнэт утгагүй санагдсан сан. Хоёр бүсгүй явсны дараа Мидори бид хоёр гарч, гудамжаар зугааллаа.

Хуучин номын дэлгүүрээс хэдэн ном авч, дахиж кафе орж кофе уугаад пинбол тоглож, цэцэрлэгт хүрээлэнгийн модон сандал дээр суугаад ярьлаа. Ихэвчлэн Мидори ярьж, би аан уун гэсээр суув. Мидоригийн ам цангаж, дэлгүүрээс кола авчрах зуур тэрээр нэг юм бичиж байв.

- Юу бичээ вэ? гэвэл Мидори:

- Онц юм биш ээ гээд гурав гуч болмогц эгчтэйгээ Гинзад уулзана хэмээн явлаа.

Бид хоёр метроны буудал дээрээс тус тусын чиглэлдээ суухын өмнөхөн Мидори гэртээ очоод уншаарай гэсээр дөрөв нугалсан цаас халаасанд минь шургуулав. Би метронд суугаад Мидоригийн захиаг уншлаа.

“Чамайг кола авахаар явсан хойгуур энэ захиаг бичлээ. Амьдралдаа анх удаа дэргэдээ суух хүндээ захиа бичиж байгаа минь энэ. Хэлэх гэсэн үгээ үүнээс өөрөөр хүргэх арга алга. Хэлсэн ярьсныг минь чи анзаарч дуулсан нь юу л бол.

Чи өнөөдөр муухай зан гаргаснаа мэдэж байна уу? Үсээ засуулсныг минь хүртэл анзаарсангүй. Үсээ ургуулж, эмэгтэй хүний шинжтэй болох гэж хэрэндээ их л хичээлээ. Уулзаад анзаарах байх гэж бодсон ч

чи ер тоосонгүй. Сайхан зохисон учир гайхуулья гэж байтал ер анзаарсангүй. Дэндүү биш гэж үү?

Хувцас хунарыг минь ч тогтож хараагүй биз дээ. Би ч гэсэн ялгаагүй эмэгтэй хүн. Өөрийн бодолдоо дарагдлаа гэхэд дэргэдэх эмэгтэй хүнээ халт харчихаж болно доо. “Үсээ сайхан засчээ” гээд хэлчихсэн бол хэлсэн ярьсныг минь дуулаагүй ч би ойлгох байлаа.

Би одоо чамд эгчтэйгээ уулзана гэж худал хэлнэ. Уг нь өнөөдөр танайд хоноё гэж бодоод унтлагын хувцас, шүдний сойзоо цүнхлээд явж байсан ч чи намайг урьсангүй. Тийм ч учраас эгчтэйгээ уулзана гэж худал хэлэхээс өөр арга мухардлаа.

Би гэж гэнэн хүн юм. Чамд над шиг хүн хэрэггүй юм байна. Ганцаараа байхыг хүсээд байвал дураараа бол доо. Садаа болохоо больё.

Хүнд хэцүү үед минь түшиж тулсан чамд хань больё гэж бодсон юм. Сэтгэлийн чинь хаалгыг хичнээн тогшоод чи онгойлгохгүй нь. Гэхдээ чамд уурлаагүй. Хүнд хэцүү үед тусалсан чамд тусалж чадахгүйдээ гуниглах юм.

Чи одоо ундаа аваад бодолд дарагдан ирж явна. Тээгэлдэж унаад сэхээ ороосой гэж хүсэх ч хүслээр минь болсонгүй.

Хажууд минь суугаад “Чи үсээ засуулчихаа юу?” гэхэд би энэ захиаг урж хаяад “Танайд очиж үзье. Хоёулаа сайхан хоол хийж идье” гэж хэлэх байлаа. Гэсэн ч чи аанай л намайг анзаарсангүй. Чи хүйтэн хөндий хүн юм.

Баяртай.

Лекцэн дээр тааралдвал надтай битгий дуугараарай.”

Би Кичижоүжигийн буудал дээр бууж, Мидори руу залгасан ч хариу өгсөнгүй. Ингээд хийх юмгүй сэлгүүцэн хичээлийн хажуугаар хийчих ажил хайлаа.

Бямба, Ням гарагт бүтэн, Даваагаас Пүрэв гарагийн оройн таван цагаас хийчих ажил олоход хэцүү. Оройн хоолны хүнс авах далимдаа Мидори руу дахиж залгавал эгч нь “Эргэж ирээгүй байна. Хэзээ ирэхийг нь мэдэхгүй” гэж билээ. Би баярлалаа гээд утсаа тавилаа. Оройн хоолны дараа Мидорид захиа бичихээр суусан ч дорвитой юм санаанд орсонгүй. Ингээд Наокод захиа илгээхээр шийдлээ.

Хавар болж, хичээлийн шинэ жил эхэлж, уулзаж чадаагүйдээ харамсаж буйгаа бичлээ. Ямар ч атугай уулзах хүсэлтэй байсан ч санаснаар болсонгүй. Гэхдээ сэтгэлийн хаттай байхаар шийдсэн. Учир нь өөр хийж чадах зүйл алга гэлээ.

“Өөр нэг зүйл хэлэхэд, би хэнтэй ч унтаагүй. Чиний зөөлөн гар, булбарай уруулыг санах төдий өөр нэгэнтэй өвөр түрийдээ орох хүсэл төрөхөө болилоо. Миний хувьд тэр мөчийг дурсан санагалзах нь юу юунаас чухал.”

Захиагаа дугтуйлж, марк наагаад хэсэг харж суув. Энэ удаагийн захиа богинохон ч гэлээ бодол санаагаа шингээж чадсан шиг санагдана. Би виски хундагалж, түүнээ хоёр балгаж уугаад унтахаар хэвтэв.

Маргааш нь Кичижоүжигийн буудлаас холгүй байрлах итали хоолны газарт амралтын өдрүүдээр хийж болох ажил оллоо. Цалин багатай ч хоол ундтай, унааны мөнгө нэмж өгдөг байлаа. Үүнээс гадна ажлын өдрүүдэд оройн ээлжийн зөөгч чөлөө авсан үед оронд нь ажиллах боломжтой. Пянзны дэлгүүрийн луйварчин зохион байгуулагчийг бодвол энэ газрын менежер нь дажгүй хүн юм. “Гурван сарын дараа цалин хөлсөө нэмнэ. Энэ долоо хоноогоос ажиллаж эхэлвэл сайн” гэж билээ.

Мидори руу дахин залгасан ч эгч нь түүнийг өчигдөр гараад ирээгүй гэхээс өөр юм хэлсэнгүй. Би ч ялгаагүй хаа явсныг нь мэдэх сэн. Танд мэдэх юм алга уу? гэж дорой дуугаар асуув. Цүнхэндээ унтлагын хувцас, шүдний сойзоо хийчихсэн явааг нь л мэдэж байлаа.

Лхагва гарагийн лекцэн дээр Мидориг олж харлаа. Ногоон ноосон цамц, зун зүүдэг байсан хар нүдний шилээ зүүжээ. Арын суудалд нүдний шилтэй шавилхан бүсгүйтэй суугаад ярина. Дөхөж очоод

хичээл тараад ярилцъя гэвэл эхлээд өнөө бүсгүй, дараа нь өөрөө өөдөөс харлаа. Үсээ засуулсанд урьдынхаас илүү эмэгтэйлэг болжээ. Гэхдээ бага зэрэг овор суусан мэт.

Мидори хариу болгож “Би хүнтэй уулзах ёстой” гэдэг юм байна.

- Би удахгүй ээ. Таван минут л болно гэсэнд “Чамтай ярих хүсэл алга” гэлээ.

Энэ үед нүдний шилтэй бүсгүй “Чамтай ярих хүсэлгүй гээд байхад” гэсэн шиг хулмалзана.

“Теннеси Уильямсын шог жүжгүүд ба Америкийн уран зохиолд түүний эзлэх байр суурь” хэмээх энэ удаагийн лекц тармагц гурав тоолоод эргэж харвал Мидори гараад явчихжээ.

Над шиг гон бие гозон толгой хүнд нар ээсэн дөрөвдүгээр сар уйтгар гунигаар дүүрэн өнгөрлөө. Залуус хувцсаа нимгэлж, хос хосоороо зугаалаад, хүүхдүүд бөмбөг хөөнө. Харин би орь ганцаараа.

Наоко, Мидори, Нагасава гээд дотны андууд минь хэдийн холджээ. Мэнд мэдэлцэх хүнгүйдээ Довтлогчийг хүртэл санагалзах боллоо. Дөрөвдүгээр сарыг ийн тайтгаршгүй ганцаардсаар үдэв.

Мидоритой хэдэнтээ үг солих гэсэн ч болж бүтсэнгүй. Ярьмааргүй байна гэх нь үнэн голоосоо тэгж бодсон аястай. Мидори нүдний шилтэй бүсгүй, эс бөгөөс богино үстэй өндөр залуутай хамт явдаг байлаа. Тэр залуу жигтэйхэн урт хөлтэй бөгөөд сагсан бөмбөгийн цагаан пүүзнээс өөр гутал өмсөхгүй.

Таван сар гарч, би байж суух газраа олж ядан, ганцаардаж гиюүрэх боллоо. Нар жаргах цагаар цэцэрлэгтээ суухад замбага цэцгийн үнэр сэнгэнэж дотор бачуурна. Нүдээ анин бүхий л ертөнцийг далдханаа мэдрэхийг хичээвч сэтгэл зүрх минь хоосорч, битүү өвдөх шиг.

Энэ мөчүүдэд би Наокод захиа бичиж, сэтгэлд таатай, баяр хөөртэй хором бүрээ цаасан дээр буулгадаг сан.

Өвс ногооны үнэр, хаврын салхи, унших дуртай ном, сонсох дуртай хөгжим, саяхан үзсэн киноныхоо талаар бичнэ. Захиагаа уншихад хүрээлэн буй орчин минь өнгө будгаар алаглаж, дур булаам болох аж. Хэд хэдэн захиа илгээсэн ч Наоко, Рэйко хоёроос хариу ирсэнгүй.

Би итали зоогийн газарт зөөгч хийж байхдаа Ито хэмээх нас чацуу оюутантай танилцсан юм. Урлагийн сургуулийн уран зургийн ангид сурдаг даруу төлөв залуу. Аажимдаа бид хоёр нөхөрлөж, ажлаа тараад хаа нэг газар орж шар айраг балган хууч хөөрдөг боллоо.

Ито өндөр нуруутай, царайлаг бөгөөд урлагийн хүн гэхэд богинохон үстэй. Дуу цөөтэй ч, сонирхол татахуйц тодорхой үзэл бодолтой. Жорж Батай, Борис Виан зэрэг франц зохиолчдын зохиол бүтээл, Моцарт, Морис Равелийн аялгуунд дуртай нэгэн. Тийм ч учраас энэ тухай хэдэн үг солих миний л адил, энэ тухай хууч хөөрчих хүн хайж байсан бололтой.

Тэрээр Инокашира цэцэрлэгт хүрээлэнгийн ард байрлах этгээд шийдэлтэй, нэг давхар байранд амьдарна. Нэг удаа урьсанд ороод гарвал өрөөгөөр нь дүүрэн зургийн хэрэгсэл байлаа. Зургийг нь үзье гэсэнд Ито зурсан зургаа хүнд үзүүлэхээс ичдэг гээд хавьтуулсангүй.

Бид хоёр Итогийн ааваасаа нууж авсан вискиг хувааж уунгаа шавар зуухан дээр загас шарж, Моцартын концерт сонсов. Итогийнх Нагасакид байх агаад тэндээ найз охинтой байснаа орхиод иржээ. Сүүлийн үед харилцаа нь хөрсөн гэх юм.

- Чи эмэгтэйчүүдийг мэднэ дээ. Хорь, хорин нэг хүрээд урьдын сайн сайхан бүхнээ үгүйсгээд эхлэх юм. Материаллаг, бодит юм сонирхоод эхэлдэг ч юм уу. Жишээ нь, найз охин маань сүүлийн үед байнга л сургуулиа төгсөөд яах вэ? гэх болсон.

- Чи тэгээд яах гэж байна?

- Зураач хүнд олигтой ажил олдохгүй л дээ. Сургууль төгслөө гээд сурсан мэдсэнээрээ ходоодоо тэжээх нь юу л бол гэхээр Нагасакид буцаад ир. Зургийн багш бол гэнэ. Найз охин маань англи хэлний багш болж байгаа л даа.

- Чи найз охиндоо тийм ч сайн биш юмаа даа.

- Харин тийм бололтой. Сармагчин шиг сахилгагүй, хүмүүжилгүй хүүхдүүдэд нэг насаараа зураг заамааргүй байх юм.

- Тэр ч тийм байж. Ер нь эртхэн хоёр тийшээ болсон нь дээргүй юу?

- Уг нь тийм. Гэхдээ хэлэх аргаа олдоггүй. Тэр надтай нэг гэрт орох хүсэлтэй болохоор хоёр тийш больё гээд палхийтэл хэлчихэж чадахгүй нь.

Бид хоёр мөсгүй виски ууж, загасаар даруулаад загас дуусмагц өргөст хэмх урт нарийн хэрчиж, цуунд дүрж идэв.

Өргөст хэмх хүр хүр хийж идэхэд Мидоригийн эцэг санаанд орлоо. Мидори надаас холдож, би гэж хүн ганцаардлын туйлыг мэдэрнэ. Тэр бүсгүйг ингэж үгүйлнэ чинээ бодож явсангүй.

Итог “Чи найз охинтой юу” гэхэд би “Бий нь бий. Гэхдээ одоо хол байгаа” гэж хэлээд санаа алдав.

- Та хоёр хэн хэнээ сайн ойлгодог биз дээ?

- Бид хоёрын хувьд тэгж найдах нь цорын ганц гарц болж байна даа.

Ито Моцартын тухай аядуухан ярилаа. Хөдөөний хүмүүс уулын замаа бузгай сайн мэдэх лугаа Моцартыг нэвтэрхий судалсан аж. Гурван настайгаасаа аавыгаа дагаж, аялгуу эгшгийг нь сонсож өсчээ.

Итогийн “Энэ хэсэг хачин сайхан. Яг одоо сонсоорой. Харин энэ нь яаж байна” гэх дуунд хөгжим сонсоход таатай. Олон сар ингэж амар амгалан, ажин түжин суусангүй.

Хоёул Инокашира цэцэрлэгт хүрээлэн дээр мандсан хавирган сарыг ажин, вискигээ дусал ч үлдээлгүй ууж дуусгалаа. Сайхан виски юм. Ито хоноод яваач гэсэнд би ажилтай гээд есөн цагт харихаар гарав. Замдаа Мидори руу залгавал харин утсаа авдаг юм байна.

- Уучлаарай, чамтай ярьмааргүй байна.

- Би мэднэ ээ. Гэхдээ чи миний цөөхөн хэдэн сайн найзын нэг болохоор ингээд холдож чадахгүй нь. Хоёулаа хэзээ уулзаж ярилцах боломжтой болохоо хэлээч дээ.

- Цаг нь болохоор хэлнэ ээ.

- Чи сайн уу? гэхэд Мидори:

- Байж л байна гээд харилцуураа тавьчихав.

Таван сарын дундуур Рэйкоогоос захиа ирсэн юм.

“Захиа илгээж байгаад баяртай байна. Наоко чиний захиаг уншихдаа их л жаргалтай санж. Би ч ялгаагүй хааяахан гуйж уншдаг юм. Дургүйцэхгүй биз дээ?”

Хариу бичилгүй удсанд өршөөгөөрэй. Чамд хэлчихээр сайн сайхан мэдээ хомс байлаа. Саяхан Наокогийн ээж Кобэгоос ирж эмчтэй уулзаад явсан. Дөрвүүл зөвлөөд, Наоког хэсэг хугацаанд эмнэлэгт хэвтүүлэхээр шийдлээ.

Наоко энд байх сонирхолтой ч сэтгэл зүйг нь хянах боломжгүй болж байна. Болдог сон бол Наокоогоо явуулмааргүй л байх юм. Хаа нэг өвчин нь сэдэрч, хараа хяналтанд байх шаардлагатай болж байна. Хий юм сонсох нь ихсээд, улам л бүгшээд байх юм.

Нөхцөл байдал иймийн учир эмнэлэгг хэвтүүлэхээс өөр замгүй нь. Хамгийн гол нь илааршина гэдэгт итгэж, хүлээцтэй байх хэрэгтэй гэж хэлж байсныг чи санаж байгаа биз ээ. Хүний нүд харанхуйд аажмаар дасдагтай адил хүлээх л хэрэгтэй.

Энэ захиа чамд хүрэх үед Наоко эмнэлэгт шилжсэн байх биз ээ. Гэнэт шийдсэн тул чамд арай хожуу дуулгалаа.

Би эмнэлгийнх нь хаягийг чамд явууллаа. Захиа занга бичээрэй. Хэрэг гарвал Наокогийн сураг ажгийг надаас ч болтугай дуулж болно шүү.

Санаагаар унасны хэрэггүй. Наоко эндээс явсан ч боломж гарвал захиа нисгэж байгаарай. Баяртай.”

Энэ хавар би долоо хоног бүр Наокод захиа бичихийн сацуу Рэйко, Мидори хоёрт хэд хэдэн зурвас илгээсэн юм. Үзэг цаас холбож суух энэхэн мөчист өчүүхэн амьдралаа тэтгэх эрч хүчээ олох шиг болдог сон.

Мидоритой уулзаагүй энэ хоёр сар уйтгар гунигаар дүүрэн байлаа.

“Анх удаа л урин дулаан хавар цагийг сунайсан урт өвлийн гурван сар шиг гуниглаж өнгөрөөлөө. Үүнд орвол хоёрдугаар сар гурвантаа давтагдсан бол дээр сэн. Одоо хэлэхэд утга учиргүй ч гэлээ үсний чинь засалт чамд сайхан зохижээ. Үнэхээр хөөрхөн харагдсан. Би одоо итали хоолны газарт ажиллаж байгаа. Амттай шпагетги хийх арга тогоочоосоо сурсан. Боломж гарвал хийж өгмөөр байх юм”

Би өдөр бүр сургуульдаа явж, долоо хоногт хоёр гурван удаа ажилд гарч, Итотой ном, хөгжмийн талаар хөөрөлдөж, түүнээс Борис Вианы зохиолуудыг авч уншин, захиа занаа бичиж, Цахлайтай тоглож, шпагетги хийж, цэцэрлэгээ арчилж, Наоког төсөөлөн гар хангалга хийж, олон ч кино үзлээ.

Мидори зургаан сарын дундуур ам нээлээ. Бид хоёр дуугаралгүй хоёр сар болжээ. Тэр өдөр Мидори хичээлийн дараа дэргэд минь суусан юм. Тэрээр шанаагаа тулаад хэсэгтээ чимээгүй суув.

Бороо хувингаар цутгах мэт асгарч байсан сан. Оюутнууд гарсны дараа Мидори халааснаасаа хайрцаг Марльборо гаргаж ирээд чүдэнз өгөв. Тамхийг нь асаавал нэг сороод:

- Миний үс зүгээр байна гэж үү?

- Сайхан зохисон байна.

- Нээрээ юу?

- Энэ дэлхийн бүх модод ховхорч унахаар л сайхан зохиж.

- Үнэхээр тийм гэж үү?

- Тийм ээ гэвэл Мидори сэтгэл нь амарсан бололтой гараа сунгалаа. Тамхиныхаа үнсийг шалан дээр унагаад:

- Явж хоолонд орьё гэсээр гарав.

- Хаашаа орох вэ?

- Нихонбашигийн Такашимая их дэлгүүрийн хоолны газар.

- Тэр хол явж яах гээ вэ?

- Заримдаа тийшээ ормоор санагддаг юм.

Ингээд бид хоёр метронд сууж Нихонбаши хүрлээ. Их дэлгүүрт орвол өглөөнөөс хойш бороо шаагиснаас тэр үү хүнгүй шахам. Чийг үнэртэж, цөөхөн хэдэн худалдагчид нь нойрмоглох ажээ. Хоёул доод давхарт байрлах цайны газарт очиж, шилэн хоргон дахь хоолыг нь сайн харж, хайрцагтай иж бүрдэл сонголоо. Үд болсон ч хөл үймээнгүй.

Их дэлгүүрт хооллоогүй уджээ гээд гялтганасан цагаан хуванцар аягатай цайнаас оочвол Мидори:

- Багадаа их дэлгүүрт хооллохыг их хүсдэг байснаас ч тэр үү, заримдаа энд ирмээр санагддаг юм. Манайхан барагтай бол дэлгүүр хэсдэггүй улс байсан даа хэмээнэ.

- Харин манай ээж дэлгүүр хэсэх дуртай байсан.

- Чи ч азтай юм.

- Ямар юмных нь азтай байхав. Би дэлгүүрээр явах дургүй.

- Дэлгүүртээ гол нь биш ээ. Аав, ээж чинь чамайг алган дээрээ бөмбөрүүлжээ л гэсэн ухаантай.

- Ганц хүү нь болохоор арга байж уу.

- Харин би багадаа их дэлгүүр орж сайхан хооллох юмсан гэж боддог байлаа. Гэлээ гээд ганцаараа идсэн гахай таргалдаггүй гэдэг дээ. Хүн ихтэй, бүгчим байдаг ч ороод гармаар санагддаг юм.

- Энэ хоёр сар их ганцаардлаа.

- Захианаас чинь мэдсэн. Хоёулаа эхлээд сайхан хооллоод авъя. Тэгэх үү?

Бид хоёр хоолоо идэж дуусмагц Мидори тамхи татлаа.

Төдхөн татаж дуусмагцаа тэр шүхрээ авч гарахаар шалавлав.

- Хаачих нь вэ?

- Их дэлгүүрт ирснийх дээвэр дээр нь гарна аа.

Дээвэр дээр байрлах хэдэн лангуу үүдээ барьжээ.

Хоёул шалба норсон лангуу, тоглоомон морь, модон сандлуудыг сүлжихэд түм түжигнэсэн Токиогийн төвд ийм эл хуль газар байгаад гайхширч билээ. Мидори том дурангаар харья гэсэнд зоос оруулж, дурандах зуур шүхрийг нь барьж зогслоо.

Буланд байх саравчтай тоглоомын талбайд хэдэн автомат тоглоом эгнүүлжээ. Хоёул тоглоомын ивээс модон дээр суугаад асгарах бороог ажлаа.

- Юм яриач. Надад хэлэх юм бий дээ?

- Тэр үед дотор давчдаад, дэнтэй дунтай л явлаа. Өөрийгөө өмөөрөх гэсэндээ тэгж хэлж байгаа юм биш. Чамайг холдоод явахаар л ойлгосон. Хажууд минь чи байсан тулдаа өдий болтол тэссэнээ ухаарсан. Энэ хоёр сар чамайг их л үгүүлж ганцаардлаа.

Би энэ хэдэн өдөр хичнээн их шаналсныг чи мэддэг ч болоосой.

- Мэдээгүй хойно одоо яая гэхэв. Гомдсондоо намайг харахыг ч хүсэхгүй болж дээ л гэж бодсон шүү.

- Ийм мулгуу байх гэж? Чамтай уулзаж учрахыг хүсч явдгийг минь мэдрээгүй гэж үү? Чи надад таалагддаг гэж хэлсэн байх аа. Би таарсан болгоноо таалж, нүд ирмэхийн зуур мартдаг хүн биш гэдгийг ойлгоогүй л явжээ дээ? Сэтгэлийг минь анзаараагүй гэж үү?

- Тэр ч тийм л дээ...

- Би ч чамд гомдсон. Дэндүү их гомдсон. Удаж удаж уулзахад өөр охин бодоод л. Намайг харах сөхөөгүй. Тэгээд хэсэгтээ уулзахгүй байвал чамайг сэхээрэх болов уу гэж санасан юм. Учир байдлаа тодорхой болгох гэж л тэр.

- Ямар учир байдал?

- Бидний харилцааг ойлгох гээд. Өдрөөс өдөрт чамд татагдаж, найз залуугаа ч тоохоо байсныг минь ойлгож байна уу? Ийм байж болохгүй биз дээ? Найз залуу маань надад таалагддаг. Цочмог зантай, гөжүүд, алсын бодолгүй, фашист ч гэлээ сайн хүн. Анхны минь хайр. Гэхдээ миний хувьд чи онцгой. Хамт байхаар нэгэн биеийнхээ нөгөө талыг олсон шиг нэг л сайхан. Үнэндээ би чамд хайртай, чамд итгэдэг болохоор алдмааргүй байна. Учраа ч олохоо байгаад түүнд энэ бүхнээ хэлж зөвлөсөн чинь чамтай дахиж битгий уулз гэсэн. Тэгсэн тохиолдолд л надтай үлдэнэ гэнэ билээ.

- Тэгээд чи яасан? гэвэл Мидори:

- Найз залуугаасаа холдсон гээд чүдэнз зуран тамхи асаав.

Энэ үед би “Яагаад” хэмээн мулгуутан дуу алдахад:

- Яагаад гэнэ шүү. Чи ч ёстой тэнэг амьтан юм. Англи хэлний үйл үгийн хувирал, математикийн онол, Марксыг уншдаг хүн ийм юм ойлгохгүй байна гэж үү? Эмэгтэй хүнээр ийм юм хэлүүлж байдаг. Би чамд хайртай болохоор найз залуугаасаа холдсон гэдгийг ойлгохгүй байна гэж үү? Би хүн л болсон хойно аль сайн сайхан гэсэнд нь дурлаж тэмүүлэх нь мэдээж. Өөрөө ч мэдэлгүй чамд дурлачихлаа.

Би хариу хэлэх гэсэн ч хоолой зангирч, дуугарч чадсангүй. Мидори тамхиа хаяад:

- Ингэлээ гээд битгий уруу царайл. Уйтгартай гэдэг нь. Чамайг өөр бүсгүйд хайртай гэдгийг чинь мэдэх болохоор чангааж зовоохгүй ээ. Гэлээ гээд намайг тэвэрч болно биз дээ? Энэ хоёр сар их л хэцүү өнгөрлөө.

Тоглоомын газрын үүдэнд шүхэр барин тэврэлдэж, уруул уруулаараа шүргэлцэн зогсоход Мидоригийн үс, хүрэмнээс бороо үнэртэнэ. Эмэгтэй хүний бие ямар учраас ийм зөөлөн, халуун байдаг билээ? Хүрэмний цаанаас хөх нь мэдрэгдэнэ. Олон сарын дараа бүсгүй хүний халуун дулаан илчийг энэ биеэрээ дахин мэдэрсэн нь энэ.

- Чамтай уулзсан тэр өдрөө би найз залуугийндаа очсон. Тэгээд хоёр тийш болсон.

- Би чамд хайртай. Үнэн сэтгэлээсээ хайртай шүү. Чамайгаа ахиж алдмааргүй байна. Гэлээ ч одоо яах учраа олохгүй юм.

- Нөгөө бүсгүйгээс болоод уу? гэсэнд толгой дохив.

- Та хоёр унтсан уу?

- Жилийн өмнө нэг л удаа.

- Дахиж уулзаагүй юу?

- Хоёр удаа уулзсан ч унтаагүй ээ.

- Яагаад тэр вэ? Тэр бүсгүй чамд сэтгэлгүй юм уу?

- Юу хэлэхээ ч мэдэхгүй юм. Энэ бүхэн хэдэн жилийн өмнөөс эхэлсэн болохоор одоо хэн хэн маань учраа олохоо байчихаад сууж байна. Хүний хувьд би тэр бүсгүйн өмнө хүлээсэн хариуцлагатай гэдгээ л мэдэж байна. Үүнээ хүнд тохож чадахгүй нь. Ямартаа ч одоогоор ингэж бодох юм. Тэр хүн надад сэтгэлгүй байлаа ч орхиод явчихаж болохгүй нь.

Мидори:

- Би халуун цустай хүн гээд хүзүүнд минь хацраа нааж:

- Чамд тэврүүлж зогсох энэ л мөчид сэтгэлээ илчилье. Хүсвэл би чиний төлөө юугаа ч зориулж чадна шүү. Би хэдий зөрүүд ч гэлээ шулуун шударга зантай, ажил хийж чадна, бусдаас дутахгүй царай зүстэй, хөөрхөн хөхтэй, хоол ч хийчихнэ. Аавынхаа өв хөрөнгийг хадгаламжинд хийчихсэн. Чи ганц хуруугаа ч хөдөлгөлгүй намайг явуулж чадна гэж үү? Би нэг явбал эргэж харахгүй.

- Энэ бүхний учрыг олоход хугацаа хэрэгтэй. Бодож тунгааж, асуудлаа цэгцэлж, шийдэх нь чухал. Надад өөр хэлэх юм даанч алга.

- Гэхдээ чи надад хайртай, алдмааргүй байна гэсэн дээ?

- Алдмааргүй байна.

Мидори бага зэрэг хөндийрч, өөдөөс минь инээмсэглэн эгцлэн ширтээд:

- Би чамд итгэдэг болохоор хүлээнэ ээ. Дэргэд минь байхдаа, тэвэрч зогсохдоо нөгөө бүсгүйгээ дурсахгүй гэж л амла. Ойлгож байна уу?

- Тийм ээ.

- Чи намайг яаж ч болно. Өдий хүртэл хангалттай шаналсан болохоор битгий л зовоогоорой. Жаргалтай баймаар байна.

Мидориг дахин үнсэхэд:

- Шүхрээ хаяад намаг чанга тэврээч гэж билээ.

- Хоёулаа шалба норно доо.

- Норвол тэр л биз. Хоёр сар тэвчсэн хойно чанга тэврүүлье.

Би шүхрээ газар тавьж, Мидориг байдаг чадлаараа тэвэрлээ. Хурдны замаар шунгинан өнгөрөх машины дуун тэртээ дороос цуурайтаж,

манан адил биднийг хүрээлнэ. Шаагих бороо үс норгож, хацар даган урсана. Мидоригийн жийнсэн хүрэм, миний шар нийлэг хүрэм нэвт норлоо.

- Дээвэртэй газар орвол дээргүй юу?

- Манайд очъё. Одоо эзгүй байгаа. Аягүйдвэл ханиад хүрнэ шүү.

- Тэгье.

Мидори:

- Хоёулаа гол гаталсан аятай норчихож. Сайхан байна шүү! гээд инээд алдав.

Ингээд бид хоёр дэлгүүрээс том алчуур авч, ээлж дараалан үсээ арчаад Мёгадани дахь Мидоригийн гэрт метро дамжсаар ирлээ. Гэртээ оруутаа Мидори эхлээд намайг, дараа нь өөрөө шүршүүрт орж, халат өмсүүлээд, өөрөө цамц, бошинз өмслөө. Хоёул гал тогоонд сууж кофе уув.

- Юм яриач.

- Юу ярих вэ?

- Юу... Чи юунд дургүй вэ?

- Тахианы мах, арьс өнгөний өвчин, чалчаа усчин.

- Өөр юм бий дээ?

- Дөрөвдүгээр сарын гунигтай үдэш, утасны аппаратны доор тавьдаг хээтэй алчуур.

Мидориг “Өөр юм бий юу?” гэсэнд “Санаанд орохгүй нь” гээд толгой сэгсэрлээ.

- Манай найз залуу... урьдын найз залуу маань нэлээд цамаан. Намайг богинохон банзал өмсөхөд, тамхи татахад, амархан согтоод муухай

онигоо ярихад дургүйцнэ. Чиний дургүй хүрмээр зан гаргавал шуудхан хэлээрэй. Би засахыг хичээе.

- Хэлээд байхаар сүйдтэй юм алга.

- Үнэн үү?

- Хувцас хунар, хэл яриа, зан байдал чинь тэр аяараа, хөлчүүрхэх нь хүртэл надад таалагддаг.

- Энэ хэвээрээ таалагддаг гэж үү?

- Өөрчлөгдлөө гэхэд надад таалагдах эсэхийг мэдэхгүй болохоор энэ хэвээрээ байсан нь дээр биз дээ.

- Чи надад хэр зэрэг хайртай вэ?

- Хайр минь энэ дэлхийн ширэнгэн ойн арслан барсыг тос болгон хайлуулах хүчтэй гэсэнд Мидори сэтгэл нь ханасан аятай:

- Хөөх. Намайг тэврээч гэв.

Цонхны цаана дуслах бороон чимээнд Мидоригийн өрөөнд орон дээр нь тэврэлдэн үнсэлдэж хэвтлээ. Хоёул хөнжлөө толгой дээгүүрээ нөмөрч, ертөнцийн үүсэл, өндөг чанах зэрэг орчлонгийн элдэв зүйлийн тухай ам хамхилгүй хүүрнэж билээ.

- Бороо ороход шоргоолжнууд яадаг бол?

- Мэдэхгүй юм. Үүрээ цэвэрлэж, нөөцөө хураадаг юм болов уу? Шоргоолжнууд ажилсаг.

- Тийм ажилсаг байж өдий болтол өсөж хөгжилгүй шоргоолж чигээрээ үлдсэн нь хачирхмаар шүү.

- Биеийнх нь онцлогоос болдог байж магад. Жишээ нь, тэд мичнээс огт ондоо хэлбэр галбиртай.

- Чамайг ийм олон зүйл мэддэггүй гэж зүүдэлсэнгүй. Ватанабэ минь хорвоогийн бүхнийг андахгүй л гэж санаж явлаа.

- Энэ хорвоо уужим шүү дээ гэсэнд:

- Уулс нь өндөр, далай нь гүн гээд халатан доогуур гараа шургуулж, эрхтнийг минь барьж үзээд царайгаа барайлган:

- Ватанабэ, ингэж хэлэхэд эвгүй ч гэлээ ийм том юм яаж миний дотор орох вэ? гэлээ.

- Надаар тоглоод л байх шинжтэй дэг ээ.

- Тэгэлгүй дээ. Гэхдээ санаа зоволтгүй. Чинийх багтана. Харж болох уу?

- Дураараа л бол гэвэл Мидори эрхтнийг минь хэсэг тэмтрээд, хойш нь шамлаж, үснээс нь зулгааж үзээд, толгойгоо цухуйлган гүнээ санаа алдав.

- Өхөөрдмөөр юм. Их таалагдлаа.

- Яамай даа.

- Чи намайг хүсэхгүй байна гэж үү? Учраа олтол энэ янзаараа байх уу?

- Ухаанаа алдтал хүсч байгаа ч учраа олох хэрэгтэй.

- Гөжүүд гэдэг нь. Би л байсан бол эхлээд хүслээ хангачихаад дараа нь бодно оо.

- Үнэндээ тэгнэ гэж үү?

- Яалаа гэж дээ. Чам шиг л сэтгэл дотроо ойлгох гээд шаналаад сууж байх биз. Иймийг чинь мэдрээд л чамд татагдсан шүү дээ. Чамдаа хайртай.

- Хэр зэрэг хайртай гэж гэвэл Мидори хариу хэлэлгүй хөхний минь товчин дээр уруулаараа зөөлөн хүрч, чивчирсэн эрхтнийг минь

гараараа оролдлоо. Тэр мөчид Наокотой байснаас даанч ондоо мэдрэмж төрж билээ. Энэ хоёр ялгаагүй энхрий зөөлнөөр таалах ч огт ондоо мэдрэгдэнэ.

- Нөгөө бүсгүйгээ бодсоор байна уу? гэхэд нь:

- Үгүй ээ гэж булзаарууллаа.

- Үнэн биз?

- Үнээн.

- Ийм үед өөр хүн бодоход дургүй шүү.

- Бодоогүй ээ.

- Хөхийг минь, эсхүл тэнд оролдмоор байна уу?

- Хүсэх л юм. Гэхдээ одоохондоо хэрэггүй биз. Эхний удаа бүгдийг нь мэдэрчихвэл мансуурч магад гэсэнд Мидори толгой дохиод, дотуур өмдөө тайлж, эрхтэн дээр минь тавьлаа.

- Наадах руугаа тавьчих.

- Бохирдоно шүү дээ.

- Битгий элдвийн юм ярь аа. Чамайг харахаар л өрөвдөх юм. Угаачихна шүү дээ. Тэвчээд суух хэрэг үү? Дураараа л тавь. Санаа зовоод байвал шинийг аваад бэлэглэнэ биз. Эсхүл миний дотуур өмд санаанд чинь нийцэхгүй нь үү?

- Хаанаас даа.

- Тэгвэл юундаа зовдог юм бэ?

Бие минь тавирмагц Мидори үрийн шингэнийг минь ажаад:

- Ямар их юм бэ? гээд уулга алдана.

- Хэтэрхий их байна уу?

- Зүгээр дээ, тэнэгхэн минь. Дураараа л бол гэж хэлсэн байх аа гэж хэлээд инээсээр үнсэв.

Орой болуут Мидори дэлгүүрээс ногоо авчирч, хоёул загасны мах, даршилсан ногоо, будааны зутан идэж, шар айраг уулаа.

Үрийн шингэнээ дундлахгүйн тулд ахиухан идээрэй. Багтаж ядаад байвал нь би суллаад өгнө.

- Мэдлээ.

- Би олон арга мэднэ. Номын дэлгүүртэй байхдаа эмэгтэйчүүдийн сэтгүүлээс сурсан. Хөл хүнд эмэгтэй нөхөртэйгээ дотносох боломжгүй учир нөхрөө урвуулчихгүйн тул яах талаар дэлгэрэнгүй бичсэн байж билээ. Өдий төдий арга байсан шүү. Туршиж үзмээр байна уу?

- Тэсэн ядан хүлээе.

Харих замдаа авсан сонингоо метронд дэлгэж суусан ч оюун бодлоо төвлөрүүлж дөнгөсөнгүй. Сэтгүүл эргүүлэх зуураа хэтийдээ юу болох, эргэн тойрон минь хэрхэн өөрчлөгдөхийг би сэрж мэдэхгүй л явлаа. Энэ дэлхий тэнхлэгээсээ мултрах шахам дэнслэх шиг санагдсан сан.

Гүнээ санаа алдсаар нүдээ анилаа. Болж өнгөрсөн бүхэнд огтхон ч харууссангүй. Энэ өдрийг би дахин туулж өнгөрүүллээ гэмээнэ өөрөөр аашилж аяглах нь юу л бол.

Дээрээс цутгах усан бороонд, тэр л байшингийн дээвэр дээр Мидориг тэвэрч жаргалдаа мансуурах байсан.

Мидори надад таалагддаг. Эргэж ирсэнд чин сэтгэлээсээ хөөрсөн. Дэргэд нь байхад амьдрал дур булаам өнгөөр гилтгэнэж гялалзах шиг болж билээ.

Халуун дулаан биеэ энгэр цээжинд минь нааж, эр биеийг минь тайтгаруулсан тэр л бүсгүйд би дурлажээ.

Мидоригийн энгэрт шигдэж, энхрий дулаан бие хаад нь эрхэлж шунан мэдрэхийг хүссэн. Эрхтнийг минь барьсан гарыг зогсоож төвдөхгүй байж. Оргилсон хүслийг минь ер хэн ч атугай дарж дийлнэ гэж үү? Тэр бүсгүйн үнэрээр амьсгалж өнгөрөөсөн энэ өдрийг мартахын аргагүй.

Өдий болтол би энэ бүсгүйд сэтгэл алдарснаа далдханаа мэдэрсэн ч хүлээн зөвшөөрөх тэнхэлгүй явжээ.

Гагцхүү Наокод өөр бүсгүйд дурласан гэдгээ хэлэх аргагүйдээ мухардсан юм. Ондоо нөхцөлд яахаа таашгүй ч, өдгөө өөр нэгэнд сэтгэл алдуурснаа хэлж зүрхлэхгүй нь. Наокод ч би хайртай. Цагийн аясаар энэ сэтгэл минь хувирч өөрчлөгдсөн ч түүний орон зай хэвээр.

Би Рэикод сэтгэлээ нээж захиа илгээхээс өөр хэрхэхээ мэдсэнгүй. Харьж ирээд саравчинд сууж, бороо шаагих цэцэрлэг тийш ширтэнгээ хэдэн үг холбоод, ширээндээ сууж захиа бичлээ.

“Сэтгэлийн гүнээс урсан гарах сэрэл мэдрэхүйнхээ тухай танд бичих нь хэцүү боловч танаас өөр зааж зөвлөх хүн нэгээхэн ч үгүй юм” гэж эхлээд Мидоритой өдий болтол хэрхэн харилцаж байснаа, энэ өдрийн үйл явдлыг товчоолон хүргэв. *“Наоког хэзээд сэтгэлдээ тээж, түүндээ хайртай хэдий ч өдгөө Мидори бид хоёрын харилцаанаас юм бүхэн шалтгаалах учиртай болжээ. Би энэ сэрэл мэдрэхүйгээ хорьж дийлэхгүй хөл алдах биз ээ.*

Наоког хайрлах миний хайр номхон дөлгөөн бөгөөд ариухан юм. Харин Мидориг би цохилох зүрх, амь амьдралыг тэжээгч ус агаар шиг бодтой хайрладаг. Энэ бүхэнд сэтгэл хөдөлж, учраа олохгүй айдаст автах шиг болох юм.

Өөрийгөө хаацайлах гээгүй ч өнөөдрийг хүртэл би шударга амьдарч, хэн нэгнийг хуурч явсангүй. Иймээс ч эдүгээ чухам юуны учир энэ толгой эргэм зөрөг замаар ухаан алдан хаашаа зүглэхээ мэдэхгүй мухардсанаа ойлгохгүй нь. Үнэндээ би яавал дээр вэ? Танаас өөр зөвлөж чиглүүлэх хүн алга” гэж бичээд шуурхай илгээмжийн марк нааж, тэр оройдоо шуудангийн хайрцганд хийв.

Тав хоногийн дараа Рэикогоос хариу захиа ирлээ. “Эхлээд сайхан мэдээгээ дуулгая.

Наоко бодсоноос хурдан дээрдэж байгаа бололтой. Утсаар ярихад үг хэлээ овоо эвлүүлчихэж байна билээ. Мөдхөн эргээд ирж магадгүй гэсэн шүү.

Харин одоо чиний тухай ярья.

Юм бүхнийг сэтгэлдээ ойр хүлээж авах хэрэггүй. Нэг нэгэндээ дурлана гэдэг хүмүүний хосгүй мэдрэмж. Хэн нэгнийг чин сэтгэлээсээ хайрласан хүн учраа олохгүй сандарч мэгддэггүй биз ээ. Гагцхүү өөртөө итгэлтэй байх нь хамгаас чухал юм.

Энгийн гэмээр хэдхэн зүйл зөвлөө. Нэгдүгээрт, хайр дурлал гээч нь ямагт тодорхойгүй байдаг учраас та хоёрын харилцаа цаашдаа хэрхэн өрнөхийг таашгүй. Дурласан нэгэндээ бүхий л бие сэтгэлээ зориулах нь шулуун шударга хүний эрхэм шинж хэмээн бодох юм.

Хоёрт гэвэл, Мидори та хоёр дотносох эсэх нь миний мэдлээс хэтийдсэн зүйл. Түүнтэйгээ сайтар ярилцаад зөв шийдвэр гаргаарай.

Харин гуравт, Наокогийн хувьд, энэ бүхнийг түрдээ мэдээгүй нь дээр болов уу. Надад найдаад, хэсэгтээ чимээгүй байхыг чамаас хичээнгүйлэн гуйя.

Дөрөвдүгээрт, өдий болтол чи Наокогийн хувьд итгэж тулсан анд нөхөр нь байсан бөгөөд өөр хүнд сэтгэл алдарсан ч түүнд чиний дэмжлэг хэрэг болох нь гарцаагүй.

Бидний орших энэ орчлон хүмүүний нэгэн адил төгс төгөлдөр бус. Амьдрал хэмээн нэрийддэг өнгөрсөн ирээдүйг холбосон энэ цаг мөч үргэлжид амар амгалан байдаггүйг чи мэднэ.

Захианаас чинь Мидорид татагдаж буйг би мэдэрсэн. Тэгсэн хэдий ч чи Наокод дурлаж тэмүүлдэг. Энэ нь муу нүгэл биш. Эрт эдүгээд ч ийм л байна. Тогтуун өдөр нуурын усанд завиар зугаалж усны мандал, цэлмэг тэнгэрт баясч хөөрдөг лугаа амьдралд ийм зүйл бишгүй.

Сэтгэлээ чилээсний хэрэггүй. Амьдралд голдуухан огт төсөөлж бодоогүй зүйлс тохиолддог шүү дээ. Бид хүссэн хүсээгүй хэн нэгний сэтгэлийг шархлуулдаг. Чиний хувьд орчлонтой нүүр тулах цаг нь иржээ.

Заримдаа чи бүх зүйлийг санаснаараа зохицуулах дуртай хэдий ч үе үеээн зүрх сэтгэлээ нээж, урсгал даган хөвөөд үз. Над шиг сул дорой эмэгтэй ч энэ амьдрал гээчид татагдах үе байх юм. Энэ хорвоод хүн болж төрснийх жаргал гээчийг амсаад л өнгөрөх учиртай.

Наоко та хоёрыг хамт байхыг харахгүй ч гэлээ хүсэл мөрөөдөл өөд тэмүүлж, жаргалтай болох боломжоо битгий алдаарай. Миний бодоход, хүнд энэ насанд нь ганц хоёрхон ийм боломж таардаг бөгөөд алдвал насан туршидаа харуусдаг юм билээ.

Сонсох хүнгүй ч би орой бүр гитараа тоглосоор л байгаа. Нэг бодлын утгагүй гэлтэй. Бороотой үдэш хэдий гунигтай гээч. Тэр нэгэн үдэш шиг Наоко та хоёртой гитар тоглонгоо усан үзэм идэж суух сан. Тэр л жаргалтай өдрүүдцээ эргэж нэг очих сон.

Ишида Рэйко 6-р сарын 17.”

Арваннэгдүгээр
Бүлэг

Наоког энэ хорвоогоос хальснаас хойш Рэйко нижгээд захиа ирүүлж, энэ явдалд өөрийгөө болон хэн нэгнийг буруутгах хэрэггүй, бороо орохтой л адил хэн бугай ч зогсоож хүчрэхгүй зүйл хэмээж билээ.

Гэсэн ч би хариу бичсэнгүй. Наоко нэгэнт бие барж, атгахан чандруу болон хувирсан хойно хариу илгээгээд яах билээ.

Наймдугаар сарын сүүлээр ажил явдал шувтарч, байрныхаа эзэд болоод ажлынхандаа хэсэгтээ эзгүй байхаа дуулгаад, Мидорид хэсэгтээ хүлээж байгаач хэмээн зурвас илгээлээ.

Гурван өдөр Токиогийн кинотеатруудаар эргэлдэж, үзвэрийг нь дуусгаад, гэртээ ирж жаал жуул юмаа цүнхлээд, дансан дахь бүх мөнгөө авч, Шижюүкүгийн буудлаас анх таарсан хурдан галт тэргэнд суусан юм.

Тэр өдрүүдэд явж өнгөрсөн газар орны нэр ус, хоног хугацаа мартагдаж баларсан ч байгалийн үзэмж, үнэр танар, дуу авиа өнөө хэр тодхон.

Галт тэрэг, автобус, ачааны машины тэвшин дээр аялж, таарсан газраа унтана. Галт тэрэгний буудал, эзэнгүй байшин, гол нуурын эрэг, цэцэрлэгт хүрээлэн, эргүүлийн цагдаагийн байрны булан, тэр бүү хэл оршуулгын газрын хажууханд хоног төөрүүлж явлаа. Хүний замд саад болохгүй, тавтай унтчих газар бол голж шилэхгүй.

Хоёр зээрдээрээ шогшиж, ядарвал тэр газраа гудсаа дэлгээд хямдхан виски балган нойрондоо умбана. Заримдаа нутгийнхан хоол унд, ялаа шумуул үргээх лаа хүж өгнө. Хааяахан цагдаа дуудаж, цэцэрлэгээс хөөгдөнө.

Тэр үест үл таних газар хоног төөрүүлж, бэдэн явахыг л хүсэж байлаа.

Сохор зоосгүй болуут гурав дөрвөн өдөр хар ажил хийж мөнгөжих бөгөөд хаа ч явсан иймэрхүү ажил олдоно. Өмнөө тавьсан зорилгогүй ч гэлээ ингэж тэнүүчлэхэд ертөнцийн тоос буданд хөшилдөн хөврөх

эсэн бусын хүн амьтан, этгээд сонин хэв маягтай нүүр тулна. Нэгэнтээ Мидоритой ярилаа. Дууг нь сонсохыг тэсгэлгүй их хүссэндээ тэр.

- Хичээл хэдийн эхэлснийг мэдэж байна уу? Өдий төдий бие даалт хийх хэрэгтэй. Гурван долоо хоног таг чиг алга болдог сонин хүн юмаа. Хаа явна? гэж билээ.

- Түрдээ Токиод очиж чадахгүй л болов уу?

- Өөр хэлэх юм алга уу?

- Арван сард ярья... гэхэд Мидори харилцуураа чулуудчихав.

Ингээд аяллаа үргэлжлүүллээ. Үе үехэн хямд зочид буудалд бууж, усанд орж сахлаа хусна. Толинд харвал би гэж хүн танигдахын аргагүй өөрчлөгджээ. Нүүр борлож, арьс хуурайшаад, нүд хонхойж, энд тэндгүй толбо, сорвитой болоод эгээтэй л агуй дотроос гарч ирсэн балар эртний хүн шиг харагдах юм.

Тэртээ өдрүүдэд би Саньин бүсийн далайн эрэг хавиар алхалж явлаа. Одоо бодох нь ээ, Тоттори, эс бөгөөс Хёогогоос умрыг зүглэн явсан шиг. Элсэн эргээр алхлахад сэтгэл тавирч, хүссэн газраа гудсаа дэлгэж амрахын сацуу түүдэг асааж, хатсан загас шарж иднэ. Хямдхан виски шимэнгээ далайн давалгаанд чих тавьж, Наоког дурсана.

Наоког нартад үгүй гэдэгт итгэж чадахгүй байж дээ. Авсыг нь хадах тэр дуу чимээг сонссон хэрнээ бие сэтгэл минь хүлцэж чадсангүй.

Түүний халуу төөнөсөн бие цогцос, бүлээн амьсгал, гэдсийг минь гижигдэх үс, эрхтнийг минь атгасан тэр нэгэн мөч, хэсэгхэн зуур амтлаад өнгөрсөн тэр жаргалтай өдрүүд санаанд илхэн. гараа сунгаваас тэмтрээд олчих шиг санагдавч тэр минь үгүй болжээ.

Залуу зандан ахуйн нэгээхэн үеийг энэ биеэрээ эзэмдсэн Наоког санахгүй байхын аргагүй байжээ. Тэртээх шөнүүд мартагдахгүй. Хожим ч ялгаагүй дотроос минь олгойдон дурсагдсаар байх юм. Тэр нэгэн бороотой өглөө шувуу хооллож байсан шар цувтай Наоко,

төрсөн өдрийн шалчийсан бялуу, бүлээн нулимс нь нэвчиж норсон энгэрээ нойр хулжсан шөнөөр дурсана. Тэр шөнө ч бороотой байсан.

Тэмээний ноосон хүрэмтэй мөр зэрэгцэн алхахдаа үснийхээ хавчаарыг байсгээд л оролддог сон. Тунгалаг нүдээрээ өөдөөс минь ширтдэг сэн. Дугариг сарыг ажиглан хөлд минь суусан тэр шөнө мөн л бороотой байжээ. Энэ дүр төрх нь далайн давалгаа мэт түрэн орж, Хэдийн холдсон анд нөхөртэйгээ учирч, Наоког амьд сэрүүн ахуй шигээ тэврэхийг яалтай.

Үхэл гэдэг зүйл энэ өчүүхэн орон зайд амьдралын төгсгөл бус нэгээхэн хэсэг нь болон орших авай. “Ватанабэ, айсны хэрэггүй. Бодь биеийг минь холдуулсан үхлийг битгий анзаар. Би энд л байна” гэж Наоко инээвхийлэн хэлэхэд уй гашуу минь тайлагдана.

Би өөрийн эрхгүй “Үхэл гээч нь энэ юм бол айгаад байх юм алга шив дээ?” хэмээн өчихөд Наоко исгэрэн шуугих давалгаан дундаас “Энд ирээд сэтгэл минь уужирлаа” гэж хариулах шиг болж билээ. Танил дотно хөдөлгөөн нь намайг тайвшруулж эмнэнэ.

Татлага эхэлмэгц Наоко холдож, хэдийн тэнхэлгүй болоод, уйтгар гуниг минь түнэр харанхуй болон хувирч нулимс асгаруулна. Уйлах гэхээс илүүтэй нулимс минь аандаа бөнжигнөн урсана.

Кизүкиг будант орчлонгоос хальснаас хойш “Үхэл гээч нь энэ амьдралын нөгөө талд бус, чухамдаа амьдралд өөрт нь оршиж буйг” сэхээрсэн юм.

Өдөр хоногийг элээхийн хэрээр Эрлэгийн элч ирэх тэр агшин ойртох нь хорвоогийн жам.

Гэсэн хэдий ч хайртай хүнээ алдсан тэр уй гашууг ямар ч үнэн анагааж аниулж чадахгүйг Наокогийн явдал ойлгууллаа.

Уйтгар гунигаа энэ биеэрээ нэвчүүлж, ертөнцийн гэрэл, сүүдрийн нэгээхэн үнэнийг мэдэж авах ч ингэлээ гээд алсдаа ирэх уй гашууг үлдэн хөөхийн аргагүй билээ.

Шунгинан исгэрэх далайн давалгаа, эрчлэн хуйлрах салхинд энэ бүхнийг ахин дахин эргэцүүлж, хэдэн лонх виски хоосолж, талх идэж, дашмагтай уснаас балгангаа орь ганцаар алхахдаа үсэндээ наалдсан элсэн ширхгийг ч сэгсэрч унагахыг төвдсөнгүй.

Жиндүү салхитай нэгэн үдэш хэмхэрсэн завины дэргэд нулимс урсган хэвтэх зуур залуухан загасчин эр дөхөж ирээд тамхи сарвайв. Арван сарын дараа татсан анхны тамхи. Залуу уйлсан учрыг минь лавлахад би ээж минь өөд болоод хэмээн худал хэлж билээ. Сайхь залуу намайг өрөвдөж, гэрээсээ шил дарс, хоёр хундага барьсаар гараад ирлээ. Хоёул элсэн эрэг дээр сууж уув. Тэр арван зургаатайдаа эхээсээ өнчирчээ. Үүрийн гэгээнээс үдшийн бүрий хүртэл борви бохис хийлгүй ажиллаж явсан ядруухан ижий нь угийн бие муутай байж. Залуугийн яриаг аан, уун хэмээн сонсож суусан ч нэг л өөр ертөнцийн үйл хэргийг хүүрнэх шиг этгээд сонин мэдрэмж төрлөө. Үймэрсэн сэтгэлийн минь нэгэн үзүүрт өнөөх залууг угзраад авах увайгүй хүсэл цухалзсан ч төдхөнөө замхарлаа. “Наоко минь энэ орчлонд үгүй болоход ижий чинь ямар хамаатай юм бэ?”

Нүдээ тас аниад, будан дунд дэмийрч суухад залуу гэв гэнэт юм идсэн эсэхийг минь сонирхлоо. Үүргэвчинд минь талх, бяслаг, улаан лооль зэргийн багашаархан хүнс бий гэсэнд одоохон гэсээр түнэр харанхуй руу ороод явчихлаа. Аргагүй ганцаар үлдэж архианаас балган суув.

Хааяагүй галт наадмын үлдэгдэл хөглөрсөн элсэн эрэг дээр ганцаар ууж суухад далай хүнгэнэнэ. Хаанаас ирсэн нь үл мэдэгдэх эцэнхий нохой түүдгийн дэргэдүүр сүүлээ шарвагануулан хэд эргэлдээд, идэх юм байхгүйг мэдмэгцээ алга болов. Хагас цагийн дараа загасчин залуу хоёр хайрцаг хоол, шил сакэ барьсаар ирж билээ. Нэг хайрцганд өглөө идэх далайн байцайтай ороомог, сүши зэхжээ.

Залуу хундага дүүргэж, би хоёр ч хүн цадчихаар сүши идлээ. Загасчин эр гэртээ хоноглооч гэсэнд би ганцаараа байх нь дээр гэв.

Тэр залуу аятайхан юм авч идээрэй гэсээр халаасанд минь таван мянган иений дэвсгэрт шургуулаад явж билээ. Мөнгө авахгүй хэмээн зүтгэсэн ч загасчин эр энэ нь анхаарал халамж тавьж буйгаас цаашгүй хэмээхэд би талархсанаа илэрхийлж аргагүйн эрхэнд мөнгийг нь авлаа.

Түүнийг явсан хойно ахлах сургуулийн гуравдугаар ангид дотно харилцаанд орсон найз охиноо гэнэтхэн дурслаа. Өдий хүртэл тэр бүсгүйн сэтгэл зүрх, бодол санааг анзаарч хайхарч явсангүйдээ гэмшсэн сэн.

Үнэхээр сайхан сэтгэлтэй охин байлаа. Сэтгэлийг нь би мэдээжийн зүйл мэт анзаарч явсангүй. Биеэ цэмцгэрхэн авч явдаг тэр бүсгүй өдгөө юу хийж, яажшуухан яваа бол? Намайг уучлаа болов уу?

Дотор давчдаж, завины хажууд бөөлжиж орхилоо. Хэтрүүлж уусандаа толгой өвдөж, загасчин залууд худал хэлж, мөнгө авсандаа хар буух шиг. Эцэс төгсгөлгүй хэрэн хэсүүчлэх аргагүй хойно Токио буцмаар ч санагдав. Хэдий болтол энэ мэт тэнүүчлэх вэ?

Хөнжлөө хуйлж, ойролцоох галт тэрэгний буудалд хүрээд Осака орох галт тэргэнд сууж, тэндээсээ Токиогийн шинкансэнд шилжлээ. Би загасчин залуугийн өгсөн таван мянган иенээр буцах тасалбар авлаа.

Галт тэрэг хүлээх зуураа сонин гарчиглавал 1970 оны 10-р сарын 2-ны өдөр гэжээ. Би гэдэг хүн бүтэн сар хэрэн хэсүүчилсэн ч уй гашуу минь нимгэрсэнгүй. Сарын өмнө ямаршуухан явсан тэр л чигээрээ эргэж ирэв.

Гэлээ ч Мидоритой ярьж төвдсөнгүй. Юу хэлэхээ мэдсэнгүй. Амнаас минь “Бүх юм өнгөрсөн. Хоёулаа сайхан амьдаръя” гэх зүрхтэй үг унана гэж үү?

Нуугдаж зугтахыг оролдсон ч Наоко энэ хорвоогоос буцаж, харин Мидори дэргэд минь үлдсэн гэдэг бодит байдалтай нүүр тулахаас аргагүй. Ингэж бодоход би гэдэг хүн өчүүхэн амьтан шиг.

Токиод ирж аанай л хэд хоног өрөөндөө бүглээ.

Дурсамж дурдатгал минь голдуухан энэ хорвоог орхиж одсон хүмүүстэй холбогдох юм. Наокод бэлдсэн өрөөний тавилга сэлтийг цагаан даавуугаар бүтээсэн бөгөөд эргэн тойрон нарийн тоосонд дарагджээ. Кизүкиг бодох нь ээ, Наоко анхнаасаа л түүнийх байсан

гэдгийг ухаарах шиг. Та хоёр хэзээд хамт байх хувь тохиолтой байж дээ.

Өв тэгш зүйлсээр хомсхон энэ хорвоо дээр би Наокогийн төлөө чадах бүхнээ зориулсан сан. Гэлээ гээд тэр чамайг сонгож, сэтгэлийнхээ гүн шиг харанхуй хөвчид өөрийгөө боомилжээ.

Кизүки минь, чи тэртээ нэгэн өдөр намайг харанхуйн оронд дагуулан одсон шүү дээ. Хааяадаа би гэдэг хүн өөрийгөө хүн амьтан шагайж үзэхгүй үзмэрийн хоосон танхимын манаач мэт санах юм.

Токиод ирсний дөрөв дэх өдөр Рэйкоогоос захиа ирж билээ. Хэл сураггүй алга болсонд санаа зовж, өглөө, оройдоо есөн цагт утсаар холбоо барихыг хүсчээ.

Орой залгавал ганц дуудав уу, үгүй юу Рэйко хариуллаа.

- Сайн уу?

- Дажгүй ээ.

- Нөгөөдөр танайд очвол болох уу?

- Токиод ирнэ гэж үү?

- Тийм ээ. Чамтай тайван уулзъя гэж бодоод.

- Наанаасаа гарах гэж байгаа юм уу?

- Эндээс гарахгүй бол танайд очиж чадахгүй шүү дээ. Найман жил боллоо. Явах цаг минь болсон байлгүй.

Би хэлэх үгээ олж ядан удтал хариулсангүй.

- Нөгөөдөр шинкансэнд суугаад, гурав хорьд Токиогийн буудал дээр бууна. Тосоод авах уу? Эсвэл Наоко байхгүй хойно Рэйко сонин биш болсон уу?

- Хаанаас даа. Нөгөөдөр гурав хорьд таныг тосно оо.

- Над шиг гитар чирсэн авгайчуул ховор хойно андашгүй ээ.

Токиогийн буудал дээр очвол Рэйко эрэгтэй хүрэм, цагаан өмд, улаан пүүз өмсчээ. Үс нь урьдын адил богинохон, зарим хэсгээрээ арзайжээ. Баруун гартаа хүрэн чемодан, зүүн гартаа хар цүнхтэй гитараа барьсан байлаа.

Намайг хармагцаа нүүр дүүрэн мишээж, би ч өөрийн мэдэлгүй инээд алдав. Цүнхийг нь авч, хоёул төв шугамын зогсоол тийш зэрэгцэн алхлаа.

- Ватанабэ, наад царай зүс чинь яачихаа вэ?

- Энд тэндгүй явсаар борогшоо байлгүй. Хурдан галт тэрэг ямар байна?

- Авах юмгүй. Цонх нь ч онгойхгүй. Идэх юм ч байхгүй.

- Юм зарахгүй байна гэж үү?

- Амт гэж авах юмгүй тэнгэрт хадсан үнэтэй тэр сэндвичийг нь тоож идэх хүн олдохгүй биз? Би Готэмбагийн буудлаас хэлтэг загастай хоол авч идэх жигтэйхэн дуртай байж билээ.

- Ингэж яриад байвал үеэ өнгөрөөсөн эмгэн гэгдэнэ шүү.

- Тэгж л байг. Нас явжээ.

Кичижоүжи хүрэх зам зуур Рэйко Мүсашино орчмын байшин барилга, өнгө үзэмжийг шохоорхоно.

- Найман жил болоход хэр өөрчлөгдөж вэ?

- Ватанабэ минь, юу мэдэрч байгааг минь чи мэддэг ч болоосой.

- Яаж байна?

- Эдгэршгүй ужгирсан ганцаардлаасаа болоод энд ирсэндээ туйлгүй айх юм. “Галзуурах”-ад ганц хуруу дутуу ч юм шиг.

- Санаа зоволтгүй ээ. Итгэл сэтгэлээ хөвчлөөд тэндээс гарч чадсан хойно болно гэж хэлээд би Рэйкогийн гараас атгалаа.

- Өөрийн сайндаа биш, Наоко та хоёрын хүчинд л тэндээс гарлаа. Ганцаараа байж суух газраа олж ядаад ямартаа ч чамтай уулзъя гэсээр ирлээ. Та хоёртой учраагүй сэн бол насаараа л тэнд үлдэх байлаа.

Би толгой дохилоо.

- Тэгээд яах бодолтой байна?

- Асахигава явна. Асахигава шүү дээ! Хөгжмийн сургуулийн найзууд маань тэнд дугуйлан нээсэн юм. Хоёр гурван жилийн өмнөөс л хэл сураг болоод байсан. Төвөөс зайдуу бөглүү газар болохоор би ч дургүйхэн байлаа. Арай гэж эрх чөлөөтэй болоод Асахигавад цөлөгдвөл гачлантайяа.

- Би тэнд очиж байсан. Их дажгүй, хөгжилтэй хот.

- Тийм гэж үү?

- Тийм ээ. Токиод байснаас л хамаагүй дээр.

- Тэртээ тэргүй очих газаргүй болохоор ачаа тээшээ ч явуулчихсан. Чи зав чөлөөгөөрөө манайхаар зочлоно биз дээ?

- Тэгэлгүй дээ. Гэхдээ энд хэд хононо байгаа?

- Болдог бол хоёр гурав хонох санаатай. Танайд байвал зүгээр үү? Надад илүү дутуу юм хэрэггүй.

- Бололгүй яахав. Би бол шүүгээн дотроо гудсаа дэлгээд унтчихаж ч чадна.

- Хэцүү биш үү?

- Санаа зоволтгүй ээ. Томоо шүүгээтэй.

Рэйко гитартай цүнхээ хөлөндөө хавчуулаад товшсоор явна.

- Асахигава орохоос өмнө дасах хэрэгтэй байна. Бодит ертөнцтэй нүүр тулна гэхээс эмээж л сууна. Мэдэхгүй зүйл их байна. Сандрах ч юм. Чамаас өөр тушиж тулах хүнгүй болохоор дэмнээд өгөөч л гэж хүсье.

- Чадлаараа л тусалъя.

- Чамд төвөг чирэгдэл болохгүй байгаа?

- Төвөгшөөгөөд байх юу байхав.

Рэйко инээмсэглээд хариу дуугарсангүй.

Зам зуур хоёул аар саар зуйл хууч хөөрсөөр ирлээ. Наокогийн зухай ганц үг унагаагүй ч арван сарын дараа Рэйког үзээд сэтгэл минь яльгүй жаахан ч атугай бүлээцэж, Наокотой зугаалж явсан тэр л цаг руу буцаад ойччих шиг болсон сон. Тэр үед Наоко бид хоёрын дунд Кизүки гэх өөд бологч байсан атал өдгөө Рэйко бид хоёрын дунд Наоко буй.

Ингэж бодоод шүүрс алдан дуугаа хураавал Рэйко ч таг чиг боллоо. Намрын эхэн сард яг жилийн өмнө анх удаа Наоког эргэхээр Киотог зорьсон тэр л өдөр шиг алтан наран байдаг илчээрээ төөнөх юм. Өөдөө ширтвээс цэнхэр өнгийн хүршгүй өндөрт үүлс зурваслан хөвнө. Дахиад намар иржээ.

Он жилийг элээх төдийд орчлонгоос одсон анд нөхөд минь холдох шиг. Кизүки арван долоотой, Наоко хорин нэгэн насандаа үүрд мөнхөрчээ.

Рэйко автобуснаас бууж, эргэн тойрныг ажаад “Ийм газарт сэтгэл амардаг юм” гэв.

-Цулгуй газар болохоор тэр биз гээд хашааны хойд хаалгаар цэцэрлэгт орж замчлавал Рэйко хавь ойроо ихэд сониучирхана.

Г эрт минь ороод уулга алдан:

- Сайхан тохилог юм. Энэ ширээ, тавиураа чи өөрөө урлаа юу? хэмээнэ.

- Тэгсээн.

- Гарын дүйтэй юм. Бас цэвэр цэмцгэр суудаг шинжтэй.

- Довтлогчийн буянд цэвэр цэмцгэр болсон. Байрны эзэд ч ам сайтай байгаа.

- Мартсанаас, эзэн нь тэр цаад талын байшинд суудаг гэсэн байх аа? Явж мэнд мэдээд ирье.

- Тэгж яах нь вэ?

- Тэгэлгүй горьгүй. Хаанахын хэн гээч нь мэдэгдэхгүй нэг авгай ирчихээд гитар балбаад байвал эвгүйрхэнэ биз дээ? Би зориуд жаал жуул бэлэг зэхээд ирсэн.

- Танаас өөр хүн ийм юм сэтгэхгүй дэг ээ.

- Хэдэн оймс илүү элээснийх мэдэлгүй дээ. Би өөрийгөө Киотоогоос ирсэн нагац эгч чинь гээд хэлчихье. Мартав аа. Хараажийн насны зөрүүтэй болохоор хар буруу юм санахгүй, эвтэйхэн ч юм уу?

Рэйко хайрцагтай бэлэг барьсаар гармагц би тагтан дээр суугаад ахиж нэг аяга цай ууж, муужгайтайгаа тоглов. Рэйко хориод минутын дараа эргэж ирлээ. Харин надад хайрцагтай сэмбэи бэлэглэж билээ.

- Та нар юун тухай ийм удаан ярив?

- Чамайг л ярьлаа. Сэтгэл сайтай, цэвэрч нямбай залуу гээд ам сайтай байна.

- Намайг уу?

- Тийм ээ, чамайг.

Рэйко муужгай эрхлүүлээд, гитарыг минь олж хармагцаа хөглөж, Карлос Жобимийн нэгэн аялгууг эгшиглүүлээ. Урьдын дурсамж минь сэдэрч, сэтгэлийн чинадаас үзэгдэв.

- Чи гитар тоглодог болоо юу?

- Амбаарт байсныг нь түр аваад жаахан тоглодог ухаантай гэвэл Рэйко:

- Тэгвэл дараа үнэгүй хичээл заана аа гээд гитараа хойш тавьж, хүрмээ тайлаад, тагтны багана налан тамхи татав.

Хүрмэн дотуураа шоотой даавуун цамц өмссөн байсанд нүд тусна.

- Гоё цамц байгаа биз?

- Гоё юмаа.

- Наокогийнх. Бид хоёр бараг ижил хэмжээтэй хувцас өмсдөг байлаа. Ялангуяа анх уулзахдаа. Дараа нь Наоко жаахан махласан. Гэхдээ хувцасных нь хэмжээ өөрчлөгдөөгүй. Өмд цамц, малгай гутал гээд ялгаагүй. Би гэж хөхгүй болохоор арай жижиг хөхөвч зүүхээс биш бусдаараа бол ялгагдах юмгүй байж дээ. Хувцсаа дундын өмч аятай сольж өмсөнө.

Түүнийг ажвал үнэндээ Наокотой андуурам бие галбиртай ажээ. Нүүрний хэлбэр нь өөр, нарийн бугуйтай учир түүнээс туранхай гэж санадаг байсан ч одоо харах нь ээ, Рэйко харин ч чанга биетэй гэмээр.

- Энэ өмд, хүрэм ч бас Наокогийнх. Хувцсыг нь өмслөө гээд дургүй байна уу?

- Яалаа гэж. Наоко ч таныг өмсөж байгаад баярлах байх.

- Энэ өмд, цамц, хүрмээ надад үлдээсэн. “Хувцсыг минь Рэйкод өгөөрэй” гэсэн ганц өгүүлбэр л бичсэн байж билээ. Сонин шүү. Хэзээ мөдгүй үхэлтэй нүүрэлдэхээр шийдсэн мөртөө хувцсандаа санаа зовж байдаг. Үүнээс чухал уй олон юм байсан л байж таарна.

- Сэтгэлд нь өөр юм үлдээгүй ч юм билүү.

Рэйко тамхиа баагиулан хэсэгтээ бодолд автав.

- Чи чухам юу болсныг мэдмээр байна уу?

- Тийм ээ. Бүгдийг нь ярьж өгөөч.

- Эмнэлэгт өгсөн шинжилгээгээр Наоко илааршиж байна гэж гарсан ч ирээдүйг нь бодоод Осакагийн эмнэлэгт эрчимт эмчилгээнд явуулсан юм. Би чамд бичиж байсан даа. Найман сарын арван хавьцаа захиа илгээсэн санагдана.

- Тийм ээ. Би тэр захиаг уншсан.

- Найман сарын хорин дөрвөнд Наокогийн ээж нь утсаар ярьж “Наоко наад руу чинь нэг очмоор байна.

Хувцас хунараа янзалж, өөртэй чинь ойрд уулзаагүйн дээр хууч хөөрч хоноё” гэж байна гэлээ. Тэгээд хамт ирэх далимдаа хувцас хунарыг нь янзалж хоноё гэсэн юм. Ингээд маргааш өдөр нь тэр хоёр таксигаар ирсэн.

Тэр оройдоо гурвуулаа элдвийг хуучлангаа юм хумыг нь зэхэж бэлдээд, Наоко ээждээ “Одоо зүгээр. Харь” гэсэнд ээж нь таксидаад харилаа. Сэргэлэн цовоо байхаар нь би ч, ээж нь ч сэжиг авсангүй. Би үнэндээ их санаа зовж байсан. Цочирдоод царай алдчихсан байх вий гээд. Эмнэлгийн оношлогоо шинжилгээнд орсон хүн нэлээд тамирддаг. Наоког уймрах болов уу гэж бодсон ч их л уужирсан шиг санагдаж билээ. Инээж хөхрөөд хэвлүүхэн ярьж байгааг нь хараад овоо эдгэрэх нь гэж бодсон. Үсчин орсон гээд, шинэ засалтаа үзүүлээд. Тэгэхээр нь ээж нь харихад гэмгүй биз гэж бодсон хэрэг. “Рэйко, энэ удаа эмнэлэгт хэвтээд бүхнээ эмчлүүлье” гэж билээ. Бид хоёр элдвийг хөөрөлдөн гадуур зугааллаа. Эндээс гараад хамт амьдарна гээд туйлгүй баярлах шиг болсон сон.

- Тантай хамт амьдарна гэж үү?

- Тийм ээ. Би “Ватанабэ яах болж байна аа” гэсэн ч “Би зохицуулчихна аа” л гэхээс өөр юм хэлээгүй. Тэгээд хоёулаа шувууны байр орж шувуунуудаа хооллолоо.

Би хөргөгчнөөс шар айраг гаргаж уухад Рэйко тамхиа асаалаа. Муужгай маань өвдгөн дээр нь тайван унтжээ.

- Наоко урьдаас бэлдсэн юм билээ. Тийм ч учраас халгиж цалгисан, эрүүл саруул болсон шиг харагдах гэж мэрийсэн биз дээ. Өрөөгөө эмхлээд, хэрэгцээгүй эд зүйл, өдрийн тэмдэглэл, чиний захиа занааг төмөр торхонд хийж овоолж байгаад цэцэрлэгт шатаачихсан. Нүдний цөцгий мэт нандигнан хайрладаг захиа занаагаа шатаахаар нь гайхширсан ч бүхнээ шинээр эхэлнэ гэхээр нь хар буусангүй.

Наоко тэр өдөр дуурч цалгисан амьдралдаа эргээд хөл тавих шиг санагдаад энэ болгоныг нь чамд харуулахыг би хичнээн их хүслээ.

Оройдоо бид хоёр дарс ууж, би ч гитараа тоглолоо. Өнөөх л Битлз, Наокогийн дуртай Норвегийн ой, Мишель. Хоёул жаал халж, хувцсаа тайлаад орондоо орлоо. Тэр шөнө жигтэйхэн бүгчим халуун байсан. Цонхоо нээсэн ч салхи орохгүй. Гадаа хар бэх түрхсэн шиг тас харанхуй. Хорхой шавж дүнгэнэж, өвсний үнэр ханхлаад. Наоко гэнэтхэн л та хоёрын хамт байсан тэр үдшийн тухай нүдэнд харагдтал нэг бүрчлэн ярьж эхэлсэн. Хувцсыг минь ингэж тайлаад, биенд минь ингэж хүрээд, би тэгж норсон, над руу тэгж хийсэн гээд л их дэлгэрэнгүй. Урьд нь эр эмийн харьцааны тухай ингэж илэн далангуй ярьж байгаагүй болохоор нь эхэндээ ч гайхлаа. Бид нэг төрлийн эмчилгээ маягаар сексийн тухай ярьдаг ч Наоко ичээд элдвийг ярьдаггүй байлаа.

“Гэнэтхэн л яримаар санагдлаа. Сонсмооргүй байвал больё” гэхээр нь би хориглож зүрхэлсэнгүй. “Эр эрхтэн дотор минь ороход хамаг бие халуу төөнөж жигтэйхэн их өвдөж билээ. Тэгсэн Ватанабэ хөлийг минь өргөөд улам лав орох шиг болсон. Өвдсөндөө үг хэлэх сөхөөгүй болсныг минь Ватанабэ мэдрээд хөдлөхөө больж хүзүү, хөхөн дээр минь удтал үнссэн. Төдхөн дотроос минь халуу дүүгэж, тэр ч аажуухан хөдөлж эхэлсэн. Рэйко, насан туршдаа түүндээ уусч, янаглаж амрагламаар хүсэл төрж билээ.” “Тэгвэл Ватанабэтэй нэг гэрт орж, өдөр болгон биесээ хайрлахад болохгүй нь юу байна” гэхэд “Тэгэх боломжгүй. Амьдралд минь ганц удаа тохиолдсон зүйл Тэр удаа л норж хуял тачаалдаа автсанаас биш урьд хожид тэгж сэрж байсангүй.” гэдэг юм байна. Би ч залуу бүсгүйчүүд ингэх нь олонтаа, яваандаа таашаал мэдэрдэг болно. Нэг удаа болсон хойно санаа зоволтгүй. Би ч ялгаагүй гэрлэснийхээ дараа хэсэгтээ болж өгөхгүй хэцүүхэн байсан

гэсэн ч Наоко “Тийм биш ээ. Би санаа зовсон зүйлгүй. Өөр хэн нэгэн хэзээ нэгэн цагт дотор минь орохыг би хүсэхгүй байна” гэсэн.

Шар айраг дуусч, Рэйко хоёр дахь тамхиа татаж барав. Муужгай өвөр дээр нь нэг суниагаад буцаад унтлаа. Рэйко жаал тээнэгэлсэн ч гурав дахь тамхиа зуусаар асаав.

- Ингээд Наоког уйлахаар нь толгойг нь илж тайтгарууллаа. Чам шиг залуу халуун бүсгүй эр хүний тэвэрт жаргал эдлэхгүй энэ насыг барна гэж юу байхав гэлээ. Халуунд хөлс, нулимсандаа норчихсон байхаар нь алчуур авчирч, нүүр биеийг нь арчлаа. Хөлрөөд дотуур өмд нь норсон байвал тайлахад нь тусаллаа. Гэхдээ элдвийн юм бодов оо. Угаасаа бид хоёр хамтдаа усанд ордог. Наоко миний дүү шиг л байлаа.

- Ойлгож байна аа.

- Наоко намайг тэврээч гэхээр нь халуунд төвөг гэвэл сүүлчийн удаа гэхээр нь биеийг нь ванны алчуураар ороогоод хэсэг тэвэрлээ. Төдхөн тайвшрахаар нь хөлсийг нь дахиж арчаад, унтлагын хувцсыг нь өмсүүлээд хэвтүүлсэнд тэр дороо унтсан. Одоо бодоход, унтаагүй л байсан юм билээ. Их хөөрхөн харагдсан. 13, 14-тэй жаахан охин шиг л. Тэгэхээр нь би санаа амраад унтаад өгсөн. Үүрийн зургаан цагт босоод харсан чинь Наоко алга. Унтлагын хувцас нь шалан дээр хэвтэнэ. Гадуур хувцас, орны толгойд тавьдаг гар чийдэн нь байсангүй. Гар чийдэнгээ авсныг бодвол харанхуйд л явжээ. Ширээн дээр “Хувцсыг минь Рэйкод өгөөрэй” гэсэн өнөө зурвас байлаа. Би ч хүн амьтан дуудаад Наоког эрэхээр гарсан. Хааяагүй эрж эрж таван цагийн дараа олсон доо. Бөхөө гээчийн олсоо хүртэл зэхээд тавьсан байж билээ.

Рэйко гүнээ санаа алдаж муужгайг иллээ.

- Та цай уух уу?

- Тэгье.

Би ус буцалгаж, цай үйгээд тагтан дээр эргэж ирлээ. Нар жаргах дөхөж, илч нь буураад, моддын сүүдэр хөлд минь хүртэл уртасчээ.

- Хэдэн цагийн дараа эмнэлгийн машин ирж, Наоког авч явсан. Цагдаагийнхан намайг жаал шалгаасан ч тэр зурвасыг нь хараад амиа хорлосон гэдгийг нь төвөггүй тогтоосон. Сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүс амиа хорлох нь тэдний хувьд энгийн л зүйл шиг байна лээ. Цагдаагийнхан явуут л чамд цахилгаан илгээсэн юм.

Ажил явдал нь нам гүмхэн болсон шүү. Дуу шуугаа хураасан хэдхэн хүн. Гэрийнхэн нь амиа хорлосон гэдгийг нь нууцлах гэж их л мэрийж байсан. Үнэндээ очих хэрэггүй байсан юм билээ. Дараа нь сэтгэл үймрээд тогтож суухаа больсон.

Ватанабэ, хоёулаа жаахан зугаалъя. Оройн хоолны юм авъя. Өлсчихлөө байна.

- Тэгье. Та юу идэх вэ?

- Сукияки. Ойрын хэдэн жил идсэнгүй. Бүр зүүдэллээ. Мах, ногоо, лапша, дуфүгээ хольж байгаад л идэхэд ч арааны шулс асгарна даа.

- Сайхан л санаа юм. Даанч шөл хийх тогоо алга гэвэл:

- Тэрийг надад даатгачих. Байрны эздээс тур авчихъя. Ингээд Рэйко хоёр хөгшнөөс тогоо, хийн плитка, хаймран хоолой авч ирэв.

- За ямар вэ дээ? Айхтар эд биз?

- Хэлээд юу гэхэв.

Зэргэлдээх лангуунаас үхрийн мах, өндөг, ногоо, дуфү, дарсны дэлгүүрээс цагаан дарс авсан бөгөөд Рэйко:

- Зээ дүүгээрээ хоол хүнс авахуулсан гэгдвэл хамаатнуудынхаа элэг доог болно. Тэгээд ч би овоо бийлэгжүү яваа. Юу гэж сохор зоосгүй наашлах вэ? гэсээр мөнгийг нь төлсөн юм.

Харьж ирмэгц Рэйко будаа агшааж, би тагтан дээр сүкияки бэлдлээ. Хоол буцлах зуур Рэйко гитараараа Бахыг аязыг донж маяг оруулан дарлаа. Хүндхэн хэсгийг нь зориуд удаан, эс бол хурдан тоглоно. Заримдаа ер хайхрамжгүй, заримдаа сэтгэлээ шингээн дарна. Өөрөө ч

аялгуундаа уусчээ. Гитар тоглох Рэйко даашинзаа ширтэх 17, 18-тай охин мэт үзэгдэнэ. Нүд нь гялалзаад, хаа нэг жимийж, үл мэдэг инээмсэглэнэ. Ингээд тоглож дуусмагц багана налж, тэнгэр өөд ширтэн бодолд дарагдлаа.

- Юм ярьж болох уу? гэвэл:

- Ярь ярь. Өлссөнөө л бодож суулаа.

- Та нөхөр, охин хоёртойгоо уулзах уу? Токиод байдаг гэл үү?

- Екохамад байдаг юм. Гэхдээ би тэр хоёртойгоо уулзахгүй ээ. Амьдралд нь садаа болоод яахав. Надтай уулзлаа гээд ямар олиг байхав.

Рэйко хайрцаг тамхи гаргаж ирээд нэгийг авч зуунгаа:

- Би ч дүүрсэн хүн. Өнгөрсөн үеийн дурсамж дурдатгалаас өөр юм даанч үлдсэнгүй. Амьдралын минь үнэ цэнэтэй гэсэн бүхэн хэдийн баларч арилсан.

- Гэсэн ч та надад энэ янзаараа л таалагддаг. Наокогийн хувцсыг өмсөж яваад чинь битүүхэн баярлаж л сууна.

- Залуухан гэхэд эмэгтэй хүний сэтгэлийг ховсдохдоо гаргуун юмаа гэж хэлээд Рэйко тамхиа асаалаа.

Би үл ялиг улсхийж:

- Бодсоноо л хэлсэн юм гэлээ.

Энэ зуур будаа агшиж, би тогоогоо хослов. Рэйко:

- Би зүүдлээгүй биз? гэсэнд:

- Зуун хувь бодитой сүкияки гэж энэ дээ.

Хоёул юм ярилгүй сүкияки савхдаж, шар айраг уугаад, будаа идлээ. Цахлай ирсэнд махнаасаа өгөв. Ингээд гэдэс гарч, багана налан саран

өөд ширтэв.

- Цадав уу?

- Тэглээ. Ёстой хэлэх үг алга. Ингэтлээ идэж байсангүй.

- Одоо юу хийх вэ?

- Ганц тамхи татчихаад халуун усанд оръё. Өрвийсөн үсээ угаая.

- Тэгье. Халуун ус энүүхэнд бий.

- Ватанабэ, нэг юм асууя. Чи Мидоритойгоо унтсан уу?

- Дотно харьцаанд орсон уу гэж үү? Үгүй ээ. Учраа олтлоо дотносоод хэрэггүй болов уу гэж бодсон юм.

- Тэртээ тэргүй бүх юм ойлгомжтой бус уу?

- Наоко байхгүй учраас сэтгэлээ амраа гэж хэлэх гээд байна аа даа?

- Үгүй дээ. Чи Наоког байхад хэдийн өөр бүсгүйг сонгосон. Чи Мидориг сонгож, харин Наоко үхлээ сонгосон. Нэгэнт л иймээс хойш үүрэг хариуцлагаа ухамсарлах хэрэгтэй.

- Би Наоког яагаад ч мартаж чадахгүй. Хаяж явахгүй гэсэн хэрнээ өөр нэгэн рүү хөрвөж орхиод явсан. Ингэлээ гээд Наоко эргээд ирэхгүй ч өөрөө өөрийгөө уучилж өршөөж чадахгүй юм. Таны хэлдгээр сэтгэлээ дагасан боловч одоо бодоход, Наоко бид хоёр анхнаасаа л гэрэл, сүүдрийн зааг дээр холбогдсон байжээ.

- Хэрвээ чи энэ явдлаас эмзэглэсэн бол түүнээ насан туршдаа мартаж ёсгүй. Үүнээс туршлага суух нь зүй. Гэхдээ энэ сэтгэлийн шаналлаа Мидоритой холбож яавч болохгүй. Ингэлээ гээд бүх юм эсрэгээр эргэж болно. Түүнийг гомдоовол харамсаад барахгүй. Хэдий

шаналантай ч сэтгэлээ хатамжил. Амьдралтай нүүр тулж, том хүн бол. Ингэж хэлэх гэж л тэр холоос энд ирлээ.

- Ойлголоо. Гэхдээ л сэтгэлдээ үүнийг хүлцэж чадахгүй юм. Наокогийн ажил явдлыг мартаж чадахгүй нь. Хүн ингэж төгсөх учиргүй.

Рэйко өөдөөс минь гараа сунгаж:

- Хэн хүнгүй л хэзээ нэгэн цагт энэ хорвоогоос явна.

- Чи ч, би ч ялгаагүй гэсээр толгойг минь илнэ.

Хоёул эрэг дагуу таван хором алхаж саунд хүрээд эргэж ирэхэд сэтгэл яльгүй ч атугай уужирлаа. Саравчинд дарс ууж суухад Рэйко:

- Ватанабэ, ахиад нэг хундага аваад ир гэв.

- Яах нь вэ?

- Наокогоо эцсийн замд нь үдье. Сайхан үднэ ээ.

Хундага авчирсанд Рэйко дарс сөгнөж, цэцэрлэгийн чулуун гэрэлтүүлэг дээр тавиад, саравчинд сууж гитараа аваад модон баганыг нь налангаа тамхиа сорлоо.

- Чүдэнз бий бол аваад ир. Уртхан бол сайн шүү гэсэнд би гал тогооноос хайрцаг чүдэнз авчраад, дэргэд нь суувал Рэйко:

- Тоглосон дууны минь тоогоор чүдэнз өр. Одоо гитараа дарна аа гэж хэлээд Генри Манцинигийн Dear Heart дууг маш цэвэрхэн, намуухнаар эгшиглүүлэв.

- Чи Наокод энэ пянзыг бэлэглэсэн байх аа?

- Тийм ээ, өнгөрсөн Зул сараар. Наоко энэ аялгуунд жигтэйхэн дуртай байж билээ.

- Би ч дуртай. Эрхэмсэг, сайхан аялгуу.

Рэйко Dear Heart-ын хэсгээс ахин тоглож, дарсаа балгаад:

- Би согтотлоо хэдэн дуу тоглох бол? Ийм маягаар үдвэл сэтгэлд сэвгүй дээ? гэх юм.

Ингээд Рэнко Битлзийн Norwegian wood, Yesterday, Michelle, Something, Here comes the sun, Fool On The Hill-ыг эгшиглүүллээ. Би долоон чүдэнз өрсөнд Рэико:

-Долоо гэж хэлээд дарсаа ууж, тамхиа асаагаад:

-Энэ залуус амьдралын баяр гунигийг хэнээс ч илүү мэдрэх юм гэсэн нь үнэндээ Жон Леннон, Пол Маккартни, Жорж Харрисон нарыг хэлсэн аж. Рэико урт амьсгаа авч гитараа бариад Penny Lane, Black Bird, Julia. When I'm Sixty Four, Nowhere Man. And I lose her, Hey Jude-ийг дарлаа.

- Хэд болов?

- Арван дөрөв.

- Пөөх, Ваганабэ, чи нэг тоглохгүй юу?

- Би ч гитар дарахдаа тааруухан.

- Ямар хамаатай юм бэ? гэсэнд би гитараа авч Up On The Roof -ыг итгэл муутайхан уянгалууллаа. Рэико жаал амарч, тамхна баагиулж аваад, дарснаасаа амтална. Тоглож дуусахад Рэико урам хайрлан алга ташиж билээ.

Дараа нь Равелийн Pavane pour une infante definte, Дэбюссигийн Clair da tune-ийн гитарын аязуудыг гайхалтай сайхан тоглов.

-Наоког бие барснаас хойш сурсан юм. Наоко ч уянгын аялгуунд дуртай байсаар өнгөрсөн дөө.

Хойно нь Бакаракийн Close To You, Walk On By, Raindrops Keep Falling On My Head, Weddingbell Bluesгэх хэд хэдэн аялгууг дарлаа.

-Хорь боллоо!

-Энэ янзаараа явуулын хөгжмийн хайрцаг болох нь байна шүү.
Хөгжмийн сургуулийн багш нар минь харвал ч түлхэж унагана даа.

Рэнко дарс шимж, тамхи соронгоо мэддэг аялгуунуудаа ээдж дараалуулан тоглоно, Бразилийн босановын хэв маягтай арваад аялгуу, Rodgers & Hart, Гершвин, Боб Дилан, Рэй Чарльз, Кэрол Кинг, Beach Boys, Стиви Уандер, Ue-wo multe arukou, Blue Velvet, Green Fields зэрэг эгшиг дуунууд хөвөрсөөр. Хааяахан нүдээ аньж толгойгоо хаялаад, тэрүүхэндээ дуулна.

Дарс дуусмагц хоёул виски уулаа. Чулуун гэрэлтүүлэг дээр тавьсан хундагатай дарсаа уугаад виски дүүргэж тавив.

- Хэд болж байна?

- Дөчин найм.

- Дөчин ес дэх аялгуу нь Eleanor Rigby, харин тавь дах нь мөнөөх Norwegian wood байлаа.

- Болов уу?

- Бололгүй дээ. Та ч мундаг юм! гэвэл Рэйко өөдөөс минь эгцлэн ширтээд:

- Ватанабэ, муу муухай зүйлээ март. Наоког санах бүрдээ энэ үдшийг л дурсаж яваарай гэхэд нь би үл ялиг толгой дохисон юм. Рэйко:

- Харин энэ аялгуу бяцхан бэлэг болог гээд урьд нэгэнтээ тоглож байсан Бахын аязыг тавин нэг дэх аялгуу болгон эгшиглүүллээ. Тоглож дуусмагцаа намуухнаар:

- Ватанабэ, намайг энхрийлээч.

- Би саяхан яг ингэж бодсон шүү.

Хөшгөө татсан харанхуй өрөөнд Рэйко бид хоёр нэг нэгнээ тэвэрч, эгээтэй л хос хоёр лугаа хүсэл шуналдаа автаж билээ. Өмд цамц, дотуур хувцсыг нь тайллаа.

- Амьдрал гэж сонин шүү. Арван есөн насаар дүү залуу дотуур хувцсыг минь тайлна чинээ зүүдэлж явсангүй.

- Өөрөө тайлах байсан юм уу?

- Үгүй дээ. Чи тайл. Гэхдээ үрчлээтсэн арьсыг минь хараад сэтгэлээр унав.

- Надад таны үрчлээ таалагддаг.

- Ингээд байвал уйлчихна шүү.

Биенд нь уруулаараа хүрч, үрчлээ таарвал хэлээрээ тэмтрэв. Охиных шиг жижигхэн хөхийг нь барьж, товчийг нь унслээ. Чийгтэж, халуу дүүгсэн хэлүүнд нь хүрвэл:

- Ватанабэ, хэрэггүй. Наадах чинь үрчлээ төдий л зүйл гэж шивнэх юм.

- Ийм үед тоглоом хийж болох уу? гэхэд:

- Уучлаарай. Энэ мэт хүнтэй дотносоогүй удсан болохоор айгаад байх юм. Өөрийгөө айлд ирээд хувцсаа тайлуулчихсан арван долоон настай охин шиг л санаад байна.

- Би ч ялгаагүй арван долоотой охин уруу татаж байх шиг санагдаад болдоггүй.

Үрчлээ гэсэн газар нь хуруугаа шургуулж, хүзүү, чихэн дээр нь унсээд, хөхийг нь имэрлээ. Амьсгаа нь өндөрсч, хүзүү нь үл ялиг чичрэхэд турьхан хөлийг нь салгаж байгаад аажуухан оров.

Рэйког “Хөгширсөн хойноо жирэмсэлчихвэл ичгэвтэр байх. Ойлгож байна уу?” гэж хэлэхэд би:

- Санаа зоволтгүй гэсээр эрхтнээ тултал нь оруулахад Рэйко бүхий л биеэрээ чичрэв. Нурууг нь илэн хэдэнтээ хөдлөөд хуралдаж хураагдсан ганцаардлаа юүлэх тэр агшинд бүхнээ умартжээ. Барьж боломгүй, юутай ч харьцуулшгүй мэдрэмж төрж билээ. Рэйкод бүхэлдээ наалдаж, халуун бүлээн дотор талд нь хэдэнтээ тавилаа.

- Намайг уучлаарай. Тэссэнгүй.

-Тэнэгхэн минь, эмэгтэй хүнтэй унтах бүрдээ ингэж санаа зовдог хэрэг уу?

-Зоволгүй яахав.

- Надтай элдэв юм бодсоны хэрэггүй. Бүхнээ март. Хүссэнээ л хий, дуртай үедээ биеэ сулла. Сайхан байв уу?

- Тэгэлгүй дээ!

- Өөрийгөө битгий барь. Сайхан л байна шүү дээ. Надад ч сайхан байлаа.

- Рэико!

- Юу гэж?

- Та хүнд дурлах хэрэгтэй. Ийм сайхан эмэгтэй ганцаараа байна гэхээр харуусмаар санагдах юм. Хэн нэгнийг хайраараа жаргаа.

- Чин сэтгэлээсээ ингэж байвал бодож болох л юм.

Дотор нь ороод өөрийг нь тэвэрч аажуухан хөдлөөд, хоёул инээж хөхрөн элдвийг ярихад сэтгэл уужирч билээ. Рэиког инээж хөхрөхөд энэ бие тэр аяараа долгисох шиг болсон сон.

Бид хоёр энэ янзаараа нэлээд удаан хэвтлээ.

- Ингэж хэвтэх яасан ч сайхан юм бэ! гэхэд нь би:

- Хөдлөх ч бас сайхан шүү хэмээв.

- Тэгвэл хөдлөөч гэхэд нь таазыг нь өргөж, лав гэгч нь ороод, бэлхүүсээрээ эргэлдэх хөдөлгөөн хийв.

Тэр шөнө бид хоёр дөрвөн удаа хурьцсан юм. Рэико цээжинд минь нүүрээ наагаад, бие нь чангарч уртаар санаа алдаад нүдээ анилаа.

- Энэ яваа насандаа ахиад эр хүний бараа харахааргүй болтлоо л эрхэллээ. Тийм үү, Ватанабэ? Ахиад эр хүнтэй дотносох явдалгүй гэж хэлээч.

- Ингэж баттай хэлчих хүн олдоно гэж үү?

Би Рэйког Асахигава руу нисвэл биед амар, хурдан гэж зөрөөд “Сэжаны хурдны замаар аялах дуртай” гэсээр хурдан галт тэргэнд суулаа.

Ингээд би түүнийг Үэногийн буудал хүргэж өгөв. Рэйко гитараа, би чемоданыг нь бариад галт тэрэг хүлээнгээ сандал дээр сууцгаалаа. Тэр Токиод ирсэн өдрөө өмссөн хүрэм, цагаан цамцтайгаа явна.

- Асахигава үнэхээр дажгүй газар уу? гэж асуухад нь:

- Дажгүй ээ. Би тан дээр заавал очно.

- Үнэн үү?

- Үнэн. Захиа ч бичнэ гэлээ.

- Чиний захианд би их дуртай. Харамсалтай нь, тэр сайхан захидлуудыг Наоко шатаачихсан.

- Захиа гэдэг цааснаас цаашгүй. Шатаасан шатаагаагүй сэтгэлд үлдэх нь үлдэнэ. Хадгалсан ч мартагдах нь мартагдана.

- Энүүхэндээ гэхэд ганцаараа Асахигава руу явна гэхээс эмээж л байна. Тиймээс захиа бичээрэй. Тэгвэл дэргэд чинь байх шиг сэтгэл уужирна.

- Бичнэ ээ. Санаа зоволтгүй. Тан шиг хүн хаана ч алзахгүй.

- Намайг битгий мартаарай.

- Таныг мартахгүй ээ.

- Хоёулаа ахиад уулзахгүй ч гэлээ Наоко та хоёрыг би хэзээ ч мартахгүй.

Рэиког эгцлэн ширтвэл нулимс дуслуулна. Өөрийн мэдэлгүй түүнийг үнсэхэд зөрж өнгөрөх хүмүүс хачирхан хялав хийх юм. Амьдрал үргэлжилсээр байхад энэ мэт ялих шалихгүй зүйлс бидэнд хамаатай сан уу? Рэико галт тэргэнд суухынхаа өмнө:

- Ватанабэ, хэлэх гэснээ чамд нэгэнт хэлсэн хойно жаргалтай байгаарай гэхээс өөр захих юм алга гээд хоёул гар барин салцгаав.

Мидори руу залгаж, үй олон зүйлийг өгүүлж хэлэх хэрэгтэйгээ, ганцхан түүнийгээ хүсэн хүлээж буйгаа, нүүр нүүрээ харан энэ бүхнээ шинээр эхлэх хүсэл тэмүүллээр дүүрэн байгаагаа хэллээ.

Мидори удтал дуугарсангүй. Таксофоны бүхээгийг толгойгоороо тулан зогсоход хэдий хугацаа өнгөрснийг бүү мэд. Нэгэнтээ “Чи хаана байна?” гэх Мидоригийн намуухан дуу сонстов.

Харилцуураа барьсаар эргэн тойрноо ажвал хаа зогсоогоо мэдсэнгүй. Хаа байх нь энэ вэ? Зөрж өнгөрөх олны дүрс л нүдэнд минь ойх юм. Ертөнцийн хаа нэгтээ би Мидориг ахин дахин дуудсаар зогссон сон.